



Монгол Улсын Их Сургууль
**ҮНДСЭН ХУУЛИЙН
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

(эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл)



МУИС-ийн Үндсэн хуулийн
эрх зүйн хүрээлэн
2023

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

(эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл)

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ
(эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл)

Хянасан:

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор (LL.D.) О.МӨНХСАЙХАН

Эмхэтгэсэн:

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр С.БАТ-ОРШИХ
МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр О.ДАРХАНБОЛД

© 2023 МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон системд оруулах, бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулахыг хориглоно

АГУУЛГА

Хурлын хөтөлбөр.....	v
Өмнөх үг.....	vii
Оршил.....	ix
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн шүүх (Цэц) хянах эсэх асуудал	1
<i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн гэрээт профессор, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D.) Ц.САРАНТУЯА</i>	
Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын объектыг сайжруулах арга зам: онол, практикийн асуудал.....	21
<i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор, Хууль зүйн доктор (Ph.D.) Х.СЭЛЭНГЭ</i>	
Үндсэн хуулийн цэцийн маргааны харьяалал, бие даасан, мэргэшсэн байдлыг дээшлүүлэх нь	43
<i>МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, Хууль зүйн доктор (LL.D.) О.МӨНХСАЙХАН</i>	
Үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх нь: ХБНГУ-ын туршлага.....	85
<i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, "Легалдата" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Т.АЛТАНГЭРЭЛ</i>	
Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам	95
<i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.БАЯСГАЛАН</i>	
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд (эрх зүйн зохицуулалтын хүрээнд).....	105
<i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Хууль зүйн газрын дарга Н.БОЛОРТУНГАЛАГ</i>	
Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчмыг бэхжүүлэхэд үндсэн хуулийн цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлага	131
<i>МХХ-ны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны тэргүүн, Хууль зүйн ухааны доктор (Ph.D.) В.УДВАЛ</i>	
Эрдэм шинжилгээний бага хурлын асуулт, хариултын тэмдэглэл, Дугаар 01	143
Эрдэм шинжилгээний бага хурлын асуулт, хариултын тэмдэглэл, Дугаар 02	163

ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

8:30-9:00	Бүртгэл
9:00-9:10	<p>Нээлтийн үйл ажиллагаа:</p> <p style="text-align: center;"><i>Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.НЯМБААТАР</i></p> <p style="text-align: center;"><i>Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Л.МӨНХБААТАР</i></p> <p>Хуралдаан даргалагч:</p> <p style="text-align: center;"><i>Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.МӨНХ-ОРГИЛ</i></p>
09:10-09:30	<p>“Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн шүүх (Цэц) хянах эсэх асуудал”</p> <p style="text-align: center;"><i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн гэрээт профессор, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D.) Ц.САРАНТУЯА</i></p>
09:30-09:50	<p>“Үндсэн хуулийн хяналтын объектыг сайжруулах арга зам: онол, практикийн асуудал”</p> <p style="text-align: center;"><i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор, хууль зүйн доктор (Ph.D.) Х.СЭЛЭНГЭ</i></p>
09.50-10:30	Асуулт, хариулт, хэлэлцүүлэг
10:30-10:40	Цайны завсарлага
10:40-11:00	<p>“Үндсэн хуулийн цэцийн маргааны харьяалал, бие даасан, мэргэшсэн байдлыг нь дээшлүүлэх”</p> <p style="text-align: center;"><i>МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор (LL.D.) О.МӨНХСАЙХАН</i></p>

11:00-11:20	“Үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх нь: ХБНГУ-ын туршлага” <i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, “Легалдата” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Т.АЛТАНГЭРЭЛ</i>
11:20-12:00	Асуулт, хариулт, хэлэлцүүлэг
12:00-13:00	Үдийн зоог
13:00-13:20	“Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” <i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.БАЯСГАЛАН</i>
13:20-13:40	“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал (Эрх зүйн зохицуулалтын хүрээнд)” <i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Хууль зүйн газрын дарга Н.БОЛОРТУНГАЛАГ</i>
13:40-14:00	“Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчмыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлага” <i>Монголын Хуульчдын холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны дарга, хууль зүйн доктор (Ph.D.) В.УДВАЛ</i>
14:00-14:50	Асуулт, хариулт, хэлэлцүүлэг
14:50-15:00	Хаалтын үйл ажиллагаа

ӨМНӨХ ҮГ

*Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон
Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх
ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг
боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий
ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн
Ц.МӨНХ-ОРГИЛ*

Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж, Үндсэн хуулийн хяналт буюу Үндсэн хуулийн шүүхийн тогтолцоог анхлан бий болгосон. Улмаар, Монгол Улсын Их Хурал 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг, 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг тус тус баталсан билээ. Гэвч, эдгээр материаллаг болон процессын хуулиудыг өнөөгийн нийгмийн хөгжил, өөрчлөлтөд нийцүүлж шинэчлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

УИХ-ын 2021 оны 12 дахь тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасан. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр эдгээр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг дэргэдээ хуулийн төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгүүдийг ажиллуулж байна.

Ажлын хэсгийн зүгээс санаачилж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодруулж, эрдэмтэн, судлаач нартай зөвлөлдөж, хэлэлцүүлгийг өрнүүлэх зорилгоор хэд хэдэн ажил зохион байгуулаад байна. Тухайлбал, 2023 оны 01 дугаар сарын 10-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчлэл” хэлэлцүүлгийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран зохион

байгуулсан. Мөн, Ажлын хэсгийн төлөөлөл 2022 оны 12 дугаар сард ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхэд Ханнс Зайдел сангийн дэмжлэгтэйгээр, 2023 оны 04 дүгээр сард БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхэд Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр тус тус айлчилж туршлага судалсан. Түүнчлэн, Үндсэн хуулийн шүүхэд холбогдох сайн туршлагыг хуулийн төсөлд тусгах үүднээс МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнд захиалга өгч, “Үндсэн хуулийн шүүхийн талаарх санал, тайлан, судалгааны эмхэтгэл” болон “Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх” сэдвээрх Венецийн комиссын хоёр тайланг орчуулуулав.

Ажлын дэд хэсгүүдийн зүгээс боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбарыг Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр Англи хэл рүү орчуулж, Ардчилсан сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA) Asia and the Pacific Regional Programme)-ийн шинжээчдэд санал авахаар хүргүүлсэн. Түүнчлэн, Ханнс Зайдел сангийн туслалцаатайгаар уг орчуулгыг ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгч асан, профессор, доктор Майкл Эйхбергерт санал авахаар илгээгээд байна.

Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Ажлын хэсгийн санаачилгаар “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндсэн хуулийн цэц, Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн хамтран 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Энэхүү хуралд манай улсын Үндсэн хуулийн эрх зүйн тэргүүлэх эрдэмтэн, судлаач, хуульчдаас нийт 7 илтгэл танилцуулж, хэлэлцүүлсэн. Тус хурлын үр дүнд өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэн тулгамдаж буй асуудал, тэдгээрийн шийдвэрлэх арга замын талаар ерөнхий хандлагыг тогтоож чадсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Тиймээс, Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулахад энэхүү хурлаас гарсан үр дүн ихэд тус хүргэнэ гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь уг хурлын зохион байгуулалтад бүх талын туслалцаа, дэмжлэг үзүүлсэн хамтран ажиллагч байгууллага, хурлын илтгэгч, нийт оролцогч эрдэмтэн, судлаач та бүхэнд гүн талархал илэрхийлье.

ОРШИЛ

*МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн сургуулийн профессор,
хууль зүйн доктор О.МӨНХСАЙХАН*

Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн нь Монгол Улсад Үндсэн хуульд ардчиллыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахын төлөө ардчилсан үндсэн хуулийн 30 жилийн ойн өдөр буюу 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр нээлтээ хийж, ажиллаж байгаа билээ. Энэ зорилгодоо хүрэхийн тулд тус хүрээлэн нь Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн судалгааг дагнасан институтийн хувьд чанарын өндөр түвшинд тогтвортой гүйцэтгэдэг болох, мэргэжлийн болон бусад сургалт явуулах, Үндсэн хуульд ардчиллын үнэт зүйлсийг сурталчлан таниулах, Үндсэн хуулийн эрх зүйчдийн хамтын ажиллагааг дэмжих, гадаад, дотоод харилцааг өргөжүүлэхийг хичээж байна.

Үндсэн хуулийн шүүх бол Үндсэн хуулийг бодит тохиолдолд хэрэглэдэг, түүнийг чандлан сахиулдаг институт буюу үндсэн хуульд ёсны баталгаа мөн. Манай улсын хувьд Үндсэн хуулийн шүүхийг Үндсэн хуулийн цэц гэсэн оноосон нэртэйгээр анх байгуулснаас хойш 30 гаруй жил болж байна. Энэ хугацаанд Үндсэн хуулийн цэцийн зүгээс Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ чамлахааргүй амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

Нийгэм өөрчлөгдөн хөгжихийн хэрээр Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг ч мөн энэхүү өөрчлөлт, хөгжилд нийцүүлэх хэрэгцээ шаардлага бий болоод байна. Өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, мэргэшсэн байдлыг улам бэхжүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн шүүхийн сайн туршлагаар процессжуулах тэргүүтэй тулгамдсан асуудал хуулийн болон практикийн шийдлээ хүлээж байна. Иймээс, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр чиглэлд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг

байгуулж, Ажлын хэсэг нь дэргэдээ хуулийн төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгүүдийг ажиллуулж байгаад үндсэн хууль судлаачийн хувьд талархаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад хувь нэмэр оруулахын тулд МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо (Ажлын хэсэг), Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндсэн хуулийн цэцтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулав. Энэхүү эрдэм шинжилгээний бага хуралд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн гэрээт профессор, хууль зүйн шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяа “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хянах эсэх асуудал”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор, хууль зүйн доктор Х.Сэлэнгэ “Үндсэн хуулийн хяналтын объектыг сайжруулах арга зам”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан “Үндсэн хуулийн цэцийн маргааны харьяалал, бие даасан, мэргэшсэн байдлыг дээшлүүлэх нь”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, Легалдата ХХК-ийн ТУЗ-ийн дарга Т.Алтангэрэл “Үндсэн эрхийн маргаан шийдвэрлэх нь: ХБНГУ-ын туршлага”, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Баясгалан “Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Хууль зүйн газрын дарга, хуульч Н.Болортунгалаг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал”, Монголын Хуульчдын холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны дарга, хууль зүйн доктор В.Удвал “Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчмыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлага” сэдвээр тус тус илтгэлээ танилцуулж, хэлэлцүүлсэн.

Энэхүү хуралд танилцуулсан илтгэл, хэлэлцүүлэг нь онол, практикийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд манай улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж илтгэж байна. Мөн, эдгээрт хөндөгдсөн агуулга нь Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг улам хараат бус, шударга, үр нөлөөтэй, төвийг сахисан, мэргэшсэн болгон төгөлдөржүүлэх, үндсэн эрхийн маргааныг харьяалуулах болон бусад маргааны харьяаллыг зохистой тодорхойлох, тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд, мөн Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж найдна.

Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгээс “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, мөн холбогдох хэлэлцүүлгийн тэмдэглэлийг эмхэтгэн хэвлэж уншигч Та бүхнийхээ мэлмийд өргөн барьж байгаадаа баяртай байна. Мөн, тус хурлын илтгэл, хэлэлцүүлгийн видео бичлэгийг тус хүрээлэнгийн цахим хуудас (<http://cli.num.edu.mn/>) болон youtube суваг (https://www.youtube.com/@cli_num)-аас үзэх боломжтой.

ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ (ЦЭЦ) ХЯНАХ ЭСЭХ АСУУДАЛ

*МУИС-ын Хууль зүйн сургуулийн гэрээт профессор,
хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D.)
Ц.САРАНТУЯА*

Агуулга

1. Үндсэн хууль тогтоогч ба хууль тогтоогч
2. Үндсэн хууль тогтоогч нь хууль тогтоогчоос дээгүүрт тооцогдох эрх мэдэл
3. Нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил үйлчлэх асуудалд
4. Үндсэн хуульд заасан “үүрдийн баталгаа” буюу Eternity clause
5. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь хууль байна
6. Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоох эрх мэдлийн аливаа шийдвэрийг (Цэц Улсын Их Хурлын шийдвэрийг) хянах тухайд
7. Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хууль Үндсэн хууль зөрчихгүй гэсэн баталгаа бий юу?
8. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлбэр болон агуулга талаас хянах нь
9. Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолын агуулгад холбогдох асуудал
10. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хянах эсэх асуудлаар бусад улсад маргадаггүй шалтгаан

1. Үндсэн хууль тогтоогч ба хууль тогтоогч

Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд "үндсэн хууль тогтоогч"¹ болон "хууль тогтоогч"² гэх хоёр ойлголт өөрийн гэсэн ялгаатай байр суурийг эзэлдэг. Хууль тогтоогч нь төрийн гурван эрх мэдлийн нэг бөгөөд гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн хамт төрийн гурван багана болж оршин тогтнодог. Тэдгээр гурван эрх мэдлийн үйл ажиллагаа өдөр тутмын шинжтэй байдаг бол *үндсэн хууль тогтоогч нь үндсэн хууль батлах*, үүгээрээ тодорхой шинэ төр, үндсэн хуультай байгууллыг зарлан тунхагладаг онцлогтой. Үүний нэг жишээ нь Монгол Улс 1992 онд шинэ, ардчилсан Үндсэн хуулиа даяар олноо тунхаглан зарласан явдал юм. Энэхүү баримт бичгээр монгол төрийн удирдлагын хэлбэр шинээр бичигдэж, төрийн эрх мэдлийг анх удаа хуваарилж, дотоод гадаад бодлогын агуулгыг цоо шинээр тодорхойлсон байдаг.

Дээрх санааг өөр өнцгөөс тайлбарлахад, тухайн үед манай улсын хууль тогтоох эрх мэдэл нь байнгын ажиллагаатай Улсын Бага хурал (50 гишүүнтэй) байсан. Энэхүү парламент нь хуулийн төсөл хэлэлцэн батлах ажиллагааг өдөр тутам эрхлэн хэрэгжүүлж байлаа. Харин Ардын Их Хурал (430 депутаттай) нь шинэ Үндсэн хуулийг баталж үндсэн эрхийн шинэ стандартын суурь мөн төрийн шинэ агуулгыг анхлан хуульчилснаар тухайн үед түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Үүнээс дүгнэхэд, Ардын Их Хурал нь 1992 оны *Үндсэн хуулийг тогтоогч юм*.

2. Үндсэн хууль тогтоогч нь хууль тогтоогчоос дээгүүрт тооцогдох эрх мэдэл

Манай үндсэн хууль тогтоогч нь Үндсэн хууль дахь нэмэлт, өөрчлөлтийг нийт гишүүнийхээ 3/4 -аар оруулах боломжийг хууль тогтоогчдоо буюу эдүгээгийн Улсын Их Хуралд олгожээ³. Хууль тогтоогч нь энэхүү заалтыг өөрчлөх эрхгүй, учир нь энэхүү квотыг Ардын Их Хурал нь хууль тогтоогч болох Улсын Их Хуралд Үндсэн хуулиар үүрэг болгосон байна. Ардын Их Хурал нь үндсэн хууль тогтоогчийн хувьд хууль тогтоогчоос буюу Улсын Их Хурлаас дээгүүрт тооцогдох эрх мэдэл юм. Иймд жишээ нь энэ заалтыг хууль тогтоогч өөрчлөх боломжгүй, зөвхөн биелүүлэх үүрэгтэй.

¹ Pouvoir constituant is the power to establish the constitutional order of a nation.

² Pouvoir constitue is vested in Congress, meaning that it is the only part of the government that can make new laws or change existing laws.

³ Монгол Улсын Үндсэн хууль (1992), Жаран есдүгээр зүйлийн 1, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 9-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

Нөгөөтэйгөөр аливаа үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь эхний ээлжид өөрөө үндсэн хуулийнхаа эх бичвэрт нийцсэн байж үндсэн хуулийнхаа нэгэн адил үйлчилнэ. Эс тэгвээс хэм хэмжээнүүдийн уялдаа алдагдаж үүнээс сөрөг үр дагавар гарах эрсдэл бий.

3. Нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил үйлчлэх асуудалд

“Үндсэн хуулийн нэгэн адил үйлчилнэ” гэдэг нь ердийн ухамсрын түвшинд шууд утгаар нь авч үзвэл нэмэлт, өөрчлөлт нь хүчин төгөлдөр Үндсэн хуулийнхаа эх бичвэр лугаа адил үйлчилнэ гэсэн үг. Энэ утгаараа үндсэн хуулийн шүүхийн (Цэцийн) харьяалалд байдаг бүх хууль, тогтоол, зарлиг гэх мэт нь энэхүү нэмэлт, өөрчлөлтөд ч гэсэн нийцэж буй эсэхийг Цэц хянах ёстой байна.

Харин үүнийг хэрэгжүүлэх гарааны гол нөхцөл нь өмнө дурдсанаар нэмэлт, өөрчлөлт нь өөрөө үндсэн хуулийнхаа утга агуулгад харшлаагүй байх явдал юм. Энэ нь аливаа улсын үндэсний эрх зүйн тогтолцоо дотооддоо зөрчилгүй байж цааш хөгжих утга санаанаас үүдэлтэй⁴. Гэхдээ нэмэлт, өөрчлөлтийг хянахад анхаарч үзэх шаардлагатай өөрийн гэсэн зүй тогтлууд байдаг. Үүний талаар хожуу өгүүлье.

4. Үндсэн хуульд заасан “үүрдийн баталгаа” буюу Eternity clause

Үндсэн хууль тогтоогч үндсэн хуулийнхаа эх бичвэрт “үүрдийн баталгаа”⁵ буюу үл хөндөгдөх тулгуурыг зааж өгсөн байдаг. Тухайлбал энэ нь манай улсын жишээн дээр, хүний эрх, эрх чөлөө, бүгд найрамдах засаг, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим, бүрэн эрхт байдал, нэгдмэл төр, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, захиргаа хуульд захирагдах, тусгай шүүхийг хориглох, шүүгчийн хараат бус байдал зэрэг үнэт зүйлс юм. Мөн Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хүний үндсэн эрх, эрх чөлөөг дордуулсан, төрийн эрх мэдлийг хуваарилсан зарчмыг үгүйсгэхийг хуулиар хориглосон байна⁶. Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа түүний

⁴ Schoc, Friedrich, “Einheit des Rechts” in *Uebungen im Oeffentlichen Recht I, Verfassungsrecht und Verfassungsprozessrecht* (Berlin, 2000), 61.

⁵ Eternity clause - constitutional provisions or constitutional principles that are immune from amendment.

⁶ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай (2010) хуулийн 5.4.3, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 9-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=368>

үндсэн бүтэц ба суурь үзэл баримтлалыг нь хөндөхгүй⁷ гэж тусгайлан заажээ. Энэ бүхэн нь энд дурдсан “үүрдийн баталгаа” буюу үл хөндөгдөх тулгуур гэсэн ойлголтын хүрээнд багтаж, хамгаалагдах асуудал юм.

Гэхдээ аливаа хэм хэмжээ, түүний дотор үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь дээрх үнэт зүйлүүдэд шууд халдсан, тэдгээрийг шууд үгүйсгэсэн шинж агуулаагүй хэдий ч ямар нэг байдлаар тэдгээрийг хэмжээ хэтрүүлэн хөндсөн бол үндсэн хуулийн зөрчилтэй эсэхийг нь тогтоох зайлшгүй шаардлага гарах юм. Тухайлбал, Чуулган болон Байнгын хорооны хуралдааны ирцийг багасгахдаа Улсын Их Хурлын ард түмний төлөөллийн байгууллага болох шинжийг нь хөндөн ардчилсан ёсны зарчимд харшилсан байж болохыг жишээ болгон дурдаж болох юм⁸. Эс тэгвээс үндсэн хуульт ёс жинхэнэ утгаараа төлөвших боломжгүй юм. Иймд үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулиа хэсэгчлэн бус, бүхэлд нь хамгаалах арга хэрэгсэл байх учиртай.

Үүрдийн баталгаа буюу үл хөдлөх тулгуурыг аливаа үндсэн хуульд бүгдийг нь төгс жагсаалтаар тоочсон байх зайлшгүй шаардлага байдаггүй.

Үл хөдлөх тулгуур, түүний агуулгын талаар үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд өгүүлж⁹, агуулгыг нь судалдаг. Үүгээр шинжлэх ухаан ба хэрэглээний уялдаа холбоо илэрдэг. Үндсэн хуулийн шүүхүүд нь тодорхой маргааныг шийдвэрлэхдээ үндсэн хуулийн хэм хэмжээг тайлбарлаж гарсан шийдвэр нь дараа дараагийн тохиолдлуудад үйлчилж, бүх байгууллагууд үүнийг нь нэг мөр ойлгож, биелүүлдэг байх учиртай.

5. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь хууль байна гэж заажээ

Дээр өгүүлснээс харахад 2010 оны парламент нь Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хадгалах, тус хуульд заасан үнэт зүйлсийг хамгаалах зорилгоор Үндсэн хуульдаа гар хүрэхийг хориглосон, хэрэв гар хүрэхээр бол анхаарч үзэх хязгаарлалтуудыг оруулжээ.

⁷ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай (2010) хуулийн 2.4, Эрх үйн мэдээллийн нэгдсэн систем, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 9-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=368>

⁸ Жишээ нь, Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6-д заасан УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдааны ирц 2000 оны Нэмэлт, өөрчлөлтөөр зохистой хэмжээнд байж чадсан эсэхийг дурдаж болох юм.

⁹ Generalsekretarin Kornprobst, Baeyrischer Verfassungsgerichtshoh, E-mail vom, 2022.10.14

Ийнхүү хязгаарлалт заахаас гадна Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна¹⁰ гэж хуульчилсан. Энэ нь аливаа парламентын батлан гаргах эрх бүхий хамгийн дээд хүчин чадалтай шийдвэр нь хууль байдагтай холбоотой. Мөн түүнчлэн уг заалт нь хууль тогтоогч өөрөө үндсэн хууль батлахгүй, түүнд гагцхүү нэмэлт, өөрчлөлт оруулна гэсэн агуулгыг давтан баталгаажуулж байгаа юм.

Нөгөөтэйгөө эрх зүйн нийт хэм хэмжээг үндсэн хууль, хууль, хэм хэмжээний акт, нэг бүрчилсэн шийдвэр гэж ангилах ба энэхүү дараалалд “нэмэлт, өөрчлөлт” гэсэн нэртэй шийдвэр, эрх зүйн актын төрөл гэж байдаггүй ажээ.

Мэдээж үндсэн хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлтийг “үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль” гэж нэрлэхгүйгээр зүгээр “нэмэлт, өөрчлөлт” гэж нэрлэж болохыг энэхүү нийтлэлээр үгүйсгээгүй ч цаана нь оршиж буй учир холбогдол, түүний онолын болон хууль зүйн үндэслэлийн талаар ийнхүү тайлбарлах шаардлага өнөөгийн нөхцөлд байна гэж үзлээ. Учир нь хуулиас дээгүүр хүчин чадалтай ямар нэг шийдвэрийг парламент буюу ердийн хууль тогтоогч гаргах боломжгүй юм.

6. Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоох эрх мэдлийн аливаа шийдвэрийг (Цэц Улсын Их Хурлын шийдвэрийг) хянах тухайд

Энэ бүхэн дээр нэмж өгүүлэхэд, Цэц нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянана гэж Монгол Улсын Үндсэн хуульд өөрт нь заасан байдаг¹¹. Тэгвэл Үндсэн хуульд 2000 болон 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь хэдийгээр хууль хэлбэрээр батлагдаагүй боловч Улсын Их Хурлын шийдвэрийн хувьд Үндсэн хуульдаа нийцэх ёстой байна. Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын аливаа шийдвэр Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах эрх бүхий цорын ганц байгууллагын хувьд, эрх бүхий субъект өргөдөл, мэдээл, хүсэлт гарахад энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээх ёстой юм. Ингэж хянах боломжтой байх нь эрх зүйн тогтолцооны уялдааг хангах гол нөхцөл болно.

Харин нэмэлт, өөрчлөлтийг хянахдаа үндсэн хуулийн аливаа хэм хэмжээг хэмжүүр болгох биш, гагцхүү дээд түвшний буюу илүү дээгүүр

¹⁰ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай (2010) хуулийн 5.2.4, Эрх үйн мэдээллийн нэгдсэн систем, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 9-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=368>

¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, 1/ хууль..., Улсын Их Хурлын бусад шийдвэр... Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 9-нд үзсэн <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

хүчин чадалтайд тооцогдох хэм хэмжээнүүд зөрчигдсэн эсэхийг хянах юм¹². Эдгээрт тухайн үндсэн хуулийн суурь болсон зарчмууд, үндсэн хууль тогтоогч нь заавал харгалзан үзэх үүрэгтэй ардчилсан суурь ойлголтууд хамаарна. Эдгээрт харшилж буй нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргахыг хориглодог ба үүнд дан ганц ардчиллын зарчим өөрөө бус, эрх зүйт нийгмийн анхдагч үзэл санаа хамаардаг байна¹³. Үндсэн хууль тогтоогч үндсэн хуулиа уг үзэл санааны хүрээнд боловсруулж баталсан байх шаардлагатай.

7. Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хууль Үндсэн хууль зөрчихгүй гэсэн баталгаа бий юу?

Өөр нэг зүйлийг нэмж хөндөхөд, ард нийтийн санал асуулгаар батлагдсан эхийг Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэхийг хориглосон¹⁴ заалт манай улсын хууль тогтоомжид хүчин төгөлдөр хэвээр байдаг. Үүнээс үүдэн, ард нийтийн санал асуулгаар батлагдсанаас бусад хуулийг Цэц хянана гэсэн логик үүдэн гардаг. Ер нь аливаа нэмэлт, өөрчлөлт нь ард нийтийн санал асуулгаар батлагдахаар Үндсэн хууль зөрчихгүй байдаг гэж ойлгож болохгүй гэдгийг энд мөн бодолцох хэрэгтэй.

1-7 дурдсан агуулгад холбогдох товч дүгнэлт:

Дээр өгүүлсэн бүхнээс дүгнэхэд, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийнхаа эх бичвэрт нийцэж буй эсэхийг үндсэн хуулийн шүүх байгууллага хянах бүрэн эрхтэй ба энэ хүрээнд 2000 болон 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Цэц тухай бүрд нь харьяалан хэлэлцэх шинжлэх ухааны болон хууль зүйн үндэслэл бүрдсэн байжээ. Харин хяналт хэрэгжүүлэхдээ юуг хэмжүүр болгон авч үзэх нь өөр асуудал юм.

8. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлбэр болон агуулга талаас нь хянах

¹² Generalsekretärin Kornprobst, Baeyrischer Verfassungsgerichtshof, E-mail vom, 2022.10.14

¹³ Мөн тэнд.

¹⁴ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай (2010) хуулийн 17.11, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 11-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=368>

Үндсэн хуулийн шүүх нь аливаа хэм хэмжээг, түүний дотор үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг *хэлбэр* болон *агуулга* талаас нь хянадаг¹⁵ ба үүний нийлбэр нь бүрэн төгс хяналт болно.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц өнгөрсөн хугацаанд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрхэн ямар байдлаар хянасан гэдгийг шинжлэх ухаанд заасан дээрх хоёр хяналтад тулгуурлан авч үзье.

А. Хэлбэрийн хяналт

Хэлбэрийн хяналт хэрэгжүүлэх үед хянагдаж буй тухайн шийдвэрийг (жишээ нь үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг) хэлэлцэн батлах *журам* зөрчигдсөн эсэхийг хянадаг онцлогтой. Үүнийг процедурын хяналт ч гэж нэрлэх нь бий.

Ингээд Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн баталсан *журам зөрчигдсөн эсэхийг хянасныг он дараалсан байдлаар* тоймлон авч үзье.

1999-2000 он: Улсын Их Хурал 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд *анх удаа нэмэлт, өөрчлөлт* оруулсан¹⁶. Үүнтэй холбоотойгоор иргэд Цэцэд хандаж, Нэмэлт, өөрчлөлт нь *агуулгын хувьд Үндсэн хуулийг дордуулсан* байна мөн нэмэлт өөрчлөлт оруулахдаа ард түмнээс санал асуугаагүй, Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо болон чуулганаар хэлэлцүүлээгүй..., зэргээр тус Нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх, батлан гаргахад *холбогдох журам баримтлаагүй* гэж үзэн Үндсэн хуульд нийцсэн эсэхийг нь хянаж өгөхийг хүсэж мэдээлэл гаргажээ¹⁷.

Тухайн үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль гэж байгаагүй тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа наад зах нь Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах өргөн мэдүүлэх журмыг баримталж болох байсан боловч баримтлаагүй. Ингээд Үндсэн хуулийн цэц 1999 оны нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай

¹⁵ Schoc, Friedrich, "Einheit des Rechts" in *Uebungen im Oeffentlichen Recht I, Verfassungsrecht und Verfassungsprozessrecht* (Berlin, 2000), 138-139.

¹⁶ Монгол Улсын Үндсэн хууль (1992), *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 14-нд үзсэн <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>.

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол, Дугаар 02, 2000.11.29, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 14-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1120>.

хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэсэн №3 дүгнэлтийг 2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр гаргасан. Түүнчлэн Нэмэлт, өөрчлөлтийн талаар өөрийгөө илэрхийлэх боломжийг Цэцэд олгоогүй байна гэж тухайн үед Цэц дүгнэлтдээ мөн дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл Цэц процедурын буюу хэлбэрийн хяналт хэрэгжүүлээд Үндсэн хууль зөрчигдсөн байна гэж үзсэн ба харин Нэмэлт, өөрчлөлтийн агуулгад байсан, “дордуулсан долоон өөрчлөлт” гэж иргэдийн дунд тухайн үед нэрлэгдсэн асуудлыг огт авч хэлэлцээгүй болно.

2000 он: Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 7 дугаар сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн Цэцийн 03 тоот дүгнэлтийг хэлэлцээд Нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг магадлан шалгах, дүгнэлт гаргах ямар ч эрх Үндсэн хуулийн цэцэд байхгүй, иймд дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөхгүй байх тухай Улсын Их Хурлын ямар нэгэн шийдвэр гаргах боломжгүй гэж үзсэн байдаг¹⁸.

2000 он: 12 дугаар сарын 29-нд Цэц их суудлын хуралдаанаараа дунд суудлын хуралдааны өмнөх дүгнэлтээ баталгаажуулж Үндсэн хуульд оруулсан Нэмэлт, өөрчлөлтийг “хэлбэр” талаас нь дахин шалгаж Үндсэн хууль зөрчигдсөн тул бүхэлд нь хүчингүй болгосугай гэсэн №2 тогтоолыг гаргажээ. Нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг хянаагүй хэвээр үлдээсэн байна. Харин 2000 онд шинээр сонгогдсон Улсын Их Хурал нь Цэцээс хүчингүй болгосон Нэмэлт, өөрчлөлтийг сайтар хэлэлцэж, процедурын зөрчлийг нь арилгаад *дахин шинээр баталсан* тул Монгол Улсын Үндсэн хуульд анх орсон Нэмэлт, өөрчлөлтийг Цэц хэдийгээр хүчингүй болгосон ч эдүгээ хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдсөн. Уг асуудлаар 2005 он хүртэл өргөдөл, мэдээлэл, хүсэлт ч Цэцэд дахин гараагүй юм.

2005 он: тус онд нэр бүхий иргэн Үндсэн хуулийн цэцэд хандан Нэмэлт өөрчлөлтөд байгаа “дордуулсан долоон өөрчлөлт”-ийг буюу нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг нь хянахыг хүсэж мэдээлэл гаргасан. 2005 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Цэцийн гишүүний тогтоол гарч дээрх Нэмэлт, өөрчлөлтийн “агуулгыг” хянахаас татгалзсан. Нэмэлт, өөрчлөлт нь өөрөө Үндсэн хууль тул Цэц нь өөрийн харьяаллын бусад

¹⁸ Мөн тэнд; “Улсын Их Хурлаар уг асуудлыг хэлэлцэх явцад Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хууль, Цэцийн тухай болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар дүгнэлт гаргасан тул түүний 03 тоот дүгнэлтийн талаар хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөхгүй байх тухай Улсын Их Хурлын ямар нэгэн шийдвэр гаргах боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм”.

бүх шийдвэрийг дээрх Нэмэлт, өөрчлөлтөд нийцэж буй эсэхийг хянана, иймд агуулга хянахгүй гэж үзжээ.

2006¹⁹, 2007, 2009, 2015²⁰ он: 2006 онд Цэцийн бага суудлын хуралдаан болж, маргаан үүсгэхээс татгалзсан гишүүний өмнөх шийдвэрийг хэвээр үлдээх тухай магадлал гарсан. Удаагаар нь Нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг хянан шийдвэрлэх боломжгүй тухай Цэц хоёр удаа албан бичгээр хариу өгч байжээ. 2015 онд мөн магадлал гарч Үндсэн хуулийн Нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг Цэц хянан хэлэлцэхгүй гэж шийдвэрлэсэн байдаг.

Хэлбэрийн хяналт хэрэгжүүлсэн талаарх товч дүгнэлт:

Ингээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг 1999-2015 онуудад Цэц хянахдаа дан ганц “хэлбэрийн” хяналт хэрэгжүүлсэн байна. Энэ үед Цэц Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг хянахгүй гэсэн байр суурийг баримталжээ. Нэмэлт, өөрчлөлтийг Цэцийн дунд болон их суудлын хуралдаанаар тус бүр “хэлбэр” талаас нь хянан хэлэлцээд Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт, тогтоол гаргаж тус Нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгож байсан хэдий ч 2000 онд шинээр сонгогдсон Улсын Их Хурал тус Нэмэлт өөрчлөлтийг бүрэн эхээр нь дахин батлахдаа хуульд заасан шаардлагыг “хэлбэр” буюу процедурын талаасаа хангасан гэж үздэг юм. Өөрөөр хэлбэл, нэмэлт өөрчлөлт оруулах журмыг энэ удаа баримталсан гэж үздэг байна.

Б. Агуулгын хяналт

Агуулгын хяналт гэж хууль тогтоогчийн батлан гаргасан хууль, бусад шийдвэр, түүний дотор үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга үндсэн хуулийнхаа эх бичвэрийн агуулгад нийцэж буй эсэхийг хянан хэлэлцэж шийдвэр гаргахыг хэлнэ. Энэхүү хяналт нь үндсэн хуулийн болон процессын шинжлэх ухаанд заасны дагуу өөрийн гэсэн логик дараалалтай алхмаар хэрэгждэг, үүгээрээ манай улсад агуулга хянадаг практикаас тодорхой хэмжээнд ялгагддаг.

Ингээд агуулгын хяналт хэрхэн хэрэгжсэн гэдгийг **он дараалж** авч үзье.

¹⁹ Үндсэн хуулийн цэцийн архивын баримт материал.

²⁰ Мөн тэнд.

2019 он: Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хоёр дахь удаагаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Үүнтэй холбоотой түүх сөхөхөд, Үндсэн хуулийн цэц 2000 оны Нэмэлт, өөрчлөлтийн агуулгын талаар 4 зүйл бүхий *саналыг* тус Нэмэлт, өөрчлөлт батлагдахаас өмнө Улсын Их Хуралд урьдчилан илгээж байсан. Улсын Их Хурал Үндсэн хуульд оруулсан Нэмэлт өөрчлөлтөө 2000 онд сэргээн батлахдаа түүнийг нь харгалзан үзээгүй, Нэмэлт өөрчлөлтдөө тусгаагүй.

Харин 2019 оны Нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар холбогдох байгууллагуудаас санал авахад Цэц УИХ-д тусгайлсан санал өгөөгүй байна. Энэ нь Үндсэн хуульд оруулсан Нэмэлт, өөрчлөлтийн *агуулгыг* хожим буюу 2022 онд Цэц хянан хэлэлцэх боломжийг нээх нэг алхам болсон. Учир нь саналаа өөрсдөө урьдчилаад нэгэнт өгчихсөн шийдвэрийнх нь агуулга Үндсэн хуультай зөрчилдөж байгаа эсэх талаар Цэц хожим маргаан үүсгэж хянан хэлэлцэх нь логикт төдийлөн нийцэхгүй.

2020 он: Цэц иргэдийн өргөдлийг агуулгаар нь (анх удаа) шалгаад 16, 22 дугаар магадлал гарган маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж тухайн асуудлаар маргаан үүсгэх шаардлагагүй гэж үзжээ.

2022 он: 2019 оны Нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэсэн заалтыг хүчингүй болгох тухай Цэцийн *их суудлын хуралдааны тогтоол* гарсан. Иймээс агуулга хянахгүй талаар 2006, 2015 онд гарч байсан магадлалуудыг Үндсэн хуулийн цэц хүчингүй болгох шаардлагатай болсон. Энэ нь 2022 онд шинээр гарсан болон өмнө гарсан шийдвэрүүдийн хооронд зөрчил гарахаас сэргийлэх алхам болжээ.

Дээрх санаатай холбогдуулж нэмэлт мэдээлэл өгөхөд, үндсэн хуулийн шүүхүүд нь нийгмийнхээ хөгжилтэй уялдуулж өмнө гаргасан шийдвэрийнхээ агуулгыг өөрчлөх тохиолдол гарахыг үгүйсгэхгүй²¹. Үүгээрээ төрийн бусад байгууллага, бусад шүүхээс ялгаатай. Тэдгээр нь үндсэн хуулийн шүүхийнхээ шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй

²¹ Prof. Dr. Lorenz Kahler, "Striktoren und Methoden der Rechtsprechungsänderung" (Nomos, 2011); Juergen Habrich, "Grenzen der Verfassungsänderungen und Kompetenzend des Verfassungsgerichts nach dem deutsche Recht" (Westerham, 2022)

байдаг бол үндсэн хуулийн шүүх нь гагцхүү үндсэн хуульд захирагдана²². Үндсэн хуулийн шүүхүүд нь гаргаж буй шийдвэрүүдээрээ дамжуулан үндсэн хуулиа нийгмийнхээ хөгжилд нийцүүлэн цогцлоон хөгжүүлж байх үүрэгтэй.

Цэц өөр хуулиудын (Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль) хүрээнд өмнө нь (1996,1998 онуудад) дүгнэлт, тогтоол гаргахдаа Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэх нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзсэн байдаг²³. Өөрөөр хэлбэл энэ агуулгын талаар өөр хуулийн хүрээнд Цэц өмнө шийдвэрлэж байсан.

Тухайн үед Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй гэж Үндсэн хуульд заасан байж. Шинжлэх ухаанд нутагшсан, хууль тайлбарлах аргуудыг ашиглан Үндсэн хуулийн цэц нь уг заалтыг өөрөөр тайлбарлаж, өөрөөр шийдвэрлэх боломжтой байсан хэмээн үзэж байгаа ч энэхүү нийтлэлийн сэдвийн томъёололд захирагдан энэ удаад уг асуудлыг хөндөлгүй үлдээв.

8-д дурдсан хэлбэрийн болон агуулгын хяналтад хамаарах товч дүгнэлт:

Аливаа хэм хэмжээг хэлбэр болон агуулга талаас нь хянах шаардлагатай гэж Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаан номлодог²⁴. Үүний дагуу үндсэн хуулийн шүүхүүд хяналтаа амьдрал, практикт хэрэгжүүлдэг байна. Хууль болон аливаа бусад шийдвэрийг хэлбэр болон агуулга талаас нь үндсэн хууль зөрчсөн эсэхийг хэрхэн хянахыг их сургуулийн түвшинд бодлого бодох, тохиолдолд задлан шинжилгээ хийхээс эхлүүлэн хэвшүүлж сургадаг нь эрх зүй өндөр хөгжсөн орны ном, зохиолоос харагддаг²⁵. Иймд үндсэн хууль зөрчигдсэн эсэх тухай маргааныг шийдвэрлэхдээ хэлбэрийн болон агуулгын хяналтын аль алиныг үндсэн хуулийн шүүхүүд хослуулах нь түгээмэл. Энэ бүхэн нь

²² Тексты законов, Закон о федеральном конституционном суде § 31.1, Информация из Федеративной Республики Германия, Второе издание, (Бонн, 1996), 58.

²³ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол, Дугаар 02, 2022.08.15, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 20-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16530977997941>.

²⁴ Gersdorf, Hubertus, “*Verfassungsprozessrecht und Verfassungsmaessigkeitspruefung*”, (Heidelberg, 2000), 47-52.

²⁵ Жишээ: Hemmer, Hans Peter, Sebastian Wuest, and Michael Kresser, „*Die 32 wichtigsten Faelle zum Staatsrecht*“, (Wuerzburg, 2009).

үндсэн хуулийн зөрчилд ямар нэг орон зай үлдээхээс сэргийлэх эерэг талтай.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны нийтлэг ололтод тулгуурлан, үндсэн хуулийн шүүхүүдийн тэргүүн туршлагыг судалснаар үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж хэм хэмжээг, түүний дотор нэмэлт, өөрчлөлтийг хэлбэр болон агуулга талаас нь хянадаг дэвшилтэт хандлагад шилжих алхмыг аажмаар эхлүүлсэн байжээ.

Энэ нь нийгмийн хөгжлийн өнөөгийн шатанд зарим талаар²⁶ ташаа ойлгогдсон, мөн түүнчлэн Цэц шийдвэр гаргахдаа Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрхэн яаж хэмжүүр болгосон нь шийдвэрийн агуулгад тодорхой бус байсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудад 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулахад хүргэсэн.

Уг өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг л Цэц хянахаар болсон. Ингэснээр Цэц цаашид Үндсэн Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хянахгүй болж байгаа нь Цэцийн бүрэн эрхийг зохицуулж буй, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтын агуулгыг явцууруулахад хүргэж, үүгээрээ үндсэн хуулийн зөрчил үүсэх орон зайг тодорхой хэмжээнд тэлэх эрсдэлийг бий болгож байна.

9. Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолын агуулгад холбогдох асуудал

Хэрэв ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улсууд болон вант улсуудад мандатыг засгийн газрын гишүүний албан тушаалтай хавсрах тохиолдол төдийлөн байдаггүй бол парламентын засаглалтай бүгд найрамдах улсуудын үндэсний хууль тогтоомжид парламентын гишүүн болон засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсрах боломжтой зүй тогтол үйлчилж байна²⁷.

²⁶ Энэ нь нийгмийн хөгжлийн өнөөгийн шатанд улс төрийн шалтгаан байх нь түгээмэл.

²⁷ Түүвэр жишээ: хавсрахыг зөвшөөрдөг- Дани, Финланд, Грек, Литва, Польш, Унгар; Хавсрах зайлшгүй шаардлагатай- Ирланд; Хавсрахыг зөвшөөрсөн атал 1980 оноос хойш сайд нар нь парламентын гишүүний мандатаас татгалзах тохиолдлууд гарч байсан; Хавсрахыг зөвшөөрдөггүй- Бельги, Болгар, Эстони, Франц, Нидерланд, Португал, Словак, Словени; ХБНГУ-д Холбооны Засгийн газрын гишүүн нь Бундестагийн

Шарль Луи де Монтескьёгийн үед эх суурь нь тавигдсан төрийн эрх мэдлийг хуваах онол нь орчин үеийн парламентын төрүүдэд, ерөнхийлөгчийн засаглалтай төртэй харьцуулахад хувьсан өөрчлөгдөж, боловсронгуй болсон байдаг²⁸. Иймээс *эрх мэдэл хуваарилах зарчмыг үндсэн хуульдаа тусгасан боловч түүнийг хэрхэн зохистой хэрэгжүүлэхээ* зохих хязгаарын хүрээнд улс бүр өөр өөрөөр шийдсэн нь харагддаг.

Мандатыг сайдын албан тушаалтай хавсрахад квот байх эсэх, түүнийг хэрхэн, яаж тогтоох нь парламентын бүрэн эрхийн асуудал. Үүнийг өөрийн орны онцлог, хүн амын тоо, хүний нөөцийн боломж зэрэгт тулгуурлан ардчилсан суурь зарчмын хүрээнд парламент шийдвэрлэх юм. Энэ бүхэн нь үндсэн хуулийн эрх зүйгээр зохицуулагдах харилцаа мөн боловч үндсэн хуульд өөрт нь зайлшгүй заах хэмжээний асуудал биш.

Нэг зүйлийг тэмдэглэхэд, Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтөд ямар нэг хэлбэрээр *тоо заахаас* аль болох *зайлсхийх* нь зохилтой. Жишээ нь ХБНГУ-ын Бундестагийн гишүүдийн тооны доод хязгаар гэж байдаг атал түүнийг Германы Үндсэн хуульд тусгаагүй. Сонгуулийн олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог тэнцүү хослуулдаг энэ улсад тойргоор болон намын жагсаалтаар сонгууль явуулаад, хэрэв зарим намын тойргоос авсан санал нь жагсаалтаар авах байсан саналаас илүү гарвал тухайн намд хамаарах Бундестагийн гишүүдийн тоо нэмэгдэх боломжтой байхаар зохицуулсан байдаг. 2021 оны сонгуулиар байгуулагдсан өнөөгийн Бундестаг 736²⁹ депутаттай, түүний өмнөх парламент 709-тэй байсан. Гэхдээ асуудал үүнд биш, харин Үндсэн хуульд *зайлшгүй байх ёстой хугацаа, тоон үзүүлэлтээс бусдыг* нь оруулахаас аль болох татгалзах нь тухайн хуулийн, төрийн, ер нь нийгмийн тогтвортой байдлыг хадгалах хүчин зүйлийн нэг болдог.

Үүнийг төдийлөн баримтлаагүй жишээ Засгийн газрын хэдэн гишүүн УИХ-ын гишүүний албан тушаалыг хавсрах тухай манай Үндсэн хуульд 2019 онд оруулж байсан нэмэлт, өөрчлөлтийн заалт юм. Ийнхүү, үндсэн хуулийн түвшинд цаг үеийн шинжтэй аливаа асуудлыг, тэр тусмаа тоо оруулж зохицуулах нь манай улсын хувьд ихээхэн уршигтай гэдгийг 2022 оны зун-намар хууль зүйн болон улс төрийн түвшинд бий болсон үл ойлголцол харуулсан.

мандатаа хадгалж үлддэг уламжлалтай, эсрэгээр ховор. Мэдээллийг улс тус бүрийн холбогдох салбар хуулиас харах боломжтой.

²⁸ Жишээ нь, Deutscher Bundestag, Aufgaben, Bundestag.de, <https://www.bundestag.de/parlament/aufgaben/>

²⁹ "Wikipedia," Wikipedia, last modified April 23, 2023, https://de.wikipedia.org/wiki/Deutscher_Bundestag

Ер нь мандатыг засгийн газрын гишүүний албан тушаалтай хавсарч болох эсэхтэй холбоотой асуудлыг үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны нийтлэг зүй тогтлын хүрээнд ердийн хуулиар зохицуулах нь зохилтой ба ингэх нь “үндсэн хуулийн хямрал” энэ шалтгаанаар үүсдэг байхаас сэргийлнэ.

Төрийн удирдлагын парламентын хэлбэртэй улсад квот тогтоох, эс тогтоох, хэрхэн тогтоох нь өөрөө үндсэн хууль дахь ардчиллын үнэт зүйлд хамаардаг, ардчилсан үзэл санааны хүрээнд хэрэгждэг, доторх агуулгад нь багтдаг асуудал тул ардчилсан ёс, хууль дээдлэх зарчмын хязгаар болон Үндсэн хуулийн үндсэн бүтцийг төдийлөн хөндөхгүй юм. Харин засгийн газрыг хуульд заасан хязгаарын хүрээнд бүрдүүлэх нь ерөнхий сайдын эрх хэмжээний асуудал юм.

Дээрх бүхнээс дүгнэн үзэхэд, үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Цэц хэлбэр болон агуулга талаас нь хянасныг хэдийгээр зөв зүйтэй гэж үзэж байгаа боловч, Үндсэн хуулийн цэцээс 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдөр гарсан 02 дугаар тогтоолтой буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно" гэснийг "Ардчилсан ёс,... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэнтэй нийцэхгүй гэж үзэн хүчингүй болгосонтой санал нийлэх боломжгүй байна.

10. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хянах эсэх асуудлаар бусад улсад маргадаггүй шалтгаан

Монгол Улсад *нийтийн эрх зүйн* хэрэг, маргаан шийдвэрлэдэг захиргааны хэргийн шүүх болон *Үндсэн хуулийн цэц* гэсэн хоёр төлийн шүүх байдаг. 2002 онд анх захиргааны хэргийн шүүх байгуулагдахад түүний эрх хэмжээг *тоочих* зарчмаар хуульчилсан байсан. Өөрөөр хэлбэл, ямар байгууллагын шийдвэрийг тус шүүх хянах вэ гэдгийг хуульд тоочиж зааж байсан бол анх 2015 онд Захиргааны ерөнхий хууль батлагдан гарч үүнтэй холбоотойгоор 2016 онд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн найруулснаар тус шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудлыг *ерөнхийлөн томъёолох зарчимд* шилжүүлсэн. Үүнд, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно гээд *эдгээрээс гаргасан шийдвэрийг* захиргааны хэргийн

шүүх хянан шийдвэрлэхээр заасан³⁰ нь уг шилжилтийг илэрхийлдэг. Ингэж өөрчилсөн нь захиргааны хэргийн шүүхийн харьяалал Монгол Улсад бусад улсын ижил төсөөтэй шүүхүүдтэй ойролцоо хэмжээнд очиход ихээхэн хувь нэмэр болсон.

Нийтийн эрх зүйн маргаан шийдвэрлэхэд *тоочих зарчмын дутагдалтай* тал нь, хуульд дурдаагүй байгууллагын, эсхүл байгууллагыг нь дурдсан хэр нь шийдвэрийг нь тусгайлан дурдаагүй бол тус байгууллагын нийт шийдвэр эсхүл тухайлсан шийдвэр нь шүүхийн хяналтаас санаатай эсхүл санамсаргүй байдлаар хасагдах боломжтой байдаг оршино.

Мөн зарим тохиолдолд тодорхой байгууллагын шийдвэрийг давхцуулан хуульчилснаар үл ойлголцол бий болох магадлал гардаг³¹. Энд жишээ нь Засгийн газрын шийдвэрийг захиргааны хэргийн шүүх болон Үндсэн хуулийн цэцийн хяналтад нэгэн зэрэг өгснийг дурдаж болох юм. Үүнээс гадна нэг шүүхийн харьяалан хэлэлцэх асуудлыг тоочих зарчмаар, нөгөөхийг нь ерөнхийлөн томъёолох зарчмаар хуульчлахад ч хийдэл, давхардал үүсэх нь бий³².

Энэхүү нийтлэлийн хүрээнд хөндөж буй асуудалтай холбон дээрх хоёр зарчмын талаар товч өгүүлэх шаардлага гарч байна. Жишээ нь, сонгодог чиглэлийн үндсэн хуулийн шүүхүүдийн бүрэн эрхийг тоочих биш, харин ерөнхийлөн томъёолох зарчмаар хуульчилсан байдаг. Тухайлбал, “үндсэн хууль зөрчсөн бүх шийдвэрийг үндсэн хуулийн шүүх хянана” гэх байдлаар ерөнхийлөн томъёолно гэсэн үг. Энэ тохиолдолд урьдчилсан хяналтын бүх шат дамжлагыг гүйцээсний дараагаар нийтийн эрх зүйн тухайлсан шийдвэрийг үндсэн хуулийн шүүх хянах боломжтой болох юм. Мэдээж хууль зэрэг парламентын шийдвэрийг хянах урьдчилсан шат дамжлага гэж байхгүй тул тэдгээрийг үндсэн хуулийн шүүх шууд харьяалан хянах юм.

Тэгэхээр “нийтийн эрх зүйн шийдвэр” гэсэн ангилалд мөн үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан аливаа шийдвэр шууд утгаараа хамаарна. Энэ тохиолдолд хууль, зарлиг... эсхүл “нэмэлт, өөрчлөлт” гэх зэргээр *шийдвэрийн төрөл* заахгүй гэсэн үг.

³⁰ Захиргааны ерөнхий хууль (2015), *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 22-нд үзсэн, <https://legalinfo.mn/>

mn/detail?lawId=11259; Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016), *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 22-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11703>.

³¹ Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй : суурь ойлголт, тулгамдсан асуудал”, (УБ, 2005), 229-238.

³² Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Дугаар 02, 2005.03.31, *Legalinfo.mn*, 2022 оны 9 дүгээр сарын 22-нд үзсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=997>.

Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг ерөнхийлөн томъёолсноор үндсэн хуулийн шүүхийн хяналтыг дор дурдсанаар ангилдаг нийтлэг жишиг байна: үндсэн эрхийн хяналт, хэм хэмжээний хяналт, (тодорхой; абстракт буюу хийсвэр), эрх мэдэл хоорондын маргаан мөн бусад³³. Жишээ нь үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь үндсэн хуулиа зөрчиж буй эсэхийг үндсэн эрхийн болон хэм хэмжээний хяналт хэрэгжүүлэхэд олж тогтоох шаардлага гарах магадлал бий.

Жишээ болгон дурдахад, ХБНГУ-д бусад улсад байдагтай адил “үндсэн хууль зөрчсөн үндсэн хуулийн эрх зүй”-н тухай буюу үндсэн хуулийн эрх зүй нь өөрөө үндсэн хууль зөрчсөн байх тухай албан ёсны ойлголт байдаг³⁴. Түүнчлэн Австри улсын Үндсэн хуулийн шүүх мөнхүү хяналтыг хэрэгжүүлж Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгох³⁵ бүрэн эрхтэй байна³⁶. Харьцуулахад, Герман улсын Холбооны Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт нь Холбооны Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэр гаргах тохиолдолд, нэмэлт, өөрчлөлтийн холбогдох заалтыг *хүчингүй болгох бус*, харин *анхнаасаа хүчингүй байсанд* тооцдог онцлогтой³⁷.

Дээрх тайлбаруудаас ажиглахад, шүүхийн эрх хэмжээг зөв томъёолон хуульчилбал үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үндсэн хуулийн шүүх хянах уу, үгүй юу гэсэн асуудлаар маргах шаардлага гарахгүй юм. Учир нь үндсэн хуулийн шүүх нь *нийтийн эрх зүйн бүх маргааныг хянан хэлэлцэх* зориулалттай. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь нийтийн эрх зүйн шийдвэр тул үндсэн хуульд нийцэх шаардлагатай байдаг. Үүнээс үүдэн түүнийг үндсэн хуулийн шүүх хянана, гэхдээ хэмжүүр нь үндсэн хуулийн, дээгүүр хүчин чадалтайд тооцогдох хэм хэмжээ байна гэсэн логик урган гардаг.

³³ Horst Sacker, “Das Bundesverfassungsgericht”, (Bonn: Bundeszentrale fuer politische Bildungsarbeit, 4th ed., 1989), 46-68.

³⁴Verfassungswidriges Verfassungsrecht bezeichnet in der rechtswissenschaft Regeln und Normen, die Bestandteil des geschriebenen oder ungeschriebenen Verfassungsrechts geworden sind, aber gleichwohl gegen die Verfassung verstossen und damit unwirksam oder wegen Verfassungswidrigkeit aufhebbar sind; Энэ талаар дэлгэрүүлж: Deutsch Wikipedia, “Verfassungswidriges Verfassungsrecht.” Wikipedia: Die freie Enzyklopadie, <https://de-academic.com/dic.nsf/dewiki/1455466>; Unconstitutional constitutional amendment (англи).

³⁵ Ex nunc.

³⁶ Georg Wilhelm, Verfassungswidriges Verfassungsrecht, *ecolox*, no. 11 (2001), 801.

³⁷ Ex tunc.

10-д дурдсан асуудалд хамаарах товч дүгнэлт:

Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг захиргааны хэргийн шүүхийнхтэй адил ерөнхийлөн томъёолох зарчимд шилжүүлбэл шүүх эрх мэдлийн салбарт үүсээд буй олон асуудлыг шийдвэрлэх боломжтой болох юм. Цэцийн эрх хэмжээг эрх зүй өндөр хөгжсөн улсуудад түгээмэл байдаг ангиллаар хуульчлах нь манайд зарим шүүх хоорондын эрх хэмжээд давхцал, хийдэл үүсэхээс сэргийлэх, Үндсэн хуулийн цэцийн чиг үүргийг бүрэн төгс болгоход нэмэртэй. Мэдээж Цэцэд хандах урьдчилсан нөхцөл нь, тухайн маргааныг шийдвэрлүүлэхээр эхлээд үндэсний эрх зүйн бүх шат дамжлагыг гүйцээсэн байх явдал юм. Үүнд харин өмнө дурдсанчлан, парламентын шийдвэр үндсэн хууль зөрчсөн эсэх асуудал хамаарахгүй.

Гэхдээ Монгол Улсад Үндсэн хуулийн цэц нь нийтийн эрх зүйн маргааныг бүхэлд нь шийдвэрлэдэг болох уу, эсхүл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн бүхий л байгууллагын шийдвэрээр нийтийн эрх зүйн маргааныг эхний ээлжид хязгаарлах уу? гэдэг нь тусдаа судлах асуудал юм. Үүнээс гадна ердийн шүүхийн дээд байгууллага (жишээ нь Улсын дээд шүүх) нь шийдвэр гаргахдаа Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг зөв ойлгож хэрэглэсэн эсэхийг иргэдийн өргөдлөөр үндсэн хуулийн шүүх харьяалан шийдвэрлэдэг хяналт бий. Энэхүү хяналтыг тавих нөхцөл Монгол Улсад бүрдсэн эсэх нь Цэцийн гишүүнд тавих шаардлагыг бусад улсад байдаг стандартад дөхүүлэх болон зарим өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэх эсэхээс ихээхэн хамаарна. Шүүхийн шийдвэр үндсэн хууль зөрчиж буй эсэхийг хянах хяналтыг цааш цаашдын хөгжлийн явцад дотоодын хууль тогтоомждоо аажмаар шилжүүлэн авах боломж бүрдэх юм³⁸.

Сэдэвт холбогдох ерөнхий дүгнэлт:

Түүх-онолын үндэслэл: Үндсэн хуулийн, Үндсэн хуульдаа нийцээгүй нэмэлт, өөрчлөлт (*Unconstitutional constitutional amendment*)-ийн ³⁹тухай үзэл баримтлал зуу гаруй жилийн түүхтэй байна. Энэхүү үзэл санааг 1893 онд Мичиганы Дээд шүүхийн дарга асан Томас Н. Кули болон 1910 онд АНУ-ын профессор Артур Мейчен нар АНУ-ын Үндсэн хуулийн 15

³⁸ Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй : суурь ойлголт, тулгамдсан асуудал”, (УБ, 2021), 227-232.

³⁹ Rozañi, Yaniv, “Unconstitutional Constitutional Amendments: The Limits of Amendment Powers”, *Oxford University Press*, (September 19, 2017)

дахь өөрчлөлт Үндсэн хууль зөрчсөн байх магадлалтай гэж дэвшүүлсэн байдаг.

Энэ онолыг бие даасан үндсэн хуулийн шүүхтэй болон үндсэн хуулийн хяналтыг ердийн шүүх нь хэрэгжүүлдэг олон оронд эдүгээ хүлээн зөвшөөрдөг⁴⁰.

Харин Финланд болон Нэгдсэн Вант улсад уг үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөггүй байна. Финландад парламентын аль ч шийдвэрийг шүүх хянахгүй, энэ улсад парламентын бүрэн эрхийн тухай үзлийг хүлээн зөвшөөрдөг бол Нэгдсэн Вант улсад бичмэл үндсэн хууль гэж байдаггүй, иймд “нэмэлт өөрчлөлт үндсэн хуульд нийцэх эсэх” тухай ярих боломж бөгөөд шаардлага байхгүй юм.

“Unconstitutional constitutional amendment” ойлголтын тодорхойлолт: “Үндсэн хуульдаа нийцээгүй, үндсэн хуулийн нэмэлт” гэж тухайн нэмэлт, өөрчлөлтийг хэдийгээр хэлбэр талаас нь зөв оруулсан ч, материаллаг агуулгаар нь авч үзвэл, үндсэн хуулийн эх бичвэрт шууд хориглосон, эсхүл шууд хориглоогүй, тухайлбал, үндсэн хуульд шууд заагаагүй үнэт зүйл, хэм хэмжээнд халдсаныг нь зөвтгөх үндэслэлгүй байхыг хэлнэ⁴¹.

Байгаа байдал (*actual status, Ist-stand, мера сущего*): Үндсэн хууль ёсыг тогтоох, төлөвшүүлэх зорилго тавьж буй аливаа улсад хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн аль аль нь үндсэн хуульдаа захирагдах шаардлагатай байдаг. Аль нэг эрх мэдэлд үндсэн хуулиас дээгүүрт тооцогдох боломж олгох, түүнийг зөрчих орон зайг үлдээх нь нийгэм зөв зохистой хөгжихөд сөрөг үр дагавартай. Манай улсад Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын шийдвэрийг бүрэн хянах хууль зүйн үндэслэл нь байсан боловч Цэцэд холбогдох хуулиудад нэмэлт оруулснаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянах хууль зүйн боломж 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн үгүй болжээ. Манай улсад үүний сацуу Цэц гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах цөөн тооны байгууллага, албан тушаалтныг хянах боломжтой (ихэнхийг нь хянахгүй) ба шүүх эрх мэдлийн шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг энд өгүүлсэнчлэн хянахгүй.

Байх ёстой зүйл (*target status, Soll-stand, мера должного*): Ойрын ирээдүйд ямар эрх мэдлийн байгууллагын шийдвэрийг нь ямар байдлаар, ямар дарааллаар үндсэн хуульд захирагдах боломжтой болохыг бодолцож хамгийн зөвд тооцогдох шийдэлд (энэхүү

⁴⁰ Сонгодог жишээ: Basic Law for the Federal Republic of Germany, art. 79, para. 3.

⁴¹ Энэ талаар дэлгэрүүлж: “Wikipedia,” Wikipedia.com, last modified January 3, 2023, https://en.wikipedia.org/wiki/Unconstitutional_constitutional_amendment

нийтлэлийн 10-т бичсэнийг харгалзан үзэж) хүрэх шаардлагатай. Ингэснээр мөн Үндсэн хуульд заасан үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг Үндсэн хуулийн цэц хянадаг болох тухай 1993 оноос хойш ярьж буй санаа аажмаар биеллээ олох бодит боломж нээгдэх юм.

Дүгнэх өгүүлбэр:

Constitutional supremacy only means that all law-making and conduct must be consistent with the Constitution, including amending the Constitution⁴²

Үндсэн хуулийг дээдлэх ёс гэж хууль тогтоох бүхий л ажиллагаа болон зан үйл, түүний дотор нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуульд нийцэхийг хэлнэ.

⁴² Eshed Cohen, "Introduction," in Constitutional Law (Кэйп Тауны Их Сургуулийн номын сан, Нээлттэй номын сан), *openbooks.uct.ac.za*, 2022 оны 9 дүгээр сарын 9-нд үзсэн, <https://openbooks.uct.ac.za/uct/catalog/download/25/38/1226?inline=1#:~:text=Constitutional%20supremacy%20only%20means%20that,Constitution%20including%20amending%20the%20Constitution.&text=As%20explained%20above%20C%20constitutions%20generally,to%20those%20arms%20of%20state>.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫН ОБЪЕКТЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ: ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

*МУИС–ийн Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор,
хууль зүйн доктор (Ph.D.)
Х.СЭЛЭНГЭ*

АГУУЛГА

1. Оршил
2. Үндсэн хуулийн хяналтын объект, хэлбэр: онол, практикийн асуудал
 - 2.1. Үндсэн хуулийн хяналтын объект
 - 2.2. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объект
 - 2.3. Үндсэн хуулийн хяналтын хэлбэр
 - 2.4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хяналтын хэлбэр
3. Монгол Улсын үндсэн хуулийн хяналтын объект, хэлбэр, түүнийг сайжруулах арга зам, шийдэл
 - 3.1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хяналтын объектыг өргөжүүлэх нь
 - 3.2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хяналтын хэлбэрийг сайжруулах арга зам
4. Дүгнэлт, санал
5. Ном зүй

1. Оршил

Монгол Улсын хувьд 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталж, үндсэн хуульд ёсыг хэрэгжүүлэх, ардчилсан үндсэн хуулийг хамгаалах зорилгоор үндсэн хуулийн шүүх болох Үндсэн хуулийн Цэцийг байгуулсан билээ. Үндсэн хуулийн хамгаалалт бий болсон үеэс үндсэн хуулийн хяналтын чиглэлээр эрдэмтэн судлаачдын судалгааны нилээд бүтээлүүд бүтээгдэж, шинжлэх ухааны эргэлтэнд орж, үндсэн хуульд ёсыг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмрийг оруулж байна.

Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухааны хүрээнд үндсэн хуулийн хяналтын асуудлын судлагдсан байдлыг эрдэмтэн судлаачдын бүтээлд онол –практикийн дүн шинжилгээ хийснээр дараахь 2 үечлэлд хувааж болно гэж үзлээ. Үүнд:

Нэгдүгээрт, Үндсэн хуулийн хяналтын судалгааны үндэс суурь тавигдсан үе. 1995 он – 2005 он

Энэ үед док. Ц.Сарантуяа нь үндсэн хуулийн хяналтын судалгаанд ихээхэн хувь нэмрийг оруулж, түүний онолын үндсийг бий болгосон байна. Док. Ц.Сарантуяа нь 1995 оноос үндсэн хуулийн хяналт, хамгаалалтын талаар олон эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг бичиж туурвисан байхаас гадна 2005 онд бичсэн “Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал” бүтээл нь одоог хүртэл үндсэн хуулийн хяналтын онол – арга зүйн гол тулгуур бүтээл байсаар байна. Мөн док. Д.Солонгын докторын зэрэг хамгаалсан “Монгол Улсын Үндсэн хуулийн хяналт, түүнийг сайжруулах нь” сэдэвт бүтээл нь үндсэн хуулийн хяналтын судалгааны ажилд ихээхэн хувь нэмрийг оруулжээ.

Хоёрдугаарт, Үндсэн хуулийн хяналтын судалгааны хөгжлийн үе. 2005 оноос одоог хүртэл

2005 оноос хойш Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр залуу эрдэмтэд төрөн гарч, док. Д.Гангабаатар, док.О.Мөнхсайхан, док. А.Бямбажаргал, Д.Ганзориг, А.Доржсүрэн гэх мэт судлаачдын бичсэн сурах бичиг, монографи, өгүүлэл, илтгэлүүд нь үндсэн хуульд ёсны хөгжилд томоохон хувь нэмрийг оруулж, Монгол Улсад эрх зүйт ёс, үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгоход тодорхой хувь нэмрийг оруулж байна.

Монгол Улсад үндсэн хуульд ёс хэрэгжиж, судалгааны бүтээлүүд нилээдгүй байгаа ч, үндсэн хуулийн хамгаалалт сул, хяналтын объект бүрэн бус, хяналтын механизм хязгаарлагдмал байгаа нь үндсэн хуулийн хяналтын объект, хэлбэрийг сайжруулж, үндсэн хуульд ёсыг бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

“Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын объектыг сайжруулах арга зам: онол – практикийн асуудал” судалгааны ажлыг норматив, герменевтик, харьцуулсан судлалын аргуудыг ашиглаж, Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын объект, хэлбэр, түүнийг сайжруулах талаархи зөв шийдэл, арга замыг тодорхойлохыг оролдлоо.

2. Үндсэн хуулийн хяналтын объект, хэлбэр: онол, практикийн асуудал

2.1 Үндсэн хуулийн хяналтын объект

Үндсэн хууль нь шууд хэрэгждэг эрх зүй болохын хувьд хууль дээдлэх ёсны үүднээс хяналтыг Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлдэг. Үндсэн хуулийн шүүх нь эрх зүйт ёс болон хууль дээдлэх ёсны үүднээс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дээд хяналтыг тавьж, үндсэн хуультай ёсны баталгааг хангадаг.

Үндсэн хуультай ёсны үзэл баримтлалын гол цөм нь үндсэн хуулийг эрх зүйн бусад эх сурвалжуудтай харьцуулахад хуулийн дээд хүчин чадалтай байх зарчим юм. Энэхүү үзэл баримтлалын дагуу төрийн аль ч байгууллагаас тогтоосон эрх зүйн акт, шийдвэр нь, тухайлбал, хууль, гэрээ, захиргааны байгууллагын болон шүүхийн шийдвэр нь үндсэн хуульд нийцэж байх ёстой. Төрийн байгууллагаас гаргасан эрх зүйн акт, хэм хэмжээ нь үндсэн хуультай зөрчилдөж байгаа бол хууль зүйн хүчин чадалгүй бөгөөд хууль зүйн хүчин чадалгүй учраас хэрэгжих боломжгүй юм.

Дээрхээс үндэслэн үндсэн хуулийн хяналтын объектод үндсэн хуулийн болон органик хууль; ердийн хууль тогтоомж; гүйцэтгэх эрх бүхий байгууллагын актууд; орон нутгийн засаг захиргааны актууд багтдаг. Ард нийтийн санал асуулгаар олонхын саналаар баталсан үндсэн хуулийн хуулиудыг ихэвчлэн Үндсэн хуулийн хяналтын объектод хамруулдаггүй. Харин ард нийтийн санал асуулгаар олонхын саналаар баталсан хуулиуд нь хяналтын объект болно. Үндсэн хуулийн хяналтын объект нь хувийн эрх зүйн актууд (гэрээслэл, гэрээ гэх мэт), шүүхийн шийдвэр, зарим оронд бие даасан хууль хэрэглээний актууд байж болдог. Үндсэн хуулийн хяналтын объектод албан тушаалтнуудын үйл ажиллагаа, улс төрийн олон нийтийн холбоо (ялангуяа улс төрийн нам) байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаа, мөн төрийн нэрийн өмнөөс эрх мэдлийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэдэг олон нийтийн холбоодын акт, үйл ажиллагаа орно.

Үндсэн хуулийн хяналтын объектод дотоодын улсын гэрээ, хэлэлцээр орохоос гадна олон улсын гэрээ объект болдог.

Үндсэн хуулийн хяналтын нэг гол объект нь үндсэн эрх юм. Герхард Робертс “Үндсэн хуулийн хэм хэмжээний ноён оргил нь Үндсэн хуулийн эхэнд бичигддэг хүний суурь эрхүүд юм”¹ гэжээ.

Үндсэн эрхийг үндсэн хуулийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үздэг тул иргэдийн гомдлоор маргаан үүсгэх хяналтын энэ институт үндсэн хуулийн шүүх бүхий улс орнуудад нийт маргааны дунджаар 95 орчим хувийг эзэлдэг байна². Иймд ХБНГУ –ын Үндсэн хуулийн 93 (1)-д Холбооны Үндсэн Хуулийн Шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэгт: 4-а)*(99) “*нийтийн засаглал үндсэн эрхийн аль нэгийг эсхүл 20-р зүйл (абзац 4), 33, 38, 101, 103 и 104 дэх заалтуудад заасан эрхийг зөрчсөн болохыг тогтоосон бол иргэн бүр үндсэн хуулийн гомдлыг гаргах эрхтэй*” гэжээ. ОХУ –ын Үндсэн хуулийн 125.4 дэх заалтад: “*ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай гомдол болон шүүхийн хүсэлтээр тодорхой тохиолдолд хэрэглэсэн буюу хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянана*” гэж үндсэн хуулийн шүүхийн объект нь үндсэн эрхийн хамгаалах болохыг улс орнууд хуульчилсан байна.

Словенийн эрдэмтэн док.проф. Арне Мавчич “Үндсэн хуулийн хяналт” бүтээлийн “Үндсэн хуулийн хяналтын объект ба субъект” гэсэн Х бүлэгт Үндсэн хуулийн хяналтын объектыг 25 объектоор тодорхойлсон байна.

2.2. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объект

Монгол улс нь 1990 оны ардчилсан хувьсгал, өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд ардчилсан Үндсэн хуулийг 1992 онд баталсан юм. 1992 оны Үндсэн хууль болон Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулиар анх удаа үндсэн хуулийн шүүхийг бий болгож, үндсэн хуулийн хяналтын объектыг хуульчилж өгсөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2; Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3-т тус тус зааснаар Үндсэн хуулийн Цэцийн хяналтын объект нь:

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр;
2. Зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр;

¹ Robbers, Gerhard, “An introduction to German Law”, (1998), 46

² Ц.Сарантуяа, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт, (УБ, 2020), 4, *Legaldata.mn*, <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>

3. Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр;
4. Монгол Улсын олон улсын гэрээ;
5. Ард нийтийн санал асуулгын талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр;
6. Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр;
7. Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагаа;
8. Улсын Их Хурлын дарга, гишүүн Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагаа;
9. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагаа;
10. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагаа;
11. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үйл ажиллагаа;
12. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл зэрэг болно.

Дээрхээс үндэслэн Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объект нь:

1. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл бүхий дээд байгууллагын шийдвэр,
2. Албан тушаалтны үйл ажиллагаа байна.

2.3. Үндсэн хуулийн хяналтын хэлбэр

Үндсэн хуулийн хяналтын хэлбэр нь улс бүрд янз бүр байдаг.

Үндсэн хуулийн хяналтын хэлбэрүүдийг:

1. Хэм хэмжээний хяналт
2. Иргэдийн өргөдөл, мэдээлэл
3. Хяналтын бусад хэлбэр гэж ангилж³ болно.

Үндсэн хуулийн хэм хэмжээний хяналтыг агуулгаас хамаарч:

- Албан ёсны (холбогдох акт гаргасан байгууллагын эрх мэдлийг хянах болон энэ актын хэлбэр, түүнийг батлах журамтай

³ Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн эрх зүйн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал”, (УБ, 2005), 113-141.

холбоотой) хяналт ба материаллаг (актын агуулгыг хянахтай холбоотой) хяналт

- Хийсвэр /тодорхой хэрэг маргаантай холбоогүй/ ба тодорхой хяналт гэж ангилдаг байна.

Албан ёсны буюу хэлбэрийн хяналт нь хууль, бусад норматив актыг батлахад тогтоосон процессын хэм хэмжээний хэрэгжилтэнд тавих хяналт болно. Харин материаллаг хяналт нь хуулийн агуулга нь үндсэн хуулийн утга агуулгатай нийцэж байгаа эсэхэд тавьж буй хяналт юм.

Хийсвэр хяналт нь тодорхой зөрчил, маргаантай холбоогүй хяналт бөгөөд эрх бүхий субъектүүдийн хүсэлтээр хэрэгждэг⁴. Хэм хэмжээний хийсвэр хяналтын хэлбэрийг ашиглан хууль тогтоох байгууллагаас батлагдсан хуулиудыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянадаг нийтлэг жишиг байна.

Хэм хэмжээний тодорхой хяналтыг ердийн болон дагнасан шүүхүүд хэрэгжүүлдэг. Ердийн болон дагнасан шүүхүүд нь өөрийн харьяаллын хэрэг маргааныг шийдвэрлэх явцад хэрэглэж буй хуулиа үндсэн хууль зөрчиж байна гэж үзвэл үндсэн хуулийн шүүхэд ханддаг⁵ аж.

Үндсэн хуулийн хэм хэмжээний хяналтыг батлагдсан цаг хугацаанаас хамаарч:

- Хэм хэмжээний урьдчилсан хяналт
- Батлагдсан хэм хэмжээний хяналт гэж ангилдаг.

Улс орнуудын үндсэн хуулийн шүүхүүд нь ихэвчлэн хууль тогтоох байгууллагаас баталсан хуулиуд нь үндсэн хуультай зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавихаас гадна хэм хэмжээний урьдчилсан хяналтыг олон улсын гэрээг хүлээн зөвшөөрөх, нэгдэн орж соёрхон батлахаас өмнө хэрэгжүүлэх тохиолдол байна. Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуулийн 125 дугаар зүйлийн 125.2.г)-д: *“хүчин төгөлдөр болоогүй ОХУ-ын олон улсын гэрээг Үндсэн хуулийн шүүх хянана”*⁶ гэжээ.

Мөн үндсэн хуулийн хяналтын хэлбэрийг:

- Заавал ба сонголттой (зөвхөн эрх бүхий субъектийн санаачилгаар хийгддэг) хяналт
- Шийдвэрлэх (эсвэл шийдвэр гаргах) ба зөвлөх хяналт (өөрөөр хэлбэл, хяналтанд байгаа байгууллагад шийдвэр нь заавал байх албагүй бол)

⁴ Мөн тэнд, 115.

⁵ Мөн тэнд, 118.

⁶ Комментарий к Конституции Российской Федерации, (Москов, 2002), 866 .

- Бүрэн ба хэсэгчилсэн хяналт (өөрөөр хэлбэл, бүхэлд нь биш, харин зөвхөн үндсэн хуулиар зохицуулсан харилцааны тодорхой хүрээнд тавих хяналт)
- Гадаад ба дотоод (өөрөөр хэлбэл өөр байгууллага биш, харин холбогдох актыг баталсан байгууллага) үндсэн хуулийн хяналт гэж ангилдаг.

Дээрхээс гадна улс орнуудын үндсэн хуулийн шүүхэд хэм хэмжээний негатив хяналтыг хэрэгжүүлдэг. Тодорхой асуудлаар хууль гаргахаар үндсэн хуульд заасан атал хууль тогтоогчоос энэхүү үүргээ биелүүлээгүй, өөрөөр хэлбэл хуулийг гаргаагүй тохиолдолд негатив хяналтыг үндсэн хуулийн шүүх тавьдаг байна. Постсоциалист улс орнуудаас Унгар улсын үндсэн хуулийн шүүх нь негатив хяналтыг хэрэгжүүлдэг бол ХБНГУлсад негатив хяналт нь иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хянах хэлбэртэй хамт хэрэгждэг⁷ ажээ.

Үндсэн хуулийн процессын эрх зүйн хувьд иргэдийн өргөдөл, мэдээлэл нь үндсэн хуулийн хяналтын нэг гол хэлбэр юм. Иргэн өөрийн үндсэн эрх нь зөрчигдсөн гэж үзвэл үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй бөгөөд энэ нь үндсэн хуульт ёс, үндсэн эрх хэрэгжих баталгаа болдог байна.

Үндсэн хуулийн хяналтын бусад хэлбэрт:

- Эрх мэдэл хоорондын маргаан,
- Улс төрийн намыг хориглох ажиллагаа,
- Үндсэн эрхийг урвуулан ашигласан эсэхийг хянах хяналт,
- Сонгуулийг хянах хяналт,
- Ерөнхийлөгчийг болон шүүгчийг хянах хяналт гэх мэт хяналтын хэлбэрүүд орно.

2.4. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын хэлбэр

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулинд Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объектыг заасан боловч хяналтын хэлбэрийг заагаагүй байна. Үндсэн Хуулийн Цэцийн маргаан хянан шийдвэрлэж буй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийснээр хяналтын дараахь хэлбэрүүд байна гэж үзэж болно. Үүнд:

1. Хэм хэмжээний хяналт
2. Иргэдийн мэдээлэл

⁷ Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн эрх зүйн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал”, (УБ, 2005), 121.

3. Сонгуулийн хяналт байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц нь хэм хэмжээний хийсвэр хяналтыг батлагдсан хууль, эрх зүйн актын хүрээнд хэрэгжүүлж байна. Харин хэм хэмжээний урьдчилсан хяналтыг хэрэгжүүлдэггүй.

Сүүлийн үед Үндсэн Хуулийн Цэцээр шийдвэрлэж буй зарим маргааныг, тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуультай холбоотой маргааныг шийдвэрлэсэн дүгнэлтийг авч үзвэл, негатив хяналтын хэлбэрийг хэрэгжүүлж байна гэж үзэх боломжтой юм.

Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэрлэж буй маргаан нь бараг 100 хувь иргэдийн мэдээлэлд үндэслэгдэж байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2019 – 2021 онд шийдвэрлэсэн маргааны шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд 2019 - 2020 онд шийдвэрлэсэн маргаан нь 100 хувь, 2021 онд 87.5 хувь нь иргэдийн иргэдийн мэдээллээр үүссэн байна. Хүснэгтээс харна уу.

Он	ҮХЦ-ийн шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийн тоо	Иргэний мэдээллээр хянан шийдвэрлэсэн хэрэг		Албан тушаалтны хүсэлтээр шийдвэрлэсэн хэрэг	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
2019 он	8	8	100%		
2020 он	13	13	100%		
2021 он	8	7	87.5%	1	12.5%
Нийт	29	28	97.0%	1	3.4%

Иймд Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын үндсэн хэлбэр нь иргэдийн мэдээлэл гэж үзэж болох юм.

Үүнээс гадна сонгуулийн үйл ажиллагаа нь үндсэн хуультай нийцэж буй эсэхэд тавих хяналт нь Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объект байхаар Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Цэцийн тухай хуулинд заасан байгаа болно.

3. Монгол Улсын үндсэн хуулийн хяналтын объект, хэлбэр, түүнийг сайжруулах арга зам, шийдэл

3.1. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объектыг өргөжүүлэх нь

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулинд Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объектыг

заасан боловч бүрэн бус байгаа нь үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна.

Словенийн эрдэмтэн док.проф. Арне Мавчичийн “Үндсэн хуулийн хяналт” бүтээлийн “Үндсэн хуулийн хяналтын объект ба субъект” гэсэн Х бүлэгт заасан үндсэн хуулийн хяналтын объекттой, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Цэцийн тухай хуулинд заасан Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объектыг харьцуулан авч үзвэл үндсэн хуулийн шүүхийн гол объект болох үндсэн хуулийн гомдол, шүүхийн болон захиргааны буюу орон нутгийн засаг захиргааны байгууллагын шийдвэр нь хянагддаггүй байна.

Словенийн эрдэмтэн док.проф. Арне Мавчичийн “Үндсэн хуулийн хяналт” бүтээлд заагдсан Үндсэн хуулийн шүүхийн хяналтын объект	Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулинд заасан Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объект
Хуулиуд	Хуулиуд
Олон улсын гэрээ	Олон улсын гэрээ
Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны журам	Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын шийдвэр
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дүрэм, журам	
Хамтын гэрээ	
Шүүхийн шийдвэр, тайлбар	
Хүний эрхийг хамгаалах асуудал /үндсэн хуулийн гомдол, нийтийн ашиг сонирхолтой холбоотой гомдол/	
Ард нийтийн санал асуулга, сонгуультай холбоотой асуудал	Ард нийтийн санал асуулга, сонгуультай холбоотой асуудал
Импичмент	Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх

Иймд Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объектод юуны өмнө дараахь объектыг оруулах шаардлагатай. Үүнд:

1. Хүний эрхийг хамгаалах асуудал /үндсэн хуулийн гомдол/
2. Шүүхийн шийдвэр, тайлбар
3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шийдвэр, дүрэм, журам

Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгалд эрх зүйн үнэт зүйл, үндсэн хэм хэмжээг тодорхойлохдоо “... Хүний эрх, эрх чөлөө...г эрхэмлэн дээдлэх” гэж заасан бөгөөд Үндсэн хуулийн 19 дүгээрийн зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж үндсэн эрхийг хэрэгжүүлэх үүргийг төр иргэний өмнө хүлээсэн. Хүний зөрчигдсэн эрхийг сэргээх үүргийг ердийн болон дагнасан шүүхүүд хэрэгжүүлдэг. Гэхдээ шүүхийн эцсийн шийдвэр гарсан ч хүний зөрчигдсэн эрх зөрчигдсэн хэвээр байх тохиолдол нилээдгүй байдаг.

Үндсэн эрх зөрчигдсэн гомдлыг эхний шатанд шүүх, эцэст нь Үндсэн Хуулийн Цэц хянаж сэргээх ёстой боловч хяналтын объект болгож хуульчлаагүй байна. Док. Ц.Сарантуяагийн хэлсэнчлэн “...иргэн хүн Үндсэн хуульд заасан цөөн тооны объектоор Цэцэд хандах эрхтэй бөгөөд үндсэн эрх энэхүү объектод ордоггүй. Иймд Үндсэн хуулийн “Хүний эрх” бүлгийн хэрэгжилт бодит байдалд хамгаалалтгүй орхигджээ”⁸

Монгол Улсад хүний хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төрийн өмнөөс хуулийн байгууллага, ялангуяа шударга шүүх хүлээдэг боловч үндсэн эрхийн хамгийн их зөрчил прокурор, шүүхийн байгууллагад гарч байна. Тухайлбал, хангалттай үндэслэлийг тогтоохгүй цагдан хорьж, шийтгээд, эцэст нь хэргийг хэрэгсэхгүй болгох явдал их байдаг.

Хүний үндсэн эрх зөрчигдсэн гомдлыг хянаж сэргээн эдлүүлэх төрийн байгууллага байхгүй байна. Док.проф. О.Мөнхсайханы хэлсэнчлэн “Үндсэн Хуулийн Цэцийн тухай хууль болон Цэцийн практикаар үндсэн эрхийг зөрчсөн шүүхийн болон захиргааны байгууллагын шийдвэр Цэцийн харьяаллын объектод багтдаггүй улмаас эдгээр шийдвэрээр үндсэн эрх нь зөрчигдсэн гэсэн агуулгатай өргөдлийг иргэн Цэцэд гаргаж чаддаггүй”.

⁸ Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт”, (УБ, 2020), 4, *Legaldata.mn*, <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>

Мөн Док. Ц.Сарантуяагийн хэлсэнчлэн “Үндсэн Хуулийн Цэц гүйцэтгэх эрх мэдлийн шийдвэрийг бүхэлд нь хянадаггүй. Захиргааны төв ба орон нутгийн байгууллага, тэдгээрт ажиллаж буй албан тушаалтны өдөр тутмын шийдвэр иргэн хүний үндсэн хуульд эрх, эрх чөлөөг зөрчих тохиолдол илүүтэй байдаг”

Хяналтын шүүхээр хэргийг эцэслэн шийдвэрлэсэн ч, хүний эрх зөрчигдсөн хэвээр байхаас гадна, хяналтын шатны шүүх нь Шүүхийн тухай хуулийн 50.1.1; 50.1.23 дахь заалтыг зөрчиж, илт бусдад давуу байдал бий болгох, хуулийг ноцтой зөрчих улмаар хүний эрхийг үл хүндэтгэх явдал хэвийн байсаар байна. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын илтгэлүүд, НҮБ –ийн зөвлөмжид үндсэн эрхийн зөрчлийн талаар нотолгоо бүхий баримтууд тусгагддаг бөгөөд энэхүү зөрчлийг ихэнхдээ шүүх, захиргааны байгууллага гаргадаг боловч шийдвэрлэгдэхгүй хэвээр үлддэг.

Ийнхүү хүний эрх зөрчигдөж, шүүхийн эцсийн шатанд ч сэргээгдэхгүй хэвээр байгаа талаархи жишээг авч үзвэл: Барилгын “А” ХХК орон сууцны хотхон барьж, иргэдэд худалдахдаа гэрээний үндсэн заалтыг болон Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан “үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах” эрхийг зөрчиж, кв.м-ын зөрүү гаргаж, түүнээс 1 – 6 тэрбум төгрөгийн ашиг олж, үндэслэлгүй хөрөнгөжсөн хэргийг хяналтын шатны шүүх нь харьяаллын бус байхад маргаагүй асуудлыг үндэслэл болгож, шийдвэр гаргаж, хүний зөрчигдсөн эрхийг сэргээхгүй орхисон. Энэ тохиолдолд шүүхийн шийдвэр нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан “үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах” эрхийг зөрчсөн гэж Үндсэн Хуулийн Цэцэд иргэн өргөдөл гаргах боломжгүй байна. Учир нь:

1. Хяналтын шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ “үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах” эрх, гэрээний зөрчлийн асуудлыг хууль ёсны гэж үзсэн бөгөөд эцсийн шийдвэр юм.
2. Монгол Улсын Шүүхүүд Үндсэн хуулийг удирдлага, үндэслэл болгон хэрэг шийдвэрлэдэггүй учраас үндсэн эрх зөрчигдсөн эсэхэд ямар нэгэн тайлбар, үндэслэлийг шийдвэртээ бичдэггүй.
3. Үндсэн хуулиар үндсэн хуулийн гомдол гаргах эрхийг иргэдэд олгоогүй болно.

Дээрхээс үндэслэн Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц нь үндсэн хуулийн шүүх учраас түүний хяналтын объектод үндсэн эрхийн гомдлыг хуульчилж, үндсэн хуульд ёсыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн Монгол Улсын үндсэн хуулийн хяналтын объектод шүүхийн шийдвэр, тайлбар /онолын үндэслэл/ байх шаардлагатай. Үндсэн хууль нь эрх зүйн тогтолцооны үндэс, үндсэн хэм хэмжээ учраас хууль тогтоох,

гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн аль нь ч түүнд захирагдах ёстой. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийг зөрчих эрх төрийн аль ч эрх мэдэлд байх ёсгүй бөгөөд энэ нь үндсэн хуульт ёс юм. Иймд Үндсэн хуулийн шүүх нь дэлхийд түгээмэл ойлгогдож буй утгаараа хууль тогтоогчоос баталсан хууль, гүйцэтгэх эрх мэдлээс гаргасан шийдвэр болон ердийн болон дагнасан шүүхийн шийдвэр төрийн тулгуур хуулийн заалтыг зөрчиж буй эсэхэд хяналт тавьдаг байгууллага юм. Энэ нь үндсэн хуулийн хяналтын сонгодог утга⁹ ажээ.

Үндсэн хуулийн шүүхээс шүүхийн шийдвэрийг хянахдаа “давж заалдах” шатны шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлдэггүй, харин дараахь 2 объектыг хянадаг. Үүнд:

- 1) шүүхээс хэрэглэж шийдвэр гаргасан хууль Үндсэн хуулийг зөрчсөн эсэх,
- 2) шүүхээс хуулийг хэрэглэж шийдвэр гаргахдаа Үндсэн хуулинд заасан үндсэн эрхийн агуулгыг буруу ойлгож тайлбарласан эсэх

Харин Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудалд шүүхийн шийдвэр хамаардаггүй байна. Өөрөөр хэлбэл, Цэц нь парламент, засгийн газар, ерөнхийлөгчийн шийдвэрийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах эрхтэй байна. Ингэснээрээ Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц төрийн гурван бус, харин хоёр эрх мэдлийн шийдвэрийг хянадагт дэлхийн улс орнуудын Үндсэн хуулийн шүүхүүдээс ялгагдах нэг онцлог¹⁰ гэж док. Ц.Сарантуяа үзжээ.

Монгол Улсад ердийн шүүхийн шийдвэр, тайлбар Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объектод багтдаггүй бөгөөд док.проф. О.Мөнхсайханы хэлсэнчлэн: Үндсэн хуульд заасан процессын эрхийг хамгаалах ёстой шүүх нь өөрөө эдгээр эрхийг ихэнхдээ зөрчдөг¹¹. Цэц анх байгуулагдсан цагаасаа шүүхийн шийдвэрээр үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэхээс татгалзаж ирсэн. Дээд шүүхийн шийдвэр, тайлбар үндсэн эрхийг зөрчсөн гэдгийг Цэц тогтоосон ч, уг шийдвэр, тайлбарыг хүчингүй болгохоос татгалзаж байсан¹²

Шүүхийн шийдвэр, тайлбар үндсэн хуультай зөрчилдөж, улмаар хүний эрхийг зөрчиж буй нэг жишээ нь Улсын Дээд Шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 11 дугаар “Эрүүгийн хуулийн 1.10

⁹ Ц.Сарантуяа, “Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт”, (УБ, 2020), 97, *Legaldata.mn*, <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>

¹⁰ Мөн тэнд, 2-3.

¹¹ О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн Хуулийн Цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж. Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: өнөө ба ирээдүй”, (УБ, 2015), 66, *Legaldata.mn*, <https://legaldata.mn/buteel/pdf?id=622>

¹² Док.проф. О. Мөнхсайхан “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн Хуулийн Цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж” илтгэлээс

дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар” юм. Энэхүү тайлбар нь гэмт этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх тухай олон улсын хүний эрхийн конвенц, пактын заалтуудыг зөрчсөнөөр Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3 –р зүйл, 16 дугаар зүйлийн 16.13 –р зүйл заалтуудтай зөрчилдөж байгаагаас гадна Үндсэн Хуулийн Цэцийн 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг зөрчсөн байна. Мөн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны ойлголтыг гажуудуулж, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.1, 1.9 дугаар зүйлийн 1.9.1, 1.9.2 дахь заалтыг зөрчсөн шинжлэх ухааны бус тайлбар юм. Дээд Шүүхийн тайлбар гарахаас өмнө шүүхүүд хуулийг зөв хэрэглэж байсан бол тайлбар гарснаас хойш хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргийг буцаах, эсвэл ял оногдуулан шийдвэрлэх болсон байна. Өөрөөр хэлбэл, нэг цаг үед үйлдэгдсэн, ижил зүйл ангиар зүйлчлэгдсэн хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргүүдийн хувьд Дээд Шүүхийн тайлбар гарахаас өмнө шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүд нь хэрэгсэхгүй болгогдсон бол, тайлбар гарснаас хойш шүүхээр шийдвэрлүүлж буй хэргүүдэд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа хийгдэх болжээ. Ингэснээр эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь “Хууль шүүхийн өмнө адил, тэгш эрхтэй байх зарчим” алдагдаж байна.

Иймд Монгол Улсын үндсэн хуулийн хяналтын объектыг сайжруулах арга замыг:

- 1) Үндсэн Хуулийн хяналтын объектыг өргөжүүлэх,
- 2) Үндсэн Хуулийн хяналтын хэлбэрийг зохистой тодорхойлох
- 3) Үндсэн Хуулийн хяналтын объект, хэлбэрийг хуульчлах явдал гэж үзэж байна.

3.2. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын хэлбэрийг сайжруулах арга зам

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын хэлбэр нь хуульчлагдаагүй бөгөөд хэм хэмжээний хийсвэр хяналт, иргэдийн мэдээлэл, сонгуулийн хяналтаас өөр хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэхгүй байгаа явдал нь үндсэн хуулийн хамгаалалтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байхаас гадна үндсэн хуульд ёс зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд дараахь хяналтын хэлбэрийг Үндсэн Хуулийн Цэц хэрэгжүүлэх шаардлагатай гэж судлаачийн хувьд үзэж байна.

Юуны өмнө үндсэн хуулийн хэм хэмжээний хяналтын хүрээнд урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэхийг хуульчлах нь зохистой байна. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц нь олон улсын гэрээ болон зарим

хуульд урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах нь өнгөрсөн борооны хойноос цув нөмрөхтэй адил юм.

Дэлхийн улс орнууд нэгдэн орсон олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны 5 дугаар сарын 3 –ны өдөр батлагдсан Венийн конвенцын дагуу улс орнууд олон улсын гэрээгээр хүлээх үүргээ заавал биелүүлэх ёстой нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг (pasta sund servanda) баримтлах үүрэгтэй байдаг учир төрөөс нэгэнт хүлээн зөвшөөрч, соёрхон баталсан гэрээг заавал биелүүлэх ёстой болдог. Иймд үндсэн хуульд нийцээгүй олон улсын гэрээнд нэгдэн орохоос болгоомжлох зорилгоор ихэнхи улс оронд олон улсын гэрээг хүчин төгөлдөр болохоос өмнөх шатанд хянах урьдчилсан хяналтыг өвөрмөц объект болгодог байна. Тухайлбал, ОХУ –ын Үндсэн хуулийн 125.2.г)-д: “хүчин төгөлдөр болоогүй ОХУ-ын олон улсын гэрээг Үндсэн хуулийн шүүх хянана” гэжээ

Док. Ц. Сарантуяа “манайд хуульчилсан..... зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг уян хатан дуализмын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг үндэсний эрх зүйг урьдал болгосон монизмтай зөрчилдсөн баримт бичиг болгоход хүргэж буйг цаашид боловсронгуй болгох шаардлагыг нөхцөлдүүлж байгаа юм” гэжээ.

Хууль тогтоомжийн мэдээллийн санд Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэрлэсэн 297 шийдвэр байх бөгөөд урьдчилсан хяналтыг хэрэгжүүлсэн шийдвэр байхгүй байна. /2022 оны 5 сарын байдлаар/ Үүнээс:

Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлэсэн маргааны төрөл	Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлэсэн хэргийн тоо	Тайлбар
Хууль Үндсэн хууль зөрчсөн	255	Дунд суудлын болон их суудлын хуралдааны шийдвэр орсон
УИХ –ын тогтоол Үндсэн хууль зөрчсөн	11	
ЗГ –ын тогтоол Үндсэн хууль зөрчсөн	14	

Сонгуулийн Ерөнхий хороо Үндсэн хууль зөрчсөн	4	
Ерөнхийлөгчийн зарлиг Үндсэн хууль зөрчсөн	2	
Ерөнхийлөгчийн хүсэлт	1	
Албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн	9	
Засгийн газар Айбекс группийн түншлэлийн гэрээ	1	1995 - 12 - 07-ны Дүгнэлт №7 ер.сайд Жасрайг огцруулах тухай хамт
Нийт	297	

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын хэлбэрийг сайжруулж, урьдчилсан хяналт тавих эрхийг хуульчлах шаардлагатай болохыг дараахь жишээгээр тайлбарлая.

Олон улсын түвшинд цөмийн энергийн тэр дундаа ураны салбарт тэргүүлэгч байгууллага нь Франц улсын “AREVA” бөгөөд Монгол Улсад 1997 онд орж ирсэн. Франц улсын “AREVA” байгууллага нь Монгол улсад 1997 онд үйл ажиллагаа явуулах болсноос хойш 2 жилийн дараа буюу 1999 онд Монгол улс нь Олон улсын “Energy charter Treaty” буюу “Эрчим хүчний Харти” гэрээнд элсэн оржээ. Энэхүү гэрээг анх 1991 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Өмнөд Голландын нийслэл “The Hague” хэмээх хотод анх баталж байсан. Хуулийн уялдаа холбоог бэхжүүлэх үүднээс Португалын Лисбон хотноо 1994 онд өөрчлөлт оруулсан. Ерөнхийдөө улс хоорондын **цөмийн энергийг эрэн хайх, үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах, ашиглах шаардлагыг хүлээн зөвшөөрч үлмаар худалдаа, олборлолт, тээвэрлэлт болон хөрөнгийн оруулалтын талаар зохицуулсан гэрээ** хэлэлцээр юм. “Эрчим хүчний Харти” гэрээний 7.1-д: Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Эрчим хүчний **материал болон бүтээгдэхүүний гарал үүсэл...үл харгалзан** ...дамжин өнгөрүүлнэ” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т: “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан заалттай зөрчилдөж, цөмийн аюултай цацраг идэвхит бодисыг эрэн хайх, үйлдвэрлэн боловсруулах, тээвэрлэх, булшлах үүргийг хүлээж байна.

Монгол Улс нь 2009 онд “Цөмийн энергийн тухай” хуулийг баталж, цөмийн энергийг ашиглах асуудлыг төрийн бодлого болгон хэрэгжүүлж байна. Иймд УИХ –ын 45-р тогтоолд: “...цаашид цөмийн түлшний үйлдвэр байгуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ” /3.2.1/, “Гадаад орнуудын туршлага судлах замаар **цөмийн болон цацраг идэвхт хаягдлын хадгалалт, бүлшлалт, боловсруулалт зэрэг нарийн хяналт, өндөр технологи шаардсан үйл ажиллагааг өөрийн оронд хэрэгжүүлэх чиглэл баримтална.**” / 4.5/ гэж заасан. 2011 оны 1 сарын УИХ –ын Чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд С. Батболд хэлэхдээ: “...Цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, боловсруулах, баяжуулах, цаашдаа цөмийн түлшний үйлдвэр байгуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх... **тэргүүлэгч Франц улсын “Арева”, Канадын “Камеко”, ОХУ-ын “АРМЗ”-ыг татан оролцуулахыг чухалчилж байна**” гэжээ. Манай улс “AREVA” -тай цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах салбарт хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичигт 2009 оны 10 дүгээр сарын 05-ны өдөр гарын үсэг зурж, улмаар тус группийн Дорноговь аймаг дахь хайгуул амжилттай болж, улмаар Улаанбадрах сумын нутаг Дулаан-Уул хэмээх газраас уран олборлож, цаашдаа олборлох үйлдвэр байгуулахаар тохиролцсон байна. 2017 он гэхэд олборлосон ураны хүдрээ боловсруулж, шар нунтаг гаргаж авах үйлдвэрээ байгуулна. Харин шар нунтаг хэлбэрт оруулсан уранаа баяжуулах үйлдвэрт экспортлохоор төлөвлөжээ. АРЕВА Майнс ХХК нэрээ 2018 онд Бадрах Энержи ХХК болгож өөрчилсөн бөгөөд 2021 онд Зөөвч-Овоо ГДУО үйлдвэрлэлийн туршилт эхний торлолоор эхэлсэн.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын иргэд Арева компанийн үйл ажиллагааг эсэргүүцэж, үл мэдэх шалтгаанаар мал олноор устгах, эрэмдэг мал төрөх, эмэгтэйчүүдийн төрөхийн өвчлөл ихсэж буйг ураны олборлолттой холбож олон удаа ярьж байсан ч, удаа дараагийн хяналт, дүгнэлтээр үгүйсгэж ирсэн. Байгаль орчны төлөө үйл ажиллагаа явуулдаг “Голомт” ТББ-ын гаргасан судалгаагаар Дорноговь аймгийн Улаанбадрах суманд хоёр нүд сохор, атанга хөлтэй ботго, хүн толгойтой хурга, уруулгүй, хөлгүй ишиг, толгойгүй хурга, хүзүүгүй хурга, гурван хөлтэй хурга, хавтгай толгойтой хурга гэх мэт ургийн гажигтай, мутацад орсон гэх 200 гаруй малын тоо байгаа аж. Харин албаныхан болоод Арева компани өдийг хүртэл үгүйсгэсээр ирсэн юм.

Төр эдийн засгийн мөнгөний бодлогоос болж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг уул уурхайн компанийн эрх ашгаас доогуур тавьж ирсэн бөгөөд Арева компанийн үйл ажиллагаанаас хүний

эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөн тохиолдолд дотооддоо аюулыг багасгахыг эрмэлзэхээс өөр арга хэмжээ авах боломжгүй болсон.. Гэтэл ХБНГУ зэрэг улс орнууд иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалж, цөмийн хаягдлыг өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхийг бүрмөсөн хориглосон байдаг юм.

Тодорхой хяналтыг Монгол Улсын хувьд ердийн болон дагнасан шүүхийн шүүгчид Дээд шүүхээр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой боловч док. Ц.Сарантуяа “Үндсэн Хуулийн Цэцийн хувьд хяналтын танил бус хэлбэр юм” гэж үзсэнтэй санал нэг байна. Учир нь:

- 1) Тухайн маргааныг хэлэлцэн шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүн Цэцэд хандах боломжгүй байна
- 2) Улсын Дээд Шүүх нийт гишүүдийн хуралдаанаар хандахдаа зайлшгүй өөрийн харьяалан шийдвэрлэх гэж буй тодорхой маргаанд хэрэглэх гэж буй хуулиар гэсэн хязгаарлалт тусгагдаагүй байна

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц нь тодорхой хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх шаардлагатай талаар дараахь үндэслэлүүдийг гаргаж байна. Үүнд:

- 1) Монгол Улсын Дээд Шүүх нь Үндсэн хуулийг зөрчсөн тайлбарыг гаргаж, хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь “тэгш эрхийн зарчим”-ыг алдагдуулж, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж чаддаггүй. Мөн шүүхэд хууль ёсны зарчим гажуудаж, бие даасан хараат бус байх зарчим алдагддаг.
- 2) Үндсэн хуульд заасан “Хэрэв Улсын Дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэсэн заалт хэрэгжихгүй байна.
- 3) Шүүгчдэд хэрэглэж буй хууль нь Үндсэн хуультай зөрчилдөж байгаа үед Үндсэн Хуулийн Цэцэд шууд хандах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, тодорхой хяналтыг агуулгаар нь хэрэгжүүлэх шаардлагатай.
- 4) 2020 оны 01-р сарын 10 –ны “Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хууль” нь Үндсэн хуультай зөрчилдсөн учраас Үндсэн Хуулийн Цэцийн тогтоолоор хүчингүй болсон. Гэхдээ энэхүү Үндсэн хуулийг болон эрүүгийн эрх зүйн суурь зарчмыг зөрчсөн хуулийг шүүгчид практикт хэрэглэж байсан. Уг нь шүүгчид Дээд Шүүхэд асуудал тавих ёстой байсан ч нэг ч шүүгч хандаагүй.

Дээрхээс үндэслэн шүүгчдийн хэрэглэж буй хууль нь Үндсэн хуультай зөрчилдөж байгаа үед Үндсэн Хуулийн Цэцэд шууд хандах эрх

зүйн зохицуулалтыг бий болгосноор шүүхийн хууль хэрэглээг сайжруулахаас гадна Үндсэн хуулийн хяналтыг сайжруулна гэж үзэж байна.

Үндсэн хуулийн хяналтын нэг объект нь эрх зүйн хийдэл бөгөөд үүнийг арилгах арга зам нь негатив хяналт юм. Негатив хяналт хуульчлагдаагүй боловч тодорхой хэмжээнд хэрэгжиж байна гэж үзэж болно. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т заасан *“Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно”* гэсэн заалтыг Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар зохицуулахдаа *“...зөвхөн нэг удаа сонгоно”* гэсэн ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших хүсэлтэй иргэнд тавигдах туйлын тодорхой шаардлагыг хоёрдмол утгаар ойлгож тайлбарлаж болохоор хуульчилж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт нэр дэвшигчид тавигдах шаардлагыг заахдаа урьд өмнө ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байгаагүй байх шаардлагыг орхигдуулж, нэг удаа сонгогдсон хүнд дахин нэр дэвших боломжийг шууд олгох үр дагавар бүхий хуулийн заалтыг тогтоосон гэсэн мэдээллийн дагуу Үндсэн Хуулийн Цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 16 –ны дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн зарим зүйл заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн бөгөөд энэхүү маргааныг Үндсэн Хуулийн Цэц шийдвэрлэхдээ негатив хяналтыг хэрэгжүүлсэн гэж зарим судлаачид (док.А. Бямбажаргал) үздэг болно.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын хэлбэрийг сайжруулах нэг нөхцөл нь иргэдийн өргөдөл, мэдээллийг хууль зүйн нэр томъёоны үүднээс зөв тодорхойлж хэрэгжүүлэх явдал юм. Үндсэн хуулийн шүүхийн хяналтын нэг гол хэлбэр нь иргэдийн өргөдөл, мэдээлэл бөгөөд док.Ц.Сарантуяагийн хэлсэнчлэн: *“иргэдийн өргөдөл, мэдээллийн институт...үндсэн хуулийн шүүхийн хяналтын утга учрыг илэрхийлдэг, хяналтын хамгийн чухал хэлбэрт тооцогддог”*¹³

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д: *“Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу ...хянан шийдвэрлэнэ”* гэж заасан боловч док. проф. О.Мөнхсайханы хэлсэнчлэн *“Цэц өргөдөл, мэдээллийг төдийлөн ялгалгүйгээр нэг агуулгаар шийдвэрлэж ирсэн”* –ээс гадна *“...өргөдөл,*

¹³ Ц.Сарантуяа, *“Үндсэн хуулийн эрх зүйн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал”*, (УБ, 2005), 122

мэдээлэл хоёрын ялгааг Цэц заримдаа гаргадаггүй”¹⁴. Хуульд болон Цэцийн практикт өргөдөл, мэдээллийг ялгаагүй, ойлголт нь ихээхэн бүрхэг байгаа учраас док.проф. О.Мөнхсайханы хэлсэнчлэн: “мэдээллийг *actio popularis* биш, *amicus curiae* (шүүхийн найз) тайлбар гэж ойлгох нь зүйтэй”¹⁵ бөгөөд “өргөдлийг үндсэн хуулийн гомдол”¹⁶ гэж ойлгох нь зүй ёсны байна.

4. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын объектыг сайжруулах арга зам: онол – практикийн асуудал” судалгааны ажлын хүрээнд дараахь дүгнэлтийг хийж, саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Дүгнэлт:

1. Үндсэн хуульд заасан үндсэн эрх нь Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объектод хамаардаггүй тул хамгаалалтгүй байна.
2. Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын объект хязгаарлагдмал байгаа тул өргөжүүлэх шаардлагатай.
3. Үндсэн Хуулийн Цэцийн хяналтын хэлбэрийг нэмэгдүүлэх шаардлагатай
4. Док. Ц.Сарантуяагийн хэлсэнчлэн, Үндсэн Хуулийн Цэц нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн шийдвэрийг хянадаг тогтолцоог бий болгосноор Монгол Улсын Үндсэн хууль бүхэлдээ шууд хэрэгждэг, шууд үйлчилдэг эрх зүй болно гэж дүгнэж байна.
5. Үндсэн Хуулийн Цэцийн хяналтыг сайжруулж, шүүхийн институтын хувьд хөгжүүлэх шаардлагатай юм.

Санал:

1. Үндсэн Хуулийн Цэцийн тухай, Үндсэн Хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудад хууль зүйн нэр томъёоны тодорхойлолтыг тусгах

¹⁴ О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн Хуулийн Цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж. Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: өнөө ба ирээдүй”, (УБ, 2015), 66, *Legaldata.mn*, <https://legaldata.mn/buteel/pdf?id=622>

¹⁵ Мөн тэнд, 78.

¹⁶ Мөн тэнд, 78.

2. Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нэр томъёоны хувьд ялгаж тодорхойлох
3. Иргэний өргөдлийг үндсэн хуулийн гомдол хэмээн үзэх нь зүйтэй гэж док.проф. О.Мөнхсайхан үзэж, 1992 оны Үндсэн хуулийг тогтоож байсан түүх, үзэл баримтлалын үүднээс тайлбарлан нотолсон байх тул “өргөдлийг үндсэн хуулийн гомдлын агуулгаар утгажуулж хуульчлах” гэсэн док. О.Мөнхсайханы саналыг хуульд тусгах
4. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, шүүгч, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ,
5. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2.5. хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын болон хяналтын шатны шүүхийн шийдвэр, үйл ажиллагаагаар хүний үндсэн эрх зөрчигдсэн эсэх;
6. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2.6. Олон улсын гэрээг соёрхон баталж, хүчин төгөлдөр болохоос өмнө Үндсэн хуультай нийцэж буй эсэхийг хянах;
7. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2.7. Үндсэн Хуулийн Цэцийн өмнө нь шийдвэрлэсэн маргааны шийдвэр нь Үндсэн хуультай зөрчилдөж буй мэдээллийг дахин хянах;
8. Үндсэн Хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7-д: хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын болон хяналтын шатны шүүхийн шийдвэр, үйл ажиллагаагаар хүний үндсэн эрх зөрчигдсэн эсэх;
9. Үндсэн Хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.8-д: хяналтын шатны шүүхийн хэрэглэсэн хууль Үндсэн хуулийг зөрчсөн эсэх;
10. Үндсэн Хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.9-д: Олон улсын гэрээг соёрхон баталж, хүчин төгөлдөр болохоос өмнө Үндсэн хуультай нийцэж буй эсэхийг хянах;
11. Үндсэн Хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.10-д: Үндсэн Хуулийн Цэцийн өмнө нь шийдвэрлэсэн маргааны шийдвэр нь Үндсэн хуультай зөрчилдөж буй мэдээллийг дахин хянах;

5. НОМ ЗҮЙ

1. Gerhard Robbers. An introduction to German Law. German.1998.
2. Ц.Сарантуяа, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт. <https://legaldata.mn/buteel/pdf?id=775>
3. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн эрх зүйн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал. УБ. 2005.
4. Комментарий к Конституции Российской Федерации. М: 2002 г
5. О.Мөнхсайхан. Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн Хуулийн Цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж. Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: өнөө ба ирээдүй. УБ. 2015. <https://legaldata.mn/buteel/pdf?id=622>
6. О.Мөнхсайхан “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн Хуулийн Цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж” илтгэл

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН МАРГААНЫ ХАРЬАЛАЛ, БИЕ ДААСАН, МЭРГЭШСЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

*МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн сургуулийн профессор,
хууль зүйн доктор О.МӨНХСАЙХАН*

АГУУЛГА

ОРШИЛ

1. ЦЭЦИЙН МАРГААНЫ ХАРЬАЛЛЫГ ЭРГЭН ХАРАХ НЬ

Үндсэн хуулийн гомдол (иргэний өргөдөл)

Үндсэн хуулийн гомдлыг зөвшөөрөхийн зэрэгцээ Цэцийн ачааллыг тохируулах боломж

Иргэний мэдээлэл (actio popularis)-ээс татгалзах нь

УИХ дахь цөөнхөөс гаргах хүсэлт (хийсвэр хяналт)

Шүүхийн хүсэлт (тодорхой хяналт)

Хүний эрхийн үндэсний комиссын хүсэлтийг зөвшөөрөх эсэх

2. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН БИЕ ДААСАН, МЭРГЭШСЭН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хоёр шатат процедураас татгалзах нь

Хууль зүйн өндөр мэргэшил

9 жилээр зөвхөн нэг удаа томилох эсхүл зөвхөн нэг удаа дахин томилох

ДҮГНЭЛТ, САНАЛ

ОРШИЛ

Дарангуй дэглэмийг халж, либерал ардчиллыг цогцлуулахыг тэмүүлж буй дийлэнх улсад үндсэн хуулийн шүүхийг байгуулсан. Дэлхийн II дайны дараа Герман, Итали, ардчилах үйл явцын дараа Испани, Португали, Зөвлөлт холбоот улс нурсны дараа Төв болон Зүүн Европын улсууд (мөн, Монгол) үндсэн хуулийн шүүхийг байгуулсан. Энэ шүүх хууль тогтоомж болон бусад акт үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлдэг. Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн биш хэргийг шийдвэрлэдэггүй бөгөөд ердийн шүүх хууль тогтоомжийн үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэггүй. Европ загвар үндсэн хуулийн хяналтыг ердийн шүүхэд өгөхөөс татгалзаж, зөвхөн үндсэн хуулийн шүүхэд өгсөн хэвээрээ бөгөөд үүгээрээ бүх ердийн шүүх уг хяналтыг хэрэгжүүлдэг Америк загвараас ялгаатай.¹

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (Цэц) бол үндсэн хуулийн шүүх мөн. Цэцийн хэрэгжүүлдэг Үндсэн хуулийн хяналтын хамгийн гол зорилт нь бусад үндсэн хуулийн шүүхийн нэгэн адил “Үндсэн хууль дээдлэх ёсыг хангах, Үндсэн хууль шууд хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх, эрх мэдлийг хязгаарлах, хүний эрхийг хамгаалах явдал юм.”²

Энэхүү судалгаа нь хоёр үндсэн бүлэгтэй. “Цэцийн маргааны харьяаллыг эргэн харах нь” гэсэн 1-р бүлэгт Үндсэн хуулийн цэц үндсэн хуулийн гомдлыг хүлээн авдаг болох үндэслэл, үндсэн хуулийн гомдлыг зөвшөөрөхийн зэрэгцээ Цэцийн ачааллыг тохируулах боломж, иргэний мэдээлэл (actio popularis)-ээс татгалзах үндэслэл, УИХ-ын нийт гишүүний аравны нэгээс доошгүйн хүсэлт (хийсвэр хяналт) болон аль ч шатны шүүхийн хүсэлт (тодорхой хяналт) гаргах боломжийг нээх хэрэгцээ, Хүний эрхийн үндэсний комиссын хүсэлтийг зөвшөөрөх эсэх асуудлыг товч судална. “Үндсэн хуулийн цэцийн бие даасан, мэргэшсэн байдлыг бэхжүүлэх нь” гэсэн 2-р бүлэгт Үндсэн хуулийн цэцийн гишүүний хууль зүйн өндөр мэргэшлийг хангах, 9 жилээр зөвхөн нэг удаа томилдог болох эсхүл 6 жилээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох үндэслэлийг танилцуулна.

¹ Америк болон Европ загварын тус тусын онцлог, төстэй талыг дараах өгүүллээс уншина уу. О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн хяналтын хоёр загвар: онцлог ба төстэй тал,” *Эрх зүй* 31, Дугаар 1 (2015): 9–28.

² Ж.Амарсанаа, “Үндсэн хуулийн хяналт, түүнийг хэрэгжүүлэх арга зам,” *Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл)* дотор, ред. Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа (УБ, 2007), 439.

1. ЦЭЦИЙН МАРГААНЫ ХАРЬЯАЛЛЫГ ЭРГЭН ХАРАХ НЬ

Үндсэн хуулийн гомдол (иргэний өргөдөл)

Харьцуулсан судалгаагаар харвал Үндсэн хуулийн шүүх нь дийлэнхдээ абстракт хяналт, үндсэн хуулийн асуулт, үндсэн хуулийн гомдол гэсэн гурван төрлийн журмаар маргаан хянан шийдвэрлэдэг.³ Эдгээрээс үндсэн хуулийн гомдол (constitutional complaint) нь үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад хамгийн үр нөлөөтэй механизмд тооцогддог тул судалгааны энэ хэсэгт авч үзнэ.⁴

Үндсэн хуулийн гомдол нь дөрвөн хүчин зүйлээр тодорхойлогддог: (1) энэ гомдол нь үндсэн эрхийн зөрчлийн эсрэг шүүхийн хамгаалалт болдог; (2) хөндөгдөж буй акт зөвхөн үндсэн хуульд нийцсэн эсэхэд чиглэдэг боловч тухайн хэргийн бусад хууль зүйн асуудлыг хөнддөггүй; (3) хөндөгдөж буй актын сөрөг нөлөөнд хохирсон этгээд энэ гомдлыг гаргах эрхтэй; (4) үндсэн хуулийн гомдлыг шийдвэрлэдэг шүүх нь хохирогчид эрхийг нь сэргээн эдлүүлэх эрх мэдэлтэй.⁵

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн аль ч актын эсрэг үндсэн хуулийн гомдол гаргах боломжтой. Хууль үндсэн эрхийг нь зөрчих гэж байвал хувь хүн энэ талаарх гомдлыг үндсэн хуулийн шүүхэд гаргаж шийдвэрлүүлж болно. Жишээлбэл, боловсролын тогтолцоог шинэчлэх хуулийн заалт нь тухайн эцэг эхэд шууд нөлөөлсөн гэдгийг ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүх эцэг эхийн гомдлоор тогтоосон.⁶ Хуулиар үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэх нь хангалтгүй. “Үндсэн хуульд нийцсэн норматив актад тулгуурласан ч үндсэн хуульд нийцээгүй актын үр дагавраар хүний эрхийн зөрчил ихэнхдээ гардаг учраас хувь хүний гомдлын дагуу шүүхийн шийдвэр

³ Мөн тэнд, 17–19.

⁴ Хувь хүн үндсэн эрхээ хамгаалуулахын тулд үндсэн хуулийн шүүхэд хандах олон янзын журам байдгийг энэ судалгааны хүрээнд бүгдийг нь хэлэлцэх боломжгүй. Эдгээр журмын талаарх дэлгэрэнгүй судалгааг харна уу. European Commission for Democracy through Law (Venice Commission), *Study on Individual Access to Constitutional Justice* (Council of Europe Publishing, 2010), [http://www.venice.coe.int/WebForms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2010\)039rev-e](http://www.venice.coe.int/WebForms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2010)039rev-e).

⁵ Gerhard Dannemann, “Constitutional Complaints: The European Perspective,” *International and Comparative Law Quarterly* 43 (January 1994): 142.

⁶ Gotthard Wuhrmann, “Introduction,” in *Gezetz Über Das Bundesverfassungsgericht: Law on the Federal Constitutional Court Rules of Procedure of the Federal Constitutional Court* (Deutscher Bundestag, 1995), 16.

болон захиргааны актыг үндсэн хуулийн хяналтад оруулах тодорхой хандлага бий болсныг ажиглах боломжтой.”⁷

Үндсэн хуульд заасан процессын эрхийг хамгаалах ёстой шүүх нь өөрөө эдгээр эрхийг ихэнхдээ зөрчдөг гэж үздэг байна. Хэргийн ачаалал байнга өсөж байгаатай холбогдуулан шүүхүүд нь үр нөлөөтэй ажиллах сонирхлын үүднээс хуулийг явцуугаар хэрэглэх замаар шударгаар шүүлгэх эрх, давж заалдах эрх зэрэг баталгааг зөрчих, дур зоргоор шийдвэр гаргах нь улам ихсэж байна.⁸ Тиймээс, үндсэн хуулийн гомдол ихэнхдээ хуулиас илүүтэйгээр хуулийг хэрэглэж гарсан шүүхийн шийдвэрийн эсрэг чиглэдэг. Энэ тохиолдолд хувь хүн ердийн шүүхээр үндсэн эрхээ хамгаалуулах бүх арга замыг ашиглаж дууссаны дараа (зарим онцгой тохиолдолд дуусгахыг шаарддаггүй) уг эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзэж байгаа бол үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрхтэй байдаг.

Шүүх хуулийн заалтад үндсэн эрхийг зөрчсөн тайлбар хийж хэрэглэсэн бол үндсэн хуулийн шүүх тухайн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгодог. Жишээлбэл, төрийн албан хаагчийн сахилгын зөрчлийг шалгаж буй шалгагчид тухайн албан хаагчийн гэрлэлт цуцлахтай холбоотой материалыг өгөхийг зөвшөөрсөн давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь тухайн албан хаагчийн “хүний нэр төр”⁹ халдашгүй байх эрх болон хувь хүнийхээ хувьд чөлөөтэй хөгжих эрхийг зөрчсөн гэж ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэсэн.¹⁰ Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, уг хэргийг тухайн шүүх рүү дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Эндээс үндсэн хуулийн шүүх хэргийн агуулгыг шийдвэрлэдэггүй гэдгийг анхаарах хэрэгтэй:

Энэ ажиллагааны явцад Үндсэн хуулийн шүүх нь шүүхийн шийдвэр зэрэг гомдолд дурдагдсан акт гомдол гаргагчийн үндсэн эрхийг зөрчсөн эсэхийг шалгах ёстой... Үндсэн хуулиас доогуурх хууль (ердийн хууль)-ийн заалтыг тайлбарлах, тухайн хэрэгт уг заалтыг хэрэглэх, хэргийн фактыг тогтоох, үнэлэх асуудлыг харьяалах шүүх нь хариуцдаг; шүүх процессын явцад үндсэн хуулийн эрх зүйг зөрчсөн эсэхийг тодорхойлох зорилгоор л Холбооны Үндсэн хуулийн шүүх эдгээр асуудлыг хянаж болно. Шүүхийн

⁷ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Study on Individual Access to Constitutional Justice*, 23.

⁸ Dannemann, “Constitutional Complaints: The European Perspective,” 152.

⁹ Human dignity гэх энэ ойлголтыг Монгол хэл рүү албан ёсоор “хүний нэр төр” гэж орчуулдаг, заримдаа “хүний эрхэм чанар,” “хүний үнэлэмж,” “хүний эрхэмсэг оршихуй,” “хүн цэнэ,” “хүний сүр сүлд” гэх зэргээр орчуулах саналуудыг дэвшүүлсэн байдаг.

¹⁰ Donald P. Kommers, *The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany*, 2nd ed. (Duke University Press, 1997), 27–29.

шийдвэрт ердийн хуулийг буруу хэрэглэсэн эсэх бол [Үндсэн хуулийн шүүхэд] хамааралгүй; харин алдаа нь үндсэн эрхийн зөрчлийг агуулсан байх ёстой.¹¹

Эндээс үзэхэд, үндсэн хуулийн шүүх зөвхөн үндсэн хуулийн асуудал руу харж, ердийн хуулийн тайлбарыг ердийн шүүхэд үлдээх хэрэгтэй. Мөн, ердийн шүүхийн хэрэглэсэн хууль нь үндсэн эрхийг зөрчсөн бол үндсэн хуулийн шүүх гомдлын дагуу тухайн хуулийг хүчингүй болгох боломжтой. Германы Холбооны Үндсэн хуулийн шүүх захиргааны акт болон шүүхийн шийдвэрийн эсрэг гаргасан хувь хүний гомдлыг шийдвэрлэхдээ олон хуулийг хүчингүй болгосон.¹²

Тодорхой тохиолдолд зөрчигдсөн үндсэн эрхээ ердийн шүүхийн журмаар хамгаалж чадаагүй иргэн Үндсэн хуулийн цэцэд үндсэн хуулийн гомдол гаргах эрхтэй болох хэрэгтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн 64.1-т байгаа “иргэний өргөдөл”-ийг үндсэн хуулийн гомдлын агуулгаар тайлбарлаж¹³ ердийн хуульд тусгах эсхүл энэ тухай Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тодорхой заах замаар үндсэн хуулийн гомдлыг хэрэгжүүлэх боломжтой. Үндсэн эрхийн гомдол – үндсэн эрхийн өргөдлийг Цэц хүлээн авдаг болох нь наанадаж гурван ач холбогдолтой юм.

Нэгд, үндсэн эрхийн гомдол нь үндсэн эрхийн хамгаалалтыг сайжруулна. Учир нь, “иргэдийн амьдралын талаар шийдвэр гаргаж байгаа хүмүүс албан ёсны эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ үндсэн хуулийн зарчмыг гарцаагүй мөрддөг” болоход энэ журам чухал үүрэгтэй.¹⁴ Үндсэн хуулийн гомдол нь үндсэн эрхийн тодорхой зөрчлийг зогсооход чиглэдэг. Абстракт байдлаар үндсэн хууль зөрчсөн гэж харагдаж буй хуульд гэхээсээ илүүтэй хуулийг үндсэн хууль зөрчиж тайлбарласан хэрэглээнд үндсэн эрхийн зөрчлийн олонх гардаг. Жишээлбэл, ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрлэсэн хэргүүдийн дийлэнх нь үндсэн хуулийн гомдлоор үүсдэг бөгөөд эдгээрийн ихэнх нь ердийн шүүх эсхүл захиргааны байгууллагын шийдвэрээр зөрчигдсөн үндсэн эрхийн зөрчилтэй холбоотой байдаг. 1993 онд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн маргааны ихэнхийг нь үндсэн хуулийн гомдол эзэлж,

¹¹ Wuhrmann, “Introduction,” 17.

¹² Jorn Ipsen, “Constitutional Review of Laws,” in *Main Principles of the German Basic Law: The Contributions of the Federal Republic of Germany*, ed. Christian Starck, 1. Aufl (Nomos Verlagsgesellschaft, 1983), 128.

¹³ О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж,” *Монгол Улсын Хууль зүйн шинжлэх ухаан: өнөө ба ирээдүй*, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (УБ: Соёмбо 2015), 64-81; Х.Тэмүүжин, *Jus Frast буюу Ёсм үз* (УБ, 2003), 231;

¹⁴ Jorn Ipsen, “Constitutional Review of Laws,” in *Main Principles of the German Basic Law: The Contributions of the Federal Republic of Germany*, ed. Christian Starck, 1. Aufl (Nomos Verlagsgesellschaft, 1983), 128.

түүний 75 хувь нь ердийн шүүхийн шийдвэр үндсэн эрх зөрчсөн тухай байсан.¹⁵ Үндсэн эрхийн тодорхой зөрчлийг иргэний мэдээлэл (*actio popularis*), абстракт хяналт, тодорхой хяналтын журмаар бүрэн хянан шийдвэрлэх боломж үгүй.

Хоёрт, үндсэн эрхийн гомдол – үндсэн эрхийн өргөдлийг Цэц хүлээн авч хянан шийдвэрлэдэг болбол Цэцийн шийдвэрийн үндэслэгээ сайжирна. Цэц олонх шийдвэртээ үндэслэлээ бичдэггүй, тайлбарладаггүй. Жишээлбэл, профессор Б.Чимид Цэцийн шийдвэрийн ерөнхий төрхийг ийнхүү дүгнэж хэлж байжээ: “Тэнд амар сууж байна. Зөрчөөгүй байна, зөрчсөн байна гээд хоёр үг биччихдэг. Тэгээд л дуусаа. Түүний шалтгаан үндэслэл гэж байдаггүй. Онолын шүүх гэж байх ёстой гэж түрүүн ярьж байсан. Гэтэл онолын үндэслэл гэж байдаггүй. Тэгэхээр бид ҮХЦ-д найдах уу, үгүй юү гэдэг асуудал үүснэ. Ийм хуультай, ийм бүрэлдэхүүнтэй байхад Цэцэд найдна гэдэг тун таамаг болчихоод байгаа юм.”¹⁶ Гэхдээ, Цэц Үндсэн хуулийн шүүх чиглэлд хөгжье гэвэл үндэслэлээ дэлгэрэнгүй бичдэг болох нь чухал.¹⁷

Үндсэн хуулийн шүүх *actio popularis*-аас үүссэн абстракт маргаанаас илүү тодорхой факттай холбоотой маргааныг түлхүү шийдвэрлэх шаардлагатай.¹⁸ “Тодорхой тохиолдолд зөрчилдсөн ашиг сонирхлууд нь шүүхийн шийдвэрт хөндөгдөх асуудлуудыг хурцалж, тодорхой, ойлгомжтой үндэслэл гаргах боломжийг нэмэгдүүлдэг.”¹⁹ Үндсэн хуулийн гомдол бол тодорхой асуудалтай нягт холбогддог. Энд хувь хүн Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагааны хохирогч болсон гэж өөрийгөө үзэж, тухайн маргаанд хөндөгдсөн хүчтэй ашиг сонирхолтой байдаг учраас өөрийн байр суурийг дэмжсэн тодорхой жишээ, чухал санаа, хүчтэй үндэслэл гаргах замаар ялахын төлөө тууштай тэмцдэг. Тодорхой маргаан дахь хүчтэй ашиг сонирхол нь Дэвид Хюмийн сэтгэл зүйн зарчмуудын нэгээр тайлбарлагдах боломжтой. Энэ бол илүү тодорхой, нарийвчилсан санаа нь хүний төсөөлөлд илүү ихээр нөлөөлдөг гэсэн зарчим:

Илүү тодорхой, нарийвчилсан санааг ойлгож хүлээн

¹⁵ Kommers, *The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany*, 27.

¹⁶ Б.Чимид, “Төрийн хуулиас иргэний хууль руу” лекцийн тэмдэглэл” (Нээлттэй нийгэм форум, 2007.01.11),

http://www.forum.mn/pdf/public_meeting/TuriinKhuuliasIrgeniiKhuuliRuu20070111.pdf;
О.Машбат, “Манайх ядуу хэвээрэй байх болно,” *My Political Articles* (blog), May 2, 2007, <http://mashbatpoliticalarticles.blogspot.com/>.

¹⁷ Munkhsaikhan O., *Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation*, 110–113, 197–212.

¹⁸ Herman Schwartz, *The Struggle for Constitutional Justice in Post-Communist Europe*, 1st ed. (University of Chicago Press, 2002), 107.

¹⁹ Jesse H. Choper et al., *Constitutional Law: Cases - Comments - Questions*, 10th ed. (West Group, 2006), 1554.

авснаас үүсэх таашаал нь таашаал эсхүл давуу байдлын тухай ерөнхий санаанаас олж авсан таашаалаас илүүтэй бидэнд нөлөөлдөг гэж Хюм үзсэн. Үнэндээ, бидний санаа хэр их ерөнхий, түгээмэл байна, төдий чинээгээр бидний төсөөлөл, таашаалд нөлөөлөх нь багасдаг.²⁰

Үндсэн эрх зөрчигдсөн тухай тодорхой жишээ нь хууль, шүүхийн шийдвэр эсхүл бусад акт хүмүүсийн амьдралд хэр их нөлөөлдөг вэ гэдгийг харуулдаг. Тиймээс, шүүгчид маргаантай холбоотой бүх факт, зарчмын талаар нарийвчилсан мэдлэгтэйгээр тухайн маргааныг шийдвэрлэх боломжтой болж, энэ хэрээр үндсэн хуулийн үндэслэгээ сайжирдаг. *Actio popularis*-аар маргаанд хувийн сонирхолтой байхыг шаарддаггүй учраас тухайн маргаан нь тодорхой асуудалтай тэр болгон холбогддоггүй. Тиймээс, Үндсэн хуулийн шүүх тухайн асуудлыг нухацтай, тодорхой хэлэлцэж шийдвэрлэхгүй байж магадгүй.

Гуравт, үндсэн хуулийн гомдол (мөн, үндсэн хуулийн асуулт) Үндсэн хуулийн шүүхийг улс төрийн шинжтэй гэхээсээ илүү шүүхийн шинжтэй институт болгон хөгжүүлнэ. Унгарт хэрэглэж байсан “иргэний мэдээлэл”-ээс татгалзаж, үндсэн эрхийн гомдлыг хянан шийдвэрлэдэг болох үндэслэлийг профессор Халмай дараах байдлаар тайлбарлаж байв: “Хэрэв Унгарын Үндсэн хуулийн шүүх парламентын дээд танхим шиг ажилладгаа больж илүү ердийн шүүх шиг ажиллахаар шинэчлэн байгуулагдвал л энэ шүүх өөрийн эрх мэдлийг хэт идэвхтэй ашигладаг гэсэн улс төрийн сөрөг үнэлэмжээсээ ангижирч чадна.”²¹ Монголд Цэц ч гэсэн ингэж Үндсэн хуулийн шүүх тал руу шинэчлэгдвэл ердийн шүүхийн шийдвэрээр үндсэн эрх тодорхой тохиолдолд зөрчигдсөн эсэхэд төвлөрнө. Улмаар, Цэц үндсэн хуулийг үр нөлөөтэй хамгаалахын зэрэгцээ улс төрийн институт (УИХ)-тэй зайлшгүй шаардлагагүйгээр зөрчилддөг нь багасаж, ардчиллыг хэрэгжүүлэгч гэдгээр нь эдгээр институтэд илүү хүндэтгэлтэй ханддаг болно.

Үндсэн хуулийн гомдол нь бүрэн болон норматив гэсэн хоёр төрөлтэй. Бүрэн гомдол (full complaint) нь нэг бүрчилсэн акт (individual act) болон түүний суурилсан норматив акт Үндсэн хуульд нийцсэн эсэхийг, харин норматив гомдол (normative complaint) нь зөвхөн норматив акт (хэм хэмжээ тогтоосон акт) үндсэн хуульд нийцсэн эсэхийг тус тус авч үздэг.²² Нэг бүрчилсэн акт гэдэгт шүүхийн шийдвэр, захиргааны актыг багтаан ойлгодог. Үндсэн хуулийн зөрчил нь тухайн

²⁰ John Rawls, *Lectures on the History of Moral Philosophy*, ed. Barbara Herman (Harvard University Press, 2000), 39.

²¹ Halmai, “The Hungarian Approach to Constitutional Review:,” 209.

²² European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §32.

хэм хэмжээ (норм)-д бус, харин тухайн хэм хэмжээний хэрэглээнд буй тохиолдолд норматив гомдол нь зөрчигдсэн эрхийг үр нөлөөтэй сэргээж чаддаггүй. Хүний эрхийн ихэнх зөрчил нь үндсэн хуульд нийцээгүй норматив актаас илүүтэйгээр үндсэн хуульд нийцээгүй нэг бүрчилсэн актын үр дагавар болж гардаг тул тэдгээр зөрчил нь норматив гомдлын хүрээнд шийдвэрлэгдэх боломжгүй.²³

Бүрэн гомдол нь хувь хүний эрхийг цогцоор нь хамгаалах боломжийг олгодог учраас түүнийг дэмжих хэрэгтэй гэж Венецийн комисс дүгнэсэн. Үндсэн хуулийн бүрэн гомдол нь Албани, Андорра, Австри, Бельги, Босни ба Херцеговин, Хорват, Кипр, Чех, Герман, Лихтенштайн, Малт, Монтенегро, Перу, Өмнөд Солонгос, Серби, Словени, Өмнөд Африк, Испани, Швейцар, Словак зэрэг улсад хэрэгждэг байжээ.²⁴

Үндсэн хуулийн гомдлыг зөвшөөрөхийн зэрэгцээ Цэцийн ачааллыг тохируулах боломж

Үндсэн хуулийн бүрэн гомдлыг Үндсэн хуулийн цэцэд өгвөл түүний ачаалал хэт нэмэгдэх вий гэсэн болгоомжлол гардаг. Бүрэн гомдлыг үндсэн хуулийн шүүхэд өгөхийг зөвшөөрдөг улсын хувьд уг гомдлыг хүлээн авахтай холбоотой олон төрлийн шүүлтүүр (филтер) тавьж үндсэн хуулийн шүүхийн ачааллыг хэвийн хэмжээнд барьдаг. Эдгээр шүүлтүүрээс наймыг нь Венецийн комиссын тайланд тулгуурлан товч танилцуулъя:

1. Гомдол өгөхөд хугацааны хязгаарлалт тавих. “Хугацааны хязгаарлалт нь тодорхой хугацааны дараа актын хүчин төгөлдөр байдал нь маргашгүй болно гэдгийг баталгаажуулдаг тул хууль зүйн тодорхой байдлыг хангахад үйлчилдэг.”²⁵ Ихэнх улсад сүүлийн шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш хоёр сарын дотор гомдол гаргахыг зөвшөөрдөг гэж Венецийн комисс бичжээ.
2. Хуульчаар төлөөлүүлэх үүрэг хүлээлгэх. Андорра, Австри, Чил, Чех, Итали, Өмнөд Солонгос, Люксембург, Монако, Польш, Португал, Сан Марино, Словак, Испанид хуульчаар заавал төлөөлүүлэх үүрэгтэй; ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүх аман хуралдаан явуулбал хуульчаар төлөөлүүлэхийг заавал шаарддаг; харин Албани, Армен, Хорват, Гүрж, Унгар, Латви, Лихтенштайн, Литва, Румын, Орос, Словени, Өмнөд Африк,

²³ Мөн тэнд, §36.

²⁴ Мөн тэнд, §34.

²⁵ Мөн тэнд, §75.

- Швейцар, Украинд хуульчаар төлөөлүүлэхийг үүрэг болгодоггүй.²⁶ Хуульчаар төлөөлүүлэхийг заавал шаардсан тохиолдолд төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаагаар хангах хэрэгтэй гэж Венецийн комисс зөвлөжээ.
3. Тэмдэгтийн хураамж авах. Үндсэн хуулийн шүүхэд хандахад тэмдэгтийн хураамж авах нь онцгой тохиолдол ажээ. Тэмдэгтийн хураамж оногдуулах тохиолдолд харьцангуй бага хэмжээтэй байвал зохих бөгөөд төлбөрийн чадваргүй хүнийг уг хураамжаас чөлөөлөх боломжийг үндсэн хуулийн шүүхэд олгох хэрэгтэй.²⁷
 4. Гомдлыг заавал бичгээр авах. Үндсэн хуулийн шүүхэд өргөдлийг бичгээр гаргасан байх ёстой ч үндэслэл бүхий хугацааны дотор гомдлын алдааг засах эсхүл гүйцээж бүрдүүлэх боломжийг олгох хэрэгтэй.²⁸
 5. Илт үндэслэлгүй, урвуулан ашигласан, эсхүл давтагдсан гомдлоос татгалзах. Ийм гомдлоос татгалзах арга хэрэгслийг үндсэн хуулийн шүүхэд олгохыг Венецийн комисс зөвлөсөн.²⁹
 6. Зөрчигдсөн эрхийг сэргээх бусад арга зам (other legal remedies)-ыг ашиглаж дуусгасан байх. Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх нь субсидар байх зарчмаар хязгаарлагддаг: Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжтой шүүхийн бүх арга замыг дуусгасны дараа үндсэн хуулийн гомдлыг өгөх боломжтой.³⁰ Өөрөөр хэлбэл, бүх шатны ердийн шүүх шийдвэрээ гаргасан эсхүл ердийн шүүхэд хандах боломжгүй тохиолдолд үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн гомдлыг хүлээн авч тухайн актыг үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэдэг.³¹ Хэдийгээр зөрчигдөн эрхийг сэргээх бусад арга замыг дуусгахыг ерөнхийд нь шаарддаг боловч хувь хүнд нөхөж болшгүй хохирол учруулах тохиолдолд хуулийн бусад хамгааллыг дуусгасан байхыг шаардахаас татгалзах зохицуулалтыг хуульчлахыг Венецийн комисс зөвлөсөн (Австри, Азербайжан, Хорват, Чех, Герман, Латви,

²⁶ Мөн тэнд, §79.

²⁷ Мөн тэнд, §81.

²⁸ Мөн тэнд, §83.

²⁹ Мөн тэнд, §84.

³⁰ Ignacio Borraro Iniesta, "Limits Of Fact, Law And Remedies: Myths And Realities Of Constitutional Review Of Judicial Decisions Constitutional Court Of Spain Experience," in *The Limits Of Constitutional Review Of The Ordinary Court's Decisions In Constitutional Complaint Proceedings*, Brno, Czech Republic, 14-15 November 2005, CDL-JU(2005)068, 3.

³¹ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §86.

Монтенегро, Словак, Словени, Швейцар зэрэг улсад ийм зохицуулалт байдаг гэжээ).

7. Шууд, ойрын хохирол учруулсан байх. Ихэнх улсад үндсэн эрхийн зөрчлийн улмаас давуу бус байдал үүссэн хүн нь өөрөө уул асуудлаараа үндсэн хуулийн гомдол гаргах эрхийг эдэлдэг.³² Үндсэн эрхийн зөрчлийн улмаас шууд, ойрын хохирол учраагүй хүн үндсэн хуулийн гомдол гаргах эрхгүй гэсэн үг.
8. Сэргээх боломжгүй биш байх. Үндсэн хуулийн хяналт нь гомдол гаргагчийн нөхцөл байдлыг агуулгаар нь өөрчлөхөөргүй бол үндсэн хуулийн шүүх нь түүний гомдлоос татгалзаж болдог (Франц, Герман, Өмнөд Африк).³³

Дээрх процедурын шүүлтүүрээс гадна дараах хоёр аргыг ашиглаж үндсэн хуулийн шүүхийн ачааллыг бууруулдаг:

1. Маргааныг сонгох асуудлыг үзэмжээрээ шийдвэрлэх. Нэг талаар, АНУ-ын Дээд шүүх тухайн хэргийг хянан үзэх эсэхийг бүрэн үзэмжээрээ шийдвэрлэдэг. Нөгөө талаар, Герман, Унгар, Словени, Испани зэрэг улсад үндсэн хуулийн хувьд чухал ач холбогдол бүхий асуудал байхгүй бол тухайн гомдлоос татгалзах боломжийг үндсэн хуулийн шүүхэд өгч, үзэмжээрээ шийдвэрлэх орон зайг тодорхой хэмжээнд олгодог.³⁴ Зөвхөн үндсэн хуулийн хувьд чухал ач холбогдолтой гомдлоор маргаан үүсгэж агуулгыг нь шийдвэрлэх, харин ийм ач холбогдолгүй гомдлоор маргаан үүсгэхээс үндэслэлээ хэлэхгүйгээр татгалзах шинэчлэлийг 1925 онд АНУ-д, 1990-ээд онд ХБНГУ-д хийснийг Испанид хэрэгжүүлж буй талаар бичжээ.³⁵ Үүний цаад санаа нь үндсэн хуулийн шүүх цөөхөн, хамгийн чухал хэргийн талаар бүтэн хэмжээний шийдвэр гаргах, харин хэт ачаалал үүсгэх болон удаан хугацаагаар хойшлуулахаас сэргийлэхийн тулд үндсэн хуулийн бусад гомдлоос шуурхай, үр нөлөөтэй татгалзах боломжийг уг шүүхэд өгөх явдал юм.
2. Хувь хүмүүс үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой улсын хувьд үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг жижиг бүрэлдэхүүнүүдэд хуваарилан, маргаан үүсгэх эсэх эсхүл бусад

³² Мөн тэнд, §89.

³³ Мөн тэнд, §92.

³⁴ Мөн тэнд, §99, 100.

³⁵ Ignacio Borrado Iniesta, "Limits Of Fact, Law And Remedies: Myths And Realities Of Constitutional Review Of Judicial Decisions Constitutional Court Of Spain Experience," in *The Limits Of Constitutional Review Of The Ordinary Court's Decisions In Constitutional Complaint Proceedings*, Brno, Czech Republic, 14-15 November 2005, CDL-JU(2005)068, 17.

асуудлыг шийдвэрлүүлдэг (үндсэн хуулийн онцгой чухал асуудал дээр нийт шүүгчийн хуралдаанаар шийдвэрлэдэг).³⁶ Жишээлбэл, үндсэн хуулийн гомдол нь амжилт олохгүй гэж жижиг бүрэлдэхүүн үзвэл түүнээс татгалзаж шийдвэрлэдэг (Австри, Герман, Словени зэрэг).³⁷ Шийдвэрлэх асуудлаас нь хамааруулан Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг өөр өөр бүрэлдэхүүнд хуваарилан ажиллуулах нь тухайн шүүхийн ачааллыг зохист хэмжээнд барихад тусалдаг.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр нөлөөг хэд хэдэн талаас нь ангилан үзэж болно. Тухайлбал, үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь бүх этгээдэд эсхүл зөвхөн тухайн маргааны талуудад үйлчлэх үр нөлөөтэй байдаг. Норматив актын эсрэг гомдлын дагуу гарсан шийдвэр нь бүх этгээдэд үйлчилдэг бол нэг бүрчилсэн актын эсрэг гомдлын дагуу гарсан шийдвэр нь зөвхөн маргааны талуудад үйлчилдэг.³⁸

Үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүхийн эрх хэмжээ нь ялгаатай бөгөөд тэдгээрийн зааг ялгаа нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, түүний үр дагавраас харагдана. Үндсэн хуулийн шүүх нь нэг бүрчилсэн актыг ихэнхдээ хүчингүй болгодог бөгөөд энэ тохиолдолд хэргийг дахин хэлэлцүүлэхээр ердийн шүүхэд буцаах эсхүл дахин хэлэлцүүлэхээр ердийн шүүхэд хандахыг нээлттэй орхих эсэхээ давхар шийддэг.³⁹ Андорра, Босни ба Херцеговин, Хорват, Чех, Герман, Унгар, Лихтенштайн, Португал, Орос, Словак, Словени, Швейцар зэрэг улсад үндсэн хуулийн шүүх нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болговол хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаадаг талаар Венецийн комисс бичжээ. Жишээлбэл, Испанид “Үндсэн хуулийн шүүх нь Дээд шүүх эсхүл давж заалдах шатны шүүхээс ялгаатай нь шүүхийн шийдвэрийг өөрчилдөггүй, харин зүгээр л хүчингүй болгодог... Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно гэдэг нь ердийн шүүх тэдгээр хэргийг дахин хэлэлцэх, гэхдээ холбогдох үндсэн эрхийг хүндэтгэж шийдвэрлэх ёстой.”⁴⁰

Чех, Герман, Мальт, Словак, Словени, Испани, Украин зэрэг улсад үндсэн хуулийн шүүх нь өөрийн шийдвэрийг зөв хэрэгжүүлж, үндсэн хуульд нийцүүлэх үүднээс юу хийхийг ердийн шүүх эсхүл холбогдох

³⁶ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §102-107.

³⁷ Мөн тэнд, §103.

³⁸ Мөн тэнд, §154.

³⁹ Мөн тэнд, §161.

⁴⁰ Ignacio Borraro Iniesta, “Limits Of Fact, Law And Remedies: Myths And Realities Of Constitutional Review Of Judicial Decisions Constitutional Court Of Spain Experience,” in *The Limits Of Constitutional Review Of The Ordinary Court’s Decisions In Constitutional Complaint Proceedings*, Brno, Czech Republic, 14-15 November 2005, CDL-JU(2005)068, 13.

байгууллагад даалгадаг; харин, бусад олон улсын үндсэн хуулийн шүүхэд ийм позитив үйлдэл хийхийг даалгах бүрэн эрх байдаггүйн улмаас түүний шийдвэр үр нөлөөгүй болох магадлалтай гэжээ.⁴¹ Иймд, үндсэн хуулийн шүүх хэргийг дахин хэлэлцүүлэхээр ердийн шүүхэд буцаавал тухайн ердийн шүүх үүний дагуу шийдвэрлэхийг үүрэгжүүлсэн заалтыг хуульчлах хэрэгтэй гэж Венецийн комисс зөвлөжээ.

Үндсэн хуулийн шүүх нь ерөнхийдөө хохирол нөхөн төлүүлэх чадамжгүй байдаг. Үүний оронд түүний шийдвэр нь ихэнхдээ тухайн хэргийг ердийн шүүхээр дахин хэлэлцэхэд хүргэдэг бөгөөд ердийн шүүх нь холбогдох хуулийн дагуу хохирлыг нөхөн төлөх эсэхийг шийдвэрлэдэг.⁴² Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн дагуу үндсэн эрхийн зөрчилд нөхөн төлбөр олгох, сэргээхэд зайлшгүй бүх арга хэмжээг ердийн шүүх авдаг.⁴³

Үндсэн хуулийн шүүх нь ердийн шүүхийн дөрөв дэх шат биш, эсхүл дээд шүүхийн дээр байдаг шүүх биш учраас ердийн шүүхээс хуулийг өдөр тутам хэрэглэж буй асуудал буюу тэдгээрийн шүүн таслах ажил руу хөндлөнгөөс оролцож болохгүй, харин өөртөө хэт ачаалал үүсгэхгүйгээр зөвхөн үндсэн хуулийн хамгийн чухал, цөөн асуудлыг л хянан шийдвэрлэдэг байх нь олон улсын сайн туршлага юм. Үндсэн хуулийн шүүхийн хяналтын хүрээ нь зөвхөн үндсэн хуулийн асуудлаар л хязгаарлагдах ёстой.⁴⁴ Үүнтэй холбогдуулан дараах хоёр зүйлийг анхаарах нь зүйтэй:

1. Үндсэн хуулийн шүүх зөвхөн үндсэн хуулийн асуудлыг, харин ердийн шүүх ердийн хуулийн асуудлыг шийдвэрлэх нарийн зааг ялгааг нь гаргаж хуульчлах хэрэгтэй. Тухайлбал, “хувь хүний гомдлоор хөндсөн асуудал нь “ердийн хуулийн асуулт” байх тул тус шүүхийн харьяаллын бус гэж Испанийн Үндсэн хуулийн шүүх олон зуун шийдвэртээ дүгнэсэн: ердийн хууль тогтоомжийг тайлбарлаж хэрэглэх нь Дээд шүүхийн тэргүүлсэн ердийн шүүхэд хамаардаг. Үндсэн хуулийн зөрчил тогтоогдоогүй л бол тухайн

⁴¹ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §163.

⁴² Мөн тэнд, §184.

⁴³ Ignacio Borraro Iniesta, “Limits Of Fact, Law And Remedies: Myths And Realities Of Constitutional Review Of Judicial Decisions Constitutional Court Of Spain Experience,” in *The Limits Of Constitutional Review Of The Ordinary Court’s Decisions In Constitutional Complaint Proceedings*, Brno, Czech Republic, 14-15 November 2005, CDL-JU(2005)068, 13.

⁴⁴ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §184.

- асуудалтай холбогдуулан шийдвэрлэх зүйл үндсэн хуулийн шүүхэд байхгүй.”⁴⁵
2. Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийг тайлбарлахдаа ердийн шүүхийн тогтоосон фактад дийлэнхдээ үндэслэдэг. Жишээлбэл, Испанийн Үндсэн хуулийн шүүх нотлох баримт цуглуулах, үйл баримтыг мөрдөн шалгах өргөн бүрэн эрхтэй боловч үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэхэд эдгээр бүрэн эрхээ ховорхон ашигладаг бөгөөд ихэнхдээ ердийн шүүхийн шийдвэр болон шүүхийн тэмдэглэл (мөн, бусад төрийн байгууллагын шийдвэр, тэмдэглэл)-д тулгуурладаг байна.⁴⁶

Иргэний мэдээлэл (*actio popularis*)-ээс татгалзах нь

Хувь хүн үндсэн хуулийн шүүхэд хандах өөр нэгэн журам бол иргэний мэдээлэл (*actio popularis*) юм. *Actio popularis* нь хууль тогтоомж болон бусад норматив актыг хэвлэн нийтлэгдсэнийх нь дараа үндсэн хуульд нийцсэн эсэхийг абстракт байдлаар хянуулахаар хандах эрхийг аливаа хувь хүнд өгдөг. Норматив актаас болж хохирсон эсэх эсхүл ердийн шүүхийн журмыг дуусгасан эсэхээс үл хамааран аливаа хувь хүн уг норматив актыг үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл үндсэн хуулийн шүүхэд мэдээлэл гаргах эрхтэй.

1989-2011 оны хооронд Унгарын Үндсэн хуулийн шүүх *actio popularis* журмаар үндсэн хуулийн маргааныг шийдвэрлэж байв. Үндсэн хуулийн шүүхэд ийнхүү хандахад хязгаарлалтгүй учраас олон зуун иргэн хуулийн талаар мэдээлэл гаргасан бөгөөд үндсэн хуулийн маргааны дийлэнхийг *actio popularis*-аар үүсгэж байсан.⁴⁷ *Actio popularis* нь үндсэн хуулийн шүүхийн ачааллыг үндэслэлгүйгээр өсгөж, уг шүүхийг улс төржүүлж байсан учраас Унгарт үүнээс татгалзах болсон. *Actio popularis* нь

⁴⁵ Ignacio Borraro Iniesta, “Limits Of Fact, Law And Remedies: Myths And Realities Of Constitutional Review Of Judicial Decisions Constitutional Court Of Spain Experience,” in *The Limits Of Constitutional Review Of The Ordinary Court’s Decisions In Constitutional Complaint Proceedings*, Brno, Czech Republic, 14-15 November 2005, CDL-JU(2005)068, 9.

⁴⁶ Ignacio Borraro Iniesta, “Limits Of Fact, Law And Remedies: Myths And Realities Of Constitutional Review Of Judicial Decisions Constitutional Court Of Spain Experience,” in *The Limits Of Constitutional Review Of The Ordinary Court’s Decisions In Constitutional Complaint Proceedings*, Brno, Czech Republic, 14-15 November 2005, CDL-JU(2005)068, 3.

⁴⁷ Laszlo Solyom and Georg Brunner, *Constitutional Judiciary in a New Democracy: The Hungarian Constitutional Court* (University of Michigan Press, 2000), 81.

Унгараас гадна Хорват, Гүрж, Македон зэрэг цөөн улсад байсан ч үндсэн хуульт ёс төлөвшсөн улсууд үүнээс ерөнхийдөө татгалздаг.⁴⁸

1992-2015 оны хооронд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлаар шийдвэрлэсэн нийт 164 маргааны 140 буюу 85 хувь нь иргэний мэдээллээр үүсжээ. Эндээс харахад, Цэцийн маргааны дийлэнх иргэдийн мэдээллээр үүсдэг. Иргэд өөрсдийнх нь үндсэн эрхтэй холбоогүй хууль эсхүл бусад дурдагдсан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Цэцэд хандахдаа мэдээлэл гаргадаг. Жишээлбэл, хууль зүйн үргэлжилсэн сургалтад сууж тодорхой багц цаг хангахыг шүүгчдэд үүрэгжүүлж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ сургалтад суугаагүй, багц цагийг хангаагүй бол хуульчийн зөвшөөрлийг хүчингүй болгохоор заасан нь Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлаар нэг иргэн 2010 онд Цэцэд мэдээлэл гаргаж байсан.⁴⁹

Монгол Улс дахь иргэний мэдээлэл нь Цэцийн харьяаллын абстракт асуудлаар бараг хязгаарлалтгүйгээр хандах эрхийг илэрхийлдэг учраас *actio popularis*-тай адилхан агуулгатай, давуу болон сул талтай. Монгол Улс социалист тогтолцооноос ардчилал руу шилжих шилжилтийн үед иргэд Цэцэд мэдээлэл гаргах замаар УИХ-ын болон Засгийн газрын олон шийдвэрүүд Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянуулж, Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх зарчмын хэрэгжилтэд хувь нэмэр оруулсан байж магадгүй. Түүнчлэн, Үндсэн хуульд нийцсэн эсэх нь эргэлзээтэй хуулийн талаар Цэцэд мэдээлэл гаргах замаар судлаачид болон хуульчид үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэхэд оролцож ирсэн.

Иргэний мэдээллээр үндсэн хуулийн маргаан үүсгэж байгаа нь дөрвөн асуудал үүсгэдэг учраас үүнээс татгалзах хэрэгтэй. Нэгд, мэдээлэл эсхүл хийсвэр өргөдөл нь тодорхой факттай холбоогүй байдаг учраас үндсэн хуулийн жишгийн эрх зүй хөгжих, үндсэн хуулийн амьд хэлэлцүүлэг өрнөхөд төдийлөн тохиромжтой биш.

Хоёрт, Цэц иргэний мэдээллээс үзэмжээрээ татгалзах боломжгүй учраас урт хугацаанд Цэцийн ачаалал хэтэрхий ихсэх, чухал асуудал дээр төвлөрөх боломжгүй болох аюултай. Иргэний мэдээллийг *actio popularis*-аар ойлгож хэрэгжүүлбэл энэ нь Цэцийг “хэт олон тооны маргаанаар дүүргэж, үндэслэл бүхий хугацааны дотор хүний эрхийн болон бусад тулсан чухал асуудлуудыг шийдвэрлэж чадахгүйд хүргэнэ.”⁵⁰ Хорватад *actio popularis* нь Үндсэн хуулийн шүүхийг хэт

⁴⁸ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Study on Individual Access to Constitutional Justice*, 21.

⁴⁹ Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №08, 2010.11.24.

⁵⁰ Durr, “Comparative Overview of European Systems of Constitutional Justice.”

ачаалалтай болгосон тул Венецийн комисс уул журмыг шүүмжилсэн.⁵¹ Хорватын Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч “нэг хүн 800 мэдээлэл гаргаж, тус шүүхийн ажлыг тасалдуулсан” гэдгээр *actio popularis*-ын аюулыг анхааруулсан.⁵² Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа хийсвэрээр нэмэгдэхэд хүрэхээр байгаг хууль зүйн доктор А.Бямбажаргал судалгаагаараа нотлон харуулжээ. 2015 оны байдлаар Цэц иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу 198 маргааныг хянан шийдвэрлэсэн бөгөөд үүнээс нэр бүхий найман иргэний өргөдөл, мэдээллийн үндсэн дээр эдгээрийн 69 тохиолдолд маргааныг хянан шийдвэрлэсэн.⁵³ Жишээлбэл, энэ хугацаанд иргэн Н.Ариунболд нь Цэцэд 64 удаа дангаараа мэдээлэл ирүүлсэн.⁵⁴

Гуравт, иргэний мэдээллийг улс төрийн зорилгоор урвуулан ашиглаж Цэцийг улс төрийн маргааны төвд татан оруулах, хэт улс төржүүлэх эрсдэлтэй. Учир нь, энэ журам нь тодорхой эрх, ашиг сонирхол хөндөгдсөн байхыг шаарддаггүй учраас улс төрийн болон бусад тоглогчид үүнийг урвуулан ашиглах боломжтой. *Actio popularis*-ыг урвуулан ашиглах боломжтой учраас энэ нь үндсэн хуулийн хяналтыг ажиллуулах практик хэрэгсэл болж чадахгүй гэж Келзен дүгнэсэн байдаг.⁵⁵ Жишээлбэл, 2015 оны Сонгуулийн тухай хуулийн 7.1.1-д “хувь тэнцүүлсэн /пропорциональ/,” 120.3-т “Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно” гэж заасны “28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар” гэж заасан нь шууд сонгох зарчим болон Үндсэн хуулийн бусад заалтыг зөрчсөн гэж Цэцээс дүгнэсэн нь Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс үндэслэлтэйгээр дэмжигдэх боломжгүй ноцтой алдаа⁵⁶ учраас уг маргааныг шийдэхэд улс төрийн зүй бус нөлөө орсон гэж мэргэжлийн хүрээнд дийлэнхдээ харддаг нь үндэслэлтэй.⁵⁷

⁵¹ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §41.

⁵² Durr, “Comparative Overview of European Systems of Constitutional Justice.”

⁵³ А.Бямбажаргал, *A Study on the Problems and Improvement of Constitutional Review in Mongolia (Dissertation)*, (Seoul: Kookmin University, 2015), 118.

⁵⁴ Мөн тэнд. *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тамгын газраас эрхлэн гаргасан хэргийн хөдөлгөөний судалгаа* (2015, УБ).

⁵⁵ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Study on Individual Access to Constitutional Justice*, 21.

⁵⁶ О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн холимог тогтолцоог хориглоогүй,” *Эрх зүй* №2 (34) (МУИС-Хууль зүйн сургууль 2016), 1-30.

⁵⁷ Үндсэн хуулийн цэц 2022.06.27-ны өдрийн 01 дугаар тогтоолоороо энэхүү ноцтой алдаагаа засаж, Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоол, Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийг тус тус хүчингүй болгосон. Энэ тогтоолд дараах байр суурийг илэрхийлсэн нь сонгуулийн

Дөрөвт, иргэний мэдээлэл нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах үр нөлөөтэй механизм болж чадахгүй байна. Нэг талаар, Үндсэн хуулийн 66.2-т заасан хүрээнд хамаарахгүй норматив актаар үндсэн эрх нь зөрчигдсэн тохиолдолд Цэцэд хандах боломж иргэнд байхгүй.

Хэдийгээр иргэдийн хувьд Үндсэн хуулийн цэцэд ямар нэг шат дамжилга шаардлагагүйгээр шууд хандах эрхтэй боловч Цэцэд хандах асуудал нь гагцхүү түүний хяналтын объектод хамаарагдах асуудлаар л хандах боломжтой. Үндсэн хуулийн 66.2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 нь хэдийгээр иргэний үндсэн эрхийг төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар зөрчсөн хэдий ч гагцхүү Үндсэн хуульд заагаагүй гэх үндэслэлээр л уг эрхээ үндсэн хуулийн түвшинд хамгаалуулах боломжийг хязгаарлах нөхцөл байдлыг бий болгож байна.⁵⁸

Нөгөө талаар, үндсэн эрхийн зөрчил дийлэнхдээ хэм хэмжээнд бус, харин хэм хэмжээний хэрэглээ, ялангуяа ердийн шүүхийн хууль хэрэглээнд гардаг ч иргэний мэдээллээр ийм зөрчлийг Цэц хянан шийдвэрлэх боломжгүй юм.

УИХ дахь цөөнхөөс гаргах хүсэлт (хийсвэр хяналт)

Үндсэн хуулийн шүүх абстракт хяналт, үндсэн хуулийн асуулт, үндсэн хуулийн гомдол гэсэн гурван төрлийн журмаар маргаан шийдвэрлэдэг талаар өмнө танилцуулсан. Судалгааны энэ хэсэгт хууль тогтоомж үндсэн хуульд нийцсэн эсэхийг шийдвэрлэдэг абстракт хяналтыг товч хэлэлцэнэ. Энэ хяналтаар үндсэн хуулийн шүүх “хууль тогтоомж парламентаар батлагдсан боловч хүчинтэй болохоос өмнө (Франц) эсхүл батлагдаж нийтлэгдсэн боловч хэрэглэгдэхээс өмнө (Герман, Итали, Испани) түүнийг үндсэн хуульд нийцсэн эсэхийг

пропорциональ элемент бүхий тогтолцоог сонгох боломжийг нээгээд зогсохгүй тэгш сонгох эрхийг хамгаалсан түүхэн ач холбогдолтой болжээ: “Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. ...” гэж зааснаар Үндсэн хуулийн үзэл баримтлал, иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах сонгуулийн зарчмын хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, түүний хувилбарыг сонгон тодорхойлох, сонгуулийг зохион байгуулах журмыг хуульчлах бүрэн эрхийг хууль тогтоогчид олгосон байна.” Үндсэн хуулийн цэц, Тогтоол №01, 2022.06.27.

⁵⁸ А.Бямбажаргал, “Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам,” *Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм* дотор (УБ, 2019), 408-409.

шийдвэрлэдэг.”⁵⁹ Тусгайлан эрх олгосон этгээдийн хэн нь ч энэ журмыг санаачлах боломжтой хэдий ч ихэнхдээ парламент дахь сөрөг хүчний гишүүд хууль тогтоомж үндсэн хуульд нийцсэн эсэхийг энэ журмаар хянуулдаг. Тиймээс, абстракт хяналт нь парламент дахь олонхоос эрх мэдлээ урвуулан ашиглаж цөөнхийг хохироохоос сэргийлж, үндсэн хуульд бүрнээ нийцэх зарчмыг хангах механизм болж ажилладаг. Үндсэн хуулийн шүүх абстракт хяналтын хүрээнд ердийн шүүхтэй холбогддоггүй боловч нөгөө хоёр журам (үндсэн хуулийн асуулт, үндсэн хуулийн гомдол)-аар тодорхой хэрэг дэх үндсэн хуулийн асуудлыг шийдвэрлэдэг.

Монгол Улсын хувьд хийсвэр хяналт нь сонгодог утгаараа хэрэгждэггүй. Иргэн Үндсэн хуулийн 66.2-т заасан маргаантай асуудлаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргах боломжтой бөгөөд энэ хүрээнд хууль тогтоомжийн хийсвэр хяналт хэрэгждэг. Харин, Үндсэн хуулийн 66.1-д Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргахаар заасныг УИХ-ын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гэж ойлгож ирсэн учраас УИХ-ын зүгээс Цэцэд хандах эсэх нь УИХ дахь олонхын санаачилгаас хамаардаг бөгөөд хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл уг олонх нь Цэцэд хүсэлт гаргахгүйгээр тухайн хууль тогтоомжийг хүчингүй болгох, өөрчлөх өргөн боломжтой. Тийм ч учраас, өнгөрсөн 30 жилийн хугацаанд УИХ-аас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан тохиолдол байхгүй юм. Иргэний мэдээллээр Цэцэд ханддаг явдлаас татгалзсан тохиолдолд УИХ дахь цөөнхийн зүгээс Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах боломжийг заавал нээх хэрэгтэй. Энэ нь парламентын олонход тавих цөөнхийн хяналтыг сайжруулах, Үндсэн хууль зөрчсөн хууль тогтоомжийг хүчингүй болгуулах нөхцөлийг хангана. Цэцэд хүсэлт гаргах эрх эдлэх эрхтэй цөөнх гэдэгт УИХ дахь эрх баригч намын эсхүл сөрөг хүчний аль нь ч хамаарах боломжтой бөгөөд цөөнхөд тооцох босгыг УИХ-ын нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн гэж тооцвол зохилтой. Учир нь, энэ тоо нь мэдээллээр нэг иргэн эсхүл УИХ-ын гишүүн Цэцэд хандах боломжтой байснаас татгалзаж буй тул мэдээллээр үүсдэг байсан маргааныг хэт хумихгүй. Мөн, Цэцэд хэн дуртай нь хандах бус, харин иргэдээс ардчилсан сонгуулиар мандат авсан нийт гишүүний 10 хувь буюу бүлэг байгуулах тооны гишүүн хүсэлт гаргах гэдэг бол тийм амархан босго биш учраас Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаас хамгийн ноцтойгоор нь хандахад

⁵⁹ A. Stone Sweet, “Constitutional Courts and Parliamentary Democracy,” *West European Politics* 25, no. 1 (2002): 87.

хүргэх, цөөнхийн хүсэлтийг урвуулан ашиглахаас сэргийлэх ач холбогдолтой.

Шүүхийн хүсэлт (тодорхой хяналт)

Судалгааны энэ хэсэгт үндсэн хуулийн асуултыг товч хэлэлцэнэ. Энэ журмаар ердийн шүүхийн шүүгчид хууль үндсэн хууль зөрчсөн эсэх дээр “тодорхой хяналт” хэрэгжүүлэхэд шууд бусаар оролцдог онцлогтой. Хэрэв ердийн шүүгч өмнө нь буй хэргийн талаарх шийдвэрт хуулийн тодорхой заалт үндсэн хуульд нийцсэн эсэхийг тогтоолгохоос хамааралтай гэж үзвэл хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоож, энэ тухай үндсэн хуулийн асуултыг үндсэн хуулийн шүүх рүү явуулдаг. Үндсэн хуулийн шүүх энэ асуултыг шийдвэрлэх бөгөөд анх асуулт явуулсан шүүх уг шийдвэрийг хүлээн авч, хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх боломжтой.⁶⁰

Тодорхой хэрэг дээр хэрэглэх хууль үндсэн хуульд нийцсэн эсэх асуудал бол тухайн хэргийг шийдвэрлэхэд амин чухал учраас ердийн шүүгчид өөрсдийн ажилтай холбогдуулан үндсэн хуулийн асуултыг хүргүүлдэг. Үндсэн хуулийн асуулт Герман, Итали, Испани зэрэг Баруун Европын улсуудад түгээмэл.⁶¹ “Тодорхой хуулиас гарч болох үр дагавар өдөр тутмын хууль зүйн практикт л илэрлээ олдог гэсэн факт”-д тулгуурладгаараа үндсэн хуулийн асуултын ач холбогдол оршдог.⁶² Ердийн шүүх нь мэдээлэл сайтай, үндэслэл бүхий хүсэлт гаргах чадвартай байдаг төдийгүй хуулийн заалтыг тодорхой тохиолдолд хэрэглэхтэй холбоотой хяналт хэрэгжүүлэх боломж олгодог давуу талтай.⁶³ Тиймээс, ердийн шүүхээс ангид тусгай шүүхийн тухай Келзений анхны үзэл санаа эдгээр Европын улсуудад өөрчлөгдсөн. Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн гомдол гэсэн гурав дах журмаар маргаан шийдвэрлэж буй тохиолдолд энэ өөрчлөлт улам тод мэдрэгдэнэ.

⁶⁰ John Ferejohn and Pasquale Pasquino, “Constitutional Adjudication: Lessons from Europe,” *Texas Law Review* 82 (2004 2003): 1689.

⁶¹ Эдгээр улсад үндсэн хуулийн шүүх ердийн шүүхийн шийдвэрийг хянах дөрөв дэх шатны шүүх шиг харагдаж, дээд шүүх шиг үйл ажиллагаа явуулах нь гэж заримдаа шүүмжлэгддэг ч үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүх хоорондын эрх хэмжээний ялгаа зааг нь үндсэн хууль болон ердийн хуулийн асуудал гэдгээрээ тодорч хэвшиж байна. Schwartz, *The Struggle for Constitutional Justice in Post-Communist Europe*, 25.

⁶² Jorn Ipsen, “Constitutional Review of Laws,” in *Main Principles of the German Basic Law: The Contributions of the Federal Republic of Germany*, ed. Christian Starck, 1. Aufl (Nomos Verlagsgesellschaft, 1983), 115.

⁶³ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §45.

Үндсэн хуулийн асуултыг үндсэн хуулийн шүүхэд тавих бүрэн эрх ердийн шүүхийн аль ч шүүгчид нээлттэй байх хэрэгтэй. Герман, Итали, Испанид ердийн шүүхийн аль ч шүүгч үндсэн хуулийн шүүхэд асуулт тавьж болдог бол Австри, Францад зөвхөн дээд шүүх болон хоёр дахь шатны шүүхэд ийм бүрэн эрхийг эдлүүлдэг.⁶⁴ Үндсэн хуулийн асуулт тавих бүрэн эрхийг зөвхөн дээд шатны шүүхэд өгдөг журам нь энэ бүрэн эрхийг бүх шүүхэд өгдөг журмаас үр нөлөөгөөр бага. Учир нь, ардчилсан дэглэм рүү шилжсэн эхэн үед дээд шатны шүүх ихэнхдээ хууль үндсэн хуультай харшилсан эсэхийг харах дургүй байдаг учраас эдгээр шүүх доод шатны шүүхийн шүүгч (эсхүл иргэн)-ээс үндсэн хуулийн асуудлыг хөндөж тавихад саад учруулах магадлалтай. Жишээлбэл, Италид “хүчинтэй хууль үндсэн хуульд нийцсэн эсэхэд анх дээд шатны шүүх бараг хэзээ ч эргэлзэж байгаагүй бөгөөд Италийн [Үндсэн хуулийн] шүүхэд асуудал тавих нь тун ховор байжээ.”⁶⁵ Ердийн шүүгч хэрэглэж буй хууль нь үндсэн хууль зөрчсөн гэсэн эргэлзээгээ үндсэн хуулийн шүүхэд шууд хандаж тайлуулахаас татгалзах нь үндсэн хууль болон түүнд нийцсэн хуульд үнэнч байх шүүгчийн тангаргаа хэрэгжүүлэх боломжийг тухайн шүүгчид хаадаг.

Үндсэн хуулийн асуулт зөвхөн дээд шатны шүүхээс эсхүл түүгээр дамжиж явдаг тогтолцоонд дээд шатны шүүх доод шатны шүүхийн үндсэн хуулийн асуултыг үндсэн хуулийн шүүх рүү явуулах эсэхийг шийдвэрлэж байгаа нь хязгаарлагдмал хүрээнд үндсэн хуулийн хяналтыг *дэ факто* хэрэгжүүлж байгаа хэлбэр. Тиймээс, тухайн дээд шатны шүүхийн болон үндсэн хуулийн шүүхээс үндсэн хуулийг янз янзаар тайлбарлах, зөрчилдөөнтэй жишиг үүсгэх боломжтой. Германд анх ямар ч шүүх үндсэн хуулийн асуултыг Үндсэн хуулийн шүүх рүү явуулж болдог байсан ч зөвхөн зохих дээд шүүхээр үүнийгээ дамжуулдаг байсан бөгөөд дээд шүүх доод шатны шүүхийн асуултын талаарх өөрийн саналыг давхар явуулах эрх эдэлдэг байжээ. Энэ улсад

⁶⁴ Францад албан ёсоор нийтлэгдсэн хууль Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах тухай үзэлд нэлээн шүүмжлэлтэй ханддаг байсан. Гэвч, 2008 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр үндсэн хуулийн асуултыг Үндсэн хуулийн зөвлөл рүү явуулах бүрэн эрхийг Францын хоёр дээд шүүхэд өгсөн. The French Constitutional Council, “Priority Preliminary Rulings on the Issue of Constitutionality,” *Conseil Constitutionnel*, accessed April 3, 2011, <http://www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/english/homepage.14.html>; Federico Fabbrini, “Kelsen in Paris: France’s Constitutional Reform and the Introduction of A Posteriori Constitutional Review of Legislation,” *German Law Journal* 9, no. 10 (2008): 1297; A. Stone Sweet, “The Constitutional Council and the Transformation of the Republic,” *Cahiers Du Conseil Constitutionnel* 25, no. Special Issue on the 50th Anniversary of the Council (2008): 65.

⁶⁵ Lorenza Carlassare, “Interlocutory Review – Abstract Review,” in *Science and Technique of Democracy No. 15: The Protection of Fundamental Rights by the Constitutional Court* (Council of Europe Publishing, 1995), 130.

дээд шүүх болон үндсэн хуулийн шүүхийн байр суурь зөрчилдсөн учраас 1956 онд “үндсэн хуулийн асуултыг үндсэн хуулийн шүүх рүү явуулах ажиллагаа дахь дээд шүүхийн оролцоог халсан.”⁶⁶

Монгол Улсын Үндсэн хуулийн 66.1-д Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Улсын дээд шүүхийн хүсэлтээр хянан шийдвэрлэхээр заасан. Нэг талаар, Улсын дээд шүүх нь ийм маргааны талаарх хүсэлтийг Үндсэн хуулийн цэцэд өөрөө шууд гаргах нь харьцангуй цөөн байдаг. 1992-2017 оны хооронд Улсын дээд шүүхээс Цэцэд 3 удаа хандан хүсэлт гаргасан.⁶⁷

Нөгөө талаас, Шүүхийн тухай хууль (2021)-ийн 6.4-т зааснаар “Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл харшилсан гэж үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний талаарх саналаа Улсын дээд шүүхэд гаргана,” уг хуулийн 25.8.6-т зааснаар Улсын дээд шүүх энэ хуулийн 73.2-т⁶⁸ заасан Ерөнхий зөвлөлийн саналын дагуу, эсхүл энэ хуулийн 6.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах бүрэн эрхтэй. Анхан болон завж заалдах шатны шүүх нь энэ саналаа Улсын дээд шүүхэд гаргах боломжтой ч Улсын дээд шүүх уг саналаас татгалзах боломжтой нь Үндсэн хуулийн хяналтын шинжтэй чиг үүрэг хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл, анхан болон давж заалдах шатны шүүх нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл харшилсан гэж үзэж саналаа Улсын дээд шүүхэд гаргадаг ч Улсын дээд шүүх заримдаа уул саналын дагуух хүсэлтийг Үндсэн хуулийн цэцэд хүргүүлдэггүй тухай шүүгчид хэлдэг. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нь Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн хууль, олон улсын гэрээг хэрэглэхээс аргагүй байдалд ордог бөгөөд энэ асуудлыг хүлээн авч хэлэлцэх, аль нэг тал руу нь хагалах боломж Үндсэн хуулийн цэцэд хомс байдаг. Анхан

⁶⁶ Lech Garlicki, “Constitutional Courts Versus Supreme Courts,” *International Journal of Constitutional Law* 5, no. 1 (January 1, 2007): 51.

⁶⁷ Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №04, 2006.4.12; Үндсэн хуулийн цэц, Тогтоол №022006.6.15; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №02, 2011.06.15.

⁶⁸ Шүүхийн тухай хуулийн 73.2-т “Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ.” гэж заасан.

болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн хувьд Үндсэн хуульд нийцсэн эсэх тал дээр эргэлзээтэй тухайн хууль, олон улсын гэрээ нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлээгүй байгаа учир Үндсэн хууль зөрчсөн байдал урт хугацаанд үргэлжлэх боломжтой. Иймээс, бүх шатны шүүх нь үндсэн хуулийн асуултыг үндсэн хуулийн шүүхэд гаргах нь хүний эрхийг шуурхай, үр нөлөөтэй хамгаалахад тустай гэж Венецийн комисс дүгнэсэн.⁶⁹

Хүний эрхийн үндэсний комиссын хүсэлтийг зөвшөөрөх эсэх

Ардчилсан улсад хүний эрхийн үндэсний байгууллагууд байгуулагдан, хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах, тайлагнах, санал, зөвлөмж гаргах төдийгүй эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх болсон. Үндсэн хуулийн шүүх бүхий олон улс (Албани, Армен, Австри, Азарбайжан, Хорват, Чех, Эстони, Унгар, Латви, Молдова, Польш, Португал, Румын, Орос, Серби, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Украин)-ад омбудсмэн болон түүнтэй төстэй байгууллага нь үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргах замаар үндсэн хуулийн хяналтыг эхлүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх хандлага бий болж байна.⁷⁰

Омбудсмэн үндсэн хуулийн шүүхэд хандахыг зөвшөөрөх нь уг байгууллагын хууль зүйн мэргэшсэн байдлын улмаас хүсэлтийн чанар дээшилдэг, мөн шүүгчид хандахаас илүүтэй омбудсмэнд хандах нь хувь хүмүүсийн хувьд илүү хялбар байдаг тул үндсэн эрхийн хамгаалалтын үр нөлөөг дээшлүүлдэг байна.⁷¹ Иймээс, Омбудсмэн эсхүл түүнтэй төстэй байгууллага (жишээлбэл, хүний эрхийн үндэсний комисс) нь өөрийн мөрдөн шалгалтын үр дүнд тулгуурлан хууль болон захиргааны норматив актын төдийгүй нэг бүрчилсэн актын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянуулахаар Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргахыг зөвшөөрөхийг Венецийн комисс зөвлөжээ.⁷²

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь зарим талаар хүний эрхийн омбудсмэний чиг үүргийг хэрэгжүүлдэг тул түүнтэй адилтган үзэж, уг комиссын эсхүл түүний гишүүний зүгээс шалгаж буй хүний эрхийн зөрчлийн асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах бүрэн эрхийг өгч болох юм. Гэвч, Үндсэн хуулийн цэцэд хандах

⁶⁹ European Commission for Democracy through Law (Venice Commission), *Revised Report on Individual Access to Constitutional Justice*, CDL-AD(2021)001, §49.

⁷⁰ Мөн тэнд, §62.

⁷¹ Мөн тэнд, §64.

⁷² Мөн тэнд, §65.

боломжийг Хүний эрхийн үндэсний комисст олгох нь үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг орлож чадахгүй юм. Венецийн комиссын зөвлөмжөөр хүний эрхийг хамгаалах хамгийн үр нөлөөтэй, үндсэн механизм нь үндсэн хуулийн иж бүрэн гомдол, харин Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг омбудсмэн эсхүл түүнтэй төстэй байгууллагад өгөх нь уг үндсэн механизм дээр оруулж буй нэмэлт элемент юм.⁷³

2. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН БИЕ ДААСАН, МЭРГЭШСЭН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хоёр шатат процедураас татгалзах нь

Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх харилцаа нь өргөн хүрээтэй бөгөөд түүнийг Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар нарийвчлан зохицуулсан. Энэ хэсэгт Үндсэн хуулийн цэцийн процедурын бүх асуудлыг бус, харин түүний процедурын цөм зохицуулалтыг авч үзэх болно. Өөрөөр хэлбэл, Европын Үндсэн хуулийн шүүхээс ялгаатай нь Цэц Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг эцэслэн шийдвэрлэх боловч ийнхүү шийдвэрлэхээсээ өмнө парламентын байр суурийг сонсдог өвөрмөц процедуртай. Энэ процедурыг хоёр шатат процедур гэж нэрлэж болно. Энэ хэсэгт хоёр шатат процедурын агуулга, түүнийг халах шаардлагын талаар хэлэлцэх болно.

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэдэг (Үндсэн хууль, 66.1). Үндсэн хуулийн 66.1-д заасан үндэслэлээр Цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргахдаа хоёр шаттай болон нэг шаттай процедураар шийдвэрлэхээр Үндсэн хуулийн 66.2-т заасан тул тус тусад нь товч авч үзье.

Нэгд, Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Цэц Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хоёр шатаар хянан шийдвэрлэхээр зохицуулсан.⁷⁴ Үндсэн хуулийн 66.1-д заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулахаар

⁷³ Мөн тэнд, §67.

⁷⁴ Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.20): 39-41, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор.

зохицуулсан (Үндсэн хууль, 66.2): хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх (Үндсэн хууль, 66.2.1); ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх (Үндсэн хууль, 66.2.2). Эдгээр дүгнэлтийг Цэцийн хэдэн гишүүний бүрэлдэхүүнтэй гаргахаар Үндсэн хуульд заагаагүй бөгөөд уул дүгнэлтийг гаргах бүрэлдэхүүнд Цэцийн бүх гишүүн орохоор хуульчлах боломжтой. Гэвч, Үндсэн хуулийн 66.2.1, 66.2.2-т заасан маргаантай асуудлыг Цэцийн 5 гишүүний бүрэлдэхүүнтэй Дунд суудал шийдвэрлэхээр 1992 оны Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар зохицуулжээ. Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гарснаар тухайн хууль, зарлиг, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ болон тэдгээрийн холбогдох зүйл, заалтын үйлчилгээ нь Цэцийн эцсийн шийдвэр гарах хүртэл түдгэлзэх бөгөөд түдгэлзүүлж эхлэх хугацааг Цэц дүгнэлтдээ тусгайлан заадаг (Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, 32.4).

2020 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (МУИХЧХДТХ)-ийн 82.1-д зааснаар Үндсэн хуулийн 66.2-т заасан маргаантай асуудлаар Цэц дүгнэлт гаргасан бол “түүнийг ёсчилсноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хуралд ирүүлдэг.” ҮХЦМХШАТХ-ийн 36.2-д “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор; хэрэв Улсын Их Хурлын чуулганы чөлөөт цагт гаргасан бөгөөд тэр нь онц болон, дайны байдал зарласнаас бусад асуудлаар гарсан бол Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.” УИХ-ын хуралдаан дээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Цэцийн гишүүдийн аль нэг нь дүгнэлтийг уншиж танилцуулах боловч УИХ-ын гишүүд Цэцийн гишүүнээс асуулт асуух эрхгүй гэж Цэц шийдсэн.⁷⁵

Цэцийн дүгнэлт УИХ руу орох боловч эцсийн шийдвэр болох хэд хэдэн нөхцөл бий. Юуны өмнө, Цэц Үндсэн хуулийн 66.2.1, 66.2.2-т заасан маргаантай асуудлаар Үндсэн хуульд нийцсэн гэсэн дүгнэлт

⁷⁵ Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №2, 2010.04.02; Үндсэн хуулийн цэц, Тогтоол №2, 2010.06.09.

гаргасан бол уг дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр нэгдсэн хуралдаанд шууд танилцуулах бөгөөд санал хурааж шийдвэр гаргахгүй, Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд тухайн асуудалд томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлж болно (МУИХЧХДТХ, 82.2.8). Мөн, Үндсэн хуульд нийцээгүй тухай Цэцийн дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрвөл уул дүгнэлт эцсийн шийдвэр болдог. Хууль, тогтоол Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол эдгээр шийдвэр хүчингүй болсонд тооцохоор хуульчилсан (МУИХЧХДТХ, 82.2.5, 82.2.6).

Үндсэн хуулийн 66.2.1, 66.2.2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана гэж заасан (Үндсэн хууль, 66.3). Өөрөөр хэлбэл, Цэцийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй эсхүл Цэцийн дүгнэлтээс УИХ татгалзсан⁷⁶ тохиолдолд хоёр дахь шат эхлэх буюу Цэц уул маргааныг дахин хянан үздэг. Нэг талаар, УИХ Цэцийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанд буюу 15 хоногийн дотор шийдвэрлэхгүй бол⁷⁷ эсхүл Цэцээс өмнө Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоосон хууль тогтоомжийг дахин баталбал⁷⁸ Цэцийн Их

⁷⁶ Хууль эсхүл бусад шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй гэдгийг тогтоосон Цэцийн дүгнэлтийн дийлэнхийг хүлээн зөвшөөрөхөөс УИХ татгалздаг. Гэвч, УИХ дахь олонхын намаас нэр дэвшигчийн нэрийг хассан тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Үндсэн хуульд нийцсэн гэж тогтоосон Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөөс нэг удаа татгалзаж байсан. Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №5, 1996.06.20; Улсын Их хурал, Тогтоол №24, 1996.08.01.

⁷⁷ Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №10, 2008.12.12; Үндсэн хуулийн цэц, Тогтоол №3, 2009.01.10. Энэ маргааныг хянан шийдвэрлээд Цэц дүгнэлтээ УИХ-д оруулсан. УИХ тухайн үеийн хуульд зааснаар 15 хоногийн дотор шийдвэрлэх ёстой байсан ч зургаан сарын турш ямар нэгэн шийдвэр гаргаагүй. Иймээс, Цэц Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу өөрийн дүгнэлтээр Үндсэн хуульд нийцээгүйг нь тогтоосон хуулийн заалтыг УИХ-ын шийдвэргүйгээр хүчингүй болгож, эцсийн шийдвэр буюу тогтоолоо гаргасан. Цэцийн энэ тогтоол нь Цэцийн эрх хэмжээг тогтоож, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан юм. УИХ-аас хууль заасан хугацаанд Цэцийн дүгнэлтийн талаар шийдвэрээ гаргахгүй бол Цэцээс УИХ-ын шийдвэр ирээгүй гараагүй байсан ч эцсийн шийдвэрийг гаргах ёстой гэдэг санааг анх Академич Ж.Амарсанаа дэвшүүлж байв. Ж.Амарсанаа, Д.Мөрөн, С.Болд, *Үндсэн хуулийн цэцийн чадавхыг бэхжүүлэн нь*, 38.

⁷⁸ Үндсэн хуулийн цэц, Тогтоол №2, 2009.05.27. Энэ тогтоолд Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хуулийн заалтыг УИХ шууд буюу агуулгаар нь дахин сэргээсэн гэдгийг Цэц тогтоож, уул заалтыг хүчингүй болгосон. Мөн, Цэцээс хүчингүй болгосон хуулийн

суудал хуралдаж УИХ-ын тогтоолгүйгээр эцсийн шийдвэрээ гаргадаг байхаар Цэц шийдвэрээрээ тогтоосон. Нөгөө талаар, Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тухай тогтоолыг Улсын Их Хурал гаргасан бол Цэц бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар буюу Их суудлаараа маргааныг эхнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргахаар хуульчилсан (ҮХЦМХШАТХ, 36.3). Цэцийн эцсийн шийдвэр (тогтоол)-ээр Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон хууль уул шийдвэр гармагц хүчингүй болно (ҮХЦМХШАТХ, 36.4). Цэцийн хуралдаанаас гаргасан дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрөөгүй бол дахин хянаж эцэслэн шийдвэрлэх хуралдааныг бүрэн бүрэлдэхүүнтэй, хэрэв энэ тохиолдолд зарим гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй бол Цэц маргааныг долоогоос доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй тус тус хийхээр заасан. Цэц хэлэлцэж байгаа асуудлыг Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэдэг ч Цэц маргааныг дахин хянан үзэж, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр хувийн саналаар эцэслэн шийдвэрлэнэ, хэрэв гишүүдийн гуравны хоёр хувийн санал авч чадаагүй бол уг хууль, тогтоол, зарлиг, бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээний заалт хүчинтэй хэвээр үлдэнэ гэж заасан.

Үндсэн хуулийн 66.4-т “Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно” гэж заасан. Энэ заалтын дагуу Цэцийн тогтоолоор хууль, тогтоолын зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгосон бол УИХ хууль, тогтоолд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлэдэг (МУИХЧХДТХ, 85.1).

Хоёрт, Үндсэн хуулийн 66.1-д заасан үндэслэлээр Цэц Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх (Үндсэн хууль, 66.2.3); Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх (Үндсэн хууль, 66.2.4) маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулахаар зохицуулсан

заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээсэн гэж хүчингүй болгосон Цэцийн дараах шийдвэрийг харна уу: Үндсэн хуулийн цэц, Тогтоол №1, 2008.01.23.

(Үндсэн хууль, 66.2). Цэц Үндсэн хууль зөрчсөн эсэх, түүнийг огцруулах буюу эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх эдгээр асуудлыг их суудлаар 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж дүгнэлт гаргахаар хуульчилсан. Дээрх дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрөх эсэх эсхүл УИХ хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд хэрхэх тухай Үндсэн хуульд тодорхой заагаагүй ч МУИХЧХДТХ-иар нарийвчлан зохицуулж байна.

Цэц дүгнэлтээ УИХ руу оруулдаг хоёр шатат процедур нь өвөрмөц учраас Үндсэн хууль тогтоогчид түүнийг яагаад бий болгосон шалтгааныг судалъя. Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх явцад нэг шатат болон хоёр шатат процедурын аль алийг нь ярилцсан байдаг. Хоёр шатат процедурыг Үндсэн хуулийн 66.2, 66.3-т заасан шигээр дээр тодорхойлсноор ерөнхийд нь ойлгож байв. Нэг шатат процедур гэдэг нь Европ дахь үндсэн хуулийн шүүхэд түгээмэл байдаг сонгодог процедур юм. Өөрөөр хэлбэл, Европ дахь Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоомж, бусад шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай эцсийн шийдвэрийг шууд гаргадаг бөгөөд уул шийдвэрээ парламентад хүргүүлдэггүй. Үндсэн хуулийн төслийн эхний хувилбаруудад нэг шатат процедур туссан байв: “Монгол улсын хууль болон хууль тогтоомжийн бусад акт, тэдгээрийн заалт нь Үндсэн хуулийг зөрчиж байгааг Үндсэн хуулийн хяналтын зөвлөл тогтоовол энэ тухай уг зөвлөлөөс шийдвэр гаргана. Үдсэн хуулийн хяналтын зөвлөлийн шийдвэрийг төрийн хэвлэлд нийтэлсэн өдрөөс Үндсэн хуулийг зөрчиж байгаа хууль тогтоомжийн акт, эсхүл түүний заалтыг хүчингүй болсонд тооцно.”⁷⁹ Үндсэн хууль тогтоогчид уул төслийн хэлэлцүүлгийн эхэн үед нэг шатат процедураас татгалзаж хоёр шатат процедурыг сонгосон ч АИХ дээр хоёр шатат процедурыг эсэргүүцэгчид олонхын дэмжлэг авч чадаагүй юм.⁸⁰

Үндсэн хууль тогтоогчид дөрвөн үндэслэлийг ярилцсаны үндсэн дээр нэг шатат процедурыг бус, хоёр шатат процедурыг сонгож авсан. Нэгд, Үндсэн хуулийн төсөл хэлэлцэх үед хууль зүйн мэргэжилд итгэх итгэл олон нийтийн өндөр биш байв. Социалист дэглэмийг хуульчид дэмжиж, хэрэгжүүлэхэд тусалж байсан гэж ойлгогдож байсан тул хууль зүйн мэргэжлийн нэр хүнд ерөнхийдөө доогуур байсан. Үндсэн хууль тогтоогчдын зарим нь өмнөх дарангуй дэглэмд иргэдийг хэлмэгдүүлэх ажлыг хуульчид гүйцэтгэсэн гэж тодорхойлж, үндсэн хуулийн хяналтаар

⁷⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн төсөл (1990.12; 1991.01.14; 1991.03.04): 21-22, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор.

⁸⁰ Ц.Элбэгдорж, Улсын Бага Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.10.20): 142; Р.Гончигдорж, Улсын Бага Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.10.20): 145, 146; Товуусүрэн, Улсын Бага Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.10.18): 46, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор.

хэт их эрх мэдлийг хуульчдад өгвөл түүнийг урвуулан ашиглаж, иргэдийг дарангуйлж магадгүй гэж болгоомжилжээ.⁸¹

Хоёрт, Үндсэн хуулийн цэц нь өмнөх дэглэмд байсан улс төрийн товчоо шиг парламент, Засгийн газар, бусад байгууллагын үйл ажиллагаанд дур зоргоор оролцож магадгүй гэж үзсэн. Жишээлбэл, АИХ-ын гишүүн Б.Нямбуу ийм зүйлийг хэлжээ:

Хэрэв энэ цэцийн ...энэнийг зөвшөөрөх юм бол энэ чинь юун улс төрийн товчооноос ч илүү тийм эрх дархтай, хэн ч авч хаяж болохгүй ийм одоо хэсэг цөөхөн хүн гарах гээд байна, энэ цөөхөн хүн чинь 9 жилийн хугацаатай, дахиад нэг сунгаж болно, 18 жилийн турш энэ чинь ерөөсөө бүрэн дархан эрх эдэлчихсэн, ийм юм болох гээд байна, тэгэхлээр энэ дотор чинь харж үзмээр зүйл их байна. ...Чимид энийг бол дундаж байгууллага байх ёстой гэж байна. Энэ заалт нь арай энэ чинь дундаж биш, хамгийн дээд байгууллага болчихоод байна, энэ нь бол энэ заасан юундаа бүр тодорхой байна шүү дээ, цэцийн гаргасан шийдийг Их Хурлаар хэлэлцээд, Их Хурал зөвшөөрөхгүй бол цэцийн шийд тэгээд л хүчин төгөлдөр болно. Цэцийн шийд хүчин төгөлдөр болох дээрээ зэрэг л тэр чинь бүхний эрхийг гартаа авчихсан ийм юу болох гэж байна. ...Эцсийн шийдийг ерөөсөө дундаж л байгууллага юм бол яагаад тэр цэц чинь өөрөө шийд гаргачих ёстой юм, тэгж болохгүй байна, жишээ нь Их Хурлаар шийдэж болдоггүй юм бол, юу ч бас цэц ч бас адилхан шийдэж чадахгүй, дундаа хаяж байх л ийм бололцоотой болох хэрэгтэй.⁸²

Үндсэн хууль тогтоогчдын нэлээд нь хууль зүйн мэргэжилд бүхэлд нь итгэхгүй байхад Үндсэн хууль зөрчсөн хууль, бусад шийдвэрийг шууд хүчингүй болгох бүрэн эрхийг Цэцэд өгөх боломжгүй байсан гэж ойлгогддог.

Гуравт, хоёр шатат процедур бол Улсын Их Хурлыг ардчилсан сонгуулиар бүрдсэн парламент учраас түүнийг “төрийн эрх барих дээд байгууллага,”⁸³ “төлөөллийн дээд байгууллага”⁸⁴ гэдгээр нь хүндэтгэх хэрэгтэй гэж үзсэний илрэл байсан. Жишээлбэл, АИХ-ын депутат Л.Цог хэлэхдээ:

⁸¹ Г.Лхагважав, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.16): 26; Х.Чойжилжав, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.16): 8, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор.

⁸² Б.Нямбуу, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.16): 41; О.Дашбалбар, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.16): 22; Д.Энхбаатар, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.16): 14, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор.

⁸³ Монгол Улсын Үндсэн хууль, 21.

⁸⁴ Г.Совд, “Үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд Үндсэн хуулийн цэцийн эзлэх байр суурь,” *Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл)* дотор, редактор Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа (УБ, 2007), 95.

...Парламентын гаргасан хууль бус шийдвэрийн дагуу өөрт нь дүгнэлт өгнө гэсэн тийм шат бид нар хийсэн байгаа. Хэрэв ингэхгүй, парламентдаа мэдэгдэхгүй тэрүүгээр нь битүү, хатуу хүчингүй болгоод байх юм бол Парламентын дээр Парламент болно гэсэн ойлголт байсан юм. Тийм учраас ёсоо ч гэсэн дагаад хууль тогтоох төрийн эрх барих дээд байгууллагадаа таны гаргасан хууль чинь ингээд Үндсэн хуулиа зөрчжээ гэсэн дүгнэлтээ явуулъя гэж. Тэгээд тэр хэрэгсэхгүй байвал өөрөө эцсийн болгож хүчингүй болгоё. Шүүхийн шийдвэрийг гарцаагүй мөрдөнө гэсэн энэ утгаараа шүүх болгоно гэж бид томьёолсон байгаа. Энэ бол би түрүүн хэлэх гээд мартсан зүйл. Энэнээс болж шүүхийн мөн чанар алдагдахгүй.⁸⁵

Хоёр шатат процедур нь Цэцийн дүгнэлтийг парламентад хүргүүлдэг ч Үндсэн хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох шийдвэр гаргах бүрэн эрхийг Цэцэд хадгалуулж, хэн бүхэн уул шийдвэрт захирагдах үүрэгтэй учраас энэ процедур нь Цэцийн шүүхийн мөн чанарыг алдагдуулахгүй гэж Үндсэн хууль тогтоогчид үзсэн.

Дөрөв дэх үндэслэл нь хоёр шатат процедур үндсэн хуулийн маргааныг тайван замаар шийдвэрлэх, Цэц болон УИХ-ын хоорондын ойлголцлыг нэмэгдүүлэх арга гэж харсан. Энэ процедур нь Үндсэн хууль зөрчсөн актаа засах боломжийг УИХ болон бусад байгууллагад олгодог. АИХ-ын депутат Б.Чимидийн тайлбарласнаар:

Дараагийн нэг тайлбар бол тэр дүгнэлт гаргаж өгөх, шийдвэрлэх ийм хоёр шат хийсэн ийм онцлогтой хийсэн нь үнэн юм. Тэгэхлээр энд бол нэг эргэх холбооны зарчмыг барьсан... Ингэхээр Үндсэн хуулийн шүүх бол туйлын утгаараа ерөөсөө энэ хууль буруу байна гээд одоо шийдчихнэ. Хүчингүй болгох тухай. Гэтэл учир явдлыг нь мэдэхийн тулд эргээд энэ чинь ингээд зөрчжээ. Энийгээ өөрөө хүчингүй болгож засаж сайжруул гэсэн нэг ийм бололцоог Ерөнхийлөгч, Засгийн газар, Их Хуралд олгох нэг ийм эргэх холбооны, өөрөөр хэлбэл учраа тайван замаар ололцох ийм вариант хийсэн юм. ...шууд тасдаж хаяад байх, тал тал тийшээгээ бас нэг эмээлийн бүүрэг шиг болчихгүйн тулд нэгэн удаад өөрөө зас гэдэг энэ бол үнэндээ хяналтын байгууллагад байдаг эрх, аливаа хяналтын байгууллага, аливаа газрын шийдвэрийг хянаж үзээд, энэ чинь буруу байна гэж эсэргүүцээд, өөрт нь юм уу, дээд байгууллагад өгөөд засуулдаг ийм хэлбэр бий. Хэрэв засч өгөхгүй бол ерөөсөө эрх бүхий байгууллагаар хүчингүй болгуулдаг ийм хэлбэр бий. Энэ хэлбэрийг монголын төр эрхийн одоогийн практикт байгаа практикийг авсан юм. Ер нь учир ийм байна. Тэгэхээр Үндсэн хуулийн шүүхээр маргаантай асуудлыг 2 үе шаттай авч хэлэлцэнэ гэж процессийн хувьд хэлж болж байгаа юм. Анхан шатанд нь

⁸⁵ Л.Цог, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.14): 55-56, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор.

дүгнэлт гаргаад, өөрөөр нь шийдүүлэх, тэгээд шийдэж өгөхгүй бол өөрөө шийдэх гэсэн ийм 2 шат байна.⁸⁶

Тэгэхлээр парламентын гишүүд, Засгийн газрын гишүүд, Ерөнхийлөгчийг хэрэг маргаанд холбогдоход уг хэрэг маргааны асуудал албан тушаалдаа байх уу үгүй юу гэдэгтэй нь энэ холбогддог юм. Албан тушаалдаа байж байгаа үед нь Ерөнхийлөгчөө, Дэд ерөнхийлөгчөө, Засгийн газраа шууд аваачиж байцаадаггүй. Тэр ч байтугай, депутатуудыг Мандатын комиссын, Их Хурлын өөрийнх нь зөвшөөрлийг авдаг. Ингэж зөвшөөрөл өгөхийн тулд тэр хуулийн байгууллагуудын мөрдсөн баримтаар биш Үндсэн хуулийн шүүхийн гаргасан дүгнэлтийн үндсэн дээр авч үзээд, тэр албан тушаалтны албан тушаалынхаа эрх, үйл ажиллагааг явуулах уу үгүй юу гэдгийг шийдэх энэ утгаар тэр импичмент гэж яриад байгаа тэр хэлбэрээр маргаан шийднэ.⁸⁷

Эндээс харвал хууль, бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Цэц шийдвэрлэх ч УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газарт уул шийдвэрийг хүчингүй болгож алдаагаа засах боломжийг олгох, эдгээр байгууллага болон Цэцийн хоорондын ойлголцлыг нэмэгдүүлэх, уян хатан арга зам гэж харжээ. Профессор Ц.Сарантуяа “Дунд суудлаас гаргасан дүгнэлт тэр бүр шууд эцсийн шийдвэр болдоггүй нь нэг талаас УИХ-д буюу маргагч бусад талд алдаагаа засах боломжийг олгох, нөгөө талаас тухайн тодорхой актын Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа хэсгийг эсхүл бүхэлд нь гаргах болсон үндэслэл, шалтгааныг тодруулан магадлах зорилготой” гэжээ.⁸⁸

Үндсэн хуулийн хяналтын хоёр шатат процедур нь ардчиллыг шинээр тогтоож буй улсад тохирч байсан байж магадгүй юм. 1990 оноос өмнөх БНМАУ-д Үндсэн хуулийн хяналт ч байгаагүй, парламентат ёс ч байгаагүй. 1990 онд БНМАУ-ын Ардын Их Хурлаас байгуулсан Улсын Бага Хурал нь манай улсын анхны байнгын ажиллагаатай парламент байв. 1992 оны Үндсэн хуулиар одоогийн байнгын ажиллагаатай парламент болох Улсын Их Хурлыг, мөн Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг шүүх болох Үндсэн хуулийн цэцийг тус тус анх байгуулсан. Өнгөрсөн хугацаанд УИХ ч, Цэц ч аль аль нь алдаа гаргаж байсан нь шинэ тутам байгуулагдсан, туршлага дутмаг байсантай холбоотой. Хэрэв Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг шууд

⁸⁶ Б.Чимид, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.20): 11-14, 39-41, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор. Мөн дараахыг харна уу: Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал*, Дэвтэр 1 (УБ, 2004), 164; Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал: шүүх эрх мэдэл*, Дэвтэр 2 (УБ, 2004), 179.

⁸⁷ Б.Чимид, Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл (1991.12.20): 39-41, *Монгол Улсын Үндсэн хуулийн архивын сан (CD)* дотор.

⁸⁸ Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал* (УБ, 2005), 173.

эцэслэн шийдвэрлэдэг байсан бол түүний алдааг засах боломжгүй байх байсан байж магадгүй. Ийм алдааг зөвхөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар л засна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь хэцүү ч Цэцийн алдаатай шийдвэрээс болж байн байн өөрчлөлт орох нь хууль дээдлэх ёсонд харш юм. Хоёр шатат процедур нь шилжилтийн үед үндсэн хуулийн шүүхээс гаргах алдааг багасгах институтийн зохион байгуулалт байсан гэж эерэг талаас нь хэлж болно.

Хоёр шатат процедур нь УИХ-ын байр суурийг сонссоны дараа хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлаарх эцсийн шийдвэрээ гаргах учраас Цэц болон УИХ-ын хооронд конструктив диалоги үүсэхийг дэмждэг. Эхний шатанд УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч (ихэвчлэн эрх зүйч мэргэжилтэй УИХ-ын гишүүн томилогддог) тухайн хууль тогтоомж Үндсэн хуулийг яагаад зөрчөөгүй үндэслэлээ Цэцэд бичгээр урьдчилан хүргүүлж, Цэцийн дунд суудлын хуралдаан дээр амаар тайлбарладаг (нөгөө талаас, өргөдөл, мэдээлэл гаргагч бас тайлбараа бичгээр болон амаар өгдөг). Үүний дараа Цэц хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэх дүгнэлтээ гаргаж УИХ-д оруулдаг. УИХ-ын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэхийг хэлэлцдэг. УИХ Цэцийн дүгнэлтээс дийлэнхдээ татгалздаг боловч заримдаа хүлээн зөвшөөрч өөрийн эсхүл Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг бусад институтийн алдааг засдаг.⁸⁹ УИХ-ын гишүүд дүгнэлтээс татгалзаж буй тохиолдолд УИХ-ын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд энэ тухай үндэслэлээ амаар хэлдэг ч дийлэнхдээ УИХ-н тогтоолд бичгээр илэрхийлдэггүй.⁹⁰ УИХ дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Цэцийн Их суудлын хуралдаанаар

⁸⁹ УИХ Цэцийн дараах дүгнэлтийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрч байжээ: Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №2, 1994.01.12; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №8, 1994.08.29; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №1, 1995.01.04; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №4, 1996.05.29; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №2, 1997.04.09; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №6, 1997.07.05; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №2, 1998.02.24; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №4, 1998.04.27; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №1, 2001.03.23; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №3, 2003.10.29; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №1, 2004.04.21; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №2, 2005.03.31; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №3, 2005.04.13; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №7, 2005.09.30; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №9, 2005.12.07; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №3, 2006.03.29; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №7, 2006.06.21; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №11, 2006.12.13; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №3, 2008.02.27; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №6, 2008.05.14; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №8, 2008.10.29; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №1, 2009.03.04; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №2, 2009.03.11; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №1, 2010.03.24.

⁹⁰ Цэцийн дүгнэлт (№03, 2021.04.28)-ийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзахдаа УИХ энэ тухай үндэслэл анх удаа 2 нүүрт дэлгэрэнгүй 1 бичсэн тогтоол баталсан ч Цэц уул маргааныг дахин хянан үзээд гаргасан тогтоолдоо үндэслэл бараг бичээгүй юм. УИХ, Тогтоол №41, 2021.05.06.

дахин хянан үздэг бөгөөд энэ үед УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн дүгнэлтээс татгалзсан үндэслэлийг амаар, бичгээр Цэцэд танилцуулдаг. Эдгээр үндэслэлийг жигнэж үзсэний эцэст Үндсэн хуулийн цэц тухайн маргаантай асуудлаар эцсийн шийдвэрийг гаргадаг. Цэц цөөн тохиолдолд ч гэсэн Дунд суудлын дүгнэлтээ өөрчилсөн⁹¹ учраас хоёр шатат процедур нь Цэц ч гэсэн өөрийн дүгнэлтийг эргэн харж алдаагаа засах боломж олгодог гэдгийг нотолдог.

Цэц шийдвэрийн үндэслэлээ байнга дэлгэрэнгүй бичдэг болбол УИХ-ын болон Цэцийн хоорондын диалоги илүү чанартай, үндэслэлтэй болох боломжтой. Өнгөрсөн 31 жилийн хугацаанд Цэцийн дийлэнх шийдвэрт маргааны хоёр тал (ихэнхдээ иргэн болон УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ын үндэслэлийг тэр чигээр нь хуулж бичдэг ч энэ талаар хангалттай анализ хийдэггүй, түүнчлэн өөрийн үндэслэлийг бараг бичдэггүй эсхүл маш товч цөөн өгүүлбэрээр дурддаг. Маргааны талууд болон олон нийт Цэцээс талуудын аль үндэслэлийг сайн, муу гэж үзсэн, эсхүл аль үндэслэлийг хүлээн авсан, аваагүй, ер нь ямар үндэслэлээр шийдэлд хүрсэн гэдгийг мэдэх эрхтэй. Үндэслэгээ дутуу эсхүл огт бичээгүй Цэцийн шийдвэрээс яагаад тухайн шийдэлд хүрсэн тухай олон нийт мэдэх боломжгүй. Цэц шийдвэр бүртээ үндэслэлээ дэлгэрэнгүй бичдэг болбол УИХ Цэцийн дүгнэлтийн шийдлийг төдийгүй үндэслэлийг нь тойрч ярьдаг болно. Цэц өөрийн дүгнэлтийн үндэслэлийг маш сайн бичдэг болбол УИХ уул дүгнэлтээс татгалзахад хэцүү. Учир нь, иргэд болон мэргэжлийн хамт олон нь Цэцийн сайн үндэслэл бүхий дүгнэлтийг дэмжиж, хамгаалах төдийгүй УИХ-аас татгалзвал хүчтэй шүүмжилдэг. Цэцээс өмнө нь гаргаж байсан сайн үндэслэлтэй дүгнэлтийг иргэд, хуульчид өргөнөөр дэмжиж байснаас үүнийг харж болно.⁹² Иймд, хоёр шатат процедурыг хадгалж байгаа тохиолдолд Цэц шийдвэр бүрийн үндэслэлээ маш сайн судалгаатай, дэлгэрэнгүй бичдэг болбол УИХ болон Цэцийн хоорондын диалоги чанаржина.

Монгол Улсад хоёр шатат процедурыг нэг шатат процедураар сольж, Цэцээс Үндсэн хуулийн бүх маргааны талаар заавал биелүүлэх эцсийн шийдвэрийг шууд гаргадаг болох нь Цэцийг бусад ардчилсан

⁹¹ Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №1, 1994.01.07; Үндсэн хуулийн цэц, Тогтоол №1, 1994.02.04; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №2, 2000.03.13; Үндсэн хуулийн цэц, Тогтоол №1, 2000.09.08; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №3, 2002.06.26; Үндсэн хуулийн цэц, Тогтоол №3, 2000.11.13.

⁹² О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дүн шинжилгээ: Ц.Нямдоржийн эсрэг Д.Ламжав нар (2007), Эрх зүй №4 (44) (МУИС-Хууль зүйн сургууль 2018), 199-218; О.Мөнхсайхан, *Цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал: УИХ э. Н.Хайдав* (2007), *Шүүх эрх мэдэл* №02 (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015), 77-916

улсын Үндсэн хуулийн шүүх шиг бие даасан болоход чиглэсэн хамгийн чухал шинэчлэлийн нэг болно. Хоёр шатат процедурын дагуу УИХ дээр Цэцийн дүгнэлтийг улс төрийн эсхүл хэт нэг талын өнцгөөс үгүйсгэж нийтэд ярьдаг учраас Цэцийн бүрэн эрх, легитим чанарыг сулруулж бие даасан байдалд нь сөргөөр нөлөөлдөг. Шварц энэ тухай дараах дүгнэлтийг хийсэн байдаг: “Шийдвэр эцсийн байх нь шүүхийн бие даасан байдлыг хамгаалахад нэн чухал. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг эцсийн байхаас татгалзах нь парламентын бүрэн эрхт байдлыг хадгалах гэсний илрэл бөгөөд Үндсэн хуулийн шүүх болон эрх мэдэл хуваарилах номлолд үл итгэж буй явдал юм.”⁹³ Монголын эрдэмтэд ч хоёр шатат процедурыг шүүмжилдэг. Жишээлбэл, профессор Ц.Сарантуяа хэлэхдээ:

Цэцийн шийдвэр бол шүүхийн шийдвэр бөгөөд түүний шийдвэрийг бусад байгууллага хэлэлцдэг нь зөв биш. Цэцийн Дунд болон Их суудлаас гарсан дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлдэг. Энэ нь хууль тогтоогч шүүхийн шийдвэрийг мэдэж хүлээн зөвшөөрдөг гэсэн ташаа ойлголтыг төрүүлдэг. Хуулийн байгууллагын гаргасан шийдвэрийн зөв эсхүл бурууг улс төрийн байгууллага хэлэлцэнэ гэдэг нь логикгүй хэрэг. Энэ тохиолдолд эрх мэдлийг хуваарилалт, шүүхийн бие даасан байдал, хууль дээдлэх ёс (the rule of law) гэсэн орчин үеийн ардчилсан зарчмуудыг хэрэгжүүлж чадахгүй юм.⁹⁴

Иймд, хоёр шатат процедур нь шилжилтийн үед буюу 1990-ээд онд тохиромжтой байсан байж болох ч үүнээс хойш шаардлагагүй болсон.

Хууль зүйн өндөр мэргэшил

1992 оны Үндсэн хуулийн 65-р зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно” гэжээ. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар Үндсэн хуулийн 65-р зүйлийн 2-т заасан “хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй” гэдэг шаардлагыг задалж тодорхойлоогүйээс⁹⁵ уг хууль үйлчилж эхэлснээс хойш Цэцийн гишүүн нь хуульч төдийгүй бусад мэргэжлийн хүн байхыг зөвшөөрч, заримдаа мэргэшсэн бүү хэл мэргэжлийн байх шаардлага тавьдаггүй практик (хэт өргөн үзэл баримтлал) тогтсон. Цэцийн гишүүн

⁹³ Schwartz, *The Struggle for Constitutional Justice in Post-Communist Europe*, 38.

⁹⁴ Sarantuya Ts., “Origin, Development and Urgent Tasks of the Constitutional Procedure Law in Mongolia,” 37.

⁹⁵ Ингэж задалж тодорхойлох боломж бий: О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь,” *Эрх зүй* №4 (36) (МУИС-Хууль зүйн сургууль 2016), 1-28

ядаж хууль зүйн өндөр мэргэшилтэй байна гэсэн явцуу үзэл баримтлалыг үндсэн хууль судлаачдын дийлэнх дэмждэг ч Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд энэ нь тусгагдахгүй 31 жил болжээ.⁹⁶

Цэцийг үндсэн хуулийн шүүх гэж Цэцийн гишүүд өөрсдөө болон Монголын Үндсэн хууль судлаачид санал нэгддэг. Цэц үндсэн хуулийн шүүх юм бол түүнд ажиллах гишүүн нь шүүгчээр ажиллах наад захын шаардлага хангасан байх ёстой. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрлэдэг үндсэн хуулийн маргаан бол хууль зүйн маргааны нэг төрөл бөгөөд түүнийг зөв, үндэслэлтэй шийдвэрлэхийн тулд хууль зүйн мэдлэг, ур чадвараас гадна үндсэн хуулийн онол, эрх зүйн философийн мэдлэгтэй, ёс зүйн өндөр шаардлага хангасан байх хэрэгтэй. Мөн, Цэцийн гишүүн нь мэргэжлээрээ тодорхой хугацаанд ажиллаж туршлага хуримтлуулах замаар эдгээр мэдлэг, ур чадвар, ёс зүйг төлөвшүүлнэ. Үндсэн хуулийн энэхүү үзэл санааг хэрэгжүүлэх үүднээс шүүгч, хууль зүйн сургуулийн багшийн, хуульч, өмгөөлөгч, прокурор, төрийн эсхүл бусад байгууллагад хууль зүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн ажлыг 10-аас доошгүй жил эрхэлсэн туршлагатай байхаар хуульчлах нь зүйтэй. Эдгээр шинжийг цогцоор нь хууль зүйн өндөр мэргэшилтэй хэмээн ойлгох боломжтой.

Ардчилсан улс дахь Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь шүүгчид тавигдах шаардлагыг хангасан байх ёстой гэсэн нийтлэг чиг хандлага бий. Европын үндсэн хуулийн шүүгч нь ихэнхдээ нэр хүндтэй шүүгч, хуульч, хуулийн профессороос бүрддэг. Жишээлбэл, Германд үндсэн хуулийн шүүхийн шүүгч 40 нас хүрсэн, *Бундестагт* сонгогдох эрхтэй, шүүгчийн чиг үүрэг гүйцэтгэх шаардлага хангасан байх ёстой. Түүнчлэн, үндсэн хуулийн шүүхийн 16 шүүгчийн зургаа нь Холбооны Дээд шүүхүүдийн шүүгчдээс сонгогдох ёстой бөгөөд бусад нь ихэвчлэн их сургуулийн хуулийн профессор байдаг. “Үндсэн хуулийн шүүх рүү чадавхгүй улс төрчид ихээр орохоос урьдчилан сэргийлэхийн тулд” эдгээр бүх шаардлагыг хатуу тодорхойлж мөрддөг.⁹⁷

⁹⁶ Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал* (УБ, 2005), 71–72; Sarantuya Ts., “Abstract of the Thesis for Doctor of Juridical Science: Origin, Development and Urgent Tasks of the Constitutional Procedure Law in Mongolia” (Sc.D, National University of Mongolia, 2008), 14–15; Ж.Амарсанаа, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц ба захиргааны хэргийн шүүх,” *Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, нийтлэлийн эмхтгэл) дотор*, ред. Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа (УБ, 2007), 321–22; Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг* (УБ, 2008), 402.

⁹⁷ Beyme, “The German Constitutional Court in an Uneasy Triangle Between Parliament, Government and the Federal Laender,” 103.

9 жилээр зөвхөн нэг удаа томилох эсхүл зөвхөн нэг удаа дахин томилох

1992 оны Үндсэн хуульд дахин томилогдохыг илэрхий хориглосон заалт ороогүй. Цэцийн гишүүнийг дахин томилох дээр ямар нэгэн хязгаарлалт хуульчлаагүй байсан учраас Цэцийн гишүүнийг дахин томилох замаар түүний бүрэн эрхийн хугацааг сунгаж ирсэн. Жишээ нь, Цэцэд 2, 3, 4 удаа томилогдсон гишүүд ажиллаж байв.⁹⁸ Жишээлбэл, Үндсэн хуулийн цэцэд 4 удаа томилогдсон ч 24 биш, бүр 26 жил Цэцийн гишүүнээр ажилласан хүн бий нь эрх зүйт төртэй улсад байх боломжгүй кэйс юм.

Европын үндсэн хуулийн шүүхийн шүүгч дийлэнхдээ урт (9-12 жилийн) бүрэн эрхийн хугацаагаар томилогддог.⁹⁹ Ийм урт хугацаа нь нэг талаас шүүгчдийн хараас бус байдал, нөгөө талаас хариуцлагын зарчмыг хангах зорилготой. “[Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн] бүрэн эрхийн хугацааг 12 жилээр хязгаарласнаар зөнөх асуудал (заримдаа АНУ-ын Дээд шүүхэд тохиолддог)-ыг үгүй хийдэг.”¹⁰⁰

Хэрэв шүүгчийн бүрэн эрхийн хугацаа хэт богино байвал үндсэн хуульд ёсны хөгжилд халтай. Шинэ шүүгч үндсэн хуулийн асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх, бичих зэрэг шүүхийн ажилд дадахад тодорхой хугацаа зарцуулах учраас 6 жил зэрэг хэт богино хугацаагаар томилох нь шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж магадгүй. Түүнчлэн, богино хугацаа нь үндсэн хуулийн зарчимч тайлбарыг тууштай хийх замаар үндсэн хуулийн эрх зүйн жишиг хөгжүүлэх боломжийг шүүгчид олгодоггүй.¹⁰¹ Богино бүрэн эрхийн хугацаатай тохиолдолд шүүгчид ойр ойрхон солигдох учраас шүүхийн шийдвэр тэр давтамжаар өөрчлөгдөх эрсдэлтэй. Ийм өөрчлөлт нь хууль дээдлэх ёс (the rule of law)-ны нэг шаардлага болох хуулийн тогтвортой байдлыг алдагдуулдаг.

Европын үндсэн хуулийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа урт төдийгүй сунгах боломжгүй байдаг. Зөвхөн нэг удаагийн урт хугацаа нь

⁹⁸ О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь,” *Эрх зүй* №4 (36) (МУИС-Хууль зүйн сургууль 2016), 1-28.

⁹⁹ О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн хяналтын хоёр загвар: онцлог ба төстэй тал,” *Эрх зүй* №1 (31) (МУИС-Хууль зүйн сургууль 2015), 9-28.

¹⁰⁰ Klaus von Beyme, “The German Constitutional Court in an Uneasy Triangle Between Parliament, Government and the Federal Laender,” in *Constitutional Justice, East and West: Democratic Legitimacy and Constitutional Courts in Post-Communist Europe in a Comparative Perspective*, ed. Wojciech Sadurski, 1st ed. (Springer, 2002), 103.

¹⁰¹ Энэ тайлбарын талаар зохиогчийн бичсэн дараах номоос үзнэ үү: Munkhsaikhan O., *Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation*, 109–160.

үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлдэг. “Дахин сонгогдох боломжгүй нь энэ шалтгаанаар талуудад тал засах сэдлийг шүүгчид төрүүлдэггүй бөгөөд энэ нь түүний хараат бус байдлыг бэхжүүлдэг.”¹⁰² Нөгөө талаас, “нэг бүрэн эрхийн хугацаанд ажилладаг шүүгчид ирээдүйн ажлын боломж руу нүд унагаж, улмаар мэргэжлийн болон бусад шүүхийн албан тушаалын томилгоонд улс төрийн байгууллага, албан тушаалтан нөлөөтэй байгаа хэмжээнд шүүгчид улс төрийн хувьд сахилгатай байдаг” гэсэн үндэслэлийг Том Гинсбург дэвшүүлсэн.¹⁰³ Нэг бүрэн эрхийн хугацаанаас гарч болох эрсдэлийг насны доод хязгаарыг ахиулж хуульчлах замаар багасгаж болно. Жишээлбэл, үндсэн хуулийн шүүгчийн насны доод хязгаар 40 байвал 40-50 насандаа томилогдож 9 эсхүл 12 жил ажиллавал тэдний ирээдүйн ажил олох сэдэл залуу шүүгчдийнхээс бага байна. Үндсэн хуульд захирагдаж, хараат бус ажиллах нь тухайн албан тушаалд томилогдсон хүнээс хамаардаг учраас улс төрийн, эдийн засгийн, болон бусад ашиг сонирхлоос хүртэж болох үр ашгийн нөлөөнөөс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг ангижруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгоход хэцүү юм.

Сунгах боломжгүй урт бүрэн эрхийн хугацаа хүн ам цөөтэй Монгол шиг улсын үндсэн хуулийн шүүхэд тохирдог. Шаардлага хангасан нэр дэвшигчдийн тоо хязгаартай учраас нэг удаагийн хэт богино хугацаа (6 жил) тохиромжгүй. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа богино боловч сунгах боломжгүй бол шаардлага хангасан нэр дэвшигчид бүгд үндсэн хуулийн шүүгч болно. Төд удалгүй тэдний хугацаа дуусаж шүүхийг орхих бөгөөд тэдний оронд шаардлага бүрэн хангахгүй нэр дэвшигч томилогдох байдал руу орно. Тийм учраас, цөөн хүн амтай улсад шаардлага хангасан Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг дахин томилуулахын тулд тэдний хугацааг сунгах боломж олгох нь тустай мэт санагдаж магадгүй. Гэвч, сунгах боломжтой бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг сулруулна. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид улс төрийн процессоор томилогддог учраас улс төрчид зөвхөн өөрсдийн сонирхолд үнэнч хүнийг дахин томилохыг эрмэлзэх хандлага ажиглагддаг.

¹⁰² Мөн тэнд.

¹⁰³ Tom Ginsburg, *Judicial Review in New Democracies: Constitutional Courts in Asian Cases* (Cambridge University Press, 2003), 47.

Олон улсын сайн туршлага

Европт үндсэн хуулийн шүүгчдийг томилох олон янзын тогтолцоо оршдог. Зарим улсад гурван өөр институт үндсэн хуулийн шүүгчдийг томилдог. Жишээлбэл, Италийн Үндсэн хуулийн шүүх 15 шүүгчтэй бөгөөд эдгээр шүүгчдийн гуравны нэгийг Ерөнхийлөгч, гуравны нэгийг парламентын доод болон дээд танхимын хамтарсан хуралдаан, гуравны нэгийг захиргааны болон ердийн дээд шүүх тус тус томилдог.¹⁰⁴ Магистрат болон магистратаар ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан хүн, захиргааны болон ердийн дээд шүүхийн шүүгч, их сургуулийн хуулийн профессор, арваас доошгүй жил практик хийсэн хуульчаас Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг сонгож томилохоор заажээ (Италийн Үндсэн хуулийн 135). Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг есөн жилийн хугацаатай томилох бөгөөд дахин томилохыг хориглодог.

Бусад улсад үндсэн хуулийн шүүгчид парламентын гишүүдийн дийлэнх олонхын саналаар сонгогддог. Жишээлбэл, Германы Холбооны Үндсэн хуулийн шүүхийн 16 шүүгчдийн хагасыг *Бундестаг* сонгож, үлдсэн хагасыг *Бундесрат* сонгодог. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн дагуу *Бундестаг* хувь тэнцүүлсэн төлөөллийн дагуу сонгогдсон 12 гишүүний бүрэлдэхүүнтэй сонгуулийн хороог байгуулдаг. Энэ хороо нийт саналын гуравны хоёр буюу наймаас доошгүйн саналаар найман үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг санал болгож, *Бундестагийн* хуралдаанд оролцсон гишүүний гуравны хоёрын санал (энэ нь *Бундестагийн* нийт гишүүний олонхын саналаас доошгүй байх шаардлагатай) авбал эцэслэн сонгогддог. *Бундесрат* гуравны хоёроос доошгүйн саналаар нөгөө найман шүүгчдийг сонгодог. “Бүх гол намууд энэ шүүхэд томилогдох аливаа шүүгчийг батламжилдаг.”¹⁰⁵ Тиймээс, парламент дахь хамгийн олон суудалтай нам, эсвэл нь парламентын бусад намтай зөвшилцөхгүйгээр үндсэн хуулийн шүүгчдийг томилох бараг боломжгүй.

Австрийн Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, 12 гишүүн болон зургаан орлогч гишүүнээс бүрдэх бөгөөд бүгдээрээ хууль зүйн эсхүл улс төрийн шинжлэх ухаанаар дээд боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан байхыг шаарддаг (Австрийн Үндсэн хуулийн 147 дугаар зүйл). Ерөнхийлөгч, Дэд

¹⁰⁴ Giancarlo Rolla and Tania Groppi, “Between Politics and the Law: The Development of Constitutional Review in Italy,” in *Constitutional Justice, East and West: Democratic Legitimacy and Constitutional Courts in Post-Communist Europe in a Comparative Perspective*, ed. Wojciech Sadurski, 1st ed. (Springer, 2002), 141.

¹⁰⁵ Ferejohn and Pasquino, “Constitutional Adjudication,” 1678.

ерөнхийлөгч, зургаан гишүүн, гурван орлогч гишүүнийг шүүгчид, захиргааны албан хаагч, их сургуулийн хуулийн профессороос Холбооны Засгийн газар санал болгосноор Ерөнхийлөгч томилдог. Үлдсэн зургаан гишүүн болон гурван орлогч гишүүнийг Төлөөлөгчийн танхим (гурван гишүүн болон 2 орлогч гишүүн)-ын болон Сенат (гурван гишүүн болон нэг орлогч гишүүн)-ын санал болгосны үндсэн дээр Ерөнхийлөгч томилдог байна.

Испанийн Үндсэн хуулийн шүүх нь Хаанаас томилогдсон (батламжилсан) 12 шүүгчээс бүрддэг (Испанийн Үндсэн хуулийн 159). Эдгээр шүүгчийн дөрвийг нь Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн тавны гурвын саналаар, дөрвийг нь Сенатын гишүүдийн тавны гурвын саналаар, хоёрыг нь Засгийн газар, хоёрыг нь Шүүхийн ерөнхий зөвлөл тус тус нэр дэвшүүлдэг байна. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг магистрат (шүүгч), прокурор, их сургуулийн профессор, төрийн албан хаагч, хуульч нарын дундаас томилох бөгөөд эдгээр нь бүгдээрээ мэргэжлээрээ арван таваас доошгүй жил ажилласан эрх зүйч (jurist) байхаар Үндсэн хуульдаа заажээ. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг есөн жилийн хугацаагаар томилох бөгөөд жил бүр гуравны нэг нь шинэчлэгдэн томилдог байна.

Венецийн комисс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг баталгааг хангах хоёр янзын хувилбарыг санал болгодог. Нэг талаас, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр дийлэнхдээ урт (9-12 жилийн) бүрэн эрхийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилох нь уул шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулахад чиглэсэн, дэлхий нийтэд шилдэг туршлагад тооцогддог юм.

“Хэн нэгэн, нэг ижил хүн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр дахин сонгогдож болох эсэх талаар Үндсэн хууль, хуулийн төслийн аль алинд ч байхгүй байна. Ийнхүү дахин сонгогдох явдлыг хориглоогүй байгаа нь шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулж болзошгүй.”¹⁰⁶

“12 жил болгон сунгагдаж байгаа Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацааны талаар хэлэхэд, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг улам нэмэгдүүлэх үүднээс Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүгч дахин сонгогдохгүй байх талаар боломжтой бол шууд тусгах нь зүйтэй.”¹⁰⁷

¹⁰⁶ CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 20.

¹⁰⁷ CDL-AD(2011)016 Унгарын шинэ Үндсэн хуулийн талаарх санал, хуудас 95.

"Венецийн комиссын зөвлөмжийн дагуу, хуулийн төслийн 153 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн арван хоёр жилийн бүрэн эрхийг дахин сунгах боломжгүйг заасан."¹⁰⁸

Нөгөө талаас, энэ зохицуулалтын зэрэгт хүрэхгүй ч дараагийн дэвшилтэт хувилбар нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох зохицуулалт юм. Тухайлбал, Венецийн комисс энэ тухай дараах зөвлөмжийг өгсөн:

"Дахин томилгоо нь шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулж болзошгүй. Гэсэн хэдий ч, урт хугацаанд алба хашсаны дараа зөвхөн нэг удаа дахин томилгоо хийх боломж нь онц сайн шүүгчдийг үргэлжлүүлэн ажиллуулах нөхцөлийг бий болгоход таатай байж болох юм (...)"¹⁰⁹

"Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний талаарх судалгаандаа шүүгчдийн бүрэн эрхийн хугацааны хувьд Венецийн комисс урт хугацааны, дахин сонгогдохгүй байхыг эсвэл хамгийн ихдээ нэг удаа л дахин сонгогдох боломжтой байхыг илүүд үзсэн. Шүүгчийг дахин сонгохгүй байх нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг улам бүр нэмэгдүүлдэг."¹¹⁰

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг хараат бус, бие даасан, мэргэжлийн болгох, үндсэн эрхийг хамгаалдаг Үндсэн хуулийн шүүх болгох талаарх энэ судалгаанд гарсан саналыг Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудад эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хэрэгжүүлэх боломжтой.

Нэгд, 1992 оны Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг оновчтой тайлбарлах замаар Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудийг дараах агуулгаар шинэчлэх хэрэгтэй:

- тодорхой тохиолдолд үндсэн эрх зөрчсөн тухай тухайн иргэний өргөдлийг үндсэн эрхийн гомдлын агуулгаар ойлгож хуульчлах;
- иргэний мэдээлэл гэдгийг үндсэн хуулийн маргааныг үүсгэх үндэслэл (*actio popularis*) гэж үзэхгүй, харин *amicus curiae* гэсэн

¹⁰⁸ CDL-AD(2013)028 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд прокурор, Шүүхийн зөвлөлтэй холбоотой Үндсэн хуулийн гурван заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд өгсөн санал, цогцолбор 24.

¹⁰⁹ CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 14.

¹¹⁰ CDL-AD(2009)042 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

агуулгаар ойлгож, нэгэнт үүсгэсэн маргааныг зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой үндэслэл, судалгааг маргааны тал биш иргэнээс авах суваг болгох;

- байгууллага, албан тушаалтны хүсэлтийг хамаарлын зарчмаар утгажуулан зохицуулах (тухайлбал УИХ дахь цөөнх буюу УИХ-ийн нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн тухай хүсэлтийг Үндсэн хуулийн цэцэд гаргах боломж олгох зэрэг);
- Цэц үндсэн хуулийн шүүх болохын хувьд түүнд ажиллах гишүүн заавал хууль зүйн өндөр мэргэшилтэй байх;
- Цэцийн гишүүнээр ажиллах хүний нөөцийн дутагдлаас сэргийлэхийн зэрэгцээ Цэцийн гишүүн нэр дэвшүүлсэн, томилсон субъектээсээ хараат бус байх баталгааг хангахын тулд нэгээс дээш удаа дахин томилохыг хориглох;
- Цэцийн гишүүнд нэр дэвшигч шаардлага хангасан эсэхийг тодорхойлохын тулд томилгооны сонсгол заавал хийдэг байх;
- УИХ-ын олонх дангаар Цэцийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэх, хүлээн зөвшөөрөгдөөгүй хүнийг томилохоос сэргийлэхийн тулд Цэцийн гишүүдийг дийлэнх олонхын саналаар томилдог болох;
- Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг дэлхийн улсуудын шилдэг Үндсэн хуулийн шүүхийн сайн туршлагад нийцүүлэн нарийвчлан зохицуулах (жишээлбэл, өргөдөл, мэдээлэл, хүсэлт хуваарилах, бүрэлдэхүүн томилох асуудлыг тохиолдлын журмаар объектив шалгуураар шийдвэрлэхээр хуульчлах гэх мэт).

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахгүйгээр дээрх зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд заахыг Үндсэн хуулийн текст, түүний хамгийн сайн тайлбар зөвшөөрдөг.¹¹¹ ХБНГУ зэрэг үндсэн хуулийн хяналт амжилттай хэрэгждэг улсын сайн туршлагаар үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрх зүйн байдлын асуудлыг заавал Үндсэн хуульд нэг бүрчлэн заах албагүй бөгөөд ердийн хуулиар зохицуулж, цаг үеийн шаардлагаар боловсронгуй болгодог байна.

¹¹¹ Дараах бүтээлээс ердийн хуулиар дээрх асуудлыг зохицуулах боломжтой гэдгийг уншина уу: О.Мөнхсайхан, “Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь,” *Эрх зүй* №4 (36) (МУИС-Хууль зүйн сургууль 2016), 1-28; О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж,” *Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: өнөө ба ирээдүй*, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (УБ: Соёмбо 2015), 64-81; Munkhsaikhan O., *Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation* (2014).

Хоёрт, 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг (цаашид “Эрдэмтэн, судлаачдын ажлын дэд хэсэг” гэх)-ийн бичгээр өгсөн санал¹¹² туссан дараах агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулах боломжтой:

- Үндсэн хуулийн 65.1: “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улс Их Хурал шүүгчээс бусад хуульчдаас, гурвыг Ерөнхийлөгч хууль зүйн сургуулийн багш нараас, гурвыг Улсын дээд шүүх шүүгчдээс санал болгосноор Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар 9 жилийн хугацаатай томилох ба Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин томилохыг хориглоно” (эсхүл “Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэж заах).
- Үндсэн хуулийн 65.2: “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.”
- Үндсэн хуулийн 66.1: “Үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай иргэний өргөдөл (гомдол) нь Үндсэн хуулийн хувьд чухал ач холбогдолтой гэж Үндсэн хуулийн цэц үзвэл уул асуудлаар маргаан үүсгэж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу эцсийн шийдвэр гаргана.”
- Үндсэн хуулийн 66.2: “Үндсэн хуулийн цэц нь Улсын Их Хурлын нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хүний эрхийн үндэсний комисс, шүүхийн хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна...” (эсхүл хоёр шатат буюу УИХ руу дүгнэлт оруулдаг процедурыг бүрэн халж нэг шатат процедур руу шилжиж Цэцээс Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлаар хамаарлын зарчмын дагуу холбогдох этгээдийн хүсэлтээр шууд магадлан шийдвэрлэж, эцсийн шийдвэр гаргадаг болох хэрэгтэй).

¹¹² Эрдэмтэн, судлаачдын ажлын дэд хэсгийг ахлагчаар Л.Өлзийсайхан, нарийн бичгийн даргаар О.Мөнхсайхан, гишүүнээр П.Амаржаргал, А.Бямбажаргал, Д.Гангабаатар, Б.Гүнбилэг, О.Машбат, Х.Тэмүүжин, Д.Сүнжид, Ц.Цогт, С.Энхцэцэг ажиллаж дараах саналыг Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 65-76.

Эрдэмтэн, судлаачдын ажлын дэд хэсгийн эдгээр саналаас Үндсэн хуулийн 66.1, 66.2-т холбогдох хэсэг нь 2019.06.06-нд УИХ-д өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдаагүй, харин Үндсэн хуулийн 65.1, 65.2-т холбогдох хэсэг нь уул төсөлд тусгагдсан ч УИХ-ын хэлэлцүүлгийн явцад хасагдсан билээ. Үндсэн хуулийн 65.1, 65.2-т дээр дурдсан агуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулбал энэ нь Үндсэн хуулийн цэцэд одоо ажиллаж буй гишүүдийн эрх зүйн байдлыг дордуулах ёсгүй юм. Иймээс, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдсан тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуульд “Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь уул нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх өдрөөс өмнө томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүнд хамаарахгүй” гэсэн утгатай заалт оруулах хэрэгтэй. Аль ч тохиолдолд эрх бүхий этгээд хандаж маргаан үүсвэл Үндсэн хуулийн цэц өөрөө уул нэмэлт, өөрчлөлт батлагдахаас өмнө томилогдсон Цэцийн гишүүний эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, нэмэлт шаардлага, хориглолт нь зөвхөн дараа томилогдох гишүүдэд үйлчлэхээр шийдвэрлэх боломжтой.¹¹³

Үндсэн хуулийн цэцийн бие даасан, хараат бус, мэргэшсэн, хүний эрхийг хамгаалдаг байдлыг дээшлүүлэх талаарх Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн дээрх саналууд нь Эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсгийн төдийгүй бусад олон эрдэмтэн, хуульчийн дунд консенсус үүссэн шинэчлэл юм. Үндсэн хуулийн цэц болон үндсэн хуулийн хяналт гэсэн сэдвүүд нь Монгол Улсад сүүлийн 30 жилд үндсэн хуулийн эрх зүй дэх хамгийн их судлагдсан сэдвийн нэг. Дээр дурдсан санал нь энэ хугацаанд хийгдсэн олон арван судалгаагаар дэмжигдсэн юм. Жишээлбэл, Үндсэн хуулийн цэцэд иргэн мэдээлэл гаргадгийг хориглох, үүний оронд үндсэн хуулийн гомдлыг харьяалуулах, УИХ дахь цөөнхийн болон аль ч шатны шүүхийн хүсэлтийг Үндсэн хуулийн цэцэд гаргах боломжийг нээх, Цэцийн гишүүнээр хууль зүйн өндөр мэргэшилтэй, шүүгчээр ажиллах шаардлага хангасан хүнийг зөвхөн нэг удаа урт хугацаагаар (9 жилээр томилох) зэрэг саналыг хууль зүйн

¹¹³ 2016 онд УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд Цэцийн гишүүнээр ажиллах хүний насны дээд хязгаарыг хуульчлах нь Үндсэн хуульд нийцсэн гэж үзсэн боловч ийнхүү хуульчлах үед Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүмүүст уг заалт үйлчлэхгүй, Цэцийн гишүүний тэтгэвэрт гарах насыг тогтоосон хуулийн заалт буцаж үйлчлэхгүй гэж Цэц шийдвэрлэсэн нь Цэцийн гишүүнийг хараат бус байдлыг хамгаалсан юм. Үндсэн хуулийн цэцийн тогтоол, Дугаар 4, 2016.06.7

шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа,¹¹⁴ Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан, хуульч Д.Ганзориг,¹¹⁵ хууль зүйн доктор А.Бямбажаргал,¹¹⁶ Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан, хууль зүйн шинжлэх ухааны доктор Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан, доктор Д.Солонго тэргүүтэй олон эрдэмтдийн баг,¹¹⁷ хуульч Х.Тэмүүжин,¹¹⁸ хуульч Н.Энхцэцэг¹¹⁹ зэрэг олон судлаач дэвшүүлсэн. Үндсэн эрхийн маргааныг Цэцэд харьяалуулах санаа нь 2003 онд УИХ-аас баталсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт орж батлагдсан төдийгүй 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Хүний эрхийн үндэсний форум – 2021”-ээс гаргасан болон бусад олон санал, зөвлөмжид туссан билээ.

¹¹⁴ Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал* (УБ, 2005).

¹¹⁵ Д.Ганзориг, “Үндсэн эрхийн маргаан – Цэц шийдвэрлэх боломж, хандлага,” 2017.06.30, <https://www.conscourt.gov.mn/?p=4102>

¹¹⁶ А.Бямбажаргал, “Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам,” *Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм* дотор (УБ, 2019).

¹¹⁷ Ч.Энхбаатар, Том Гинсбург, П.Амаржаргал, М.Батчимэг, Ц.Даваадулам, О.Мөнхсайхан, Д.Солонго, *Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ* (УБ: Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, 2016), 206; Munkhsaikhan O., *Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation* (2014).

¹¹⁸ Х.Тэмүүжин, *Jus Frast буюу Ёсм үг* (УБ, 2003), 231;

¹¹⁹ Н.Энхцэцэг, “Абстракт хяналт ба Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын систем: Харьцуулсан судалгаа”, *Үндсэн хууль ба эрх зүйт ёс -II* (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2010), 19-23.

ҮНДСЭН ЭРХИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ НЬ: ХБНГУ-ЫН ТУРШЛАГА

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант,
“Легалдата” ХХК-ийн ТУЗ-ийн дарга
Т.АЛТАНГЭРЭЛ*

АГУУЛГА:

1. Оршил
2. Холбооны Үндсэн хуулийн шүүх
3. Иргэний гомдлоор хянах хууль зүйн үндэслэл
4. Үндсэн эрх ба түүний зөрчил, хязгаарлалт
5. Үндсэн эрхийн гомдлын хяналт, үр дагавар
6. Дүгнэлт

1. Оршил

Герман улс Дэлхийн 2-р дайны дараагаар хоёр хуваагдсан бөгөөд Баруун Герман нь ХБНГУ болж Үндсэн хуулиа анх 1949 онд баталсан түүхтэй юм. Тус Үндсэн хуульдаа ХБНГУ нь ардчилсан, социал төр улс¹ гэж тодорхойлсон. Социал төр гэдгийн агуулга үндсэндээ зах зээлийн эдийн засаг бүхий нийгмийн халамжийн хүчтэй тогтолцоог хэлэх бөгөөд ямар ч иргэн амьдралынхаа туршид ямар ч хүнд нөхцөлд орсон байлаа гэхэд тэр иргэн хүнийхээ хувьд эдийн засаг, нийгмийн халамжийн доод баталгааг эдлэх тухай хүн төвтэй төр улсын тухай ойлголт юм. Социал төр нь хүний эрхийн хамгааллын амин чухал үзэл баримтлал бөгөөд энэ агуулга нь Үндсэн хуулийн бүхий л хэсэгт тусгалаа олсон, харилцан шүтэлцээтэй оршиж байдаг.

ХБНГУ-ын Үндсэн хууль хамгийн эхний заалт буюу 1.1-т нь “хүн бүр эрхэм, халдашгүй эрх чөлөөтэй” гэж заасан байдаг нь тохиолдлын хэрэг өчүүхэн ч бус юм. Дэлхийн 2-р дайн болон тоталитар нийгмийн хар сүүдрээс гашуун сургамж авч, ардчилсан улсын суурь бичиг баримт болох Үндсэн хуулиа цоо шинээр бичиж боловсруулахдаа дахин ийм аюул дэгдэхээс бүрэн сэргийлэх, чингэхдээ аливаа төр улсаас хүний эрхийг дээгүүрт, хамгийн эхэнд эрэмбэлэхийг чухалчилсан хэрэг. Учир нь, дарангуйлагчид хуулийн нэрийг барин хүний эрх, эрх чөлөөг уландаа гишгэж, гэмт явдлаа зөвтгөж байсан нь эрх зүйн позитивист онолын сул тал гэж үздэг. Харин германы Үндсэн хууль нь хүний эрхийг жам ёсны эрхийн үүднээс тайлбарладаг буюу хүний эрхийг төрөөс хүнд олгож буй ямар нэгэн бэлэг биш харин хүн бүрд байгалиасаа төрмөл, өөрт нь заяагддаг эрхэм оршихуй гэж үздэг. Энэ агуулгаар нь хүний эрхийг төрийн байгуулалтын тухай зохицуулалтаас дээгүүр эрэмбэлсэн бөгөөд Үндсэн хуулиа ч энэ агуулгаар тайлбарлан хэрэглэдэг билээ. Тухайлбал, Үндсэн хуулийн 1.2-рт “Хүний эрхэм байдлыг дээдлэн хүндэтгэх, сахин хамгаалах нь төрийн бүх эрх мэдлийн үүрэг мөн²” гэж заасан байдгийг харвал хүний эрхийг дээдлэх үүрэгт хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл бүгд захирагдаж байна.

¹ ХБНГУ-ын Үндсэн хууль (1949), 20 дугаар зүйлийн 1.

² ХБНГУ-ын Үндсэн хууль (1949), 1 дүгээр зүйлийн 2.

2. Холбооны үндсэн хуулийн шүүх

Хүний эрхийг Үндсэн хуулийн шүүх гэх дагнасан шүүхээр хамгаалуулах тогтолцоо нь анх Австри улсын нэрт хуульч Х.Келзений байгуулж байсан австрийн үндсэн хуулийн шүүхийн уламжлалд суурилан ХБНГУ-д бий болсон бөгөөд өдгөө тус улсын Үндсэн хуулийн шүүх нь эх газрын эрх зүйн үндсэн хуулийн хяналтын гол төлөөлөл, орчин үеийн хамгийн амжилттай яваа шүүх болж чаджээ³. ХБНГУ-ын иргэдийн эрх нь дотооддоо Үндсэн хуулийн шүүхээр, олон улсад Европын Хүний эрхийн шүүхээр ижил сайн хамгаалагддаг нь тус улсын хүний эрхийн хамгааллын үзүүлэлт өндөр байхад шууд нөлөөлдөг.

Тухайлбал, ХБНГУ нь хүний эрхийн хамгаалал, хүний хөгжлийн үзүүлэлтээр дэлхийд тэргүүлдэг орнуудыг нэг юм. Freedom House 2022 оны хүний эрхийн байдлаар 100 онооноос 94, Дэлхийн шударга ёсны индекс (World Justice Project) 139 улсаас эхний 5-дугаарт, Дэлхийн банкны Хүний капиталын индексээр 1-с 0,8 оноо авсан үзүүлэлттэй байна. Ийнхүү хүний эрхийн хамгаалах тогтолцоо маш сайн хөгжсөн байгаагийн нэг томоохон шалтгаан нь хүний эрхийн үр дүнтэй, бодитой хамгаалалт юм. Тэгвэл энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэгч болох Холбооны Үндсэн хуулийн шүүх (Bundesverfassungsgericht) нь анх 1951 онд Карлсруэ хотод байгуулагдсан байдаг. Ийнхүү нийслэл хот Берлинээс хол байгуулсан нь түүнийг төрийн бусад эрх мэдлийн байгууллагаас хараат бус байдлыг хадгалахад зорилготой юм.

Хэдхэн жилийн өмнө Холбооны Үндсэн хуулийн шүүхийн 70 жилийн ой болж, тус байгууллага нь иргэдийн хамгийн их итгэл хүлээсэн, урт хугацаанд цаг үеийн олон сорилт, шалгуур, нийгмийн хөгжлийн үе шатыг амжилттай давж чадсан, жинхэнэ утгаараа хүний эрхийг тууштай сахин хамгаалагч, дээд хараат бус шүүх, Үндсэн хуулийн манаач болсон байна. Тийм ч учраас тус шүүхийн үйл ажиллагаа, гаргасан түүхэн шийдвэрүүд нь дотооддоо төдийгүй олон улсын тавцанд анхаарал, судалгааны төвд байж, нийгэм дэх хүлээсэн үүргээ үлгэрлэн биелүүлэгч болж чаджээ.

Бүтцийн хувьд Холбооны Үндсэн хуулийн шүүх (ХҮХШ) нь хоёр Сенаттай, тус бүр нь найман шүүгчдээс бүрддэг⁴. Сенатууд нь чиг үүргээ хуваан, нэгдүгээр Сенат нь төр иргэний харилцааны асуудлаар дагнадаг бол хоёрдугаар Сенат нь төрийн байгууллагын маргааныг шийдвэрлэдэг. Сенатын нэгдсэн хуралдааныг гол төлөв өмнө гарсан

³ ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн цахим хуудас, https://www.bundesverfassungsgericht.de/DE/Das-Gericht/das-gericht_node.html

⁴ Мөн тэнд.

шийдвэрийг өөрчлөх, эсвэл хоёр Сенатын санал зөрж буй тохиолдолд хийдэг байна.

Бүх асуудлаар Сенатын найман гишүүн оролцож шийдвэрлэх биш, харин Сенат нь дотроо гурван танхимтай (Kammern) бөгөөд эдгээр нь гол төлөв үндсэн эрхийн маргааныг тус бүртээ шийдвэрлэдэг.

ХҮХШ-ийн шүүгчийг парламентын хоёр танхим болох Бундестаг болон Бундэсратаас тэнцүү хувиар томилдог тогтолцоотой⁵.

Үндсэн эрхийн маргааныг ямар ч иргэн санаачилж гомдол гаргах эрхтэй бөгөөд

ийм маргаан нь жилд шийдвэрлэж буй маргааны дийлэнхийг буюу 70-90 хувь эзэлдэг байна. ХҮХШ нь үүсгэн байгуулагдсанаас хойшхи 70 жилийн түүхийн хугацаанд буюу 1951-2020 онуудад нийт 250.000 орчим гомдлыг авч хянасан байна. Нийт хянасан үндсэн эрхийн маргааны 3 % -ийг хангаж шийдвэрлэсэн байна⁶. Өөрөөр хэлбэл, ХҮХШ нь зөвхөн төрийн байгууллагын эрх зүйн маргаанаар дагнадаг байгууллага биш харин иргэд шууд хандах боломжтой ард түмний шүүх гэж хэлж болох юм.

3. Иргэний гомдлоор хянах хууль зүйн үндэслэл

ХБНГУ-ын Үндсэн хуульд хуулийн эрэмбэ их чухал үүрэгтэй бөгөөд тус хуулийн 1.3-р зүйлд төрийн бүх эрх мэдэл, үүнд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл бүгд Үндсэн хуульдаа захирагдана, тийм ч учраас тэдгээрийн гаргасан, Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй аливаа шийдвэрийг Холбооны Үндсэн хуулийн шүүх нь хянах эрхтэй байдаг. Үүнд, иргэний, захиргааны, эрүүгийн хэргийн шүүхийн эцэслэсэн шийдвэрүүд ордог бөгөөд ХҮХШ нь зөвхөн үндсэн эрхийн зөрчигдсөн эсэхийг Үндсэн хуулийн агуулгаар нь хянадаг аж. Хэнбугай ч (үүнд иргэн эсхүл хуулийн этгээд багтана) өөрийн үндсэн эрх зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрх нь Үндсэн хуулийн 19.4, 93.1.4а-д зааснаар нээлттэй байна. ХҮХШ нь хүний эрхийн зүйл заалтыг ихэнхдээ тодорхой хэрэг маргаанд тайлбарлах байдлаар хөгжүүлж иржээ.

ХҮХШ нь үндсэн эрхийн маргаанаас гадна үндсэн хуулийн байгууллагын маргааныг⁷, хэм хэмжээний хийсвэр хяналтыг эрх бүхий этгээдийн хүсэлтээр⁸, хэм хэмжээний тусгай хяналтыг шүүхийн

⁵ Мөн тэнд.

⁶Jurgen Brohme, ed., "70 Years German Basic Law: The German Constitution and its Court: Landmark Decisions of the Federal Constitutional court of Germany in the Area of Fundamental Rights" (Berlin: Duncker & Humblot GmbH, 2019)

⁷ ХБНГУ-ын Үндсэн хуулийн 93 дугаар зүйлийн 1.1.

⁸ ХБНГУ-ын Үндсэн хуулийн 93 дугаар зүйлийн 1.2.

хүсэлтээр⁹ гэх зэргээр нийт 19 төрлийн процессын ажиллагаа явуулдаг буюу өргөн хүрээний маргааныг харьяалан шийдвэрлэх эрхтэй байна¹⁰.

Үндсэн хуульд 1-19 зүйлд үндсэн эрхүүд, харин процессын эрхүүд 101-104 зүйлд хуульчлагдсан байдаг.

Үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн шүүх үүсгэх үндэслэл нь дараахь нөхцөлд бий болдог. Үүнд,

(1) хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн аливаа шийдвэр, үйлдэл, эс үйлдэл тухайн иргэний өөрийнх нь үндсэн эрхийг шууд, одоо зөрчсөн байж болзошгүй байх;

(2) гомдлын субсидиар байдал буюу бүх шатны шүүхээр хянагдаж эцэслэсэн, эсхүл захиргааны байгууллагын урьдчилсан хяналт хийгдсэн байх;

(3) тухайн шийдвэр гарснаас хойш нэг сарын хугацаанд гомдол гаргана.

Ямар ч иргэн шударга шүүхээр зөрчсөн эрхээ сэргээлгэх эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх боломжийг хангахын тулд ХҮХШ-д үндсэн эрхийн гомдол гаргахад тэмдэгтийн хураамж авдаггүй, өмгөөлөгч заавал оролцохыг шаарддаггүйгээрээ онцлогтой.

4. Үндсэн эрх ба түүний зөрчил, хязгаарлалт

Германы философич Георг Йеллинек нь хүний эрхийн сонгодог гурван үүргийг тодорхойлсон байдаг¹¹. Үүнд, хүний эрхийн үүрэг нь нэг талаас иргэний субъектив эрхийг төрийн халдагаас хязгаарлах зорилго агуулдагаараа негатив шинжтэй байна. Эл тохиолдолд төрийн үйлдэл, эс үйлдэл нь хүний эрхэд халдаж эсхүл хязгаарлаж буй явдал гэж үзнэ. Харин нөгөө талаас иргэн төргүйгээр эрхээ эдлэх боломжгүй нөхцөлд төр энэ боломжийг нь эрхийг нь хамгаалах, эдлүүлэх нөхцөлийг хүний эрхийн позитив шинжийн үүрэг гэнэ. Энэ төрлийн хүний эрхэд тухайлбал процессын эрхүүд хамаардаг. Гуравдугаарт, төр нь өөрөө идэвхтэйгээр нийгмийн гишүүн болох иргэний эрхийг биежүүлэх, хэрэгжүүлэх үүрэг бөгөөд үүнийг актив үүрэг гэнэ. Тухайлбал, жагсаал цуглаан хийх нийгмийн эрх хамаарна. Хүний эрхийн дээрхи сонгодог эрх зүйн онолоос хойш объектив эрх зүйн, либерал, социал төрийн өнцгөөс тайлбарлах байдлаар улам хөгжүүлсээр ирсэн байдаг. Хүний эрх нь төрийн гурван

⁹ ХБНГУ-ын Үндсэн хууль (1949), 100 дугаар зүйлийн 1.

¹⁰ ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 13-р зүйл

¹¹ Jellinek, Georg, "System der subjektiven Rechte", (Berlin: Verlag von Julius Springer, 1919), 87, 94.

эрх мэдлийн үйлдэл, эс үйлдэл, шийдвэр гаргах эрх хэмжээний хэмжээ хязгаарыг объектив байдлаар эрх зүйн аргаар хязгаарлаж байна.

Хүний эрхийн заалт нь Үндсэн хуульдаа мөнхийн заалт гэж оруулсан нь тэдгээрийг хууль тогтоогч өөрчлөх эрхгүй байдаг.¹² Хүний хамгаалал нь төр иргэн хоорондын, босоо шугамын, нийтийн эрх зүйн харилцаа гэж үздэг. Харин иргэд хоорондын эрх тэгш харилцаанд Үндсэн хууль шууд үйлчлэхгүй, харин тусгайлсан Иргэний хуулиар хамгаалагдана. Ингэхдээ иргэний эрх зүйн тохирсон аргаар нь хүний эрхийн хамгааллыг суулгаж өгдөг¹³. Иргэний эрх зүйн тэгш харилцаанд хэрэглэх Иргэний хуулийг үндсэн хуульд нийцсэн байдлаар тайлбарлах, хэрэглэхийг гуравдагч этгээдэд нөлөөлөх (*drittwirkung der Grundrechte*)¹⁴ зарчмын дагуу хүний эрхийг иргэний тэгш, хэвтээ харилцаанд авчирдаг.

Үндсэн хуулийн хамгийн эхний заалт буюу 1.1-р зүйлд хүний эрхэм, халдашгүй, эрх чөлөөт байдлыг тунхагласан. Ингэснээр энэ зүйл заалтыг үндэслэн хүний эрхийг хамгийн дээд, төр улсаас ч дээгүүр¹⁵ гэж үздэг. Хүний үндсэн эрхийн гомдол шийдвэрлэх нь дагнасан шүүх болох Үндсэн хуулийн шүүхийн харьяалах маргааны гол төрөл юм. Төрийн бүх эрх мэдэл хүний эрхийг хамгаалах нь шууд үйлчлэх эрх зүй гэдгээр дагаж мөрдөх үүрэг хүлээдгээрээ өмнө зөвхөн гүйцэтгэх эрх мэдэлд хамаарч байсан Ваймарын Үндсэн хуулиасаа ялгардаг.

ХБНГУ-ын төр эрх зүйн үндсэн ойлголт нь *Rechtstaat* нь эрх зүйт төр, англи хэл дээр *rule of law* хууль дээдлэх ёс нь дүйдэг ч тэрнээс илүү өргөн агуулгатай юм. Учир нь, англи америкийн эрх зүйд *rule of law* нь парламентын бүрэн эрхт байдал, төрийн дээд эрх мэдэл гэж үздэг бол германы эрх зүйд эрх зүйт төр нь төрийн бүх эрх мэдэл хүний эрхийг дээдлэх, хүний эрхийг зөвхөн хууль үндэслэн (*Vorrang des Gesetzes*) зөвхөн легитим, органик хуулиар хязгаарлах (*Vorbehalt des Gesetzes*), хязгаарлалт нь өөрөө тэнцвэрийн, зохистой байх зарчимд нийцэх (*Verhaeltnismaessigkeitprinzip*) ёстой гэсэн эрх зүйн өргөн утга агуулгыг илэрхийлдэг. Үүнээс харвал, германы үндсэн хуулийн эрх зүйд иргэн нь эрхээ эдлэхдээ төрөөс зөвшөөрөл авах бус харин төр нь иргэний үндсэн

¹² ХБНГУ-ын Үндсэн хуулийн 79-р зүйлийн 3.

¹³ Jurgen Brohme, ed., "70 Years German Basic Law: The German Constitution and its Court: Landmark Decisions of the Federal Constitutional court of Germany in the Area of Fundamental Rights" (Berlin: Duncker & Humblot GmbH, 2019)

¹⁴ Pieroth, Bodo, and Franz-Wilhelm Schlink, "Grundrechte Staatsrecht II", (Berlin: Verlag C.H. Beck, 2013), 173.

¹⁵ Jurgen Brohme, ed., "70 Years German Basic Law: The German Constitution and its Court: Landmark Decisions of the Federal Constitutional court of Germany in the Area of Fundamental Rights" (Berlin: Duncker & Humblot GmbH, 2019)

эрхийг хязгаарлахад хууль зүйн үндэслэл шаардаж байгаа нь хэдийнээ хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм¹⁶.

Төрийн эрх мэдлийн аливаа шийдвэр, үйлдэл, эс үйлдэл нь тэнцвэртэй, зохистой байх зарчимд нийцэж буй эсэхийг авч хянахдаа шүүх нь дараахь гурван өнцөгт хяналтын хүрээнд авч үздэг. Үүнд,

- (1) тухайн халдлага эсвэл хязгаарлалт хууль ёсны зорилготой эсэх;
- (2) хүний эрхийг хамгийн бага хөндөж буй эсэх;
- (3) зорилгод хүрэх арга нь зохистой, тохирсон байна.

Хэрвээ хоёр ба түүнээс дээш хүний эрх хоорондоо зөрчилдөх тохиолдолд төр аль алиныг нь хамгаалах үүрэгтэй бөгөөд үүнд практик зөвшилцөл (praktischer Konkordanz)-ийн зарчим хэрэглэнэ. Энэ нь зөрчилдөж буй хоёр эрхийн аль алиныг боломжит байдлаар хамгаалах хувилбарыг сонгох тухай юм. Энэ тухай Үндсэн хуулийн 98 -р зүйлд заасан байдаг.

Мөн Үндсэн хуулийн дотоод хязгаарлалт гэж байдаг. Энэ нь Үндсэн хуульд шууд нэрлээгүй хүний эрхийг бусад эрхийн хүрээнд агуулгаар нь хязгаарлах боломжтой юм¹⁷. Үүнийг *verfassungsimmanente Schranken* гэж нэрлэдэг.

5. Үндсэн эрхийн гомдлын хяналт, үр дагавар

Үндсэн хууль нь иргэдийн өдөр тутмын амьдралын хэсэг буюу бодитойгоор хэрэгждэг амьд эрх зүй юм. Учир нь, Үндсэн хуулийг эрх зүйн онол болон хэрэглээ талаас нь тайлбарлаж, тодорхой хэрэг маргаанд хэрэглэдгээрээ ХҮХШ нь онцлогтой шүүх юм. Иргэн хүн тус хуулийн 93.1.4а -г үндэслэн үндсэн эрхийн гомдлыг тус шүүхэд гаргана. Гомдлын хяналтыг авч үзэхдээ дараахь дарааллыг баримталдаг. Үүнд,

- (1) Зөрчигдсэн байж болзошгүй хүний эрхийг хүрээг тодорхойлох;
- (2) Үндсэн эрхийн зөрчил бий болсон эсэх (хувь хүн болон маргааны зүйлийг хянана);
- (3) Төрийн эрх мэдлийн халдлага нь хуульд үндэслэсэн эсэх, органик хуулиар тухайн эрхийг хязгаарласан эсэх, халдахыг зөвшөөрсөн эсэх (Schranke)
- (4) Хуулийн хязгаарлалтыг хязгаарлах нь (Schranken-Schranke тэнцвэрийн зохистой харьцааны шалгуурыг ашиглах)

¹⁶ Pieroth, Bodo, and Franz-Wilhelm Schlink, "Grundrechte Staatsrecht II", (Berlin: Verlag C.H. Beck, 2013), 13.

¹⁷ Мөн тэнд, 252.

ХШҮХ нь Үндсэн хуулийг тайлбарлахдаа үгийн утгын, системчилсэн тайлбар хийнэ (бусад зүйл заалт, текстийн хүрээнд), эцэст нь хуулийн зорилго, агуулгыг авч үзнэ.

Үндсэн эрхийн маргааныг ХҮХШ нь шийдвэрлэх эрх зүйн үр дагавар нь тухайн үндсэн эрхийг зөрчсөн гэж үзвэл тухайн шийдвэр, хууль журам, захиргааны актыг хүчингүй болгох эрхтэй байдаг бөгөөд төрийн бүх эрх мэдэл тухайн шийдвэрийг дагаж мөрдөх үүрэгтэй. Шүүхийн шийдвэрийг Холбооны дээд шүүх рүү буцаах бөгөөд үндсэн хууль зөрчсөн шүүхийн шийдвэрийг цааш хэрхэхийг тухайн шүүхийн бүрэн эрхийн асуудал болж хувирдаг. ХҮХШ нь өөрөө ямар ч хохирол барагдуулах эсвэл эрүүгийн ял оноох шийдвэр гаргадаггүйг анхаарах нь зүйтэй.

ХҮХШ нь түүхэндээ маш олон нийгэм, эдийн засаг, хүний эрхийн өндөр ач холбогдол бүхий шийдвэр гаргаж байсан бөгөөд хүний эрхийн зүйл заалт бүрийг ийнхүү бодит хэрэг бүрээр тайлбарлаж хөгжүүлж иржээ. Тухайлбал, хувь хүний халдашгүй байх эрх чөлөө болон урлах, бүтээх эрх чөлөө хоёрын асуудлаархи Мефисто (Mephisto) хэрэг, үндэсний тооллогын үеэр хувь хүний мэдээлэл өгөх эрх, эхийн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх болон үр хөврөлийн амьд явах эрхийн талаархи абортын хэрэг, жагсаал цуглаан хийх Брокдорфийн хэрэг зэрэг олон тооны анхаарал татсан түүхэн шийдвэрүүдийг гаргасан байдаг¹⁸.

6. Дүгнэлт

ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаанд хуулийн эрэмбэ, дараалал чухал үүрэг гүйцэтгэж, Үндсэн хуулийн хяналтыг системтэй, эмх замбараатай болгож байгаараа их онцлогтой байна. Төрийн бүх эрх мэдэл (хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх) Үндсэн хуульд захирагдаж, Үндсэн хуулийн биелэлтийг дагнасан шүүхээр хэрэгжүүлж, бүх эрх мэдлийн шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн эсэхэд ХҮХШ нь хянах бүрэн эрхтэй байна.

Иргэн бүр үндсэн эрхээ хамгаалуулахаар ХҮХШ-д хандах нь хийсвэр, онолын, нэрийн төдий биш харин маш бодитоор, өөрт нь шууд эрх зүйн үр дагавар үүсгэх тодорхой процессын механизм ажиллаж байна. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь хууль зүйн шинжлэх ухааны онол, практикийн асар их ач холбогдолтой бөгөөд нэн тэргүүнд тухайн улсынхаа ёс суртахуун, зарчим, үндэсний үндэсний үнэт зүйл

¹⁸ ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн цахим хуудас, https://www.bundesverfassungsgericht.de/DE/Das-Gericht/das-gericht_node.html

тайлбарлаж байгаагаараа нийгэмдээ түүхэн үүрэг хүлээдэг. Иймдээ ч хэдэн арван жил өнгөрсөн ч ард иргэдийнхээ итгэлийг даасан төрийн гол институци болж чадсан бөгөөд нийгэмд хувь хүний эрх болон нийтийн эрх ашиг тэнцвэрийг хангах чухал үүргийг хэрэгжүүлэгч гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

*Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн
Г.БАЯСГАЛАН*

Монгол Улс ардчилсан шинэ тогтолцоонд шилжин эрх зүйт төрийг бүрдүүлэх үндэс болсон шинэ Үндсэн хуулийг 1992 онд батлахдаа Үндсэн хуулийн цэц нэртэй Үндсэн хуулийн шүүхийг байгуулсан билээ. Энэ нь дэлхийн ардчилсан олон улс орнуудын түгээмэл чиг хандлагад нийцсэн цоо шинэ институтийг Монгол Улсад анх бий болгосон түүхэн ололт болсон юм. Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийг хэлбэрэлтгүй сахин хамгаалахын тулд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг хянаж, төрийн эрх мэдлийг зохистой хязгаарлах, хүний хөндөгдсөн, эрхийг сэргээн тогтоох чадамжтай байгууллага байх ёстой. Энэ хүрээнд авч үзвэл Үндсэн хуулийн цэцийн эрх зүй нь зарим талаар уг шаардлагыг хангаж чадахгүй байна.

Шинэ Үндсэн хууль баталсны дараа 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Бага Хурлаас Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг, 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг тус тус баталж, Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг эдгээр хуулиар зохицуулж ирсэн. Үндсэн хуулийн цэц байгуулагдсанаас хойших 30 жилийн хугацаанд уг 2 хуульд зарим нэмэлт, өөрчлөлт орсныг эс тооцвол Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, үндсэн зарчимтай уялдуулан, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэлийн үйл явцыг тусгасан дорвитой өөрчлөлт хийгдээгүй өнөөдрийг хүрсэн байна. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэж ирсэн туршлага, энэ талаарх онолын суурь болон харьцуулсан судалгаа хийгдээгүй үед дээрх хуулиудыг баталсныг дурдах нь зүйтэй. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг дэлхийн бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн нийтлэг жишигт ойртуулах, үндсэн хуулийн эрх зүйн маргааныг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлэн онолын түвшинд, хараат бус, үнэн зөв, бодитой шийдвэрлэх эрх зүйн орчин, бусад баталгааг

бүрдүүлэх, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжлийг шинэ шатанд гаргах хэрэгцээ шаардлага энэ цаг үед зүй ёсоор үүсээд байна.

Иймд энэхүү илтгэлийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам гэсэн сэдвийг тухайлан авч үзэж, энэ талаар нээлттэй, шинжлэх ухаанч, алсыг харсан хэлэлцүүлэг өрнүүлэхийг зорьсон болно.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” хэмээн заасан.

Уг заалтыг задалж үзвэл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол

1. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих
2. Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах
3. Үндсэн хуулийн маргааныг магадлан шийдвэрлэх гэсэн бүрэн эрх бүхий байгууллага
4. Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа гэсэн харьцангуй бие даасан томъёоллыг илэрхийлсэн гэж үзэхээр байна.

Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргээ энэ хуульд заасан маргааны талаар дүгнэлт гаргах, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргааныг магадлан шийдвэрлэх замаар хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнээс үзэхэд, органик хуулиар Үндсэн хуулийн цэцийн чадамжийг хязгаарласан уу гэх асуудал үүсэх бөгөөд Үндсэн хуульд тусгасан Үндсэн хуулийн цэцийн “Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих” бүрэн эрхийн агуулгыг тодорхойлох, цаашлаад дүгнэлт гаргах, магадлан шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх механизмыг ялгамжтай зөв тогтоосон эсэхийг нягтлах, нэгдсэн ойлголтод хүрэх асуудал чухал байна. Үндсэн хуулийн цэцийн хяналтын хүрээг Үндсэн хуулийн зохицуулалт, түүгээр илэрхийлсэн ойлголтын хүрээнд өргөжүүлэх чиглэлээр Үндсэн хуулийн процессыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хоёр. Эрх зүйт төр бүхий нийгэмд Үндсэн хууль нь тогтвортой, нийгмийн харилцааг бодитой зохицуулах гол нөхцөл бол түүний биелэлт үр дүнтэй байх явдал юм. Тиймээс Үндсэн хуулийн биелэлтийг хангаж, шууд үйлчлэх хэм хэмжээ болгох зорилгоор Үндсэн хуулийн хяналтыг бий болгосон гэж үздэг. Дэлхийн улс орнуудын Үндсэн хуулийн

хяналтын тогтолцоо, загвар харилцан адилгүй байх хэдий ч Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангаж, Үндсэн хуульт ёсыг хамгаалах эрхэм зорилгын хувьд нийтлэг шинжтэй бөгөөд иргэдийн үндсэн эрхийн хамгаалах гол механизм болж иржээ.

Эрдэмтэн судлаачдын холбогдох бүтээлийг судлан үзэхэд Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг өргөтгөх буюу иргэний үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэх нь зүйтэй гэсэн байр суурьтай хүмүүс цөөнгүй байна.

Үүний зэрэгцээ, Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэх маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл болон салбар хуулиар тогтооходоо жагсаалт гаргах байдлаар буюу “тоочих” хэлбэрээр тусгасан нь харьяалан шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлэх буюу иргэний үндсэн эрхийг хяналтыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байгааг дурдаад, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг Үндсэн хуульдаа нэгэнт тоочиж заасан тул Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар уг асуудлыг бүрэн шийдвэрлэх боломж хомс гэсэн байр суурьтай эрдэмтэд ч байна.

Үндсэн хуульт ёсыг үр нөлөөтэй хамгаалах чухал хүчин зүйл нь иргэдээс үндсэн эрхийн талаарх гомдлоо гарган шийдвэрлүүлэх боломжтой байх явдал юм. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий Монгол Улсын Үндсэн хуулийн цэц үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэдэг байх нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг хамгаалах гол механизм тул уг эрхийн хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, боловсронгуй болгох нь Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлын нэг гэж үзэхээр байна.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяа “Иргэдийн өргөдөл, мэдээллийн институт Үндсэн хуулийн процессын эрх зүйн гол бүрдүүлбэр, үндсэн хуулийн шүүхийн хяналтын утга учрыг илэрхийлдэг, хяналтын хамгийн гол хэлбэрт тооцогддог.”¹ гэж иргэдээс Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах асуудал нь Үндсэн хуулийн эрх зүйн гол судлагдахуун, үндсэн институт болохыг тодорхойлон тусгасантай илтгэгч санал нэг байна.

Гагцхүү Монголын нөхцөлд уг асуудлыг хэрхэн зохицуулах прагматик шийдлийг олох нь чухал байна.

¹ Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал*, (УБ, 2005), 122

Гурав. Үндсэн хуулийн биелэлтийг хянадаг бие даасан шүүхийн тогтолцоо нь Үндсэн хуулийн хяналт үр дүнтэй хэрэгжих шалгарсан тогтолцоо бөгөөд Үндсэн хуулиар хамгаалсан эрх мэдэл хуваарилах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх, институтийн тэнцлийг хангах нэг гол баталгаа болж чаддагаараа бусад хэлбэрээс давуутай байдаг онцлогтой. Тодруулбал, эрх мэдлийн тэнцлийг хангах Үндсэн хуулийн шаардлагыг онол, практикийн хувьд хангахуйц, илүү үр ашигтай хувилбар нь дээрх загвар гэдэгт олон эрдэмтэд санал нийлдэг байна.

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх гол хэлбэрүүд нэгэнт тогтож, тэдгээрийн онцлог, шинж чанарт нь үндэслэн холбогдох эрх зүйн механизм, зохицуулалт хөгжиж ирсэн, тухайлбал, Үндсэн хуулийн шүүхийн хяналтын үндсэн хэлбэр бол хэм хэмжээний хяналт бөгөөд энэ нь дотроо урьдчилсан болон батлагдсаны дараах хяналт, негатив хяналт, хийсвэр /абстракт/ болон тодорхой хяналт гэж ангилдаг нь хууль зүйн шинжлэх ухаанд хэдийнээ хүлээн зөвшөөрөгджээ. Түүнчлэн үндсэн эрхийн маргаан, төрийн өндөр албан тушаалтын импичмент буюу Үндсэн хуулиар олгосон эрх мэдлийг урвуулан ашигласан эсэх маргаан, эрх мэдэл хоорондын зөрчилдөөн, улс төрийн намын, сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэдэг.

Дээр дурдсан хяналтын хэлбэрүүд нь өөр өөрийн онцлогтой бөгөөд үр нөлөөний хувьд ч харилцан адилгүй. Иймд улс орон бүр Үндсэн хууль, Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулиа батлахдаа эдгээр хэлбэрүүдээс өөрийн орны онцлог, Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх зорилттой уялдуулан хуульчлан тогтоож хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хэрэгжүүлж буй хяналт нь дээр дурдсан хэм хэмжээний хяналт, тэр дундаа хийсвэр хяналтын хэлбэрийг гол төлөв агуулдаг. Мөн негатив болон тодорхой хяналтыг хэрэгжүүлсэн цөөн тохиолдол байдаг.

Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн хяналтыг шүүхээс хэрэгжүүлэх уг тогтолцоог нэгэнт хүлээн авсан орны хувьд уг тогтолцооны боломжийг дутуу дулимаг бус бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, чадамжийг нь нийгэмдээ үр нөлөөтэй ашиглах хэрэгтэй бөгөөд энэ хүрээнд хяналтын дээрх хэлбэрүүдийг Үндсэн хуулийн цэцээс хэрэгжүүлэх боломжийг нээх, холбогдох процессыг тодорхой болгох шаардлага байна. Тухайлбал, негатив хяналтыг хэрэгжүүлэх нь буруу гэсэн шүүмжлэл гарч байсан, тэгвэл ямар хүрээнд уг хяналтыг хэрэгжүүлэх вэ гэдэг талаарх тодорхой зохицуулалтыг хуульчлах, шалгуурыг Үндсэн хуулийн процессын эрх зүйн нийтлэг хандлагын хүрээнд тогтоох нь зүйтэй юм.

Дөрөв. Дэлхий дахинаа Үндсэн хуульт ёсны төлөвшилд Үндсэн хуулийн шүүхийн үүрэг нэн өндөрт тавигдаж, төрийн эрх барих байгууллага, албан тушаалтнуудын хууль дээдлэх хэмжүүр, үндсэн хуульт ёсны төлөвшлийн баталгаа болж байна. Үндсэн хуульт ёс, Үндсэн хуулийг дээдлэх болон хуулийг сахин биелүүлэх, хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах явдлыг хангах шаардлагад үндэслэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадлыг Үндсэн хуулиар баталгаажуулан тодорхойлсон байдаг. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь тухайн асуудлаар цаашид нийтээр дагаж мөрдөх, удаан хугацаанд үйлчлэх, жишиг тогтоох хандлагатай байдгаараа бусад байгууллагын шийдвэрүүдээс онцлог төдийгүй нийгэмд үзүүлэх нөлөө ихтэй, иргэд болон албан тушаалтнуудын хууль дээдлэх чиг хандлагыг тодорхойлж өгдгөөрөө онцлог.

Үндсэн хуульт ёс /мөн Парламентат ёс ч мөн адил/ болон хууль дээдлэх зарчим төрийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болон хөгжиж байгаа тул төрийн байгууллагын зүгээс илт Үндсэн хууль зөрсөн байдлаар шийдвэр, үйл ажиллагаа явуулах нь хомс болж байна. Иймд уг нөхцөл байдлыг харгалзан төрийн үйл ажиллагааны олон талд хандлагатай уялдуулан Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн олон төрөл бий болж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Үндсэн хуулийн шүүхийн нөхцөл заасан шийдвэр (Conditional decision)-ийн хэлбэр улам бүр хөгжиж байна. Энэ мэт хандлагыг нэвтрүүлэх асуудал Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйд тулгамдаж байна.

Ех тунс, ех-нунс зарчмыг зохистой уялдуулах, эрх зүйн актыг анхнаас нь хүчингүй болгох тохиолдол байхыг үгүйсгэхгүй, үүний процессын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд Үндсэн хуулийн цэц ч энэ алхмыг хийж 2021 онд 01 дүгээр тогтоолоороо Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийг хүчингүй болгохдоо ашиглаж, хүний эрхийг хамгаалсан жишиг тогтоосон шийдвэр гаргасныг дурдъя.

Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэц дараах маргааны хянан шийдвэрлэж байна. Үүнд:

- хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;
- ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв

байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

- Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;
- 4/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

Дээрх бүрэн эрхийн талаарх зохицуулалтыг Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяа дүгнэхдээ “Цэц одоо үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хууль тогтоох эрх мэдлийг бүхэлд нь (хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр), гүйцэтгэх эрх мэдлээс зөвхөн заримыг (зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр) нь хянах эрхтэй, харин шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэрийг хянах боломж хуульчлагдаагүй байна”² гэсэн байдаг нь Цэцийн харьяалан шийдвэрлэх маргааны өнөөгийн байдлыг тодорхой илэрхийлсэн дүгнэлт болсон байна.

Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн хяналтыг бүрэн гүйцэт, иж бүрэн хэрэгжүүлэхэд шүүх болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтыг шийдвэр, үйл ажиллагааг тодорхой хязгаартайгаар Үндсэн хуулийн хүрээнд хянах боломжийг Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжийн хүрээнд олгож процессжуулах боловсронгуй болгох асуудал анхаарал татаж байна.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн болон процессын хуулиар иргэдээс гаргах өргөдөл, мэдээлэл, гомдлыг агуулгыг тухайлан тодорхойлж томъёолсон зүйл байхгүй. Харин Үндсэн хуулийн процессын эрх зүйн хувьд иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөж байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх аль ч асуудлаар Үндсэн хуулийн цэцэд **өргөдөл** гаргах бол, өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөөгүй боловч нийтийн ашиг сонирхлын үүднээс Үндсэн хуулийн цэцэд хандахдаа **мэдээлэл** ирүүлдэг гэж тайлбарладаг. Харин эрх бүхий байгууллага албан тушаалтан Үндсэн хуулийн цэцийн харьяаллын аль ч асуудлаар хүсэлт гаргах боломжтой гэж хуульчилсан. Гэтэл Үндсэн хуулийн процессын эрх зүйн хүрээнд Үндсэн хуулийн шүүхэд хандах хамаарлын зарчмыг баримталдаг нийтлэг жишигтэй бөгөөд өөрт шууд

² Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал* (УБ, 2005), 122-129

хамааралгүй асуудлаар хандах нь улс төрийн болоод хувийн сонирхол, ашиг сонирхлын бусад хүчин зүйл нөлөөлж, шүүхэд зохиомол ачаалал үүсгэнэ гэж үздэг. Иймд Үндсэн хуулийн цэцэд хандах хамаарлын зарчмыг хүлээн зөвшөөрч, өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах шалгуур, шаардлага хүрээг тогтоох нь шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандахдаа хэрэглэж байгаа хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар л хандах зэргээр тодорхой хүрээг тогтоох боломжтой.

Долоо. Одоо мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрхтэй. Гэтэл Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хандсан тохиолдол 30 жилийн хугацаанд нэг ч удаа гараагүй байна. Энэ нь Улсын Их Хурал олонхоороо баталсан хууль, шийдвэрийнхээ талаар олонх нь санал нэгдэж Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянуулахаар Цэцэд хандах үндэслэл байдагтай холбоотой. Иймд Улсын Их Хуралд бүлэг байгуулах тооны гишүүн Үндсэн хуулийн цэцэд хандах буюу цөөнхийн үндэслэлийг харгалзан үзэх боломжийг Үндсэн хуулийн процессын хүрээнд олгох боломжтой юм.

Мөн дээр дурдсан хамаарлын зарчмаар хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэр, мөн сонгуулийн үр дүн болон мандатад нөлөөлж болох Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн, түүнчлэн эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн буюу түүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэж үзвэл Улсын Их Хурлаас тодорхой тооны гишүүд хүсэлт гаргаж болохоор тусгаж болно.

Найм. Цэцийн бие даасан, гишүүний хараат бус, эрх тэгш байдлыг хангах үүднээс шүүхийн нийтлэг жишгийн дагуу Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуваарилах болон Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилохдоо урьдчилан тогтоосон журмын дагуу тойргийн зарчмаар хуваарилах шинэчлэлийг хийх шаардлага тулгарч байна. Энэ нь цэцийн бие даасан, хараат бус байх зармын гол баталгаа болно. Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж Цэцийн нэг гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг дангаараа шийдвэрлэдэг өнөөгийн журам нь дэлхийн бусад улс оронд байхгүй жишиг юм. Иймд процессын эрх зүйн нийтлэг хандлага, Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны ерөнхий зарчмын хүрээнд Цэцийн бага суудлын хуралдаанаар дээрх асуудлыг шийдвэрлэх асуудлыг судлан үзэх нь зүйтэй .

Ес. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь хууль ёсны хүчин төгөлдөр болсноор буюу эцсийн шийдвэр гарснаар заавал биелэгдэх шинж чанартай болдог. Ингэснээр бусад этгээд /аливаа байгууллага албан тушаалтан, иргэн хэн ч/ төдийгүй Үндсэн хуулийн шүүх өөрөө ч дагаж мөрдөх, биелүүлэх агуулгыг өөртөө агуулж байдаг. Уг зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлд баталгаажуулсан.

Гэсэн хэдий ч онолын хүрээнд Үндсэн хуулийн шүүх нь өөрийн шийдвэрээрээ Үндсэн хуулийн асуудлыг иж бүрэн шийдэж чадаагүй, эсвэл шинэ нөхцөл байдал үүсгэх боломж нь нээлттэй гэж үздэг. Ийм тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг дахин хянан үзэх боломжийг тодорхой шалгуурын хүрээнд нээж өгч хуульчилдаг жишиг байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд “шинэ нөхцөл байдал илэрсэн” гэж тодорхойлсныг хэрхэн авч үзэхийг тодруулах шаардлагатай гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлд маргааныг дахин хянан шийдвэрлэх үндэслэлийг хуульчилсан бөгөөд эдгээр үндэслэлээр хуралдаанд бэлтгэх шатнаас эхлэн дахин хянан шийдвэрлэхээр заасан. Үүнд:

- 1/Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй;
- 2/урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасан;
- 3/шинэ нөхцөл байдал илэрсэн.

Дээрх үндэслэл бүрдсэн бол Цэцийн дарга маргааныг дахин хянан шийдвэрлэх тухай тогтоол гарган Их суудлын хуралдаан хийхээр заасан боловч ямар процессоор тухайн ажиллагааг явуулах талаар, тухайлбал хэрхэн Цэцийн гишүүдийн олонхын саналыг хэрхэн тооцох зэрэг асуудал нь хуулиар тодорхой бус буюу хийдэлтэй зохицуулагдсаны улмаас өнгөрсөн 30 жилийн хугацаанд уг зохицуулалт хэрэгжээгүй статистик байна.

Бусад улсын практикаас харахад нөхцөл байдал өөрчлөгдөх /change of circumstance/, шинээр илэрсэн нөхцөл байдал буюу нотлох баримт илэрсэн /newly discovered evidence/ гэх 2 нөхцөлд дахин хянан шийдвэрлэх тохиолдлыг тухайн улсын онцлогтой уялдуулан өөр өөрөөр тодорхойлсон байна. Мөн Үндсэн хуулийн хяналтын хүрээнд авч үзвэл маргааныг дахин хянан үзэх буюу өмнөх шийдвэрийг хянах боломжийг тодорхой нөхцөл зааж хуульчлах тохиолдол байх бөгөөд overruling хэлбэрээр, харин нотлох баримттай холбогдох асуудлаар /үндсэн эрхийн маргаанд гол төлөв/ re-open case гэсэн агуулгаар авч үзсэн байна.

Иймд Үндсэн хуулийн процессын эрх зүйн хүрээнд Үндсэн хуулийн шинжтэй маргааныг дахин хянан шийдвэрлэх ойлголт, үндэслэл, журам, процессыг тодорхой болгох хуульчлах шаардлагатай байна.

Нэгтгэж дүгнэхэд, эрх зүйт төрийн үндсэн зорилт бол хүний үндсэн эрх, эрх чөлөөг хувь этгээдээс эхлээд төр, түүний эрх бүхий байгууллага, албан тушаалтан, нийгмийн олонх, хувь хүн ер нь хэн ч бай хүндэтгэн хүлээн зөвшөөрөх, тийм нөхцөл байдлыг нийгмийн болон эрх зүйн тогтолцооны хүрээнд бий болгох явдал байдаг. Энэхүү зорилт нь зөвхөн Үндсэн хуульдаа хүний эрх, эрх чөлөөг тодорхойлон баталгаажуулснаар хангагдахгүй. Харин хүний эрхийг шүүхийн журмаар хамгаалах механизмыг зүй зохист байдлаар хөгжүүлж чадвал илүү баталгаажих юм. Энэ үүднээс Үндсэн хуулийн Цэцийн процесс ажиллагааг өөрийн орны онцлогтой уялдуулан дэлхий нийтийн эрх зүйн хөгжил, түгээмэл чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох нь чухал байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД (ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД)

*Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
Тамгын газрын Хууль зүйн газрын дарга
Н.БОЛОРТУНГАЛАГ*

АГУУЛГА

1. Оршил
2. Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат ба тулгамдаж буй асуудлууд
 - 2.1. Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг урьдчилан шалгах шат
 - 2.2. Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааны шат буюу гомдлыг урьдчилан шалгах ажиллагаа
 - 2.3. Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд бэлтгэх шат
 - 2.4. Маргааныг Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хэлэлцэх шат
 - 2.5. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлт
 - 2.6. Маргааныг дахин хянан шийдвэрлэх
3. Дүгнэлт

1. Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг хэлбэрэлтгүй сахин хамгаалах зорилгоор төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллагууд болон эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаа, шийдвэр Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг хянаж, түүнд нийцүүлж эрх баригчдын эрх мэдлийг хязгаарлах, хүний хөндөгдсөн, хязгаарлагдсан эрх, эрх чөлөөг сэргээн тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Уг бүрэн эрхээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин чухал нөлөөтэй.

Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг зохицуулсан анхдагч эх сурвалж нь Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль бөгөөд уг хуулийн Тавдугаар бүлэг Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон байдаг.

Шинэ Үндсэн хууль баталсны дараахан 1992 оны 5 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Бага Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг, 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг тус тус баталж, Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг дээрх хоёр хуулиар зохицуулж ирсэн. 1992 оноос одоог хүртэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд 1996, 1997, 1999, 2003, 2005, 2015, 2016, 2020, 2021, 2022 онуудад нийт 11 удаа, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд 2005, 2009, 2015, 2016, 2020, 2021(2 удаа), 2022 онд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч эдгээр өөрчлөлтийн хүрээнд нь агуулга, зарчмын томоохон өөрчлөлт ороогүй юм. Харин өнөөдрийн байдлаар үйлчилж байгаа нийт хуулийн 118 хуульд Үндсэн хуулийн цэцийн талаарх хэм хэмжээг тусгасан байна.

Үндсэн хуулийн хяналтыг шүүхийн журмаар хэрэгжүүлж байсан туршлага байхгүй, Үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжөөгүй байсан үед анх Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хуульд материаллаг болон процессын хэм хэмжээг хамт хуульчилсан байсан. Харин 1997 онд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг баталснаар процессын зохицуулалтыг дээрх хуулиас тусгаарласан боловч зарим зохицуулалт нь одоо ч тухайн хуульд хэвээр байгаа билээ. Энэ нь зарим процесс ажиллагаанд материаллаг хуулийг хэрэглэх, эсхүл дээрх хоёр хуулийг хамт хэрэглэх байдлыг үүсгэдэг. Тухайлбал, Монгол Улсын

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийг энд дурдаж болно.

Үүнээс үзэхэд Үндсэн хуулиар тодорхойлсон Үндсэн хуулийн цэцийн чиг үүрэг болон Үндсэн хуулийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуулийн цэцийн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна. Цаг хугацааны хувьд 1992 оноос хойш бусад материаллаг салбарын төдийгүй, процессын хууль тогтоомж бүхэлдээ 1-2 удаагийн давтамжтай шинэчлэгдэн хөгжиж ирсэн байхад Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг хөнжил зогсонги байгаа нь шүүмжлэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулгын төслийг боловсруулах ажил 2013 оноос эхэлсэн хэдий ч өнөөдрийг хүртэл бодит үр дүнд хүрээгүй байна. Харин 2019 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, 2021 оны 11 дүгээр сард Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дэргэд Үндсэн хуулийн цэцийн талаарх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд тодорхой ажиллагаа хийгдэж эхлээд байгаа бөгөөд энэхүү эрдэм шинжилгээний хурлыг мөн зохион байгуулж байгаад талархалтай байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат ба тулгамдаж буй асуудлууд

Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд зааснаар тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлдэг. Иймд Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгарч байгаа асуудал, сорилтыг эдгээр үе шатын хүрээнд тодорхой системтэйгээр танилцуулж, холбогдох саналаа тухай бүр илэрхийлэхийг зорилоо.

Холбогдох хууль болон Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг судлан үзэхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах үе шат буюу дараалалттайгаар хэрэгжиж байна. Үүнд:

1. Урьдчилан шалгах шат:

-Иргэдийн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага албан тушаалтны хүсэлтийг хүлээн авах;

-өргөдөл мэдээлэл хүсэлтээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэх буюу урьдчилсан шалгалтыг хийх;

-маргаан үүсгэх эсэх талаар шийдвэр гаргах.

2. Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааны шат /Энэ шатанд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх эсэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэдэг учир эрх зүйн үр дагавар буюу агуулгын талаас нь авч үзвэл урьдчилан шалгах үе шатны нэг дэд хэсэг гэж үзэж болно/

3. Маргаан үүсгэсэн асуудлаар Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд бэлтгэх шат /энэ үе шатыг Дунд суудлын хуралдаанд бэлтгэх болон Их суудлын хуралдаанд бэлтгэх гэж тус тусад нь үе шат болгох боломжтой боловч эрх зүйн зохицуулалтыг хүрээнд уг үе шатыг заагласан зохицуулалт байхгүй тул нэг үе шат болгон авч үзлээ/

4. Маргааныг Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хэлэлцэх шат /дээрх тайлбар мөн адил хамаарна/

5. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буюу дүгнэлт, тогтоол гаргах, биелэлтийг хангах шат /мөн ялгаатай үе шатаар авч үзэх боломжтой боловч нийтлэг зохицуулалт үйлчилдэг/

6. Хууль заасан үндэслэлээр маргааныг дахин хянан шийдвэрлэх шат зэрэг болно.


Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй шийдвэрлэвэл зохих, хүндрэлтэй асуудлыг дээрх үе шаттай нь уялдуулан дараагийн хэсэгт тусгалаа.

2.1. Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг урьдчилан шалгах шат


Үндсэн хуулийн цэцэд хандах

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчсөн маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсвэл Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэдэг.


Монгол Улсын Үндсэн хуулийн цэц анх байгуулагдсан 1992 оноос өнөөг хүртэлх буюу 2021 оныг дуусталх хугацаанд 3500 орчим өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч хянасан байна. Харин Үндсэн хуулийн цэцэд хандах эрх бүхий байгууллага, албан тушаалтан буюу Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос 25 гаруй хүсэлт ирсэн нь нийт хандсан өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлын 0.7 хувийг эзэлж байна. Энэ хугацаанд Улсын Их Хурлаас хүсэлт ирж байгаагүй болно.



Үндсэн хуулийн цэцэд хандсан байдлыг төрлөөр нь харуулбал,



ХҮСЭЛТ ИРҮҮЛСЭН БАЙДАЛ



Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандах иргэдийн хандлага өөрчлөгдөн, тэднээс ирүүлж буй өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн тоо жил

ирэх тутам улам өсөн нэмэгдэж байна. Цэц байгуулагдсан эхний жилүүдэд нэг жилдээ 20 гаруйхан өргөдөл, мэдээлэл ирдэг байсан бол одоо сардаа л үүнээс хэд дахин их болж, ирж буй өргөдөл, мэдээллийн хууль зүйн үндэслэл, нотолгоо ул суурьтай болж хөгжиж иржээ.



Ирсэн өргөдөл мэдээллийн 10-аад хувьд нь маргаан үүсгэн хянан шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна. Бусад 90 хувь нь Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй, эсвэл бусад байгууллагын эрх хэмжээний асуудал байдаг.

Үндсэн хуулийн цэц нь шүүх болохын хувьд эрх бүхий этгээд хандсанаар Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлнэ. Үндсэн хуулийн цэцийн дарга агсан доктор, профессор Г.Совд “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар” номдоо “Үндсэн хуулийн цэц маргааныг хянан шалгаж дүгнэлт гаргах үйл ажиллагааг тодорхой үндэслэлээр хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан эрх бүхий субъектийн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг үндэслэн үүсгэн явуулдаг. Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг өөрийн санаачилгаар явуулбал шүүх биш яллах байгууллага болж хувирахад хүрнэ.”¹ гэсэн байдаг.

Нэр томъёоны хувьд иргэний өргөдөл, мэдээлэл, түүнчлэн гомдлын талаар Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг зохицуулсан хоёр хуульд тухайлан тодорхойлоогүй байна. Харин эрх зүйн толь бичгүүдэд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд

¹ Г.Совд, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар”, (УБ, 1999), 12-13

заасан агуулгаар өргөдөл, мэдээлэл, гомдол гэсэн ойлголтыг тусгайлан тодорхойлсон байна².

Харин Үндсэн хуулийн процессын эрх зүйн хувьд иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөж байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх аль ч асуудлаар Үндсэн хуулийн цэцэд **өргөдөл** гаргах бол, өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөөгүй боловч нийтийн ашиг сонирхлын үүднээс Үндсэн хуулийн цэцэд хандахдаа **мэдээлэл** ирүүлнэ. Харин иргэний Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөл, мэдээллийн хүрээнд маргаан үүсгэхээс татгалзсан шийдвэрийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн гаргасан бол өргөдөл, мэдээлэл гаргагч иргэн дээрх шийдвэрийг эс зөвшөөрч **гомдол** гаргана. Мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяалал тогтоохоор Цэцэд хандахдаа гомдол гаргахаар заасан байдаг.

Үндсэн хуулийн цэцэд хандах хэлбэр, онцлог

Цэцэд хандах хэлбэр	Агуулга, онцлог	Гаргах эрх бүхий этгээд	Шийдвэрлэх
Өргөдөл	Иргэн өөрийн эрх, ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөж байна гэж Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандах хэлбэр	Монгол улсын иргэн, хууль ёсоор оршин суугаа харьяалалгүй	Цэцийн гишүүн урьдчилан шалгаж маргаан үүсгэх эсэхийг

² С.Нарангэрэл, *Монголын эрх зүйн эх толь бичиг*. (УБ, 2015), 113, 270, 340, "өргөдөл" гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх заалтад зааснаас бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг ойлгоно. Өргөдөл нь санал, мэдэгдлийн шинжтэй байж болно. "санал" гэж төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг;

"мэдэгдэл" гэж Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан хүсэлтийг;

"гомдол" гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг тус тус ойлгоно гэж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлээр тодорхойлсон.

Мэдээлэл	Иргэн өөрийн эрх, ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдсөнөөс бусад үндэслэлээр буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандах хэлбэр	хүн, гадаадын иргэн	нь шийдвэрлэнэ.
Гомдол	Цэцийн гишүүний маргаан үүсгэх эсэх талаарх тогтоолыг эс зөвшөөрч хандах хэлбэр	Цэцийн гишүүний маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх шийдвэрийг эс зөвшөөрсөн өргөдөл, мэдээлэл гаргагч, эсхүл хариуцагч тал	Гурван гишүүний бага суудлын хуралдаанаар шийдвэрлэнэ.
Хүсэлт	Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлаар хэлбэр	Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын	Цэцийн гишүүн шууд маргаан үүсгэнэ.

Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүхийн журмаар хэрэгжүүлдэг бусад улс орны туршлага, эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд нийтлэг байдлаар аливаа иргэн Үндсэн хуулийн шүүхэд хандахдаа зөвхөн өөрт хамаарах асуудлаар буюу өөрийн эрх, эрх чөлөө нь “зөрчигдсөн” гэх үндэслэлээр хандахаас бус, өөр бусад иргэн, нийтийн эрх ашгийн өмнөөс хандах эрхгүй байдаг. Торуулбал, өөрт хамааралтай байх, шууд байх, одоо цагт байх, шаардлагатай арга

хэмжээг авсан байх зэрэг нөхцөлийг хангаж Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргадаг.

Харин Монгол Улсын хувьд дээр дурдсан хязгаарлалт байдаггүй онцлогтой. Ийнхүү иргэн хүн Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх аль ч асуудлаар хандах өргөн эрхтэй байдгаараа бусад улсын Үндсэн хуулийн шүүхээс онцлогтой. Энэ талаар Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан, академич Ж.Болдбаатар Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийг тайлбарласан эрдэм шинжилгээний тайлбартаа “Иргэн хүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлаар ямар нэг тусгай нөхцөл, болзол шаардлагагүйгээр Цэцэд шууд хандаж болдог. Учир нь энэ талаар хуульд ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй. Энэ эрх Монгол Улсын иргэд төдийгүй, Монгол Улсын нутагт хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд олгосон байдгаараа зарим орны Үндсэн хуулийн шүүхээс онцлог юм.”³ гэсэн байдлаас харж болно.

-Уг онцлог нь зарим “давуу тал”-ыг агуулдаг боловч бодит байдал дээрээ хэд хэдэн сөрөг үр дагаврыг үүсгэж байдаг. Үндсэн хуулийн цэцийн практикийг судлан үзэхэд дараах дутагдалтай тал ажиглагдаж байна. Үүнд:

(1) Иргэний зөрчигдсөн үндсэн эрх бүрэн сэргээгдэх боломж дутмаг байх.

2014 онд иргэн Л-ын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдлийн дагуу Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зөвхөн өмгөөлөгчөөр уламжлан Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхээр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтыг зөрчсөн эсэх маргааныг 2014 онд шийдвэрлэсэн. Иргэн Л нь дээрх зохицуулалтыг улмаас Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлж чадаагүй бөгөөд өмгөөлөгчийн шаардсан үйлчилгээний хөлсийг эдийн засгийн боломжгүйн улмаар хяналтын шатны шүүхэд хуулийн хугацаанд гомдол гаргаж чадаагүй байдаг. Үндсэн хуулийн цэц энэ маргааныг хэлэлцээд Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний өөрийгөө өмгөөлөх эрх болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхийг зөрчсөн хэмээн үзэж тухайн заалтыг түдгэлзүүлж улмаар УИХ-аас уг заалтыг өөрчилсөн боловч бодит амьдрал дээр иргэн Л-ын зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлж чадаагүй юм. /Эрх зүйн зохицуулалтын хувьд

³ Ж.Амарсанаа нар, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, Ханнс-Зайдел сан, (УБ, 2008), 281

ийм боломж байхгүй бөгөөд Цэцийн шийдвэр гарсан цагаас хойш үйлчилдэг (ex nunc) зарчим/

(2) Цэцэд хандах уг эрхийг зүй бусаар буюу бусад ашиг сонирхлын үүднээс /олон нийтэд танигдах, улс төр, нам зорилгоор гэх мэт/ ашиглах, аливаа нэг захиалга, даалгавартайгаар өргөдөл, мэдээлэл гаргах,

(3) Үндсэн хуулийн цэцэд зохиомол ачаалал үүсгэх зэрэг болно.

Эрх зүйн хэм хэмжээний онолыг үндэслэгч Ханс Кельзен нийтийн эрх ашгийг илэрхийлсэн мэдээллийн талаар дүгнэж хэлэхдээ “нийтийн эрх ашгийг илэрхийлсэн мэдээлэл /actio popularis/ нь Үндсэн хуулийг хамгаалах хүчирхэг баталгаа юм. Гэвч ийм мэдээлэл гаргагч нь өөрийн эрхээ зүй бусаар ашиглах өндөр магадлалтай, мөн Үндсэн хуулийн шүүхэд ийм мэдээлэл ихээхэн ачаалал үүсгэх эрсдэлтэй байдаг”⁴ гэж үзэж тэрээр ийм зохицуулалтыг дэмждэггүй байжээ.

Монгол Улс ч энэ хүрээнд Үндсэн хуулийн процессын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар Үндсэн хуулийн цэцэд хандах эрх бүхий этгээдийг тодорхой болгох боломжтой юм. Тухайлбал, иргэн эрх зүйн акт, албан тушаалтан⁵ Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргана. Харин албан тушаалтныг огцруулах асуудлаар бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүсэлт гаргах эрхтэй байхаар холбогдох маргаан тус бүрд хандах эрх бүхий этгээдийг судалгаанд үндэслэн тодорхойлон хуульчлах боломжтой юм.

Иймд дээр дурдсан нөхцөл байдлуудыг судлан үзэж Үндсэн хуулийн цэцэд хандах эрх бүхий этгээдийн хандах асуудлын хүрээ, хамаарлыг процессын хуулиар тогтоох нь зүйтэй байх бөгөөд хуулийн хүрээнд өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлтийн агуулгын тодорхой болгон Үндсэн хуулийн цэцэд хандах зохицуулалтыг нарийвчлан хуульчилснаар дээр дурдсан зарим асуудлуудыг шийдвэрлэх боломжтой байна.

-Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах ажиллагаа

Үндсэн хуулийн цэцийн гишүүн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авч урьдчилан шалгана, харин хүсэлтийг хүлээн авсан гишүүн **шууд** маргаан үүсгэн шалгана гэж хуульд заасан. Үүнийг Үндсэн хуулийн цэцэд хандаж буй иргэн, нөгөө талаас эрх бүхий байгууллага, албан

⁴ Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт”, орчуулсан Г.Баясгалан, Д.Сугар, Д.Одбаяр, (УБ, 2014), 63

⁵ Монгол Улсын Үндсэн хууль (1992), Жаран зургадугаар зүйлийн 2.

тушаалтны хууль зүйн боловсрол, мэргэшсэн байдал, ажлын албаны ялгаатай байдалтай холбож тайлбарладаг.

Өргөдөл, мэдээллийн урьдчилан шалгах ажиллагааг Цэцийн гишүүн 14 хоногийн дотор явуулахаар хуульчилсан.⁶ Харин хүсэлтээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа “шууд үүсгэнэ” гэж хуульчилсан нь хүсэлтийг хүлээн авмагц аливаа ажиллагаа явуулахгүй нэн даруй үүсгэх, эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзахгүй гэсэн агуулгатай эсэх дээр санал зөрөлдөх тохиолдол практикт гардаг. Иймд дээрх “шууд” гэсэн ойлголтын агуулгыг тодорхой болгох шаардлага үүсжээ.

Мөн хуульд заасан дээрх 14 хоногийн хугацаа төдийлөн оновчтой бус буюу богино юм. Өргөдөл, мэдээлэлд тусгасан асуудал нь Үндсэн хуулийн маргаан мөн эсэхийг тогтоохын тулд холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тайлбар, тодорхойлолт, лавлагаа бичгээр авах, ижил төстэй хэргийн лавлагаа судалгаа хийх зэрэг тохиолдолд уг хугацаа хангалтгүй байдаг. Үүнээс шалтгаалан уг хугацааг сунгах тохиолдол олон гардаг бөгөөд нийтлэг заалтыг баримтлан хугацааг сунгадаг нь гомдол, шүүмжлэл гаргах үндэслэл болж байна. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийн 70 гаруй хувийг нэг гишүүний тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байдаг. Эдгээрийн 40-50 орчим хувьд нь урьдчилан шалгах хугацааг сунгасан үзүүлэлттэй байна.

Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах нь Үндсэн хуулийн зөрчлийг таслан зогсоох гол хөшүүрэг болоод зогсохгүй, нөгөө талаас ач холбогдолгүй хүнд процесс буюу эрх зүйн үр дагаваргүй хуралдаан хийхээс сэргийлэх, улмаар бусад маргааны талаар үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлнэ. Иймд уг хугацааг нэмэх шаардлагатай юм. Бусад улсад уг хугацааг 30 ба түүнээс дээш хоног байхаар зохицуулсан нь нийтлэг байна. Тухайлбал, ОХУ-д урьдчилсан судалгааг 2 сарын дотор хийдэг бол Австри, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бусад шатуудын адил тодорхой хугацаа заадаггүй байна. БНСУ-ын тухайд иргэдийн гомдлыг урьдчилан шалгаад 30 хоногийн дотор Бага суудлын бүрэлдэхүүнээс татгалзсан шийдвэр гаргаагүй бол үүссэнд тооцдог зохицуулалт үйлчилдэг.⁷

Өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах шатанд Цэцийн гишүүн чухам ямар ажиллагаа хийх талаар хуульд тодорхой заагаагүй. Иймд

⁶ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, 21.2

⁷ БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, Арт. 72

тухайн асуудлыг бүрэн дүүрэн, судалгаанд үндэслэн шийдвэрлэхийн тул холбогдох ажиллагааг Цэцийн гишүүд хийж ирсэн бөгөөд энэ хүрээнд хуралдаанд бэлтгэх явцад хийгдэхээр хуульд заасан ажиллагаануудаас аль шаардлагатайг явуулдаг жишиг тогтоод байгаа. Иймд хуулийн хийдлийг даван туулсан уг практикийг харгалзан, холбогдох журмыг хуульчлах, эсхүл тухайн шатны онцлогт тохирсон ажиллагааг хуульд тодорхойлон тусгах нь зүйтэй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар Цэцэд хандах эрх бүхий этгээд нь эрх зүйн байдлын хувьд ямар онцлогтой болох, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрх, хүлээх үүрэг нь ялгаатай эсэхийг тодорхойлон хуульчлаагүй. Дээрх хуулийн 18 дугаар зүйлд Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг хуульчилсан боловч Үндсэн хуулийн цэцэд хандах хэлбэр /өргөдөл, мэдээлэл, хүсэлт/-тэй нь уялдуулан авч үзээгүй, нийтлэг байдлаар зохицуулсны зэрэгцээ, шаардлагаасаа аль ч шатанд татгалзах эрхтэй⁸ байхаар хуульчилсан.

Онолын хувьд нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүхэд, тэр дундаа Үндсэн хуулийн шүүхэд хандахад диспозитив зарчим тодорхой хүрээнд хязгаарлагдаж, тухайн хүсэлт, мэдээллээсээ татгалзах эрхийг хаадаг. Үүний нэг илрэл бол Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно.” гэж заасан. Учир нь нийтийн ашиг сонирхлын үүднээс гаргасан хүсэлт, мэдээлэл, нэхэмжлэлд өөрт хамааралтай байх, шууд байх, шаардлагатай арга хэмжээг авсан байх зэрэг хүнд шаардлага тавигддаггүй тул улс төрийн зорилгод ашиглах, хууль бус нөлөөлөл үзүүлэх зорилгоор хандах, далд байдлаар ашиг сонирхлын зөрчил, авлигын асуудал хөндөгдөх магадлалтай байдагтай холбоотой.

Цэцийн практикт ч дээрх онолын хүрээнд шийдвэр гаргасан нэг тохиолдол байдаг. Засаг даргыг томилсон Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамжид холбогдох маргааныг 2018 онд Их суудлын хуралдаанаар хянан шийдвэрлэхэд дээрх үзэл баримтлалын дагуу иргэн С-ийн татгалзлыг хүлээн авахгүйгээр маргааныг хянан шийдвэрлэж 02 дугаар тогтоолыг гаргасан байдаг. Гэтэл 2021 оны 02 дугаар тогтоолоор уг үзэл баримтлалыг эсрэгээр нь хэрэгжүүлсэн байна. Иймээс уг асуудлыг нэг мөр болгон нарийвчлан хуульчлах хэрэгтэй бөгөөд хууль тогтоомжоор илүү дэлгэрүүлэн зохицуулах, онол, үзэл

⁸ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, 18.4

баримтлалын хувьд Үндсэн хуулийн эрх зүйн судлаачдын түвшинд нийтлэг ойлголт, хандлагатай болох шаардлага байгаа нь мөн харагдаж байна.

Өнөөгийн нийгмийн чиг хандлага, тулгарч буй сорилт (цар тахал, цахим хөгжил, техник, технологийн хурдацтай дэвшил гэх мэт/-той уялдуулан дэлхийн бусад улсын туршлагын дагуу Үндсэн хуулийн цэц иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, мэдээлэл, гомдол авах боломжийг хуульчлах шаардлага мөн өсөн нэмэгдэж байна. Өнөөгийн практикт цахим шуудан ашиглан өргөдөл, мэдээлэл хүлээн авч байгаа боловч энэ нь Цэцийн тухай хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөөгүй, иймд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг⁹ нийтлэг байдлаар хэрэглэн хүлээн авч байна.

Бусад улс оронд Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах хандлага нийтлэг болсон байна. Тухайлбал, ОХУ, БНСУ-д өргөдөл, гомдол хүлээн авах ажиллагааг цахим программ нэвтрүүлэн шийдвэрлэсэн байна.

-Маргаан үүсгэх эсэх талаарх шийдвэр гаргах

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт маргаан үүсгэхээс татгалзах 4 үндэслэлийг заасан. Гэвч Цэцийн гишүүний маргаан үүсгэхээс татгалзах тухай тогтоолд уг үндэслэлээс дурдаагүй байх тохиолдол байдаг. Энэ нь процессын эрх зүйн онол, чиг хандлагын хүрээнд Үндсэн хууль болон Цэцийн тухай хууль дахь “өөрийн санаачилгаар” гэсэн ойлголтын хүрээнд Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхэд хамаардаг. Тодруулбал, тухайн хандсан асуудал нь хэдийгээр Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарч байгаа боловч Цэцийн гишүүн тухайн асуудлаар урьдчилсан шалгалт хийгээд уг асуудал нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг **илт** зөрчөөгүй буюу Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй, маргаан үүсгэх шаардлагагүй гэсэн итгэл үнэмшилд хүрсний үндсэн дээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тохиолдлууд байгаатай холбоотой.

Дээр дурдсан “илт” гэдгийн хэмжүүр, шалгуурыг нэг мөр болгох боломж ярвигтай асуудал. Үндсэн хуулийн хяналт бүхий орнуудын Үндсэн хуулийн эрх зүйн процесс, түүний дотор өргөдөл хүлээн авах,

⁹ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 9.1, 12.3

түүнийг урьдчилан шалгах явцад “илт” гэсэн томъёоллыг хэрэглэсэн тохиолдлууд байдаг. Австри, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулиар тухайн асуудал Үндсэн хуулийн шүүхийн харьяаллын бус нь илт, Үндсэн хуулийн маргааны шинжийг илт агуулаагүй байвал өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг буцаах тохиолдол олонтой гардаг байна. Гэхдээ бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн зохицуулалтуудыг судлан үзэхэд шүүгч дангаараа шийдвэрлэдэг зохицуулалт төдийлөн байдаггүй бөгөөд бүрэлдэхүүнээрээ шийдвэрлэдэг хандлага тогтсон байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт маргаан үүсгэхээс татгалзах 4 үндэслэлийн хоёр нь хэлбэрийн шинжтэй буй Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны зүгээс хариу өгч, бүрдүүлбэр хангуулах боломжтой үндэслэл байдаг. Иймд энэ талаарх зохицуулалтыг тодорхой болгох, мөн хуулийн шаардлага хангасан бөгөөд харьяаллын асуудлаар хандсан боловч уг асуудал нь илт үндсэн хуулийн маргааны шинжгүй бол хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг процессын хуульдаа тусгах боломжтой байна.

Бусад улсын туршлагыг судлан үзэхэд ихэнх тохиолдолд маргаан үүсгэх эсэх асуудлыг бүрэлдэхүүнтэйгээр 3-5 шүүгч шийдвэрлэдэг бөгөөд санал нэгтэй татгалзсанаас бусад тохиолдолд маргаан үүссэнд тооцдог зохицуулалт нийтлэг байна. Харин Монгол Улсын хувьд өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж байгаа Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах асуудлыг дангаараа шийдвэрлэж байгаа нь Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар шийдвэрлэх ёстой маргааныг орхигдуулах эрсдэлийг дагуулна. Иймд бүрэлдэхүүнтэйгээр буюу Бага суудлын хуралдаанаар маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй юм.


Дээрх нөхцөл байдлыг дүгнэн үзвэл, Үндсэн хууль зөрчсөн талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд иргэн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүсэлт гаргах, тэдгээрийг хүлээн авах, урьдчилан шалгах, түүнд холбогдох хугацаа, маргаан үүсгэх асуудлыг шийдвэрлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх үүргийн талаарх зохицуулалтыг гадаад болон дотоодын шүүхийн жишигт ойртуулан илүү боловсронгуй болгох шаардлага Үндсэн хуулийн процессын эрх зүйд тулгарч байна. Тухайлбал, өргөдөл, мэдээлэл, хүсэлт гэх нэр томъёог хуульчлах, хамаарлын зарчмыг тогтоох, тус тусын онцлогтой нь уялдуулан тодорхой шаардлагыг тодорхойлох, мөн өргөдөл, мэдээлэл гаргагчийн маргаан үүсгэхээс татгалзах үндэслэл, журмыг тодорхой болох, уг

асуудлыг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх, урьдчилан шалгах хугацааг бодит байдалтай уялдуулан тогтоох зэрэг тулгамдсан асуудал байгааг шийдвэрлэх хэрэгтэй байна.


2.2. Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааны шат буюу гомдлыг урьдчилан шалгах ажиллагаа

Иргэний гаргасан өргөдөл, мэдээллийн хүрээнд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэхээс татгалзсан шийдвэрийг Үндсэн хуулийн цэцийн нэг гишүүн гаргасан бол Үндсэн хуулийн процессын эрх зүйн хүрээнд өргөдөл, мэдээлэл гаргагч иргэн дээрх шийдвэрийг эс зөвшөөрч **гомдол** гаргана. Гэхдээ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар зөвхөн маргаан үүсгэхээс татгалзсанаас гадна маргаан үүсгэсэн шийдвэрт маргагч буюу хариуцагч тал гомдол гаргах боломж нь нээлттэй байхаар хуульчилсан байдаг.

Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тоон үзүүлэлтээс харахад өнгөрсөн 30 жилийн хугацаанд нийт шалган шийдвэрлэсэн өргөдөл, мэдээлэлтэй харьцуулахад 14.5 хувьд нь гомдол гаргасан дундаж үзүүлэлттэй байна.



Дээрх зохицуулалт (21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг¹⁰)-ад “Үндсэн хуулийн цэцэд маргаан **үүсгэх эсэх талаарх** гишүүний шийдвэр” гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь Цэцийн гишүүний маргаан үүсгэсэн болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан



шийдвэрийн аль аль нь хамаарах агуулгыг илэрхийлж байна.

Үүнээс улбаалан практикт Цэцийн гишүүний маргаан үүсгэсэн тогтоолд гомдол гаргасан тохиолдлууд гарсан бөгөөд ийнхүү гомдол гаргах нь тухайн маргааныг хянан шалгах ажиллагаанд саад учруулах, хугацаа алдах, Дунд суудлын хуралдаанд бэлтгэх ажиллагааг тасалдуулах, ачаалал үүсэх зэрэг олон сөрөг үр дагавартай. Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрсөн эсэх асуудлаар маргаан үүсгэхэд тухайн этгээд өөрөө гомдол гаргасан тохиолдол гарч байсан боловч Бага суудлын хуралдаанаас Цэцийн гишүүний маргаан үүсгэсэн шийдвэрийг хэвээр үлдэхээр шийдвэрлэсэн байдаг¹¹.

Үүсгэсэн маргааныг Цэцийн хуралдаанаар хэлэлцэхэд маргаан үүсгэсэн үндэслэл мөн хянагддаг тул дээрх ажиллагаа нь хууль зүйн хувьд ач холбогдолгүй. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх эсэх талаарх гишүүний шийдвэр” гэсэн ойлголтыг зөвхөн “Үндсэн хуулийн цэцэд маргаан

¹⁰ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (1997), 21 дүгээр зүйлийн 4; Өмнө нь энэ хэсэгт байсан Цэцийн аль нэг гишүүн санал гаргах талаарх зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар дүгнэлтээр Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 46 дугаар тогтоолоор уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн

¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Дугаар 08, 2007.06.20.

үүсгэхээс татгалзсан гишүүний шийдвэр” гэж цаашид ойлгон хэрэглэх, эсхүл энэ агуулгаар уг заалтыг өөрчлөх хэрэгтэй юм.

Мөн дээрх хуульд өргөдөл, мэдээлэл гаргагч нь Цэцийн гишүүний тогтоолыг эс зөвшөөрсөн тохиолдолд ямар хугацаанд гомдол гаргах талаарх зохицуулалтыг тусгаагүй бөгөөд практикт хоёр, гурван жилийн дараа гомдол гаргасан тохиолдол бий. Гэтэл бусад улсын үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд хэлбэрийн шаардлага хангаагүй гэж буцаасан зэрэг шийдвэрт гомдох боломжит хугацааг 60-90 хоног байхаар тогтоосон туршлага байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд эс зөвшөөрч гомдол бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.” гэж заасан. Тодруулбал, “маргагч талууд” маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрт гомдол гаргахаар заасан нь бодит байдалд нийцээгүй. Учир нь маргаан үүссэн тохиолдолд оролцогч талууд нь маргагч тал болох бөгөөд дээрх тохиолдолд маргаан үүсгээгүйтэй холбогдуулан гомдол гаргаж буй тул “маргагч тал” гэх нэр томъёог хэрэглэх нь үндэслэлгүй юм. Харин уг гомдлыг гаргах эрх нь өргөдөл, мэдээлэл гаргагч иргэнд хадгалагдаж байгаа билээ.

Мөн хуульд Бага суудлын хуралдааны талаарх тусгай зохицуулалтыг хуульчлаагүй. Тодруулбал, дээр дурдсан 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан ерөнхий зохицуулалтаас өөр хэм хэмжээг хуульд тусгаагүй учир гомдлыг Бага суудлын хуралдаанаар хэлэлцэх, уг хуралдаанд бэлтгэх ажиллагаатай холбоотой асуудлыг Дэгээр зохицуулж байсан. Хуулийн уг тодорхой бус байдал нь зарим тохиолдолд хууль хэрэглээний зөрүү үүсгэх, гомдол гаргагч нар үндэслэлгүй гомдол, санал гаргах зэрэг маргаантай байдлыг үүсгэж, процесс ажиллагааны хүндрэлийг бий болгож ирсэн. Иймд хуулийн энэхүү хийдэлтэй байдлыг арилган, Бага суудлын хуралдаан болон тухайн хуралдаанд бэлтгэх ажиллагаатай холбоотой зохицуулалтыг процессын хуульд тусган хуульчлах, дээр дурдсан “маргагч тал” гэх нэр томъёог өөрчлөх шаардлагатай байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд

гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан байдаг боловч тухайн ажиллагааг явуулах процесс ажиллагаа, холбогдох журмыг хуульчлаагүй. Иймд Дэгийн хүрээнд уг асуудлыг зохицуулсан бөгөөд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяалал тогтоолгох тухай “гомдол”-ыг өргөдөл, мэдээллийн нэгэн адил хүлээн авч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэн, маргаан үүсгэсэн тохиолдолд Дунд суудлын хуралдаан хийхээр Дэгээр зохицуулсан байдаг.

Тухайн заалт хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш иргэдээс 30 гаруй удаа хэргийн харьяалал тогтоолгохоор хандсан байна. Харин 2005, 2010, 2017 онд холбогдох гомдлын дагуу маргаан үүсгэн Дунд суудлын хуралдаан хийжээ. Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн 2005 онд 03, 2010 онд 08 дугаар магадлалаар тус тус иргэний гомдлын хүрээнд хэргийн харьяалал тогтоох үндэслэлгүй байна гэсэн шийдвэрийг гаргасан байна. Харин 2017 оны 11 дүгээр магадлалаар нэр бүхий иргэдийн гомдлын хүрээнд /12 шүүгчийн асуудал/ хэргийн харьяалал тогтоож, Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад зааснаар (хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэцээс шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх) Улсын дээд шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн боловч тухайн асуудлыг хэлэлцэх журмыг хууль тусгаагүй байна гэсэн үндэслэлээр шийдвэрлээгүй байна.

Агуулгын хувьд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа буюу шүүхүүдээс тухай асуудлыг шийдвэрлэхээс татгалзаж байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох асуудал ердийн шүүхийн тогтолцооны хүрээнд шийдвэрлэх асуудал учир Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэх нь үндэслэлгүй юм. Мөн хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох бүрэн эрхийг Улсын дээд шүүх хэрэгжүүлэхээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлд (25.7.4) шинээр тусгаж өгсөн байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хүчингүй болгох нь хууль тогтоомжийн нэгдмэл байдлыг хангах, Цэц болон Улсын дээд шүүх зэрэгцээ ажиллагаа явуулах, үр дүнгүй ачаалал бий болгохоор сэргийлэх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад зааснаар хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг Улсын дээд шүүх хянан шийдвэрлэх бүрэн эрхийн хэрэгжүүлэхээр заасан. Гэтэл дээр дурдсан тохиолдлоос харахад уг

бүрэн эрхийг хэрэгжүүлэх процессын зохицуулалтыг холбогдох хуулиудад тусгаагүйгээс Үндсэн хуулиар тодорхойлсон Улсын дээд шүүхийн энэхүү бүрэн эрх тунхаг төдий болгож үлджээ. Иймд Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомж болон Шүүхийн тухай хууль, холбогдох процессын хуульд энэ талаарх хэм хэмжээг тусгах хэрэгтэй байна.

2.3. Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд бэлтгэх шат

Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмууд нь холбогдох хуулиудад хэт ерөнхий томъёологдсон байдаг. Үндсэн хуулийн цэц нийтийн эрх зүйн маргааныг шийдвэрлэдэг тул энэхүү онцлогтой уялдуулан шүүх нотлох зарчим Цэцэд үйлчлэх ёстой. Энэ үндэслэлээр холбогдох процессын хуульд уг зарчмыг тусгах, Үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэж байгаа маргааны мөн чанар, агуулга, шийдвэрийн үр дагаврын онцлогтой нь уялдуулж бусад зарчмын агуулга болон хэрэгжүүлэх хүрээг тодорхой болгох зэргээр шийдвэрлэвэл зохих асуудлууд байна. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд бэлтгэх шатанд гүйцэтгэх ажиллагаа буюу нотлох баримт цуглуулах талаарх эрх зүйн зохицуулалт нь хуульд ерөнхий байдлаар тусгасан бөгөөд холбогдох ажиллагааны талаарх нарийвчилсан хэм хэмжээг хуульчлаагүй.

Тодруулбал, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлд Цэцийн хуралдаанд бэлтгэх явцад гүйцэтгэх ажиллагааг тоочих маягаар хуульчилж, тодорхой журмын дагуу хэрэгжүүлэх ажиллагааг /үзлэг, нэгжлэг хийх, энэ талаарх даалгаврын холбогдох шүүх, эрх бүхий байгууллагад өгөх гэх мэт/ тусгаагүй буюу нарийвчилсан журмыг тодорхойлоогүй билээ. Иймд энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгон хуралдаанд бэлтгэх ажиллагааны одоогийн зохицуулалтыг сайжруулах, талуудын (маргааны нэг тал нь иргэн, нөгөө тал нь төрийн байгууллага, албан тушаалтан байдаг) тэгш байдлыг хангаж нотлох баримтад холбогдох хэм хэмжээ, зарчмыг илүү тодорхой болгох нь Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг шүүхийн жишигт ойртуулах, Үндсэн хуулийн процессын эрх зүйн нийтлэг хандлагад нийцэхэд чухал нөлөөтэй юм.

Түүнчлэн маргааныг нэгтгэх, тусгаарлах маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох, хуралдаан хойшлуулах зэрэг ажиллагаа болон холбогдох үндэслэлийг нарийвчлан хуульчлах нь зүйтэй байна. Мөн хуралдаанд бэлтгэх явцад маргаан үүсгэх үндэслэл болсон маргааны

зүйл өөрчлөгдсөн, үгүй болгох, эсхүл холбогдох албан тушаалтан огцорсон, чөлөөлөгдсөн гэх мэт нөхцөл байдал үүсвэл хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалт хуульд байхгүй тул энэ талаарх хэм хэмжээг хуульчилж эрх зүйн тодорхой байдал бий болгох чухал нөлөөтэй юм.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой тусгаагүй бөгөөд 18 дугаар зүйлд маргагч талуудыг эрх үүргийг заасан боловч гэрч, шинжээч, орчуулагч зэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдын эрх зүйн байдал, ажиллагааны явцад хэрэгжүүлэх эрх үүргийг хуульчлаагүй байдаг. Үүний улмаас бусад хуулийн холбогдох хэм хэмжээг хэрэглэх (11 дүгээр зүйлийн дагуу) шаардлага үүсдэг боловч тухайн зохицуулалт Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны онцлогт тэр бүр нийцэхгүй байх нь олонтой. Үүний зэрэгцээ маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг оролцуулах эсэх асуудал (оролцуулах шаардлага практикт гарах боломжтой) нь маргаан дагуулдаг. Иймд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон бусад оролцогч, гуравдагч этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох тэдний онцлогтой нь уялдуулан холбогдох хэм хэмжээ, журмыг хуульчлах нь Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжилд чухал ач холбогдолтой байна.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд бэлтгэх хугацааг 30 хоног байхаар хуульчилсан. Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэж байгаа маргааны агуулга, хүрээ өргөн, гаргах шийдвэрийн үр нөлөө их, цаашид жишиг болж нийтэд үйлчилдэг онцлогоос хамаарч Цэцийн хуралдаанд бэлтгэх ажиллагааг бүрэн дүүрэн явуулах нь чухал байдаг. Торуулбал, энэ шатанд Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэх хуулийн шаардлагын үүднээс холбогдох байгууллага, албан тушаалтнаас тайлбар, тодруулга авахаас гадна, бусад нотлох баримт цуглуулах, тухайн асуудлаарх онол, үзэл баримтлалын судалгаа хийн чиг хандлагыг тодорхойлох, түүхчилсэн болон харьцуулсан судалгаа явуулах, ижил агуулгатай шийдвэртэй танилцах, шинжээч томилон дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагааг явуулдаг тул 30 хоногт эдгээр ажиллагааг гүйцэтгэх боломж хомс, сунгах тохиолдол нийтлэг гардаг билээ. Иймд уг хугацааг нэмэх, бусад улсын жишигт ойртуулж 90-180 хоног болгох нь зүйтэй байна.

2.4. Маргааныг Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хэлэлцэх шат

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 25-29 дүгээр зүйлд Цэцийн хуралдааны нийтлэг зохицуулалтыг хуульчилсан бөгөөд Дунд, Их суудлын хуралдааны талаарх нарийвчилсан хэм хэмжээг хуульд тусгаагүй байдаг. Үүнээс хамаарч тухайн хуралдааны онцлогтой холбоотой шийдвэрлэх шаардлагатай асуудал олонтой гарч ирсэн. Иймд тухайн хуралдааны ажиллагаа, үе шатны онцлогт тохирсон нарийвчилсан журмыг хуульд тусгахын зэрэгцээ, тодорхой төрлийн маргааныг шийдвэрлэх тусгай журмыг хуулиар тогтоох боломжтой юм. Тухайлбал, бусад улсад тухайн маргааны (импичмент, сонгуулийн маргаан гэх мэт) онцлогоос хамаарч хэлэлцэх журам нь өөр өөрөөр байхаар хуульчилсан нь олонтой.

Үндсэн хуулийн цэц байгуулагдсанаас хойш хуралдаан хийх байдал жил ирэх бүр өсөн нэмэгдэж байгааг харгалзан хуралдаан хийх процедурыг нарийвчлан хуульчлах шаардлага ч өсөн нэмэгдэж байна.



Нийт хуралдаан 765



Мөн Үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны онцлог, маргааны хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, мөн чанартай нь уялдуулан онолын шүүх болохын хувьд бүх маргааныг нээлттэй, хэлэлцүүлэгтэйгээр хийх хандлага дэлхий нийтэд хумигдсан байна. Өөрөөр хэлбэл, маргагч талуудын мэтгэлцээн нь тухайн Үндсэн хуулийн асуудлын шийдвэрлэх тухайлан ач холбогдолгүй гэж үзэж нээлттэй хэлэлцүүлэггүйгээр, зөвлөлдөх тасалгааны журмаар хуралдаанаа хийх нийтлэг жишиг тогтож, онцгой тохиолдолд нээлттэй хуралдааныг хийдэг болжээ. Энэ талаарх судалгааг хийж өөрийн орны онцлогт тохирсон журмыг маргааныг хэлэлцэх үе шатанд тусгах боломжтой.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар маргааныг хэлэлцэх энэ шатанд шийдвэрлэвэл зохих олон асуудал үүсдэг. Цэцийн хуралдааны явцад бүрэлдэхүүнийг татгалзан гаргах, хуралдааныг хойшлуулах, маргагч талууд харилцан тохиролцох, хариуцагч тал шаардлагыг хүлээн зөвшөөрөх, маргагч тал шаардлагаасаа татгалзах, шаардлагаа нэмэгдүүлэх, хүсэлт гаргах гэх зэрэг асуудал үүсдэг тул тодорхой зохицуулалтуудыг процессын хуульд тусгах шаардлага зүй ёсоор бий болсон байдаг. Тухайлбал, процессын хуулийн 18 дугаар зүйлд Цэцийн хуралдаан зөвлөлдөхөөр завсарлахаас өмнө аль ч шатанд өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх эрхтэй гэж заасан тул маргагч тал хуралдааны явцад хамааралгүй асуудлаар шаардлага, үндэслэл гаргах, шалгаагүй асуудлыг шийдвэрлүүлэхээр шаардлагаа нэмэгдүүлэх тохиолдолд гаргадаг нь тодорхой журмыг хуульчлаагүйтэй холбоотой юм.

Иргэдээс өргөдөл, мэдээлэл гаргахдаа уялдаа холбоо бүхий бусад зохицуулалтыг иж бүрэн судлаагүй, тодорхойлохгүйгээр Цэцэд хандах

тохиолдол цөөнгүй гардаг. Иймд үндсэн хуулийн дээд хяналтыг хэрэгжүүлж байгаагийн хувьд Үндсэн хуулийн цэц харилцан хамааралтай, агуулгын хувьд ижил, эсхүл тухай заалтыг эш татсан, үндэслэн гаргасан эрх зүйн актын мөн хянах, Үндсэн хууль зөрчсөн агуулгатай бол түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрэн эрхийг хэрэгжүүлэх ёстой. Энэ нь Үндсэн хууль зөрчсөн агуулгатай хуулийн бусад зохицуулалт үйлчлэн хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс сэргийлэх, Үндсэн хуулийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Мөн Цэцийн бие даасан, Цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан, хуралдааны хэвийн ажиллагааг алдагдуулсан иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуульд тусгаагүй орхигдуулсан байгааг тодорхой болгон холбогдох /Зөрчлийн тухай хууль/ хуульд тусгах хэрэгтэй байна. Маргаан хянан шалгах ажиллагаанд оролцогч буюу маргагч талууд Цэцийн хуралдааны дэгийг зөрчих, Цэц болон түүний гишүүдэд хуурамч баримт бичиг өгөх, Цэцийг хүндэтгээгүй үйлдэл гаргавал хэрхэн шийдвэрлэх, ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхой бус байгааг анхаарах хэрэгтэй.

2.5. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлт

Сүүлийн жилүүдэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр үндэслэл багатай гарсан гэж шүүмжлэл дагуулах болсон. Үүний үндсэн шалтгаан нь Цэцийн шийдвэр гаргах талаарх эрх зүйн зохицуулалттай холбоотой хэмээн судлаачийн зүгээс үздэг. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэцийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг нэн даруй уншин сонсоно.” гэж заасан. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Цэц шийдвэрээ ёсчилсноос хойш 24 цагийн дотор хүргүүлэх талаар заалтыг хуульчилсан байдаг. Үндсэн хуулийн цэцийн практикийг судлан үзэхэд хуулийн дээрх заалтын дагуу шийдвэрээ танилцуулахаас өмнө Цэцийн шийдвэр дээр бүх гишүүд гарын үсгээ зурж дараа Цэцийн хуралдаанд уншиж, сонсогдог. Иймд Цэцийн шийдвэрийн үндэслэлийг боловсруулах цаг хугацаа хуулийнхаа хүрээнд тун бага байна. Тодруулбал, Цэцийн хуралдаанаар маргааныг хянан хэлэлцсэний дараа 2-4 цагт /зарим тохиолдолд 1 цаг/ багтаан шийдвэр гаргахаар зөвлөлдөж, шийдвэрийн үндэслэлээ бичиж ёсчилдог байна.

Иймд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлийг онолын түвшинд, үндэслэл сайтай, ойлгомжтой гаргах шаардлагын үүднээс

Цэцийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулснаас хойш тодорхой хугацааны дараа буюу 14-30 хоногийн дараа шийдвэрийг бүрэн хэмжээгээр, бичгээр үйлдэн ёсчлохоор хуульчлах боломжтой. Мөн хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүн тусгай болон зэрэгцээ санал гаргах эрхтэй байх, хүсвэл хэвлүүлэх боломжийг хуулиар олгох нь шийдвэрийн чанарыг нэмэгдүүлэх нэг хөшүүрэг болно.

Мөн Цэцийн шийдвэрийн бүтэц, бүтцийн хэсэг тус бүрд тусгах агуулгыг илүү тодорхой болгон зааж, үндэслэл хэсэгт тухайн маргаанд холбогдох Монгол Улсын Олон улсын гэрээ, ижил агуулга бүхий маргааныг хянан шийдвэрлэсэн Цэцийн өмнөх шийдвэр зэргийг эш татан заах талаарх зохицуулалтыг тусгах нь зүйтэй юм. Энэ хүрээнд мөн Цэцийн шийдвэрийн үр дагавар, хэрэгжилтийг хангахтай холбоотой зохицуулалтыг шинээр хуульчилж болохоор байна.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн биелэлтийг хангах явдал бол Цэцийн шийдвэрийн үр нөлөөг хангах гол хөшүүрэг юм. Энэ үүднээс тодорхой зохицуулалт хуульд тусгах, бусад процессын хуулийг эргэн харж, уялдуулах нь тулгамдсан асуудал болжээ. Ингэснээр Үндсэн хуулийн цэцийн шийдвэр үр нөлөөтэй хэрэгжиж, Үндсэн хуулийн хяналтын зорилго биелнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд нийцээгүй хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, сонгуулийн төв байгууллагын шийдвэр, түүнчлэн өмнөх шийдвэрээ Цэц хүчингүй болгосон нь тэрхүү хууль, зарлиг, шийдвэр, гэрээний улмаас учирсан хор хохирол болон бусад үр дагаврын асуудлыг шийдвэрлэх шууд үндэслэл болохгүй. Гагцхүү Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл тогтоогдсон бол Цэцийн шийдвэрийг баримтлан хэргийг зохих хууль тогтоомжийн дагуу дахин хянаж болно.” гэж заасан боловч хэрэгжилтийг хангахын хэм хэмжээг холбогдох хуульд буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тусгаагүй байдаг.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “... Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно.” гэж зааж, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн биелэлтийг хангах онцгой ажиллагааг хуульчилсан. Энд заасан тохиолдол бий болсон бол Их суудлын хуралдаан хийх бөгөөд хялбаршуулсан ажиллагааны журмаар Үндсэн

хуулийн зөрчлийг шуурхай таслан зогсоож буй нэг хэлбэр гэж үзэж болохоор байна. Дээрх заалтын “эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээх” гэх ойлголт нь өргөн хүрээг хамарч байх тул цаашид нарийвчлан судалж ойлголтыг нэг болгох шаардлагатай юм. Мөн Цэцийн нэг гишүүний бүрэн эрхийн хүрээнд шууд Их суудлын хуралдаан хийхээр зохицуулсан байгааг эргэн харах, тухайн ажиллагааны журам тодорхой бус байгааг нарийвчлан хуульчлах нь зүйтэй байна.

2.6. Маргааныг дахин хянан шийдвэрлэх

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлд маргааныг дахин хянан шийдвэрлэх үндэслэлийг хуульчилсан бөгөөд эдгээр үндэслэлээр хуралдаанд бэлтгэх шатнаас эхлэн дахин хянан шийдвэрлэхээр заасан. Үүнд:

1/Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй;

2/урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасан;

3/шинэ нөхцөл байдал илэрсэн.

Хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй” гэх үндэслэл нь ойлголтын хувьд маргаангүй хэрэгжиж байгаа бөгөөд бусад 2 үндэслэл нь агуулгын хувьд тодорхой бус хэрэгжүүлэх журам нь хуульчлагдаагүй тул практикт нэгдсэн жишиг тогтоогүй, маргаантай асуудал хэвээр байсаар байна.

Иймд шинэ илэрсэн нөхцөл байдал гэх ойлголтыг өргөн хүрээнд (улс төр, нийгмийн өөрчлөлт, эрх зүйн шинэ орчин бий болгох гэх мэт өргөн хүрээнд) авч үзэх эсэх, эсхүл бусад процессын хуулиар тодорхойлсон шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн нотлох баримтад холбогдох явцуу хүрээнд авч үзэх эсэхийг нэг мөр болгох, түүнчлэн “урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасан” гэх үндэслэлийн хүрээнд “маргааныг дахин хянах шийдвэрлэх шаардлага”-д ямар нөхцөл байдал хамаарах, олонхын саналыг бүрдүүлэх журам, ийнхүү санал, санаачилгыг хэн гаргах, иргэдээс уг асуудлаар хангах эсэх гэх мэт шийдвэрлэх шаардлагатай олон асуудал байгааг энд тэмдэглэж байна. Шийдвэрлэвэл зохих эдгээр асуудлуудын талаар нарийвчилсан судалгаа хийж, хууль хэрэглээний нэгдсэн байр суурийг тодорхойлох, энэ талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж судлаачийн зүгээс үзэж байна.

3. Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгарч байгаа дээрх сорилт бэрхшээлийг даван гарахын тул Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг зохицуулсан хуулиудад зарчмын шинжтэй шинэчлэл хийх, нэр томъёог тодорхой болгох, зарим процессын журмуудыг нарийвчлан хуульчлах нь тулгамдсан асуудал болжээ. Энэ зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг өөрийн орны онцлогийг харгалзан, дэлхийн бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн нийтлэг жишигт ойртуулж, процессын эрх зүйн хөгжил, түгээмэл чиг хандлагад нийцүүлэн сайжруулах шаардлага үүсээд байна.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгож, үндсэн хуулийн эрх зүйн маргааныг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлэн онолын түвшинд, хараат бус, үнэн зөв, бодитой шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар шийдвэрлэх боломжтой юм.

Ийнхүү Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь манай улсын үндсэн хуулийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх, үндсэн хуулийн процессын эрх зүйн цаашдын хөгжлийг хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал нөлөө үзүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮНЭТ ЗҮЙЛ, ҮЗЭЛ САНАА, ЗАРЧМЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭР ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ БАЙХ ШААРДЛАГА

*МХХ-ны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны тэргүүн,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)
В.УДВАЛ*

АГУУЛГА

1. Оршил
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн онол, арга зүйн зарим асуудал
3. Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчим ба Цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх асуудал
4. Дүгнэлт (Цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлага)

1. Оршил

Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдаад 30 жил өнгөрч байгаа ч бид энэхүү Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчмуудыг ойлгож, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд алдаж онох үзэгдэл тасралтгүй үргэлжилсээр байна. Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчмууд нь хүн төрөлхтний бүтээн бий болгосон үнэт зүйлсийн нэг болох үндсэн хуульт ёсны үзэл, сургаалд үндэслэсэн билээ. “Үндсэн хуульт ёс” хэмээх ойлголтыг улс төрийн, эрх зүйн, философийн зэрэг олон шинжлэх ухааны арга зүйгээр янз бүр тодорхойлсон байдаг ч “**Үндсэн хуульт ёс** гэдэг нь эрх зүйн онол, зарчимд суурилж, Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсийн баталгаа болох Үндсэн хуулийн шүүх (цэц) төрийн эрх мэдлийн дур зоргын үйлдлийг хязгаарлах үзэл санаа, зохицуулалт юм”¹

Эртний Грек, Ромын үеэс гүн ухаантнууд, сэтгэгчдийн бүтээл туурвилд улс нийгмийн ашиг сонирхол, нийтийн эрх ашигт нийцсэн төрийн харилцаа юу байх талаар олон үзэл санааг боловсруулж байжээ. Тухайлбал, Францын философич, Соён гэгээрлийн хөдөлгөөний төлөөлөгч, түүхч, социологич, хуульч, зохиолч Барон де Монтескье “Хуулийн амин сүнс” бүтээлдээ эртний Грек-Ромын үеэс XVIII зуун хүртэл улс төр, нийгэм, эрх зүйн түүхэн хөгжлийг судалж, эрх зүй төдийгүй метафизик, этнологи, соёлын антропологиогийг хүртэл тусгасан байдаг. Тэрээр “Хэрэв хууль тогтоох эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгдвэл эрх чөлөө хэрэгжихгүй бөгөөд хууль тогтоогчид дарангуйлагч хуулийг тогтоож, дарангуйлал үүснэ. Харин шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд мөн л эрх чөлөө үл оршино”² гэжээ. Энэ зарчим, үзэл санаа дэлхийн бараг бүх улсын Үндсэн хуульд сууж, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай байлгахын тулд төрийн эрх мэдлийн төвлөрлийг задалж, тодорхой чиг үүргээр дамжин хэрэгжих эрх мэдлүүдэд хуваарилан, нэг эрх мэдлийг нөгөө эрх мэдлээр хянуулж, төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрт, нэгдмэл байдлыг бий болгох зарчим болон хөгжсөөр байна. Хэн уг зарчмыг зөрчиж алдаа гаргана, тэнд дарангуйлал үүсдэг зүй тогтол байдгийг дэлхийн улсуудын төрийн түүх харуулж байна.

¹ В.Удвал. “Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн үүрэг: харьцуулсан судалгаа” Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээлийн хураангуй. (УБ, 2022), 9.

² Монтескье, Барон де, “Хуулийн амин сүнс”, *МОНСУДАР нийгмийн ухаан №5*, (УБ, 2009), 14

Үндсэн хуульт ёс гэдэг нь үндсэн хуулийн гадна орших үнэт зүйлсийг хамгаалдаг Үндсэн хуультай байхыг хэлнэ³ гэж Кембрижийн их сургуулийн эрдэмтэн Марлин Вайнд тодорхойлжээ. Хүн төрөлхтөн Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хууль ёсны байх зарчим, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл санаа, үнэт зүйлийг үндсэн хуулиараа хамгаалах ёсыг боловсруулж, түүнийгээ мөрдсөөр иржээ. Өөрөөр хэлбэл, “Үндсэн хуульт ёс” хэмээх ойлголт нь үндсэн хуулиар урьдчилан тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, нийгмийн харилцааг зохицуулж байгаа Үндсэн хуулийн зүйл, заалтын зэрэгцээ нийтээр дагаж мөрдөхөөр тогтсон үзэл санаа, үнэт зүйлийг дагаж, түүнийг хамгаалах ёс гэж үзэж болох юм.

Энэхүү илтгэлээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчмыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр ямар үүрэгтэй, Цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлагын ач холбогдлыг тодорхойлохыг зорьсон болно.

2. Монгол улсын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн онол, арга зүйн зарим асуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” хэмээн заасан. Үндсэн хууль болон бусад хуулийн биелэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага, албан тушаалтнууд байдаг ч, Үндсэн хуулийн цэц зөвхөн Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих үүрэгтэй. Энэ утгаараа Үндсэн хуулийн цэцийн хяналтын үйл ажиллагаа нь объектын хувьд нэлээд явцуу байхаар Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар зохицуулагдсан байдаг.

Үндсэн хуулийн цэц дор дурдсан албан тушаалтны үйл ажиллагаа Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргана:

Монгол Улсын Ерөнхийлөгч
Улсын Их Хурлын дарга, гишүүд
Монгол Улсын Ерөнхий сайд

³ Wind, Marlene, “European Constitutionalism Beyond the State”, *Cambridge University Press*, (2003), 1-3

Засгийн газрын гишүүд
Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
Улсын Ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэхэд Цэц
хяналт тавьдаг болно.

Мөн Цэц Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хүлээн авч магадлал, дүгнэлт, тогтоол гаргадаг бөгөөд маргааныг магадлан шийдвэрлэх асуудлаа бие даасан процессын хуулиар зохицуулдгаараа онцлог.

Үндсэн хуулийн цэцийн "дээд хяналт" тавих бүрэн эрхийн онцлог нь: Нэгдүгээрт, Цэцийн хяналтын зүйл нь хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай Үндсэн хууль байдаг. Хоёрдугаарт, Цэцийн хяналтын объект нь төрийн дээд байгууллага, түүний өндөр албан тушаалтнуудын шийдвэр, үйл ажиллагаа байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн биелэлтийг хангахын тулд өөр ямар ч байгууллагад харьяалагддаггүй байгууллага, албан тушаалтнуудын шийдвэр, үйл ажиллагаа хяналтын объект болдог. Гуравдугаарт, Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийг давж заалдах, өөрчлөх, хүчингүй болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан байхгүй⁴ гэдгээрээ онцлогтой.

Европын Үндсэн хуулийн шүүхийн загвар ёсоор Үндсэн хуулийн хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъект нь Үндсэн хуулийн шүүх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн шүүх төдийгүй, зөвхөн Үндсэн хуулиар харьяалуулсан төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн өндөр албан тушаалтан Үндсэн хуулийг хэрхэн биелүүлж байгаад шүүхийн журмаар хяналт тавьж байгаагаараа Үндсэн хуулийн үнэт зүйлс, үзэл санаа, зарчмын баталгаа болдог. Хэдийгээр өнөөдрийг хүртэл Үндсэн хуулийн цэцийг шүүх мөн биш гэж маргаж байгаа ч Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /The Constitutional Court of Mongolia/ бол Үндсэн хуулийн шүүх гэдгийг Үндсэн хуулийн хяналтыг Европ загвараар хэрэгжүүлдэг, үндсэн хуулийн шүүхийн институцтэй улсуудын нийтлэг жишигтэй харьцуулан авч үзье. Эдгээр нийтлэг шинж нь: 1. Үндсэн хуулийн хяналтыг тухайн улсын төрийн тогтолцооны онцлогоос хамааран харилцан адилгүй нөхцөл байдалд хуульчлан баталгаажуулсан байдаг. 2. Институцийн хувьд шүүх эрх мэдлээс ангид бие даасан байгууллага Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг. 3. Үндсэн хуулийн зөрчилтэй холбогдох гомдолд үндэслэсэн хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн хяналтыг ердийн шүүхээс тусгаарласны үндсэн дээр үүссэн. 4. Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн байдал захиргааны болон санхүүгийн хувьд бие даасан байх нь үндсэн

⁴ Г.Совд, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар", (УБ, 1999), 19

хуулийн шүүхийн бие даасан байдлын урьдач нөхцөл болдог. 5. Үндсэн хуулийн хяналт нь парламентын баталсан хуулийг хүчингүй болгох эрхтэй. 6. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид улс төрийн эрх мэдэл бүхий этгээдээс томилогддог. 7. Хэлэлцэх асуудлын ихэнхийг Үндсэн хуульд аливаа хууль нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэх асуудал эзэлдэг. 8. Энэ загварын хяналт нь заримдаа урьдчилан сэргийлэх зорилготой ч олонхи тохиолдолд хариуцлага хүлээлгэх шинжтэй байна. Энэ бүх шинж манай Үндсэн хуулийн цэцэд байгаа гэдэг агуулгаар Үндсэн хуулийн цэцийг Үндсэн хуулийн шүүх гэж үзэх боломжийг бүрдүүлж байна.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр Үндсэн хуулийг хамгаалах хэрэгсэл юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хувьд онол, арга зүйн маргаантай асуудлууд байдаг ч Цэцийн шийдвэрийн үндэслэлийг Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл баримтлал болон үндсэн хуульт ёсны нийтлэг жишигт нийцүүлж гаргадаг байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үндсэн хуулийн цэц эрх зүйн онолын үндсэн зарчимд нийцсэн шийдвэрийг гаргах учиртай. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т “Цэц Үндсэн хуулийг зөрчсөн тухай дараах маргаантай асуудлыг хянан үзэж, дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулах бөгөөд хэрэв дүгнэлтийг нь Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Цэц дахин хянан үзэж Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан эцсийн шийдвэр гаргана” гэж заасан. Мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн “Цэцийн шийдвэр” хэмээх дөрөвдүгээр бүлэгт Цэцийн шийдвэртэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Эдгээрийг нарийвчлан авч үзвэл, бидний хөндөж буй асуудал буюу үндсэн хуульт ёс, Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйл, ардчилсан үзэл санаа, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн зарчимд үндэслэж, Цэц шийдвэрээ гаргах шууд зохицуулалт байхгүй. Гэвч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэж Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад оршино” хэмээн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг тодорхойлсон байдаг билээ.

Манай улстай ижил төстэй пост социалист орнуудад 1990-ээд онуудад шинээр байгуулагдсан болон шинэчлэн байгуулагдсан Үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн шүүхүүд эрх зүйт

төр, ардчилал, зах зээл гэсэн үндсэн хуулийн зарчмуудыг өөрийн шийдвэрээрээ тайлбарлан тодотгож байсан нь Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх зарчмын талаарх эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байна. Өнөөдөр Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх замаар гаргасан шийдвэр нь зөвхөн хууль хүчингүй болгодог эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд гаргаж байгаа позитив гэж нэрлэгддэг шийдвэр нь илүү ач холбогдолтой болж байна.

Түүнчлэн зарим улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль шийдвэр гаргах шинэ боломжуудыг бий болгож, хамгийн зохистой хэлбэрээр шийдвэрээ гаргахад шүүхэд чөлөөт сонголтыг олгосон байдаг. Словений судлаач, доктор Арне Мавчич “Үндсэн хуулийн хяналт” бүтээлдээ: “Үндсэн хуулийн шүүх нь тайлбарласан шийдвэр гаргах замаар эрх зүйн тогтолцоонд байгаа маргаантай зохицуулалтыг маргаангүй байгаа, эсхүл үндсэн хуульд агуулгаараа нийцэж байгаа хүрээнд нь хэвээр үлдээж, нийцээгүй хэсгийг эрх зүйн хэрэглээнээс шууд бусаар хасах замаар шийдвэрлэдэг”⁵ гэжээ. Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаанд гарч байгаа энэ мэт шинэ үзэгдлийг сайтар судалж, Үндсэн хуулийн цэцийн практикт төлөвшүүлэх боломж байгаа гэж үзэж байна.

Мөн Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоогчтой харилцахдаа ихэвчлэн өөрийгөө хязгаарлах зарчмыг баримталдаг бөгөөд хуулийн заалтыг тайлбарлахдаа тухайн заалтын хязгаарыг давахгүй байх ёстой гэж үздэг. Үндсэн хуулийн шүүх шийдвэрээрээ Үндсэн хуулийг тайлбарлах чиг үүргийг Үндсэн хуульдаа шууд заасан улсууд байхад манайх шиг шууд заагаагүй ч улсууд байгаа бөгөөд Үндсэн хуульт ёсны үндсэн зарчмын хүрээнд тухайн асуудлыг зөв төлөвшүүлж байгаа улсууд цөөнгүй байна. Үндсэн хуулийн шүүх шийдвэрээрээ Үндсэн хуулийг тайлбарлах нь үндсэн хуулийг тогтвортой байлгахад чухал ач холбогдолтой гэж үздэг билээ.

Аливаа хуулийн хэрэгжилтийг хангахад нийгмийн амьдралын өөрчлөлт, эрх зүйн хөгжлийг даган хууль хэрэглэж, тайлбарлах замаар Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх, эрх чөлөө хэрэгжих боломжийг бүрдүүлдэг байна.

⁵ Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт”, орчуулсан Г.Баясгалан, Д.Сугар, Д.Одбаяр, (УБ, 2014), 37-38

3. Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл санаа, зарчим ба цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх асуудал

Монголын Хуульчдын Холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооноос 2022 онд хийсэн судалгаагаар Монгол Улсын Үндсэн хуулийн үнэт зүйл, үзэл баримтлал, зарчмууд, Үндсэн хуульт ёсны зарчим, хэм хэмжээг баримтлан хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлж шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцээс гаргасан 296 шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд Үндсэн хуульт ёсыг бэхжүүлж, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхэд дээрх шийдвэрүүд чиглэсэн боловч маргаанд өртсөн шийдвэрүүд цөөнгүй байна.

Өнгөрсөн хугацаанд Үндсэн хуулийн үзэл санаа, Үндсэн хуульт ёсны зарчим, Монгол Улсын Үндсэн хуулийн үнэ цэн бүхий үнэт зүйлсийг удирдлага болгон гаргаж байсан шийдвэрүүд практикт цөөнгүй бий. Жишээ нь, Үндсэн хуулийн цэц 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдөр “аливаа төрийн байгууллага, албан тушаалтанд хуулиар зөвшөөрснөөс бусдыг хориглодог нь нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйт төрийн үндсэн зарчим мөн” хэмээн дүгнэлтдээ бичсэн нь эрх зүйт төр нь Монгол Улсын Үндсэн хуулийн салшгүй хэсэг учраас төрийн байгууллага, албан тушаалтан дээрх зарчмыг заавал биелүүлэх үүрэгтэй гэдгийг шийдвэрийнхээ үндэслэл болгосон хэрэг юм.

Мөн Үндсэн хуулийн цэц 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд хүйсээс шалтгаалсан ялгамжтай байдлыг бий болгосон” гэх үндэслэлийг дүгнэлтдээ заан “ижил нөхцөлд хүүхдээ асарч байгаа” эмэгтэй болон эрэгтэй хүн хүйсээс үл хамааран тэтгэмж авах боломжийг авч үзсэн нь тэгш эрхийн зарчмыг үндэслэл болгосон явдал болно.

Цэцийн шийдвэр гармагцаа хуулийн хүчин төгөлдөр болж биелэгдэх хүчин чадалтай, тухайн асуудлаар цаашид нийтээр дагаж мөрдөх, удаан хугацаанд үйлчлэх, жишиг тогтоох хандлагатай байдгийг эрдэмтэд, судлаачид тэмдэглэсэн байдаг.

Академич Ж.Амарсанаа “Үндсэн хуулийн шүүх өөрийн тогтоолдоо актыг хүчин төгөлдөр бус гэж тооцсоны улмаас зохицуулалтгүй үлдсэн харилцааг зохицуулахаар шинээр хууль гаргах, эсхүл үйлчилж байгаа хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлт оруулахыг өөрийн тогтоолдоо хууль тогтоогчид зөвлөмж болгодог явдлаараа Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнийг манай Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд дорвитой нэвтрүүлэх шаардлагатай.”, Доктор, профессор Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанаараа Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж их

суудлын хуралдаанаараа тухайн хуулийг хүчингүй болгох эсэх тухай тогтоол гаргадаг. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь аль нэг тохиолдолд буцаж үйлчлэх талаар зохицуулалт манай хуульд тусгаагүй тул энэ талаар цаашид судалгаа хийж, ирээдүйд гарах шийдвэрийнхээ хүчин чадал, үр нөлөөг дээшлүүлэх боломжтой юм.”⁶ хэмээн бичсэн байдаг.

Үндсэн хуулийн цэцийн гишүүд Үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн дүгнэлтээ итгэл үнэмшилтэй, үндэслэлтэй гаргах шаардлагатай. Тухайн шийдвэр гаргах процессын хүрээнд эрх зүйн шинжлэх ухаан-онолын тодорхой асуудлыг шийдвэрлэдэг учраас Үндсэн хуулийн цэцийн гишүүн эрх зүйч мэргэжилтэй, хуульч байх шаардлагатай. Энэхүү шаардлага нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэр үндэслэлтэй гарах урьдач нөхцөл болох юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 2-т байгаа “...улс төрийн өндөр мэргэжилтэй” гэдэг нь улс төрийн албан тушаалд ажиллаж байсан хүнийг нэрлэж байгаа хэрэг биш бөгөөд улс төрийн мэргэшлээр суралцаж, төгссөн хүний тухай асуудал. Энэ нь хууль зүйн өндөр мэргэжлийн дараа нэмэлтээр тавигдаж байгаа шаардлага хэмээн ойлгож болно.

Үндсэн хуулийн үнэт зүйл, суурь зарчим, үзэл баримтлалыг хамгаалах үндсэн арга нь шүүхийн хяналт боловч хүний үндсэн эрхээр баталгаажсан төрийн эрх мэдлийн тэнцвэртэй хуваарилалт, нэг нь нөгөөгөө хянаж чадах улс төрийн тогтолцоо чухал юм. Үндсэн хуульт ёсны үндсэн зарчмын нэг нь эрх мэдлийн төвлөрлийг сааруулж, эрх мэдэлтний дур зоргын үйлдлийг хязгаарлах зарчим юм. Гэтэл манай улсад улс төрчдийн, хууль тогтоогчдын хүсэл сонирхлоос шалтгаалан дээр дурдсан тогтолцоо төлөвшиж чадахгүй байна. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсарч хаших асуудал Үндсэн хуулийн цэцээс “хавсарч ажиллаж болохгүй” агуулгаар удаа дараа шийдвэрлэж байсан ч УИХ агуулгаар нь дахин сэргээж байсан төдийгүй тухайн асуудлаар Үндсэн хуульд 3 дахь удаагаа 2022 оны 8 сард өөрчлөлт оруулсан явдал юм.

Үндсэн хуулийн цэц үндэслэл бүхий шийдвэр гаргахад Цэцийн гишүүдэд хууль зүйн тусгай мэдлэг чухал шаардлагатай төдийгүй үндсэн хуулийн маргааныг хэлэлцэж байх үед учир шалтгааны үндэслэлээс гадна хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгт тулгуурласан оюун дүгнэлт чухал үүрэгтэй.

⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Ханнс-Зайделийн сан, “Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага” ОУЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл”. (УБ, 2012), 152-161.

Нийгмийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалтын чанар нь зөвхөн эрх зүйг бүтээх үйл ажиллагаанаас төдийгүй эрх зүйг амьдралд хэрэгжүүлэх эрх зүйн хэм хэмжээний оновчтой, тодорхой шийдлүүдтэй салшгүй холбоотой байдаг. Эрх зүйг амьдралд хэрэгжүүлэх чухал хэлбэрийн нэг нь яах аргагүй эрх зүйн хэрэглээ юм. Эрх зүйн хэрэглээний тайлал нь шүүхийн шийдвэр байдаг. Үндсэн хуулийн цэц/шүүх/-ийн шийдвэр яав ч улс төрийн шийдвэр байж болохгүй. Өнөөдрийн төрийн байгууллагын соёл хүч түрэмгийлсэн шинжтэй байгаа нь Цэцийн шийдвэрт нөлөөлж байдгийг Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 тогтоол харуулсан гэж үзэж байна. Цэцийн шийдвэрийг үндэслэн УИХ яаравчлан Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт хийж үндсэн зорилгоо биелүүлсэн боловч, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх” гэсэн нэмэлтийг 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр оруулж, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гаргасан нь анхаарал татаж байна. Монгол Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхийн хүрээнд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай, Үндсэн хуулийн цэцийн тухай гэсэн хоёр хуульд 2022 оны 8 дугаар сарын 24-нд нэмэлт оруулсан.

4. Дүгнэлт (цэцийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлага)

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулийн үзэл санаа, үнэт зүйл зарчим нь 1990 оноос өмнө үйлчилж байсан Үндсэн хуулиудаас эрс ялгаатай билээ. Эдгээр ялгаа нь Үндсэн хуулийн эх бичвэрээс гадна Үндсэн хуулийн цоо шинэ үзэл санаа, тухайн үзэл санаанд суурилах үнэт зүйлтэй салшгүй холбоотой байдаг. Ийнхүү 1992 оноос Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, үнэт зүйл, зарчим олон зүйл дээр өөрчлөгдөн шинэчлэгдэж, Үндсэн хуульд ёсны дэлхий нийтийн нийтлэг жишигт нийцэн хөгжиж байна. Эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг эрх зүйн шинэ нөхцөл байдалд зүгширч төлөвшихөд Үндсэн хуулийн цэц онцгой үүрэг гүйцэтгэх ёстой бөгөөд гаргаж буй шийдвэрээрээ хүний эрхийн баталгааг хангаж, төрийн институциудын эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилд, харилцан хяналттай байх зарчмыг хангана. 30 жилийн дараа эрх мэдлийн хуваарилалт үеэ өнгөрөөж байна гэж нэг хэсэг нь сурталдаж байгаа ч төрийн эрх мэдэл төвлөрсөн тохиолдолд

дарангуйлал дахин сэргэдэг гэдгийг бид ямагт санах хэрэгтэй болж байна.

Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчид эрх мэдлийн хуваарь, хяналт тэнцвэрийг алдагдуулсан тохиолдол бүрийг Үндсэн хуулийн цэц зөв шийдэх хэрэгтэй бөгөөд энэ агуулгаар Цэц, Үндсэн хууль амьдралд хэрэгжих баталгаа нь болдог билээ. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр улс төрийн шийдвэр байж болохгүй. Энэ асуудлыг эрх зүйн зохицуулалтад хамааруулах шаардлагатай юм. Хууль зүйн үр дагавар бүхий шийдвэр гаргадаг Цэцийн гишүүнээр улс төрч ажиллах ёстой гэдэг буруу ойлголт нь Цэцийн шийдвэр улс төрийн шийдвэр байх ёстой гэсэн буруу соёлыг төлөвшүүлж байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн сүүлийн шийдвэрүүдийн талаар онолын болоод үзэл бодлын олон байр суурийг хуульчид илэрхийлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц өөрийн шийдвэрийн үндэслэл хэсэгт яагаад тухайн асуудлыг Үндсэн хууль зөрчсөн буюу зөрчөөгүй вэ гэдгийг тайлбарлаж, нотлохгүй байгаагаас тухайн шийдвэрийг эрх баригчдын захиалгаар гаргасан эсвэл улс төрийн шийдвэр гаргалаа гэх хандлага гарсаар байна. Мөн УИХ-ын гишүүд ч Үндсэн хуулийн цэц өөрөө Үндсэн хуулиа зөрчсөн шийдвэр гаргадаг гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байдаг. 2021 оны 9 дүгээр сарын 28-нд УИХ-ын гишүүн Б.Энхбаяр iToim сайтад⁷ өгсөн ярилцлагадаа:

“...Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр бөгөөд эцсийн шийдвэр байна гэдэг Үндсэн хуулийн заалт байгаа учраас намайг хэн хэлэх вэ, хэн шүүх вэ гэдэг байдлаар хандаж “хүчиндэж” байна. Хуулийн процессын дагуу шийдвэрээ гаргасан бол асуудал байхгүй. Их суудлын хуралдааны энэ шийдвэр Шүүхийн хуулийг гацаанаас гаргаж байгаа учраас талархалтай байгаа. Гэхдээ ялсан ч хуулийн дагуу, хуулийн хүрээнд ялмаар байна шүү дээ” гэсэн байдаг. Тэрээр цааш нь “Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэл, хүсэлтээсээ хэзээ татгалзаж болох вэ гэсэн нарийвчилсан процессын хууль байхгүй. Саяын тохиолдол шинэ жишиг болж байна. Ерөнхийлөгч Цэцийн дунд суудлын хуралдааны шийдвэрийг УИХ хүлээж авахгүй гэж тогтоол гаргасны дараа хүсэлтээ буцаан татаж байгаа гэдгээрээ онцлог буюу шинэ байлаа. ... Мөн УИХ-ын тогтоолыг хянаж шийдвэр гаргах ажиллагааг огт хийгээгүй...байж УИХ-ын тогтоолыг

⁷ Б.Энхбаяр, “Б.Энхбаяр: Үндсэн хуулийн цэц өөрөө Үндсэн хуулиа зөрчсөн”, Itoim.mn, 2021.09.28, <https://itoim.mn/article/A6311/29744>

хүчингүй болгож байгаа нь ч хууль зөрчсөн үйлдэл” гэсэн байдаг.⁸

Үндсэн хуульд хууль, эрх бүхий байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэдийн үйл ажиллагаа нийцэж байх, хуульд захирагдах ёс (The rule of law)-ыг тогтоосон жишгийг харгалзан Үндсэн хуулийн цэц улс төрийн дарамт шахалтаас ангид байх шаардлага зүй ёсоор үүсэж байна. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд захирагдан, судалгаанд үндэслэн, төвийг сахисан, бие даасан шийдвэрээрээ дамжуулан аливаа эрсдэлээс ангид байх боломжтой. Үүнээс улбаалж төрийн эрх мэдлийн хуваарилалтын харилцаанд Үндсэн хуулийн шүүхийн статусыг зөв тодорхойлох, Цэцийн магадлан шийдвэрлэх ажиллагааны цар хүрээ, мөн чанар, шалтгааныг Үндсэн хуульд ёсны зарчимтай уялдуулан эрх зүйн шинэ зохицуулалтад хамруулах шаардлага ч үүсэж байна.

⁸ Мөн тэнд

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН АСУУЛТ, ХАРИУЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 01¹

2022 оны 10-р сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Ш.Цогтоо: Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй гэдэг номыг бүтээсэн юм. Манай сургуулийнханд тараагдсан л даа. Одоо нэг тараасан хүн нь хүртэл манай Солонгоо багш тэнд сууж байх шиг байна. Гэхдээ энэ танд очоогүй байж магадгүй. Очсон ч байсан гэсэн танд өгчихье. Хэрэг болж магадгүй.

Ц.Мөнх-Оргил: Заа баярлалаа.

Ш.Цогтоо: Эхлээд би асуултаа тавья. УИХ-ын хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилоос нэг асуулт асууя. Энэ УИХ, тухайлбал Г.Занданшатар дарга Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үндэслэж Засгийн газрын бүтцэд өөрчлөлт хийж болохгүй. Цэц хууль тогтоогчдын бүрэн эрхэнд халдлаа. Цэц ер нь цаашдаа ч ингэж ийм нэмэлт, өөрчлөлт хийж болохгүй гээд Цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Товчдоо бол би энэ яриад байгаа асуудалд цэг тавьсан гэж ойлгож байгаа. УИХ ер нь Цэцийн энэ тэнэглэлийн эсрэг өөр яалтай ч билээ. Өөр ийм шийдвэр авахаас ч өөр аргагүй байсан байх гэж би боддог юм. Тэр Цэцийн шийдвэр 7 хоног ч үйлчлээгүй. Цаашид ч үйлчлэхгүй. Гэхдээ бол суурь нь хэвээрээ байгаа шүү. Кейс тэр чигээрээ байгаа. Хэн ч ашиглахад тийм бэлэн кейс байгаа. Тэгэхээр энэ их үр дагавартай юмыг бол хуульчдын давлагаагүйгээр, сэхээтний өргөн давхарга бол эсэргүүцэж, зэвүүцэж дургүйцээд зөндөө л юм болоод байна л даа. Гэтэл энэ асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал байнга хийгээд л дахин дахин хэлэлцээд л зарим нь бүр дахин хянуулах гээд ч байгаа юм шиг, магадгүй боловсронгуй болгуулах гээд ч байгаа юм шиг. Ер нь бол цаад утгаараа УИХ-ын шийдвэрийг эсэргүүцээд ч байгаа юм болов уу? гээд зөндөө ийм мөн биш болсон юм ярих бололтой юм аа. Үүнийг нь ер

¹ Constitutional Law Institute, NUM, “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурал”, дүрс бичлэг, YouTube, 2022.12.22, <https://www.youtube.com/watch?v=Xuw4ZZnn-Ak>.

нь та юу гэж үзэж байна вэ? Зөндөө юм болж байна. 7 хоногийн өмнө бол Хуульчдын холбооны өдөржин, шөнөжин хурал болсон. 7600 хуульч бараг оролцсон гэж би бодож байна, бүх сувгаар нээлттэй байсан. Одоо хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа. Тэгээд ямар хажуугаас хараад сууж байгаа биш. Дунд нь сууж байгаа хүн та ер нь энийг юу гэж үзэж байна вэ? гэж танаас энэ асуултыг асуучаад энэ хооронд нь өөрийнхөө саналыг хэлчихье гэсэн юм.

Асуудал хөндсөн, илтгэл хэлэлцүүлж байгаа бүх илтгэгч нарт болон Үндсэн хуулийн хяналтын дампуурал буюу Цэцийн завхралыг нээлттэй хүлээн зөвшөөрч чадаж байгаа УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар, УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ж.Нямбаатар, Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг гээд та нарт бол баярлаж талархаж байгаагаа хэлмээр байна. Гэхдээ энэ эрдэм шинжилгээний хурлын ерөнхий сэдэв, илтгэгч нарын сэдвүүд бол Үндсэн хуулийн хяналт бол яах вэ? Дажгүй. Ер нь бол алдаа, оноотой ч гэсэн болоод л байгаа. Цаашдаа бол жоохон жоохон боловсронгуй болгох юм л байгаа гэсэн ийм маягаар үргэлжлэх юм байна гэж ойлгогдоод байна л даа. Би өөрийнхөө саналыг шуудхан хэлчихье. Саналаа шуудхан хэлчихэд бол нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолчхов оо. Боловсронгуй болгох гэж оролдвол яг саяын Үндсэн хуулийнх шиг, Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульдаа халддаг шиг завхрал болж мэдэх тийм нигуур бол зөндөө ажиглагдаж байна. Иймэрхүү юм чинь цааш цаашаагаа үргэлжлээд байвал улс төрийн хямралд хүрч, нийгмийг төөрөгдөлд оруулна. Энэ бол бараг зүй тогтол шүү дээ. Бусад оронд тохиолддог. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бол би Хуульчдын холбооны формыг дахиад дурдъя. Анхны хууль тогтоогч 5 хүн оролцсон. За тэрэнд оролцож байгаа хуульчид 300 гаруй хүн бол алгаа хорстол алга ташаад, бид нарыг ч үг хэлүүлэхгүй, тэд нарт байн байн асуулт тавиад ингээд их өргөн хэлэлцүүлэг болсон. Дээр нь бол миний хувьд миний тавьсан илтгэл Хуульчдын холбооны сайтад тавигдсан. Тэгэхээр надад бол тодорхой санал байхгүй. Тэр сайтаас манай ажлын хэсгийнхэн, манай Хууль зүйн байнгын хорооны ажилтнууд хараад би Цэцийн талаар юу гэж боддог, яагаад ингээд байгаа талаар бол бүгдийг нь тэнд бол 8 хуудас юманд сайхан багтаагаад, цэгцлээд тавьчихсаныг “Хуулийг мухар сохроор шүтсэний хэрэггүй гэдэг” нэрэн дор сайт, пейжүүд дээр тавиулчихсан байна лээ. Тэрийг яах вэ та нар минь хэлээд энэ дээр хэлсэн гээд бодчихоорой гэж. Ингээд Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох гэж оролдсоноос болбол дараах ойр зуурын 3 арга замыг авч үзвэл яасан юм бэ дээ гэж, таныг үг хэлэхээр, гишүүнийг үг хэлэхээр, төрийн нарийныг үг хэлэхээр

тэр дотроос гэнэтхэн санаад энийг хэлмээр санагдсан юм. Нэг дэх нь бол О.Мөнхсайханы илтгэл дээр ч гарч байна лээ. Энэ цэцийн гишүүдийн томилгоо буюу томилох, сонгох энэ механизмыг хар аа. Энд бол ойрхон байгаа. Гар доор чинь гаргалгаа байгаа. Одоо мэдэхгүй тэр энд тэндхийн сайтууд дээр бичсэнээр бол нэг л гэнэтхэн хэн гээл Нанзаддорж, Буяндэлгэр, Ш.Солонгоо, Туулхүү гээд 4 муу хүн цэцэд хандчихаад байгаа юм шиг ийм юм ярьдаг юм. Би дээр нэмээд нэг юм хэлчихье. Энэ цэцэд очих гишүүдийг сонгохдоо пионерын зөвлөлийн дарга байсан, эвлэлийн үүрийн дарга байсан, хувьсгалт хорооны дарга байсан, сонгуульд хэчнээн удаа төвийн болон орон нутгийн сонгуульд оролцсон хүнийг бол битгий тавьж бай. Тэд нар бол ингээд хуулийг, шүүхийг завхруулаад хаячхаж байна шүү дээ. Ийм мэтээр ийм юмаар л харна уу гэхээс биш бол тэр нэг одоо, 6700 хуульч би цэцэд очвол би хийж чадна гээд хараад сууж байх чинь заавал тэр нэг улс төрөөр дамжсан хүмүүсийг юм уу, бизнесээр дамжсан хүмүүсийг тэр лүү тавихгүй байж болно шүү дээ гэж надад бодогддог юм. Хоёрдох нь бол үндсэн эрхийн гомдол буюу constitutional complaint-ыг хүн болгон ярьж байна. Би ч гэсэн ярьдаг. Энэ чинь бол Үндсэн хуульдаа л, Үндсэн хуулиа л өөрчилнө гэсэн үг. Ер нь бол ийм юм руу чадвал орох нь зөв. Чадахгүй бол будлиулаад нэг жижигхэн жижигхэн жоохон мэс засал хийх гэж байгаа болбол нэг гоо сайхны мэс заслууд хийх гэж байгаа бол баллаад хаяна. Нүүр ч үгүй, нүд, хамар ч үгүй болгоод хаячихна. Энэ чинь бол ийм их аюултай тоглоом гэдгийг хэлмээр байна. Гуравдах нь бол хяналтыг боловсронгуй болгох гэж оролдсоноос тэр жижиг юм руугаа л, сая Цэцийн Үндсэн хуульд халдаад бусад УИХ-ын авч байгаа арга хэмжээ нь байгаа бололцоогоо шавхаад дууссан гэсэн үг. Нэгэнт дууссан юмыг эсвэл бүр өөр юм руу оруулбал constitutional complaint-руугаа оруул орсон шиг ор. Гадна, дотнынхоо туршлагаар, ард түмэндээ Үндсэн хуульд өөрчлөлт оруулдаг замаар. Орохгүй бол энэ хүмүүсээ зөв, эрүүл болго. Ингэх гээд байвал болно гэж бодож байна баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа Цогтоо багш.

Д.Үүрцайх: Тэгэхээр би Ц.Сарантуяа багшаас асуух гээд байна. Өөрөөр хэлбэл, саяын Цэцийн шийдвэрийн агуулгыг дэмжиж, ер нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн цэцийн хяналтын объект мөн, дэлхийн улсуудын жишиг ийм байгаа гэдгийг хэлж өгсөнд баярлалаа. Ер нь бол Цэцийн саяын энэ маргаан дагуулаад байгаа “давхар дээл”-тэй холбоотой шийдвэр, тогтоол гарсантай холбоотойгоор маш олон янзын үзэл, бодлууд нэгэнт гарсан. Гэхдээ би үүн дээр хамгийн гол нь Цэцийн шийдвэрийн үндэслэл зөв, буруу эсэх асуудлыг хөндөхөөсөө илүү Цэц бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах журмын тухай хуульд байгаа “Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал юу вэ?” гэдгийг өөрөө тодорхойлдог байдлаар, өөрөөр хэлбэл, журмын хуульд тэрийг нь тодорхойлж өгөөгүй учраас Цэц 2019 оны “давхар дээл”-ийг хязгаарласан заалт эрх мэдлийн хуваарилалттай холбоотой асуудлыг хөндөж байгаа учраас үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалдаа нийцэхгүй байна гэж шийдсэн. Өөрөөр хэлбэл, 2000 оны нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчөөгүй. Тэр бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа. 2000 оны нэмэлт, өөрчлөлттэй холбоотой маргаанууд нь бол тухайн үедээ шийдэгдчихсэн. Тэгэхээр 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар юу руу орсон бэ? гэхээр Засгийн газар гэдэг тогтолцоотой байсныг Ерөнхий сайдтай, сонгодог парламентын ардчиллын чиглэл рүү өөрчилсөн ба 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр тэрийг баталгаажуулаад, Ерөнхий сайд кабинетаа мэддэг болох гэх мэт энэ чиглэл рүү хөгжөөд явж байгаа. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал энэ чиглэл рүү хөгжиж байгаа гэж би ойлгодог. Энийг ч гэсэн Цэцийн саяын тэр шийдвэр баталгаажуулжээ гэж би харж байгаа. Одоо тэгэхээр миний хамгийн эгдүүцэл төрүүлээд байгаа зүйл бол УИХ-ын хариу үйлдэл байгаа юм. Өөрөөр хэлбэл, УИХ Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тэр өөрчилж болохгүй мөнхийн зарчмаа Үндсэн хуульдаа тусгаад, ийм байдлаар Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянах хүрээ хязгаарыг тодорхой болгох тэр боломж нь нээлттэй байтал наана нь ердийн хуулиар Үндсэн хуулийг давсан ердийн хууль батлаад Үндсэн хуулиар олгогдчихсон Үндсэн хуульд үгчлэн заагдчихсан Цэцийн бүрэн эрх, дээрээс нь Үндсэн хуулийн цэцийн саяын шийдвэрээр Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээ болох нь тогтчихсон Үндсэн хуулийн заалтыг давсан ердийн хууль батлаад Цэцийн тухай, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх журмын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр Үндсэн хуулийн хэм хэмжээний адил үйлчлэх ёстой. Дээрээс нь Үндсэн хуулийн цэцийн хүчингүй болгочихсон Үндсэн хуулийн заалтыг дахиж хүчингүй болгоод, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг ийм утгагүй юм батлаад, ингээд жинхэнэ төрийг самарч байгаа ийм үйл ажиллагаа болчихлоо. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал гэдгийг яаж ойлгож тайлбарлах ёстой юм бэ? гэдэг асуулт, нэгдүгээрт. Хоёрдугаарт, энэ УИХ-ын хариу реакци буюу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэ асуудлыг шийдэх ёстой байсан юм биш үү гэсэн ийм 2 асуултыг тавимаар байна. Ер нь бол би мэдээлэл гаргаж Цэцийн энэ шийдвэр гаргахад хүргэсэн, төрийг самарсан этгээд болчихоод байгаа. Гэхдээ тэр үед намайг хэвлэлээр, сошиалаар боорлож

байсан, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг шүүж байсан тэр “төрд хэрэгтэй зайран”-гууд миний энэ яриад байгаа хууль гарчхаад байхад хаана байгаа вэ? Үндсэн хуулийн цэц дээр очсон уу, та нар? Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргачихсан байгаа юу? Ийм 2 нүүртэй, жинхэнэ энэ институцыг устгах ажлыг хийж байгаа хүмүүс энэ асуудалд өөрөө өөрсдийнхөө үзэл бодолд тайлбар өгнө биз ээ. Баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Ц.Сарантуяа багш хариулах уу?

Ц.Сарантуяа: Өөрчлөлт оруулаад нэмэлт, өөрчлөлтийн хянахаа больж байгаа нь Үндсэн хуулийг давсан ийм шийдвэр боллоо гэж хэлж байна гэж ойлгосон. Тийм ээ. Үндсэн хуулийн 66.2-т Үндсэн хуулийн цэц нь УИХ-ын шийдвэрийг хянана гэж байдаг. Ямар шийдвэр гэдэг нь тоочигдоогүй. Бусад, хууль, бусад. Үндсэн хуулийн УИХ-ын бүрэн эрхийг зохицуулсан 25-р зүйлд хууль батална, нэмэлт, өөрчлөлт оруулна гээд бүгдээрээ цаашаагаа байж байгаа. Үндсэн хуулийн 66.2-оор бол УИХ-ын аливаа шийдвэрийг Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэх тэр орон зай үлдчихсэн. Харин Цэцийн тухай хууль, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар нэмэлт, өөрчлөлтийг хянахгүй гэж орж байгаа нь Үндсэн хуулийн цаад үнэт зүйл, утга агуулга, багтаамжийг явцууруулсан хууль болсон гэдэг нь үнэн. Гэхдээ явцуурсан нь зөв, буруу гэдгийг би одоо яриагүй. Энэ холбогдох шүүгчид, гишүүд хэрвээ ийм асуудал ярих юм бол дуугарах байх л даа. Үндсэн хуулийн орон зай багаслаа гэдэг нь үнэн. Нэмэлт, өөрчлөлтийг хянах, хянахгүй байх асуудал манай хууль тогтоомж боловсронгуй биш байгаагаас манайд яригдаад байгаа юм. Бусад улсын хууль тогтоомж илүү төгөлдөр байгаагаас тэнд яригдахаа больчихсон байна гэдгийг би түрүүн дурдах шиг болсон. Өшөө ямар асуулт байлаа.

Д.Үүрцайх: Суурь үзэл баримтлал

Ц.Сарантуяа: аан тийн. Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг слайд дээр дурдсан байсан шүү дээ. Тийм ээ?. Тэгэхээр тэр суурь үзэл баримтлалыг Үндсэн хуульд төгс жагсаах боломжгүй. Тэгэхээр та хэд мэдээлэл өгөхдөө ардчилсан ёс, хууль дээдлэх ёс төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж өгсөн байх. Яагаад гэвэл манай Монголд Үндсэн хуулийн цэц нь өргөдөл, мэдээлэл хүлээж аваад Үндсэн хуулийн ямар заалт зөрчигдөж байна, өөрөө тогтоох боломжгүй. Хэрэв та нар нэг заалт өгөх юм бол тэр нь зөрчигдөж байна уу? үгүй юу? гэдгийг л хянах боломжтой. Энийг яваандаа засах шаардлагатай. Яагаад гэвэл өргөдөл, мэдээлэл гаргагч тэр болгон оноож Үндсэн хуулийн заалтыг хэлдэггүй. Магадгүй цаад фондоо зөрчилтэй заалт тухайн заасан заалтыг нь зөрчөөгүй бол зөрчөөгүй байна гэж шийдвэр гаргах орон зай байдаг. Тэгэхээр яваандаа Үндсэн хуулийн цэц өөрөө

олж тогтоодог байх шаардлагатай. Харин ямар шийдвэр Үндсэн хууль зөрчөөд байгаа юм бэ? гэдгийг, яагаад зөрчөөд байгаа юм бэ гэдгийг өргөдөл, мэдээлэл гаргагч өгчихдөг байвал зохилтой. Нэгэнт Үндсэн хуульд тэр үнэт зүйлийг, тэр "idea"-г үзэл санааг бүхэлд нь заах боломжгүй учраас л Үндсэн хуулийн шүүхүүд Үндсэн хуулийн эрх зүйн ухаанд тулгуурлаад улам цогцлоон хөгжүүлж байдаг. Нийгэм хөгжиж байна. Үндсэн хууль бол статик. Хөгжихгүй байгаа шүү дээ, тэр зүйл заалт нь өөрөө хөдлөөд байхгүй шүү дээ. Тийм ээ. Нийгэм хөгжөөд байгаа учраас тэр нийгмийн хөгжлийн чирч яваа субъект нь Үндсэн хуулийн шүүх тэр үнэт зүйлийг зөв, ардчилсан ёс гэдгийг тухайлбал 39.1-тэй зөв тулгаж шалгах хэрэгтэй. Тэр тохиолдолд Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийг өөрийнхөө шийдвэрээр цогцлоон хөгжүүлж нийгэмтэйгээ алхуулж байна гэсэн ийм л утга санаа байна. Түүнээс биш яг энэ үнэт зүйлийг заагаагүй байна гэж болохгүй. Яагаад гэвэл ардчилсан ёсны зарчим өөрөө их гүнзгий, өргөн агуулгатай. Тэр нь 39.1-тэй яаж холбогдож байгаа юм бэ? л гэдэг байна. 39.1 нь. Парламентын ардчилал өөрөө хавсрахыг зөвшөөрдөг. Яаж хавсрах нь эрэлт, хэрэгцээнээс шалтгаалдаг. Тэр хэмжээ хэтэрвэл, түрүүн Алтангэрэл ярьж байх шиг байна лээ, тэр халдлагын хэмжээ зохимжит хэмжээнээс хэтэрвэл Цэц тэрийг таслан зогсоох ёстой.

Д.Чихаажав: Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар хэрэгжих ийм л асуудлууд үндсэндээ тавигдлаа гэж би ойлгож байна. Тухайлбал, Үндсэн хуульд өргөдөл, гомдол гаргах, иргэдийн эрхийг хязгаарлах, мэдээж шүүхийн тайлбар, хүний эрхтэй холбогдсон шийдвэрийг хянах гэх мэт ийм ийм зүйлүүд ярьж байна. Тэгэхээр үндсэн хуулийн судлаачид ярьж байна, би өөрөө мөн дэмждэг. Гэхдээ, энийг хэрэглэх болсон уу? үгүй юу? гэдэг дээр тухайлбал нэг асуулт байна. Үндсэн хуулийн хяналтад оролцож байгаа субъектүүдэд Үндсэн хуулийн цэцээс гадна түүнд гомдол, мэдээлэл гаргадаг субъектүүд байгаа шүү дээ. Иргэн, Үндсэн хуулийн байгууллагын толгойлогч нар ерөнхий шүүгч, улсын ерөнхий прокурор, ерөнхийлөгч гээд. Гэтэл 30 жилийн хугацаанд Үндсэн хуулийн байгууллагын удирдлагуудаас Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан гомдол тэр гомдлуудын 1 хувьд ч хүрэхгүй байна. 0,1 хувь хүрэх юм уу, үгүй юм уу гэдгийг би бол сайн үзээгүй. Гэтэл энэ хүмүүс мэдээлэл өгөхгүй, ийм хариуцлагагүй байж байх үед иргэдийн тэр гомдол гаргах эрхүүд хязгаарлагдвал хэн гомдол гаргах юм бэ? гэсэн нэгдүгээрт асуулт. Хоёрдугаар асуулт, Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал 1992 оны Үндсэн хуульд байна уу? эсвэл 2000 оны өөрчлөлтийн аль нь Үндсэн хуулийн үзэл баримтлал байна вэ? Түрүүн тэр асуулт асуугч хэллээ. 2000 оны 7 өөрчлөлтөөр бий болсон үзэл

баримтлалд харшилсан учраас саяын Үндсэн хуулийн цэцийн тогтоол гарсан гэсэн ийм асуулт асуух шиг боллоо. Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, үндсэн бүтэц гэж одоо 1992 оны Үндсэн хуулийг гэж ойлгож байна уу? 2000 оны нэмэлт, өөрчлөлтийн тэр хэсгүүдийг ойлгоод байна уу? гэж ийм асуулт байна. Гуравдугаарт нь, Үндсэн хуулийн цэцийн хяналтыг боловсронгуй болгоход Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн хариуцлага, ёс зүй маш чухал юм байна гэдгийг саяын үйл явдал харууллаа л даа. Энэ 02 дугаар тогтоолыг гаргахад оролцсон Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг эргүүлэн татах үндэслэл болох уу? Би энийг яагаад асуугаад байна вэ? гэхээр Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг эргүүлэн татах талаар Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын холбоо, санал болгосон байгууллагуудад хүсэлт гаргасан юм. Гэтэл Дээд шүүхээс хариу ирсэн. Дээд шүүхээс ямар хариу ирсэн бэ? гэвэл хууль зөрчсөн гэдэг нь шүүхээр тогтоогдоогүй. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5-р зүйлд заасан тийм нөхцөл байдал бий болоогүй. Тэгэхээр Үндсэн хууль зөрчсөн гэдгийг шүүх тогтоох ёстой юм уу? хэн тогтоох ёстой юм. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг бол тодорхой хэлж өгөөч ээ. Хоёрдугаарт, би Сарантуяад хэлэх гээд байгаа юм. Үндсэн хуулийн түрүүн би хэлсэн, хяналтын субъектийг өргөжүүлье гэж ярьж байна. Энэ дээр эс үйлдэл гэдэг юм ерөөсөө хянагддаггүй. Өнгөрсөн 2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр 1 удаа эс үйлдлийг хянасан. Яагаад гэвэл ерөнхийлөгч 1 удаа 6 жилээр томилогдоно гэдэг заалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд оруулаагүй нь Үндсэн хууль зөрчлөө гэсэн дүгнэлт гарсан. Энэ одоо эс үйлдлийг хянасан анхны тохиолдол байх. Тэгэхээр эс үйлдлийг хянах ёстой юм шиг санагддаг. Яагаад гэвэл би түрүүн хэллээ. Олон объектууд цэцэд гомдол гаргах эрх үүрэг бүхий хүмүүс гомдол гаргаагүй, ерөнхийлөгч, ерөнхий прокурор, ерөнхий шүүгч. Ерөнхий шүүгч сая нэг Эрүүгийн хуульд хандсан тухай сонслоо. Энэ ийм байна. Үндсэн хуулийн томилгооны асуудлыг түрүүн ярих шиг боллоо. Өнөөгийн энэ томилгооны байдал бол үнэхээр Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн хараат бус байдлыг алдагдуулж байна л даа. Өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн хянаж байгаа субъектийн шийдвэрүүдийн бараг 90 гаруй хувь нь хууль тогтоомжууд байгаа. Хууль тогтоогчдын шийдвэрүүд тавигддаг. Гэсэн атлаа хууль тогтоогч нар Цэцийн бүх гишүүдийг томилдог. Энэ ажиллагаа бол үндсэндээ болохгүй байна гэж би өөрөө хувьдаа үздэг. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг хэн томилдог болох вэ? гэвэл 1992 онд байсан 2 шаттай, 2 танхимтай ийм парламентын дээд танхим нь өөрөө Ардын их хурал нь Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилдог, чөлөөлдөг байвал хараат бус байдал, улс төрчдөөс, улс төрөөс, хууль

тогтоогчдоос хараат бус байдлаар байх нь алга болох болов уу? гэж би хувьдаа бодож явдаг юм. Баярлалаа.

О.Мөнхсайхан: Д.Чилхаажав гуайд баярлалаа. Эхний асуулт бол үндсэн эрхийн гомдол, шүүхийн шийдвэр зэрэг бусад объект Цэцийн хяналтад хамаарах асуудал бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хийгдэнэ л гэж хэлж байна. Миний хувьд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт шаардлагагүйгээр хийх боломжтой гэж байр сууриа илэрхийлсэн. УИХ, Ерөнхийлөгч, Дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гээд эд нараас хүсэлт бага өгч байна гэж. Дээд шүүх бол харьцангуй хууль хэрэглэж байгаатай холбоотой хүсэлтүүд өгөөд байгаа. Ерөнхийлөгчөөс хэд хэдэн удаа өгсөн. Ерөнхий прокурор, УИХ хоёр бол өгөөгүй байгаа. Үүний цаад шалтгаан юу вэ? гэхээр иргэний мэдээлэл өөрөө ямар ч шүүлтүүргүйгээр бүх юмыг аваачаад өгчихдөг. Их хурлын гишүүд шууд аваад хуулийн тодорхой заалт Үндсэн хууль зөрчсөн гээд мэдээлэл өгчихдөг, иргэний хувьд өгчихдөг шүү дээ. Энэ тохиолдол зөндөө байдаг. Энэ бол бас нөлөөлж байгаа байх гэж бодож байна. Иргэний мэдээлэл гэж бид нарын хэлээд байгаа зүйл бол actio popularis-тай төстэй. Энэ бол өөрөө маш аюултай. Сүүлдээ парламентын хууль арай гэж гардаг. Судална, боловсруулна, өргөн барина, хэлэлцэнэ гээд. Ардчилсан сонгуулиар гарч ирсэн парламентын тэр хуулийн үнэ хүндэд маш сөргөөр нөлөөлдөг. Хэн дуртай нь аваачаад хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаан үүсгүүлэх боломжийг нээчихдэг. Нөгөө талаар урвуулан ашиглах ийм эрсдэлтэй. Энэ мэт шалтгаанаар энийг халах нь зүйтэй гэдэг байр суурь байгаа. Энийг халсантайгаа зэрэгцээд яг л тэр ном, шинжлэх ухаанд нь байдгаар эрх нь зөрчигдсэн хүн л одоо ердийн шүүхэд хандах болон бусад замаар эрхээ хамгаалуулж чадаагүй бол ханддаг тэр ном журмаар нь явах. Ингэснээр урвуулан ашиглахгүй болох. Парламентын цөөнх мөн хүсэлт гаргадаг. Иймэрхүү байдлаар шийдчих юм бол болох байх аа гэж бодож байна. 3 асуулт учраас 2 багш маань нэмээд хариулах байх.

Ц.Мөнх-Оргил: 3 дахь асуулт нь, негатив хяналтыг асуугаад байна.

О.Мөнхсайхан: Негатив хяналтыг Цэц хэрэгжүүлсэн жишээг бол Жалхаажав гуай та өөрөө дурдлаа. Үндсэн хуулийн 66.2-т байгаа шийдвэр гэдэг бол нэг талаасаа тодорхой үйлдэл эсвэл тодорхой акт гаргах, нөгөө талаас эс үйлдэхүй багтсан гэж харж байгаа. Тэр утгаараа бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүйгээр хянагдах боломж бол Үндсэн хуульд байгаа юм болов уу? гэсэн бодолтой байна.

Ц.Мөнх-Оргил: Тухайн үед үйлчилж байсан эрх зүйн орчин ба ийм дүгнэлт гаргах эрхтэй гэж үзэж байна.

Ц.Мөнх-Оргил: Та дараа нь асуултаа асуугаад саналаа хэлээрэй. Дэс дарааллаар, дараалал авчихсан байгаа. Одоо Х.Тэмүүжин гишүүн дараа нь Мөнхцэцэг гишүүн.

Х.Тэмүүжин: Асуулт гэхээс илүүтэйгээр 3 санал байна. Анх Цэц 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийгдсэний дараагаас дунд суудал дээр их маргаан үүссэн. Тэр маргааны үр дүн гэдэг юм уу эсхүл тэр маргааны сургамж одоо хүртэл гүйцэт хариултаа авч чадаагүй учраас маргаан эцэслэгдэхгүй явж байгаа. Тэрний нэг нь яах аргагүй тэр УИХ-ын бусад хууль, шийдвэрүүд гэдэг үгийг Үндсэн хуулийн текст дээр байгаа тэр үгийг яаж ойлгох вэ? гэдэгт одоо хүртэл маргаж байгаа. Тухайн үед энэ маргааны нэг том шалтгаан юу байсан бэ? гэхээр ерөнхийлөгчийн зүгээс хориг тавигдсан. Тэгэнгүүт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд ерөнхийлөгч хориг тавих ёстой юу, үгүй юу гэдэг маргаан гараад энэ хууль мөн үү, УИХ-ын бусад шийдвэр үү гэдэг маргаан гараад ерөнхийлөгчийн тэр үйлдэлтэй манай судлаачид бараг 100 санал нэгдсэн байх. Ерөнхийлөгчид тийм эрх мэдэл олгогдохгүй гэдэг тийм байр суурь маш хүчтэй явсан. Тэгэнгүүт нөгөө тал нь Цэц яг ийм алхмыг хийсэн. Тэгэнгүүт Цэц дээр энэ нь байх уу, үгүй юу гэдэг маргаан гараад нөгөө УИХ-ын бусад шийдвэрүүдийг нь Цэц нэг өөрөөр ойлгоод, ерөнхийлөгч нэг өөрөөр ойлгох боломжтой юу гэдэг ийм асуудал хөндөгдсөн. Энэ одоог хүртэл эцэслэгдээгүй байгаа. Дахиад нэг үүнтэй холбоотой маргаан юун дээр явсан бэ? гэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудал дээр Цэцээс санал авдаг асуудал чинь юу юм бэ?. Цэцийн санал гэж буруу. Энийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр Цэц санаачлагчийн дайны санал оруулах юм уу эсхүл процессын нэг шалгуур болгоод Цэцээс зөвшөөрөл авч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орох юм уу? тийм маргаан мөн өрнөсөн. Энэ дээр ямар нэгэн шийдэл, УИХ-аас нэгдсэн байр суурь очоогүй бас маргаантай явж байгаа. Үндсэн эрхийн холбоотой асуудал дээр Б.Чимид багшийн байр суурийг манай ихэнх багш нар яг өөр өөрсдөдөө тааруулж тайлбарлах гэж оролддог. Б.Чимид багш “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” дээр одоо байгаа Үндсэн хуулийн боломж дээр нь ашиглаад иргэний үндсэн эрхийн хяналтыг Цэцэд өгч болно гэдэг байр суурь илэрхийлээд тэр баримт бичиг дээр угаасаа улс төрийн зорилт болгоно гээд биччихсэн юм. Харамсалтай нь маш олон хүн, үе үеийн цэцийн гишүүд энэ эрх мэдлийг Цэцэд авахын эсрэг зогсдог. Өөрсдийн Цэцийн үйл ажиллагааны практикаа гол болгож өмнөө бариад энэ бол бидэнд төвөгтэй байдал үүсгэх юм байна гээд нуухыг нь авах гэж байж сохлов гэх зэрэг их гоё гоё үгээр үүний эсрэг зогсдог. Энэ зогсож байгаа бодлогоо ерөнхийлөгчтэй хавсаалдах

байдлаар миний санаж байгаагаар Үндсэн хуулийн цэцтэй холбоотой энэ шинэтгэлийн хоёр ч хуулийг нурааж гацааж зогсоож байсан. Үндсэн хуулийн яг байгаа текст дээр нь хангалттай боломж байгаа юм. Анх Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг бичихдээ алдаа гаргаж бичсэн байсан. Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг юу гэж бичсэн бэ? гэхээр Үндсэн хууль дээр гурван бүрэн эрхтэй. “Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болгоно.” гэсэн текст байсны гурван бүрэн эрхийн нэгийг нь малгай болгож тавиад дээд хяналт тавихдаа маргааныг магадлан шийдвэрлэнэ, өргөдөл гаргана гээд биччихсэн. Энэ практикаараа олон улирал явж байгаа. Энэ практикаа ерөөсөө өөрчлөхгүй байгаа. Цэцийн тухай хуулийн тэр зүйл заалтыг өөрчилсөн ч гэсэн Үндсэн хуулийн яг текст дээр бичсэн ч гэсэн бүрэн эрхээ нэмэгдүүлэхийг ерөөсөө зорихгүй байгаа. Тэгэхээр дээд хяналт тавина гэдэг нь ямар чиг үүрэг вэ?, маргааныг магадлан шийдвэрлэх гэдэг нь ямар үүрэг юм бэ?, дүгнэлт гаргана гэдэг нь ямар чиг үүрэг юм бэ? энэ гурвын үр дүнд Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа яаж болж байгаа юм бэ? гэдэг байдлаар задалж утгажуулахгүй бол одоо болтол зөвхөн дүгнэлт гаргах эрх мэдлээ тойрч эргэлдэж байгаа. Маргааныг магадлан шийдвэрлэх гэдэг эрхийг ч гэсэн бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа. Үүний ард талын заалт дээр нь дахиад юу байгаа вэ? гэхээр иргэн өргөдөл, мэдээлэл гаргана. Ийм ийм асуудлаар Цэц маргааныг шийдвэрлэнэ гэж байгаа. Дараа нь маргаантай асуудлаар хянан үзэж дүгнэлт гаргана. Хянан үзэж, хянан шийдвэрлэнэ гэж 2 текст бичигдчихсэн байгаа. Гэтэл зөвхөн хянан үзэх гэдэг энэ эрх мэдлийг тойроод Үндсэн хуулийн бүрэн эрх хэрэгжиж байгаа бөгөөд процессын хүрээнд зөвхөн энд хүрээд явж байгаа. Дахин хянан үзнэ гэдэг нь өмнөх хянан үзэж байгаа дүгнэлтийн хэмжээнд л ярьж байгаа. Яаж иргэний өргөдлийг, маргааныг шийдвэрлэх вэ? гэдэг энэ чиг үүргүүдийг нэмэх боломж нь үндсэн эрхийн хүрээнд бол хангалттай гарч ирэх боломжтой байгаа боловч энэ текстүүдтэй холбоотой судалгаанууд, шинжлэх ухааны тайлбарууд, судлаачдын байр сууриуд гараад миний санаж байгаагаар 22 жил болж байна. 22 жилийн дотор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт зөрж шахаад байгаа болохоос биш Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр наана нь энэ асуудлуудыг шийдэх гарц ямар байгаа вэ? гэдэг дээр хангалттай ярилцахгүй байгаа. Хангалттай ярилцахгүй байгаагаас гадна процессын асуудал. Процессын асуудал дээр 2016 оны 1-р сарын маргаан байна. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг ил тод болгохтой холбоотой хууль тогтоомжийн өөрчлөлт хийгдсэн чинь Хуульчлаагүй байгаа нь Үндсэн хуулийн цэцэд маргаангүй, УИХ алхаа цохиогүй байгаа шүү дээ,

маргаанаа авч хэлэлцээд тэр заалтуудыг хүчингүй болгосон. Тэрний байгаа 2, 3-н кейс байгаа. Манай Үндсэн хуулийн цэцэд байсан маш олон хүмүүс үүнийг шүүмжилж байна лээ. Тухайлбал, УИХ-ын тогтоол гаргаад нарийн царигтай холбоотой төмөр замын хэргийг шийдсээр байтал төсвөөс мөнгө гаргаад Засгийн газар хууль бус шийдвэр гаргаад ерөнхийлөгч нь оролцоод тэнд өөр царигаар төмөр зам тавьж байснаа энэ нь гэмт хэрэг болоод эхлэнгүүт Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргаад тэр төмөр замыг барьж байгаа хүнээр гомдол гаргуулж байгаад Цэцээр хүчингүй болгуулчхаж байгаа юм. Одоо тэр хүмүүс нь буцаад эрүүгийн хэргээр шалгагдаж байгаа. Гэхдээ Цэц гэмт хэргийн хамсаатан болчихсон. Энэ мэт бодитой шийдвэрүүд зөндөө байгаа. Цөөн биш. Тэгэхээр яаж Цэцийн шийдвэрийг гаргаж байгаа процессыг ил болгох вэ? Үүнтэй холбоотой бас хэд хэдэн гомдол маргаанууд гарч байсан. Тэрний хамгийн том энгийн жишээ. Цэцийн зөвлөлдөх тасалгаа гэдэг ойлголт ер нь дэлхийд байдаг уу? Асуулт шүү дээ. Парламентын буюу ард түмний төлөөлөгчдөөр сонгогдож байгаа хууль тогтоох үйл ажиллагаа бүх нөхцөлөөр энд авчрахыг шаардана. Тэр хуулийг нь хүчингүй болгож байгаа Цэцийн зөвлөлдөх тасалгаа гэдэг ойлголт ийм далд байх уу? Үндсэн эрхийн буюу тийм маргааныг шийддэггүй энэ Цэц яагаад зөвлөлдөх тасалгаатай байдаг юм бэ? Тэр нь яагаад нууц байдаг юм бэ? Цэцийн гишүүд нь яагаад тусгай санал бичиж болдоггүй юм бэ? Бичсэн эсхүл байр суурь нь яагаад Цэцийн шийдвэртэй цуг ил гарч болдоггүй юм бэ? гэдэг энэ асуултыг тавьсны, эсхүл энэ хуулийг хэрэгжүүлэх гэж оролдсоныхоо төлөө юу болсон гэхээр Цэц, ерөнхийлөгч 2-ын хавсаадалтайгаар тэр хуулиудыг татаж авч байсан тохиолдлууд байгаа. Тэгэхээр наад Цэцийн үйл ажиллагааг ил тод болгох уу? Хаалттай, нуугдмал байдлыг яаж ингэж хөрсний цаанаас ил гаргаж ирэх үү гэдэг процессын хувьд маш чухал шийдлийг хүлээж байгаа. Хоёрт нь үндэслэл, нийт хамтарсан гарын үсгийнхээ ард нуугдаад үлддэг цэцийн гишүүдийн хариуцлагагүй шийдлийг яаж ил болгох вэ гэдэг асуудал бас их чухал байгаа.

Ц.Мөнх-Оргил: Цэцийн зөвлөгөөний танхимын нууц гэж асуудал яриад байна. Нэгдүгээрт, зөвлөгөөний танхим гэж байна уу?, хоёрдугаарт, нууц гэж байна уу? гэж асууж байна. Дараа нь тэр тусгай санал гэж байна. Тусгай санал ч яахав ерөнхийдөө ойлгомжтой. Тэнд сууж байгаа хүмүүс бүгд ойлгочихсон, тодорхой асуудал ярьсан. Ер нь яахлаараа ч шүүгч хүн тусгай санал бичиж болдоггүй юм. Яахлаараа ч хэвлэж болдоггүй юм. Тэр их ойлгомжгүй сонин заалт байгаа юм. Тэрийг хаячихъя. Зөвлөгөөний танхимын нууцын асуудлыг ярья.

Ц.Сарантуяа: Зөвлөлдөх тасалгаа нь шүүхийн журмаар үйл ажиллагаа явуулахад заавал байх ёстой, энэ бол хуралдааны нэг хэлбэр. Тэр зөвлөлдөх тасалгаанд юу хийдэг вэ? гэхээр гишүүд энэ маргааны талаар өөрийнхөө байр суурийг илэрхийлдэг. Ямар шийдвэр, ямар үндэслэлээр гаргах вэ? гэдэг энэ саналаа хэлдэг. Энэ зөвлөлдөх тасалгааны үеэр магадгүй заавал нийтэд ил болж болохгүй хувь хүний мэдээлэл, төрийн, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой, , хүний нэр, эрүүл мэндтэй холбоотой ийм мэдээллүүд яригдах магадлал байдаг учраас тэр үндэслэлийг гаргаж тавьж шалгаж байж байж шийдвэр гаргадаг, санал хураадаг. Ийм учраас шүүхийн журмаар үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд зөвлөлийн хэлбэрээр биш зөвлөлдөх тасалгаа байхаас өөр аргагүй. Энийг бол доторх дэгээрээ зохицуулаад явчихдаг. Тусгай саналын асуудлыг 1993 онд би хүртэл хөндөж тавьж байхдаа мэддэггүй байсан байхгүй юу. Цэцэд орж ажиллаагүй байх үедээ. Зүгээр л цөөнх болсон гишүүн өөрийнхөө байр суурийг нийтэд илэрхийлээд ийм тунгалаг шүүх байх ёстой, гэж үздэг. Шүүх бол үйл ажиллагаагаа ил тод явуулах ёстой. Цөөнхийн байр суурь ил тод байж гэмээнэ, олонх хариуцлагатай болно гээд би ийм юм яриад яваад байдаг байсан юм. 1993 онд шүү дээ. Цаг явахын хэрээр хугацааны эрхээр хүн чинь оймс элээгээд арай илүү ойлголттой болно. Зөвлөлдөх тасалгаанд тусгай саналыг хэрвээ нөгөө гишүүн би өөрөө бичье гэвэл бичих эрх одоо хүртэл нээлттэй. Өөрөөр хэлбэл, би тусгай санал өгье гэж гишүүн өөрөө үзэх юм бол шүү дээ. Гэхдээ тэрийг хэвлүүлэх гэж байгаа юм биш хавсаргах эрх нээлттэй байгаа. Хэвлүүлэх нь арай илүү нэг алхам урагш байх л даа. Түүнээс бус өөрийнхөө илэрхийлэх гэсэн саналыг заавал тусгай саналд нийтэд хавсаргах үүрэгтэй болчих юм бол заавал автоматаар хавсаргаад байдаг болчих юм бол зөвлөлдөх тасалгаанд саналаа нээлттэй хэлэх тийм гишүүн олдохоо болих байх аа. Маргааныг бүрэн дүүрэн шийдвэрлэх боломж хумигдана.

Ц.Мөнх-Оргил: Би уг нь ингэж асуугаад байгаа байхгүй юу Сараа багшаа. Тусгай саналаа бэлдчихлээ, хавсаргачихлаа, тэгээд нөгөө шүүгч тусгай саналаа хэвлүүлмээр байна шүү дээ. Тийм үү.

Ц.Сарантуяа: Тийн тийн.

Ц.Мөнх-Оргил: Хэвлэ гээд шахаад байгаа юм биш байхгүй юу. Сонголт нь байгаа. Би хэвлэж ч болно, хэвлэхгүй байж ч болно. Тэгсэн чинь Дээд шүүхийн шүүгч нарын тусгай саналыг ч хэвлэж болохгүй. Цэцийн гишүүдийн тусгай саналыг ч хэвлэж болохгүй гээд Цэц дүрэм гаргачхаад байгаа байхгүй юу. Тэрийг л Х.Тэмүүжин гишүүн асуугаад байна л даа.

Ц.Сарантуяа: Тийн. Ер нь одоо Тусгай саналтай гишүүн хэрвээ өөрөө хүсэх юм бол тэрийг нийтэлж болох нь яваандаа Үндсэн хуулийн цэцийн холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох нэг алхам байж болох юм. Тусгай саналаа нийтэд хүргэх асуудал. Намайг Цэцийн гишүүн болохоос өмнө өвгөн партизаны гэгчээр Үндсэн хуулийн цэц ямар олонхоор шийдвэр гаргаснаа зарласан юм гэнэ билээ нэг хэсэг. Үүнээс болоод жигтэйхэн их нийгэмд улс төржилт явагдаад энэ гишүүн л ийм санал гаргасан байж таараа, нөгөө гишүүн өөр санал гаргасан байж таараа, энэ манай талын, энэ танай талын гээд ийм юм яваад яригдаад ирэхээр энийг зогсоосон юм гэж ойлгосон.

Ц.Мөнх-Оргил: Ойлголоо. За баярлалаа. Ц.Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Өнөөдрийн хэлэлцүүлгийн гол үзэл баримтлалыг бол хөндөж байна. Үндсэн эрхийн асуудлыг бол Үндсэн хуулийн цэцээр шүүх нь бол зарчмын хувьд зөв. Гэхдээ О.Мөнхсайхан багш Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр Үндсэн хуулийн үндсэн эрхийн асуудлыг суулгаж болно гэдэг асуудлыг ярьж байна. Миний хувьд бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж 66.2 дээр шинэ заалт оруулж байж үндсэн эрхийн асуудлыг Цэц рүү өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Хоёрдугаарт нэг ийм асуудал байна. Манай Үндсэн хуулийн үүрдийн баталгааг тусдаа хуулиар гаргаад өгчихсөн байгаа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар. Бусад улсуудад Үндсэн хуулийн процессын практикаас харахад энэ нь манай хууль хүчгүй буюу тусдаа хууль байгаа учраас УИХ Үндсэн хуулийн бус ердийн хуулийнхаа процессоор өөрчлөөд явчхаж байгаа юм. Жишээлбэл, саяны энэ зургийг харвал Германы Үндсэн хуулийн 79.3 дээр бас байгаа юм. Үүрдийн баталгааг тусгайлан заагаад оруулчихсан. Миний хувьд Үндсэн хуулийн гол суурь үзэл баримтлалуудыг Үндсэн хуульдаа тусгах нь зүйтэй гэдэг судлаачидтай санал нэг байдаг юм. Үүн дээр гол судлаачид болох Ц.Сарантуяа багш, Х.Сэлэнгээ багш юу гэж боддог юм бэ?

Сая Х.Тэмүүжин гишүүн чухал асуудал дурдсан шүү дээ. 68.1 дээр буюу Үндсэн хуульд нэмэлт оруулах эрхтэй албан тушаалтан хууль санаачилна. Гэхдээ Үндсэн хуулийн цэцээс санал авна гэдэг маань сая 8 сард асуудал үүсэхэд бол яригдсан. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийг дэмжлэг олгох тухай хуулийн төсөл дээр 68.1-ийг илүү тодорхой болгох шаардлагатай. Цэц яг ямар санал өгөх юм бэ. Энийг бол хэлмээр байна. Сүүлийн асуулт нь О.Мөнхсайхан доктор бол Үндсэн хуулийн цэцийг 9 жилийн хугацаатай 1 удаа сонгоно гэсэн санал оруулаад яваад байгаа. Үүн дээр манай бусад хуульчид маань юу гэж боддог юм бэ? Германд бол 12 жилээр 1 удаа. Энэ бол улс төрөөс хараат бус хамгийн чухал

зүйл байгаа. Үндсэн хууль, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд бид нар Үндсэн хуулийн гол эрхүүдийг цэц рүү оруулсан ч гэсэн хамгийн маргаантай асуудал улс төртэй холбоотой байдаг. Тийм учраас яаж цэцийн гишүүдийг улс төрөөс хараат бус болгох вэ? Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийхээр бол тодорхой ийм саналууд та нарт байгаа болов уу?

Ц.Сарантуяа: Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг шүүгчид тавигдах шаардлагатай дөхүүлбэл зүгээр гэж боддог. Нэн ялангуяа хэтийн ирээдүйд магадгүй аль нэг шатны шүүхийн эцсийн шийдвэрийг Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчиж байна уу? үгүй юу? гэж авч үздэг болох юм бол, тухайлбал, шүүгч Үндсэн хуулийн тодорхой зүйл заалтыг зөв ойлгож уу? үгүй юу? гэдгийг хянах тийм зохицуулалт ороод ирэх юм бол Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлага шүүгч болох болзлоос доогуур байж болохгүй. Тийм учраас нээх жигтэйхэн олон юм бодолгүйгээр хамгийн нэгдүгээр шаардлага бол шүүгч болох болзол гэж би үзэж байна. Би жишээ татахаар гадаадын юм битгий ярь гэдэг л дээ. Гэхдээ яахав нэг ярьчихъя. Германы Үндсэн хуулийн шүүхийн 16 гишүүн 2 танхимтай. 16 гишүүний тус бүр 3 нь Холбооны шүүхийн, Холбооны ердийн аль нэг шүүхийн, Дээд шүүхийн шүүгч байсан хүн байх болзолтой байдаг. Энэ байгууллага хууль хэрэглэдэг байгууллага тул ийм зөвлөлдөх тасалгаатай, ийм шүүгч болох болзол хангасан ийм хүн байх шаардлагатай гэж үзэж байна. Бусад өөр шалгуур яаж тавихыг нь энэ манай хуулийн төсөлд зэрэгт заах байх л даа. Та бүхэн ярилцах биз. Нөгөөтэйгөөр үндсэн эрхийн хяналтыг оруулаад ирэх юм бол орон зай байна. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон Үндсэн хуульд өөрт нь дээд хяналт гээд тавьсан бичсэн байна. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж байгаа юм чинь болохоор үндсэн эрх орох юм. Энэ бол Үндсэн хуулийн хамгийн чухал бүрдүүлбэр гэж ярьж байна. Тийм ээ. Энэ бүгдийг ойлгоод байна. 1993 оноос хойш ярьж байна. Миний хувьд, би өөрөө хуульч хүний хувьд энэ тоочих зарчим, ерөнхийлөн томъёолох зарчим нэг хуульд хоёулаа хослоод орохыг буруу гэдгийг л ойлгоод байна. Нэг хуульд хослоод орчихсон байхыг хараагүй. Магадгүй энэ нь жигтэйхэн гоё хувилбар байж болох юм. Би гэхдээ эрх зүй өндөр хөгжсөн орны холбогдох хуульд ийм зүйл хараагүй. Аливаа хаана ч нэгэн газар нэг их байхгүй тийм юмыг оруулж ирэх болгондоо манайх хямралд ордог шүү дээ. Хаа нэгэн газар зүй тогтол болоогүй юмыг оруулж ирэхэд сүүлд нь хямрал учирвал хэн хариуцах юм бэ? Тэгэхээр Үндсэн хуульд болдог бол өөрчлөлт оруулаад Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх асуудлыг ерөнхийлөн томъёолох зарчмаар өөрчилчихвөл зүгээр байна.

Хоёрын хооронд хийж болно. Гэхдээ та бүхэн бод л доо. Энэ нэмэлт, өөрчлөлтийг хянах уу? үгүй юу? гэдэг дээр 20 хэдэн жил маргаж байна шүү дээ. Яг энэ шиг тухайн энэ үндсэн эрхийг хянах уу? хянахгүй юу гэдэг дээр маргаад эхлэх байх гэж би айж эмээж байна. Тийм учраас хийвэл цэвэрхэн, зөв номоор нь хийвэл зүгээр юм аа гэж бодох юм. Гишүүнтэй санал нэг байна.

Ц.Мөнх-Оргил: Өөрөөр хэлбэл Сараа багш та Ц.Мөнхцэцэг гишүүнтэй санал нэг байна гэсэн үг байна шүү дээ. Тийм үү.

Ц.Сарантуяа: Тийн.

Ц.Мөнх-Оргил: Таны энэ хэлж байгаа асуудлуудыг Цэцийн бүрэн эрхэд хамруулаад шийдүүлье, нэг мөр шийдүүлье гэдэг нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийж байж, хийвэл үр дүнтэй болно оо л гэж хэлж байгаа юм байна шүү дээ. Санал нэг байна гэсэн үг үү?

Ц.Сарантуяа: Зүгээр нэг үр дүнгээс гадна сүүлд нь хямрал гарахгүй, тийм ээ. Бид нар хожим нь толгойгоо шаахгүй. Дахиад ийм хурал хийгээд сууж байхгүй. Үнэт зүйлийг, үүрдийн баталгааг Үндсэн хуульдаа заагаагүй учраас арга буюу 2010 оны хуульд Б.Чимид багш ердийн хуульд оруулсан юм шүү. Уг нь Үндсэн хуульдаа заачихвал төгс жагсаалт биш ч гэсэн дурдчихвал зүгээр ээ. Бас санал нэг байна.

Ц.Мөнх-Оргил: Заа ойлголоо.

н.Мөнхдалай: Мөнхдалай гэдэг хүн байгаа юм аа. Үндсэн хуультай холбоотой үг хэлэхэд 1989 оны 12-р сар, 1990 оны 1-р сард Францын Үндсэн хуулийг Орос хэлнээс орчуулсан хүн байгаа юм.

Энэ бол 2012 оны Бяраагийн Чимид гуайн эх барьсан Ардын их хурлын 420 хэдэн депутатуудын баталсан энэ Үндсэн хуулийн араг яс нь боллоо шүү гэж Бяраагийн Чимид гуай надад бол хэлж байсан юм. Уншаад үзэхэд хавар, намрын чуулганы эхлэх хугацаа, дотор нь бүлэг тааралдаад. Тэрнээс хойш бол би Үндсэн хуулийг зохих хэмжээгээр судалсан гэж хэлж болохоор хүн байгаа юм. Гарчигтаа байж байна. Эрүүгийн хууль, бусад хуулиудад хариуцлагын тогтолцоо, ял шийтгэлийн хуулийнхаа төгсгөл рүү нь бичээтэй байдаг. Үндсэн хуульд бол тийм юм байхгүй. Хяналтыг бол хөндлөнгийн 9 хүн хариуцна гээд Цэц гээд орхичихсон. Тэр хүмүүс бол Үндсэн хуулийн философи, дээрээс нь логик утгыг бол мэдэхгүй харагдаад байгаа юм. Хуульчид нэг нийгмийн байгууллагын иргэний доторх харилцааг ойлгохоор бол хууль хэвлэлийнхэн маргаад үсгээр биччихвэл болчих гээд байгаа юм. Гэтэл хүн төрөлхтний оршин тогтнож байгаа философиор бол ерөөсөө хоол, хувцас, орон сууц, дээр нь агаараар амьсгалаад гишгээд явж байдаг оршихуй газар нутгийг хэлээд байгаа юм. Манайх бол философигүй хуулиуд батлаад явдаг. Жишээлбэл, Үндсэн хууль дээр юу хэлэх вэ?

гэвэл 70 заалт 6 бүлэг байгаа шүү дээ. Үүний дотор байгаа эрх гэдэг үгийг тоолоод үзэхэд хүний эрх нь 32 үг байгаа юм. 32 өгүүлбэр, үг, үсгүүд байгаа юм. Дээр нь Засгийн газар, УИХ, Үндсэн хуулийн цэц, Шүүх эрх мэдэл, Орон нутаг, засаг захиргаа гээд нийтдээ 111 үндсэндээ эрхийн чиглэлтэй. Хариуцлага гэдэг үг бол ерөөсөө ганцхан байгаа юм. Тэр нь ерөнхийлөгч УИХ-ын өмнө ажлаа хариуцна. Тэр нь бол хэрэгждэггүй. Элбэгдорж нэг удаа тайлан тавьсан. Их хурлын Дэмбэрэл гэдэг хүн байсан. Ерөнхийлөгч өөрийнхөө үүргийг 200 дахин биелүүллээ гэж Дэмбэрэл гуай хэлсэн шүү. Гэтэл бодит амьдрал дээр 200 битгий хэл 10, шударга ёсны биелэлт байхгүй байна. Энэ утгаараа философигүй байна. Дээрээс нь логик утгагүй байна. Дээрээс нь Үндсэн хуулийг 1992 онд баталснаас хойш 3 удаа өөрчлөөд хаялаа. 2000 оны нэмэлт, өөрчлөлтийн гол баатар бол Монгол ардын Хувьсгалт намын дарга байсан Намбарын Энхбаяр байсан. Ардчилсан намаас Ц.Элбэгдорж. Бяраагийн Чимид гуай бол өөрөө амьд байж байсан. Дээрээс нь Н.Багабанди ерөнхийлөгч баталж гарын үсэг зурсан. Энэ нэг хэдэн эзэд байна. Түүхэнд гарах байх. Энд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 1990 онд хийхдээ нөгөө 76-г чинь 39 нь хуралдаа ирээд хурал хүчинтэй болно. 39-ийн олонх нь 20, 20-оос 30 хувь нь ирээд хууль батална. Энэ хуулиуд бол бүгд хүчин төгөлдөр бус хуулиуд Үндсэн хуулийн агуулгаар. Энийг Монгол ард түмэн биелүүлэхгүй байх эрхтэй. Тэр дотроо бол Монгол ардын 30-р Их хурлын тайлан илтгэлд 800 хүний эрхийн зөрчил байна. 318 хууль байна гээд ярьсан. Ингээд замбараагүй болсон. Хүн төрөлхтөнд шинжлэх ухааны үндэстэй тэр бичгийн хэлбэрээр хүн төрөлхтний хийсэн 2000-иад жилийн түүхтэй юм. Үлгэр, домог, Одиссей. 1000-иад жилийн түүхтэй манай Нууц товчоо зэрэг. Энэ бүх бичиг баримт сүүлдээ хууль, утга, уран зохиол зэрэг янз бүрийн шинжлэх ухааны салбар гээд сүүлдээ цаасандаа дарагдсан л даа. Энэ дээр бол Нобелийн шагналын хороо утга зохиолын салбарынхан дүгнэлт гаргасан. Дэлхий дээр дүгнэлт гаргадаг гуравхан газар байгаа. 1-рт, НҮБ байна. 2-рт, ДЭМБ. 3 дахь нь , Нобелийн шагналын хороо бол утга зохиолоор дамжуулаад хүн төрөлхтний бас нэг,

Ц.Мөнх-Оргил: Та одоо яг Үндсэн хууль руугаа ор.

н.Мөнхдалай: Манай Монголын 800 хуулиас Үндсэн хууль бол хамгийн утгагүй, эрүүл бус ийм хууль гэдгийг би хэлэхийг хүслээ. Юу нь эрүүл бус байна вэ? гэхээр нэгдүгээрт, сая одоо тэр 2000 оны өөрчлөлтийг ярилаа. Тэнд чинь одоо би түрүүн хэлчихлээ. Ерөөсөө залхуурлын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт. 2 дахь өөрчлөлт нь О.Мөнхсайхан голдуу дурдсан. Энэ бол Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт Д.Лүндээжанцан гуай эх барьсан. Тэр дээр ганцхан үгийн утга

л ярина. Шүүхийн сахилгын хороо гээд шүүхийг шүүдэг ийм нэг байгууллага Үндсэн хуульд оруулаад ирчихсэн. Би Шүүхийн сахилгын хорооны 10 гишүүн байдаг юм байна. Хуралд нь 2 удаа суулаа. Та болоод маргааны талууд ажиглагчийн эрхтэй оролцоно шүү. Үг хэлэх эрх байхгүй гээд хурал даргалагч ганцхан үг хэлж байна. Гэтэл нөгөө Үндсэн хууль дээр чинь бол үг хэлэх эрхтэй гэж бичээд байдаг. Үндсэн хуулийг чинь уландаа гишгэж байна шүү дээ. Хамгийн сүүлд нь одоо хэлье. УИХ-ын гишүүдийг 150 болгоё оо гээд 32 нам уралдаад Монгол Улсыг сүйрүүлэх нь байна шүү дээ. Би судалж үзсэн.

Ц.Мөнх-Оргил: Тэр асуудлын талаар Мөнхдалай гуай өнөөдөр энд яриагүй байгаа тэрийг дараа яриарай.

н.Мөнхдалай: Дэлхий дээр нэг парламентын гишүүнд оногдох хүний тоо бол дунджаар 160 орчим. Хятад улс бол 3000 депутатуудад 1 хүнд 485000 хүн байна. Ийм учраас манайх нэмэхгүй харин хасна. Одоо 76 хүнийг хүн амын тоонд хуваавал, дэлхийн дунджийг харвал манай бол 21 хүнтэй байхад болохоор байгаа шүү. Энийг анхааралдаа аваарай.

Ц.Мөнх-Оргил: Одоо таны цаг дууссан. Цаг чинь дууссан. Та микрофоноо зохион байгуулагчид өг.

н.Мөнхдалай: Би энийгээ хэлэхгүй бол болохгүй. Би Эрүүгийн хуульд нэг бүлэг оруулсан. Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг гэдэг бүлэг. Тэрийгээ улс төрчдөд бол өгсөн. Энийг та нар хууль санаачлах эрхтэйгээр Засгийн газар, ерөнхийлөгч, УИХ хуулийг өргөн бариач ээ гээд байгаа юм. Манайх бол Үндсэн хуулийн эсрэг миний тоолж үзэж байгаагаар 35 гэмт хэрэг харагдаад байна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

н.Мөнхдалай: Сахилга гэдэг үг Шүүхэд бол тангаргаа өргөнө. Хариуцлага, шударга ёсны хороо гэж байгаа. Хариуцлага, шударга ёсны хороо гэж Үндсэн хуульдаа нэмэлт оруулах хэрэгтэй байгаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

П.Сайнзориг: Би ерөөсөө хоёрхон асуулт асуучихъя. Нийт илтгэгч нараасаа асууж байгаа шүү. Сэдвүүд мөн сонирхолтой байна. Маш олон жил ярьж байгаа сэдвүүд байна. Зарим хүмүүстэй нь 100 хувь санал нэг байна. Цэцийн хяналтын субъект, объектыг ярихаасаа өмнө Цэц гэдэг байгууллагынхаа мөн чанарыг бид хэд зөв тодруулж чадсан уу? гэдэг дээр судлаачид маань хэлээч. 1992 оны Үндсэн хуулийн цэцийн мөн чанарын хувьд бусад орон шиг зөвлөл шиг байгууллага эсхүл шүүх тал руугаа байгаа юм уу эсхүл тэдний хүрээнд хийчхээд энэ бол шилжилтийн үеийн зохицуулалт, гэхдээ байгаа байхгүй юу. Энэ чиглэлээр хяналтын объектыг ч юм уу, субъектийг дэлгэрүүлж болно. Процедурьг илүү нарийвчилж болно. Гэхдээ байгууламжийнхаа мөн

чанарын хувьд яг одоогийнхоороо явж болох уу? Мэдээж энэ дээр заримыг нь Үндсэн хуульд гар хүрч байж л шийдэх асуудлууд байж магадгүй. Хоёрдугаарт, хяналтын субъект, объектыг жоохон тоочиж бичсэний асуудлын цаана дэлгэрүүлж авч үзэх нэлээн олон юмнууд байгаа. Жишээ нь, түрүүн би нээлттэй дээр хэлсэн. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр шат, шатны Үндсэн хуулийнхаа, Улсын дээд шүүхийн шийдвэрийг ч хүчингүй болгож байдаг ийм сонин сонин шийдвэрүүд гарлаа. Бүр хяналтгүй. Энийг Хууль зүй, дотоод хэргийн яам оролцох ямар ч бололцоогүй ийм шийдвэрүүд гарч байна. Хоёрдугаарт бол сүүлийн үед нэлээн шүүмжлэлтэй хандаж байгаа зүйл бол УИХ-ын байнгын хорооны шийдвэр. УИХ-ынх нь тогтоол хуулиа давсан, чиг үүрэгт нь байхгүй асуудлаар баахан байнгын хорооны шийдвэрүүд гарч байгаа. Энийг хэн хянах юм бэ? гэдэг асуудал. Эсвэл олон улсын гэрээний асуудлуудыг урьдчилж хянуулж болох уу? гэдэг ч юм уу. Магадгүй Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх хууль дээр байгаа шүү дээ. 1992 оны 02-р сарын 12-ны өдрөөс өмнөх хуулиудыг хянахгүй гэсэн мөртөө өнөөдөр тэр Үндсэн хуулийн хавсралт хууль буюу Шилжилтийн хуулийн хуулиар бүх шинэчлэлтийг хийж чадаагүй. Газрын хэвлийн тухай хууль ч юм уу, Засгийн газрын эрх олгох гээд. Маш их хуулиуд ашиглагдаад хэрэглэгдээд яваад байгаа. Үндсэн хуульд гэдэг юм уу энэ хууль дээдлэх зарчмаа хамгаалах асуудал дээр энэ бүх хязгаарлалтуудыг та бүхэн юу гэж боддог вэ? товчхон товчхон байр сууриа хэлчхээч. Хоёрдугаар асуудал нь эс үйлдэхүй дээр байр сууриа хэлээч. Хамгийн анхны эс үйлдэхүй бол Иргэний процессын хууль дээр эс үйлдэхүйг Цэц авч шийдэж процесс дээр өөрчлөлт оруулж байсан парламент. Тэндээсээ эхлээд жишиг тогтоод эс үйлдэхүйг хянадаг болж байгаа. Энэ дээр судлаачид маань ямар байр суурьтай байна вэ? Сүүлийн хоёрхон санал байна. Алтангэрэл судлаачтай адилхан байна. Хуулийн хэрэглээний эрэмбийн асуудлыг бид нар зөв ойлгож явах ёстой байна. Өөрөөр хэлбэл, хамгийн түрүүнд нэг удаагийн шинжтэй онцгой хууль тэгээд тухайлсан хууль, тэгээд ерөнхий хууль үйлчилдэг, эрэмбийн хувьд. Гэтэл органик хууль юм уу, ердийн хуулийн асуудлыг бид нар ихэнхдээ хольж хутгадаг буюу Хууль батлах кодыг бид үндсэндээ хаячхаад байгаа. Тэгэхээр сүүлдээ хууль батлах кодгүй болоод ирэхээр УИХ-ын олонх гэдэг юм уу, 50+1 бүх хуулиудыг өөрчлөх юм уу, боломж байгаад байгаа учраас бүх зүйлүүдийг сүүлдээ Үндсэн хууль руугаа чихэж оруулах ийм хандлага руу явж эхэлж байх шиг байна. Бид нар цаашдаа органик буюу Үндсэн хуулийн шинжтэй хуулиудыг сонгогдсон гишүүдийн 66 хувь баталдаг гэдэг ч юм уу, энэ хууль батлах кодуудыг Үндсэн хуульдаа зааж өгнө. Өөрөөр хэлбэл,

Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа жигдэрнэ. Үндсэн хууль руу халдах байдал ч гэсэн багасна гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас байр сууриудаа хэлээч ээ гэж. Хамгийн сүүлийнх дээр нэг юм байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль дээр логикгүй асуудлууд байна. Жишээ нь, УИХ-ын гишүүн өөрийнхөө бүрэн эрхийг нэмэгдүүлэх асуудлаар, Засгийн газар өөрийнхөө бүрэн эрхийг нэмэгдүүлэх асуудлаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт санаачилж болохгүй гээд байдаг. Гэтэл Үндсэн хуулийн зүйл заалт болгон буюу санаачилга маань өөрөө бусад зүйлтэйгээ уялдах ёстой. Энэ хязгаарлалтуудаас яагаад шүтэлцээг нь хийж чадахгүй, уялдуулж чадахгүй, дандаа хагас дутуу орж байгаа нь сүүлдээ улс төрийн түвшинд би энэ хэсгийг нь даагаад, ерөнхийлөгч энэ хэсгийг нь өргөн бариад дээр нь нааж нийлүүлдэг ч юм уу сүүлдээ энэ хуулийг батлах уу, батлахгүй юу гэдэг чинь УИХ-ын гарт байгаа. Заавал ингэж наад талд нь зүй бус хязгаарлалтууд, энэ зүйлүүд гараад байгаа. Та бүхэн байр сууриа илэрхийлээч ээ гэж байгаа юм.

Х.Сэлэнгэ: Үндсэн хуулийн цэц бол Үндсэн шүүхийн үүрэг функцийнхээ хүрээнд тодорхой хэмжээнд хуульчлагдсан гэж миний хувьд үзэж байна. Бусад илтгэгч нар юу гэж үзэхийг мэдэхгүй байна. Өөрөөр хэлбэл, Францын Үндсэн хуулийн зөвлөлтэй адилгүй Үндсэн хуулийн шүүхийн хүрээнд хуульчлагдсан байгаа. Нөгөө талаас та бүхэнтэй санал нэг байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулахгүйгээр Цэцийн өөрийнх нь үүрэг функцийг, мөн чанарыг нь бүрэн сайжруулах боломжгүй гэж ойлгож байна. Дараагийн нэг асуулт байсан. УИХ-ын Тамгын газрын шийдвэр, бусад шийдвэрүүд бас Үндсэн хууль зөрчөөд байна яах вэ? гэдэг асуулт байна гэж ойлгосон. Хэрвээ буруу ойлгоогүй бол. Цэц өргөдөл, мэдээлэл гаргасан тохиолдолд хяналтыг тавьж байгаа шүү дээ. Өргөдөл, мэдээлэл гаргасан тохиолдолд Цэц бол зөрчлийг бүрэн хянаж шийдэх боломжтой. Гэхдээ энэ бол түрүүн яригдсан. Цэц бол өөрөө боловсон хүчний мэдлэг, чадвараасаа болоод янз бүрийн шийдвэрүүд гаргаад байгаа. Миний хувьд бол ийм хариултыг өгөх байна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН АСУУЛТ, ХАРИУЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 02¹

2022 оны 10-р сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Ц.Мөнх-Оргил: Үндсэн эрхийн асуудал дээр саяынхаа дүгнэлтийг хийх юм бол үндсэн эрхийг хамгаалах асуудал хүссэн, хүсээгүй манай Цэцийн үйл ажиллагааны гол хэлбэр болох нь л дээ, ер нь бол цаашдаа. Энийг хийхийн тулд бид нар энэ зөвлөгөөг ч хийгээд, хуулиа янзлах гээд байгаа шүү дээ. Хэрвээ тэгчих юм бол Цэцийн үйл ажиллагаанд их хэмжээний өөрчлөлтүүд гарах нь ээ. Зохион байгуулалт, бүтэц, процесс, ажлын ачаалал, ганцхан өргөдөл, мэдээллээр дахиж томъёолж тодорхойлохоос эхлүүлээд хэзээ юуг нь гомдол гэж үзэх юм, хэзээ юуг нь мэдээлэл гэж үзэх юм, тэр хийсвэр хяналт байх юм уу, бодоод байхад хоёулаа зэрэг давхцаж байдаг хаана ч байхгүй л дээ тийм ээ. Үндсэн эрхээ хамгаалуулах гээд өргөдөл өгч байдаг, хажуугаар нь бид нарын яриад байгаа actio popularis-ийн хэмжээнд өөрт нь хамаагүй асуудлаар нь хийсвэр дүгнэлтүүд гаргуулах гээд өгөөд байх юм бол Цэц бол жишээ нь ачааллаа дийлэхгүй л дээ гэх мэтийн практикийн ач холбогдолтой олон олон асуудлууд урган гарч ирээд байгаа юм. Хэдүүлээ цааш нь ярилцъя. Сая хүмүүсийн ярьсан, асуусан, илтгэлүүдийг сонсохоор тийшээгээ бид нарын яриа чиглэх гээд байна уу даа гэж бодож байна. Баасан гуай.

Л.Баасан: Баярлалаа. Төрийн нэг том институтийн үйл ажиллагаатай холбоотой эрдэм шинжилгээний сургалт, илтгэлүүдийг их анхааралтай сонслоо. Сайхан илтгэлүүд болж байна. Би сэтгэгдлээ л хэлчихье. Цэцийн гишүүн байсны хувьд, энэ асуудлыг судалгааны өнцгөөс хамтатган хэлэхийн хувьд Цэц бол Үндсэн хуулийн баталгаа болсон байгууллага. Энэ байгууллага нь бол 30 жил үнэхээр энэ үүргээ биелүүлж ирсэн. Цэцийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах

¹ Constitutional Law Institute, NUM, “Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурал”, дүрс бичлэг, YouTube, 2022.12.22, <https://www.youtube.com/watch?v=Xuw4ZZnn-Ak>.

асуудал байх шиг байгаа юм. Тэр дотор нь байсан ажиллаж байсан бид нарын ч үйл ажиллагаатай холбоотойгоор. Жишээ нь хамгийн сүүлд Ц.Сарантуяа докторын илтгэлтэй холбоотой, О.Мөнхсайхан ч гэсэн ярьж байна лээ. Үндсэн хуулийн өөрчлөлтийг Цэц хэлэлцсэн явдалд би жоохон эмзэг хандаж байгаа. Үндсэн хуулийн өөрчлөлт чинь Үндсэн хууль шүү дээ. Яагаад Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны хяналтын объект болгож байгаа юм. Эсвэл Үндсэн хуулийн өөрчлөлтийг баталсан УИХ-ын тогтоол гэж байгаа юм болбол арай өөр агуулга. Үүнийг ямар улс төрийн гар хөл болсноос ингэж хэлээгүй, үндсэндээ үүнээс хойших Цэцийн үйл ажиллагаатай холбоотойгоор Монголд ажиллаж байгаа зарим өөрчлөлт, шинэчлэлүүд илэрч байна, цуг хууль бусаар явж байна лээ шүү дээ. Үндсэн хуулийг өөрчлөх батлах, ард түмнээр хэлэлцүүлэх, тэдэн хувийн санал билээ, дийлэнх олонхын гээд энэ чинь болсон юм уу, тэгсхийгээд сандраад, бачимдаад явчихна лээ. Ийм маягаар, би гаднаас хараад дүгнэхэд, Цэцийн маань нэр хүнд сүүлийн үед жаахан тиймэрхүү болчихоод байгаа юм биш биздээ. Үүнтэй холбогдуулан би хоёр л санал хэлэх гэсэн юм.

Цэцийн үйл ажиллагааг сайжруулж, улам төгөлдөржүүлэе гэж бодож байгаа. Энэ дээр хэд хэдэн эрх зүйн орчныг сайжруулах асуудал байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ёстой. Иргэний үндсэн эрхийн асуудлыг оруулъя гэдэг юм уу, яадаг юм. Би өөрөө дэмждэг л юм. Манайхан бүтцийн өөрчлөлт хийгээд асар мундаг хүч тавьж Герман шиг байвал болох л байх. Эсвэл хязгаарлалт хийвэл болох л байх. Би үүнийг ерөнхийд нь дэмжиж байгаа юм. Үндсэн хуульд тэгээд Цэцийн бүтэц, зохион байгуулалт энэ Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийн асуудлыг өнөөдөр энэ хуралдаанаас гаргах, шийдвэр байдаг ч юм уу бодмоор байна. Хоёрдугаарт нь энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг өөрчилж. Ёстой түрүүн яриагүй байна. Өргөдөл гэж зүйл. Нэгэнт л шүүх юм чинь нэхэмжлэл гэж заагаад тэгээд хангаагүй бол буцаачихдаг шүү дээ. Татгалзчихдаг. Яг энэ стандарт руу оруулмаар байгаа юм. Тэгэхээр Үндсэн хуулийн Цэцийн тухай хууль дээр шинээр илэрсэн нөхцөл байдлын асуудлыг тусгая гээд ярьж байна. Би мөн энийг дэмжиж байна. Хуралдаанд бэлдэх үе шатыг илтгэл дээр нэлээн юмнууд оруулж байна лээ. Үүнийг бол бодох ёстой. Дараагийн нэг хуулийг, Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэх тухай хуулийг нэлээн өөрчлөх шаардлагатай юм болов уу даа. Бусад орны туршлага ч байна, өөрийн татаж ирсэн туршлага. Сая В.Удвалын илтгэл дээр сонин үг гараад байх юм. Үндсэн хуулийн цэцээр дамжуулж ямар нэгэн улс төрийн бусад хүчнүүд хууль бус үйл ажиллагаа явуулах юм уу, яах юм тиймэрхүү маягийн ойлголтууд сонсогдсон. Тэр бол их эвгүй үг. Тэгээд байгаа юм.

Яагаад энэ Үндсэн хуулийн цэцээр оролдоод байгаа юм. Ж.Амарсанаа академичийг яагаад оролдоод байгаа юм, тийм ээ. Одоо Н.Чинбатыг яагаад оролдоод байгаа юм. Үүний цаана ямар зорилго байгаа юм. Бид улс төрийн үүднээс авч үзэж байгаа юм бус, Цэцийг бэхжүүлэх үүднээс ийм ийм юмнуудаар бол Цэцийн тухай хууль дээр өөрчлөлт оруулдаг юм уу, ахиж шинэчлэн найруулах, энэ бүх хуулиудыг байгуулах ажлын хэсэг байгаа юм байна л даа. Урьдчилж нэг үзэл баримтлалын зүйлүүдийг боловсруулаад, урьдчилж тавиад Цэцийн гишүүдээрээ, цэцийн тэр олон докторууд байна шүү дээ, үүгээр саналыг нь ав. Манай МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн тэнхимийн олонх хүмүүсүүд байж байна. Бусад их, дээд сургуулиудын олон Үндсэн хууль судлалын докторууд байна. Эдгээр хүмүүсийн саналыг авъя л даа. Аваад хэчнээн олон хүнээр хэлэлцүүлнэ, төдий чинээ сайн хууль, акт гаргах, төдий чинээ урт хугацаанд амьдрах ийм эрх зүйн хэм хэмжээ болох гэсэн ийм саналтай байна. Өөр сүүлд нь нэг санал хэлэхэд бол Үндсэн хуулийн цэцийн эрдэм шинжилгээ, судалгаа, үйл ажиллагааны, шинжлэх ухааны үндэслэлийг бид өөрчилмөөр байна. Өөрийнхөө юмандаа дүгнэлт хийдэг, судалдаг, хэдэн жилээр Цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийгээд танилцуулдаг байвал яасан юм. Цэцийн нэг гишүүний тогтоол, уншиж байсан. Таны өгсөн өргөдөл бол уншиж үзэхэд тэр хууль нь Үндсэн хуулийг зөрчсөн маргаан биш болох нь тогтоогдож байна гэж хариу өгөөд татгалзсан байна лээ л дээ. Энэ бол буруу л зүйл. Харин миний бодлоор саяын манай В.Удвал, бусад илтгэгчдийн хэлдгээр таны харин энэ өгсөн өргөдөл чинь, хүсэлт чинь Үндсэн хуулийн цэцэд хүсэлт, гомдол гаргах стандартыг хангаагүй учраас таны өргөдлөөс татгалзлаа гэвэл харин болох л байх. Цэцийг онилдгийг урьдчилж гаргаж байгаа ийм алдаа байгаа. Үүнийг жишээ нь шинжилгээний байгууллага нь судлаад, ер нь ингэдгээ больё, Цэцийн даргын даалгавар авдаг юм уу яадаг юм, ингээд явбал яасан юм бэ. Цаашид Цэцийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд бид нартай хэрвээ харьцвал миний хувьд бол хамтарч ажиллахад бэлэн, бололцооныхоо хэрээр туслахыг бодож байна. Баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Ж.Бямбаа багш. Дараа нь Д.Мөнхтуяа шүүгч.

Ж.Бямбаа: Нэгдүгээрт, микрофон тун ойрхон байна. Хоёрдугаарт, ахмад улсууд үг хэлж байна. Хуучин цагт номын дуун дээр ахмадууд үг хэлэх дуртай байдаг. Хэлэхгүй бол үлдэж чаддаггүй золиг юм шүү дээ. Би цөөхөн хэдэн санаа хэлье. Нэгдүгээрт, энэ Цэцийн хяналтын объектыг боловсронгуй болгох гэж байна. Энэ их нарийн юм яригдлаа. Би зүйрлүүлж хэлье. Жишээ нь, манай Эрүүгийн эрх зүйн Германыхан,

сайхан сайхан Германд боловсрол эзэмшсэн улсууд ярьж байна шүү дээ. Ер нь бол объектив, субъектив талын хоорондын харилцан үйлчлэлийн асуудал сүүлийн үед их яригддаг болчихсон. Жишээ нь, энэ үйлчлэлийн хүрээнд тодорхойлохгүй болбол цэвэр объектоор хөөцөлдөх юм бол эрүү төөрдөг. Жишээ нь, Сонгуулийн хууль зөрчихсөн болбол зарим хүмүүс, УИХ-д сууж байгаа хүмүүс төрийн ёсыг гэмтээнэ гэж үздэг. Зарим нь засаг захиргааны дүрэм зөрчсөн, Сонгуулийн хууль тогтоомж өөрчлөх журам зөрчсөн гээд объектоосоо болж зүйлчлэл янз янзаар хувирдаг учраас манай залуучууд бол Цэцийн хяналтын объектыг их системчилж үзэх хэрэгтэй, эрх мэдэл хуваарилах онолын түвшинд. Эрх мэдэл хуваарилах онолыг манайд зарим их том академич хүртэл эсэргүүцэж байгаа шүү дээ, сүүлийн үед. Ёс суртахууны асуудал, Чингисийн улбаат сургаалыг үл тоож, эрх мэдэл хуваарилах онолд хэт хошуурч, өргөн сагсны шийд маягаар үзэж, дээрээс шууд хяналт тавина гэдэг зохиомол хэргээ болих хэрэгтэй гэж хэлж байх юм. Юуны түрүүнд анхаарч үзээрэй гэж хүсэх гэсэн юм.

Хоёрдугаарт, миний хэлэх юм болбол Үндсэн хуулийн 67-р зүйлийг нягталж үзээсэй. Энэ их түүхэн юм шүү дээ. Б.Чимид гуайгаас огт дутахгүй Г.Совд гэж хуульч байсан юм. Г.Совд хуульч Цэцийн дарга хийж байх хугацаандаа Үндсэн хуулийн цэцийг гурвантуулаагүй, байна шүү цаана чинь, санаачилга гарсан байна Үндсэн хууль руу өөрчлөлт оруулах саналыг Үндсэн хуулийн цэцийн хуралд оруулах нь байна шүү, аягүй бол бид нар бүх юмаа унших нь ээ, судлах нь ээ гээл ямар санал гаргах гэж байгаа юм, огт ойлгомжгүй юмнууд нуугдаад байдаг. Тэгсэн гэнэтхэн шөнө дунд 2 цагийн үед Дэлгэр Монгол орноо дуулаад явчихсан. Тэгсэн чинь нөгөө өөрчлөлт батлагдчихсан юм байна лээ. Тэр үед тийм дуу гэдэг сонин тохиолдол их байдаг байсан юм л даа, ордонд. Дуулах нэг хэрэг. Өөрөөр хэлбэл, манаачийг үл тоож ер нь асуудлыг, жишээ нь манай Л.Баасан багш ярьж байна шүү дээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг бол Үндсэн хууль мөн гэж. Р.Гончигдорж бид нар тэгж анх гаргаж ирж байсныг би сайн санах юм. Их хурлаас гаргаж байгаа юм бол Их хурлын 25-р зүйлд орсон дараалсан хууль, хууль тогтоомж, зарлиг гэсэн рүү ордоггүй байгаад байна. Гэнэтхэн Үндсэн хууль батлаад явчих юм, ямар сонин юм болоод байгаа юм гэж. Үүнийг цөмөөрөө бодож үзье. Энэ эс боловч 67-р зүйлээр ямар нэгэн асуудлаар Цэцтэй заавал холбогдох ёстой. Цэцийн санал гэж зовоосон, тийм дэмий буруудаагүй. Тэр нэг хяналтын систем байх ёстой. Ядаж л санал өгөх систем байх ёстой. Манаачаас нь асуухад складыг эвдэж болохгүй. Энэ санааг миний залуучууд сайн анхаарч үзээрэй гэж хүсэх байна.

Гуравдугаарт, манайд сүүлийн үед их улстөржиж байгаа, улстөржилт бол гаж өвчин шахуу юм шүү дээ. Манай эрх зүйд улс төр нөлөөлөх гэж их оролддог. Би зүгээр эшлэл авъя гэж бодож байна. Би эшлэл хэлэхдээ дуртай. Цэцийн 25 жилийн ой болоход гаднын яг 3 доктор үг хэлсэн юм. ХБНГУ-ын Үндсэн шүүхийн гишүүн Зегулиа Кристал Бүрф гэж, Солонгос улсын Ким Чин Жүн гэж хүн. Туркийн Режие Аке энэ дээр бол хэлж байсан. Жишээ нь Зегулиа “Улс төр эрх зүйд нийцэх учиртай. Харин эрх зүй улс төрд нийцэх алба байхгүй.”. Солонгосын доктор бол хэлсэн, “Улс төр бол муу шинжүүдтэй. Улс төр өөрийн муу шинжээ хууль, эрх зүй дээр тавих оролдлого байх юм.” гэж. Би Үндсэн хуулийн цэцийн өөрчлөлт оруулахад ийм мэтийн холбоо бүхий байгууллагуудын эрдэм судлалын хүмүүсүүдийн бас ном зохиол мэтээр, практик хэрэглээний асуудлуудыг сайн судалж үзээсэй гэж бодож байгаа юм. Энэ бол манайд гарцаагүй хэрэг болно. Эцэст нь хэлэхэд, баярласан гэдгээ хэлж байгаа юм. Дордохын 7 өөрчлөлт гэсэн нэртэй байсан. Гэтэл өнөөдөр тавигдсан 7 илтгэл маань долуулаа ер нь Үндсэн хуулийг сайжруулах их эрмэлзэл бүхий, хөгшин хүний толгой хүртэл, чихийг нь онгойлгосон их сайхан илтгэлүүд тавилаа, бодмоор. Энэ илтгэлүүдээ цааш нь судалж, эдгээрийг бол эрдэм судлалын байгууллагуудаар хэвлүүлж, хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлтүүдийг, бас л өөрийн саналыг хэлсэн түрүүчийн нэг эрэгтэй хүн орж ирлээ шүү дээ. Ийм маягийн олон санал хэрэггүй. Энэ бол Үндсэн хууль маань байхгүй болчихож магадгүй. Энэ гол гол асуудлуудыг хөндсөн докторуудын санал их амин саналууд тавьж байна шүү. Германыг бол заавал судлах ёстой. Түүнээс гадна Зүүн өмнөд Азийн орнуудыг заавал судлах ёстой. Орхиж огт болохгүй. Ингэж харьцуулж бид Үндсэн хуулийн цэцийн асуудлуудыг тодорхой болговол их сайн. Ялангуяа процессын хуулийг их нарийн болгож авахгүй болбол түрүүн Н.Болортунгалаг маань маш их аятайхан санал өгч байна. Манай процесс чинь цөм янз бүр болчихсон шүү дээ. Процессын хэв хэлбэр гэж байна. Нэг мөр дотор багтдаг мөртөө аальгүй, сагсуу. Ром-Германых ч юм шиг, эсвэл цэвэрхэн нүүдэлчин сэтгэхүй өшөө өөр үгээр ч хэлж байсан л даа, Нүүдэлчин сэтгэхүйд автсан манай өөрийн онцлог ч юм шиг, эсвэл зэрэгцүүлж авсан ч юм шиг. Ингэж шүүрч болохгүй. Бүх юм шинжлэх ухааны ор үндэслэлтэй байдаг учраас энэ илтгэлүүдийг болон дээрээс нь бусад салбаруудад нэн даруй тарааж, ялангуяа энэ сэргэлэн сайхан залуучуудын саналыг сайн сонсох юм болбол бодитой, суурьтай, судалгаатай болно гэж бодож байна. Ингээд болно оо. Баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Д.Мөнхтуяа шүүгч.

Д.Мөнхтуяа: Санал хэлье. Илтгэгч нараас бол асуулт байхгүй. Юуны өмнө Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг өөрчлөх асуудлаар энэ хэлэлцүүлэг зохион байгуулж байна. Энэ асуудал цагаа олсон гэхээсээ илүү бүр зөрчилдөж байгаа ажил гэж би хувьдаа боддог. Үндсэндээ өнөөдрийн энд цугласан, ингээд харахад илтгэлд зориулсан илтгэл гэхээсээ илүү харьцангуй мэргэжлийн, харьцангуй ярьж байгаа зүйлийнхээ талаар ойлголттой хүмүүс байна. Би жоохон нарийн юм яриадахъя.

Юуны өмнө Үндсэн хуулийн цэцийн энэ хуулиудыг шинэчлэх үзэл баримтлалыг бол дэмжиж байна. Энэ процессын Үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжүүлээгүй 30 жилийн проблемыг хураасан. Яг үнэндээ бол сая Тамгын газрын даргын илтгэлээс та бүхэн анзаарсан байх. Тодорхой юм юу ч байхгүй. Бүх юм нь тодорхойгүй, эсвэл зохицуулалт нь дутуу. Ийм учраас Цэцийн гишүүдтэй холбоотой шүүмжлэл гэхээсээ илүү энэ ерөөсөө энэ институцийг процессынх нь хувьд ямар ч тодорхойгүй байдалд олон жил барьснаас болоод үндсэндээ хэн ямар шийдвэрийг ямар үндэслэлээр гаргах вэ гэдэг нь тодорхойгүй болчихсон. Өнөөдөр би хуульчийнхаа хувьд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой, дээрээс нь нийтийн эрх зүйн хүрээнд Захиргааны шүүх дээр зарим маргаан давхацдаг учраас нэлээн ялангуяа Үндсэн хуулийн цэцээс Засгийн газрын шийдвэрийг хянаж байгаа, Ерөнхий сайдын шийдвэрүүдийг хянаж байгаа шийдвэрүүдийг Цэцээс гаргасан шийдвэрүүдтэй 2 жил нэлээн судалгаа хийсэн. Миний хоёр ч илтгэл хэвлэгдсэн байдаг. Үүнээс харахаар ямар үндэслэлээр маргаан үүсгээд байгаа юм, ямар үндэслэлээр үүсгэхгүй гээд байгаа юм. Засгийн газрын шийдвэрийг ямар тохиолдолд хянана гээд байгаа юм, ямар тохиолдолд хянахгүй гээд байгаа юм. Ерөөсөө ингээд барьж аваад хэлчих юм байдаггүй. Үндэслэл дотор л лав юм олддоггүй юм. Жишээ нь, Ерөнхий сайдын аймгийн Засаг даргыг томилсон шийдвэрүүдийг хэд хэдэн удаа Үндсэн хуулийн маргаан биш гээд буцаачихсан. Тэгснээ 1, 2 удаа мөн байна гээд аваад шийдчихсэн. Засгийн газрын шийдвэр ердийн хууль зөрчсөн бол хянахгүй гээд зөндөө буцаачихсан байдаг. Тэгснээ заримыг нь хянана аа, ердийн хууль зөрчсөн нь Үндсэн хууль зөрчсөнтэй адилтгаж үзнэ ээ гээд шийдвэрлэчихсэн 1, 2 шийдвэр. Энэ процесс нь ерөөсөө тодорхойгүй учраас энд яасан гэхээр одоо субъектив дур зорго үйлчилж эхэлж байгаа юм. Улсын Дээд шүүх 2017 онд Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хууль зөрчсөн хуулийн талаар мэдээлэл гаргасан. Хуулиараа УДШ-ээс гаргаж байгаа тохиолдолд шууд маргаан үүсгэдэг. Энд шууд маргаан үүсгээд Үндсэн хуулийн цэцийн гишүүн 2 жил нам

барьсан байдаг юм. Ямар ч хариу байхгүй. Яасан нь бүү мэд 2 жил барьчаад сая энэ хавар билүү 3, 4 сард билүү, нэг албан бичиг ирсэн. Танай мэдээллээр үүсгэсэн маргааныг дуусгавар болголоо, маргаан шийдвэрлэх ажиллагааг. Учир нь энэ хууль нь хүчингүй болчихлоо гэсэн нэг ийм бичиг. Энэ нь ямар учиртай болчихоод 2 жил ингээд барьчаад байлгаад байгаа юм. Ер нь 4, 5 жил барьчих боломжтой юм уу үгүй юм уу гээд тэнд бол яамаар байгаа вэ? гэдгээсээ шалтгаалаад процесс бол ингэж явж ирсэн байдаг юм. Тийм учраас процессын эрх зүйг хөгжүүлээгүй ингэж барьснаас болоод олон ийм сөрөг үр дагавар учирсан. Одоо энэ хуулийг шинэчлэн найруулах замаар энэ бодитой процессыг тодорхой болгохгүй бол процессын шударга ёс байхгүй газар бол өөр шударга ёс юм уу, өөр үндэслэл ярих боломж байхгүй л дээ. Тийм учраас одоогийн энэ хяналтын чиг үүргээ Цэц маань ер нь хэр зэрэг хэрэгжүүлж байна вэ? гэдэгт эхний ээлжид бид нар дүгнэлт өгөөд тэгээд болж байгаа, болохгүй байгаа зүйлээ дүгнэлт өгөөд энийг яаж засах вэ? гэдэг асуудлаа ярих боломж байна. Олон судалгаа гарсан. Судлаачид энд сууж байна. Судалгаанууд зөндөө гарсан.

Цэцийн шийдвэрийн үндэслэл бүхий байдал. Хүн болгон л яриад байна. Яг үнэндээ бол яагаад Үндсэн хууль зөрчсөн гэж үзээд байгаа юм. Яагаад ялангуяа зөрчөөгүй гэж үзээд байгаа юм. Ерөөсөө үндэслэл нь байдаггүй. Та нар Цэцийн олон шийдвэрүүдээс хараарай. Тал хуудсан дээр Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гээд. Дээрээс нь нарийн цариг ч гээл ярьж л байна. Эсвэл одоо ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агнатыг хэнээс нь авах уу? Ямар хувь хэмжээгээр авах уу? гээл УИХ-ын хууль баталчихаар Үндсэн хууль зөрчлөө гээл хүчингүй болгочих юм. Хуульч бид нар хүртэл уншаад зарим юмыг нь бол үнэндээ ойлгодоггүй. Сайн шийдвэрүүд бол байгаа. Яагаад үүнийг Үндсэн хуультай холбоод, яагаад шийдчихэв ээ гээд. Саяын 02 дугаартай тогтоол яриад байна. Мөн адилхан. Ямар агуулгаараа энэ чинь Үндсэн хуулийн зөрчил болчихов оо гээд ойлгохоор сайн ойлгогдож өгөхгүй, үндэслэл байдлыг сайжруулах шаардлага.

Энэ дээр түрүүн мөн хүмүүс яриад байна. Үндсэн хуулийн цэцийн чадавхыг сайжруулъя аа. Энэ томилгоо, ямар хүн томилох ёстой юм, яах ёстой юм. Би бодохдоо жоохон процессын тулхтай хүмүүс хэрэгтэй байх шиг байгаа юм. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэнэ гэж бид нар өдөр тутам ярьдаг, тийм үү. Процессыг дагадаг дадал гэдэг юм уу, яг ингээд ажиллагаа эхэллээ, процесс дагалаа. Гэтэл процесс ярьдаг, зөвлөгөө өгдөг, процесс мэддэг хүмүүс бас хэрэгтэй байх шиг байгаа юм. Гэтэл энд чинь дандаа процесс багт ажилладаггүй хүмүүс яваад суучихаар очоод ядаж л Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх

ажиллагааны хуралд орчхоод оролцогч хүсэлт гаргахаар тэр хүсэлтийг нь бүрэлдэхүүн шийдвэрлэдэг гэдэг наад захын ойлголт ерөөсөө байхгүй байгаад байхгүй юу. Хэдийгээр хуульд нь заагаагүй ч гэсэн нэгэнт хүсэлт гаргаж байгаа бол бүрэлдэхүүнээрээ хэлэлцэн шийддэг ч гэдэг юм уу тэ. Энэ бол шүүхэд тогтчихсон ойлголт байх жишээтэй.

Ийм асуудлууд яриад бид нар үндсэндээ юу гэж ойлгоод байна вэ гэхээр Цэц маань 30 жил явахдаа процессоо хөгжүүлж чадсангүй. Хөгжүүлэх гэхээр хууль тогтоомжийг нь засаж өгсөнгүй ээ. Гэтэл яг өнөөдөр одоогийнхоо эрх хэмжээнийхээ хүрээнд хяналтын чиг үүргээ яг одоо болоод сайн тултал нь хэрэгжүүлж чадаж байгаа юу гэдэг нэг асуудал байна. Гэтэл энэ юмныхаа учрыг ч сайн олоогүй, юмаа засаж чадаагүй байж байтал одоо эрх хэмжээний, хяналтын чиг үүргийг нэмэгдүүлэх асуудлыг ярьж эхэлж байна. Би зүгээр нэг юманд санаа зовж байгаа. Мэдээж хэрэг Герман шиг л болмоор байна ер нь бол. Хуулийн өөрчлөлт хийх цаг болсон уу?, Нийгмийн бодит шаардлага бий болсон уу? Суурь хөрс нь бүрдсэн үү? гэдэг нь хамгийн чухал асуудал. Өнөөдөр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг нь сайжруулаад хуулиа одоо УИХ-аас гарч байгаа шийдвэр, Засгийн газраас гарч байгаа шийдвэр, Ерөнхий сайдаас гарч байгаа шийдвэр, Ерөнхийлөгчийн шийдвэрээ Үндсэн хуульд нийцүүлээд яг ямрыг нь хянах юм, ямрыг нь хянахгүй юм, хянавал яаж хянах юм, үндэслэл нь юу юм гэдэг юм нь дээрээ тогтож чадаагүй байж байж дахиад ингээд хяналтын чиг үүргийг нэмэгдүүлэх асуудлыг яригдахаар миний зүгээр хуульчийн хувьд би бол жоохон санаанд эргэлзээд байна. Уг нь бол зөв. Ер нь тэгж явмаар байна.

Үндсэн хуульд үндсэн эрхийн маргаан шийдвэрлээд эцсийн шийдвэр гаргадаг болмоор байна. Гэтэл одоогийн байгаа байдал, би хийсвэрээр бодохоор, энэ чинь өөрөө үндсэн эрхийн маргаан хянана гэдэг чинь Дээд шүүхийн шийдвэрээр эцэслээд шийдвэрлэгдчихсэн хэргийг Үндсэн хуульд нийцээгүй, зөрчлөө гэдэг агуулгаар Үндсэн хуулийн цэц 4 дэх хяналт болж орох гэж байна. Гэтэл энэ тохиолдолд зарим судлаачийн илтгэл дээр гарч ирж байна л даа. Зөрчсөн гэвэл шийдвэр хүчингүй болгоно. Хэлэхэд их амархан. Энэ тэгээд яах юм. Эрүүгийн хэргийн гурван шатны шүүх хүчингүй болголоо, яах уу?, анхан шатан дээрээ очих юм шиг байна, эсвэл захиргааны шүүх, иргэний хэргийн шүүх шийдвэрийг хүчингүй болговол бодвол зааж өгөх юм шиг байна л даа. Ийм ийм ингээд ингээд энэ дүгнэлт чинь Үндсэн хууль зөрчсөн байна. Тэгэхээр бид нар шүүн таслах ажиллагааны нэг зарчим бол Дээд шатны шүүхүүд доод шатны шүүхдээ чиглэл өгдөггүй, хориглодог, тийм ээ. Өөрөөр хэлэх юм бол шүүгч бие даасан байдлаар шийдвэр гаргадаг.

Тэгвэл Цэц ингээд шийднэ ээ, ингээд болохгүй юм байна гээд заагаад өгчих юм бол тэрийг анхан шатаар дахин шийдэж байх ямар шаардлага байх вэ? Цэц тэр дор нь маргааныг шийдээд явах хэрэгтэй, наад зах нь. Энэ бол маш том өөрчлөлт байхгүй юу. Үндсэн эрхийн маргаан буюу субъектив эрхийн маргаан шийдэх гэж байна шүү дээ. Энэ тохиолдолд эрүү, иргэн, захиргааны процесс бүхэлдээ хөдөлнө. Бүхэлдээ хөдөлнө. Тэгэхгүй бол болохгүй. Тэгэхгүй бол үндсэн эрхийн маргаан шийдвэрлээд Үндсэн хуулийн цэц сонсох шиг ийм амар биш. Гэтэл өнөөгийн байгаа байдал нь би одоо ийм юм хийсвэрээр төсөөлөөд байна. Нийтийн эрх зүйн хүрээнд гарсан маргаан шийдвэрлэдэг Захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй илүү түлхүү хамааралтай. Зарим судлаачид дээр ч гараад байна. Иргэн хоорондын маргаан биш ээ. Наадах чинь Засгийн газарт. Яг үнэндээ өнөөдөр Захиргааны хэргийн шүүхэд Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайдын шийдвэр бүгд хянагдаж байгаа. Гэтэл Үндсэн хуулийн цэц давхар хянадаг юм. Яагаад хаана нь салах юм, салахгүй гэдэг нь ч ойлгомжгүй. Авмаар байвал авдаг, авмааргүй байвал авдаггүй ийм юм тогтчихоод. Дээд шүүх Захиргааны шүүхийн шийдвэр, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр одоогоор миний мэдэж байгаа судалж байгаагаар зөрчсөн юм байдаггүй юм. Зөрчвөл яах юм гэдэг амьдрал дээрээ. Яг алийг нь дагах юм гэдэг асуудал яригдана. Ямар асуудал гарах уу? гэхээр жишээ нь би бодлоо л доо. Бид нар дээр ч гэсэн Үндсэн хуульд заасан эрх зөрчигдсэн гээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн үндэслэлд дурдагдаад гомдол гаргаад яваад байдаг. Ямар асуудал байна вэ? Одоо Хууль зүйн яамны үүдээр гараад л үндсэн эрхийн зөрчил. Замаар дүүрэн гялгар хавтан наачихсан. Цас орчихсон. Ингээд халтирч унана, хөл гараа хугалах эрсдэл бэлэн. Яг амьдарч байсан байшингийн урд байшин барьчихлаа, нар хаачихлаа, нар үзэх эрх зөрчлөө. Гараад машинд дайруулах нөхцөл бэлэн байна. Агаарын бохирдол гээд уушгины өвчтэй боллоо. Энэ чинь өөрөө хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах Үндсэн хуульд заасан эрхийг зөрчлөө. Энэ маргаан чинь л хамгийн түрүүнд Үндсэн хуулийн цэцэд очно. Яаж шийдэх юм үүнийг жишээлбэл. Яг үнэндээ бид нар төсөөллөөрөө яг ямар асуудалтай учрах гэж байгаа гэдгээ тодорхой мэдэхгүй бол зөвхөн одоо ийм байдаг учраас, үзэл санааны хувьд Герман шиг болмоор л байна. Гэтэл өнөөдөр цаг нь болсон уу, үгүй юу гэдэг дээр энэ хуулиудыг хэлэлцэх явцдаа ажлын хэсэг үзэл баримтлал дээрээ нэлээн эерэг болон сөрөг үр дагавруудаа тооцох нь зөв байх. Дээрээс нь нарийн судалгаа хэрэгтэй. Яг өнөөдөр үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц хүлээн авч шийдэхгүйгээс болоод нөхцөлдөө ямар байдал үүсэж байгаа

вэ?, үүссэн байдал байгаа вэ судалгаа. Хэдэн байнга яригддаг эрүүгийн ч байдаг юм уу 1, 2 хэрэг гээд ярьдаг юм. Өнөөдөр шүүх бол жилд 90000 хэрэг маргаан шийдэж байгаа, эрүү, иргэн, захиргааны анхан шатны шүүхүүд. Ингээд яваад байдаг яг үнэндээ шүүхийн шийдвэрээр үндсэн эрхийг Үндсэн хуулийн 16-р зүйлд заасан үндсэн жам ёсны эрх нь үнэхээр зөрчигдөөд, болохоо байчхаад энэ Үндсэн хуулийн цэц хянахаас өөр аргагүй болоод байгаа тийм судалгаа гаргаж бас харах хэрэгтэй. Ямар асуудал тулгамдаад байгаа юм. Тэрний оронд бол миний хувийн бодол бол цаашдаа энэ чиглэл рүүгээ явах байх. Үндсэн хуулийн цэц хүчтэй сайн байвал бид нарын зорилго бол нэг. Тийм учраас цаашдаа мэдээж үүн рүүгээ явах байх. Тэрний наана юуны өмнө эхлээд өөрийнхөө процессыг, Үндсэн хуулийн процессыг жигдлээд энэ процессынхоо дагуу тогтмоор байна, хөгжлийнхөө. Энэ түвшиндээ асуудалгүй байна гэвэл дараа нь эрх хэмжээг нь нэмэгдүүлж болно, бүр өөр тогтолцооны өөрчлөлт хийхэд бэлэн хөрс сууриа бэлдэх хэрэгтэй байна гэж хараад байна. Хэт огцом ингээд юмаа олоогүй, засаж залруулах зүйл зөндөө байхад ингээд эрх хэмжээ нэмнэ, тогтолцоо өөрчилнө гэхээр ёстой нөгөө бөөн хөл толгой нь мэдэгдэхгүй хэцүү байдал руу орох вий гэдэг болгоомжлол харагдаж байна, төсөөлөгдөж өгөхгүй байгаа учраас. Тийм учраас хуулийн төсөл боловсруулах үндсэн болон дэд ажлын хэсэгт олон хүмүүс ажиллаж байгаа юм байна. Ингээд мөн ултай суурьтай судалгааны үндсэн дээр цааш цаашдаа хэд хэдэн жилээр ямар ирээдүй харж байгаа билээ, тэрнийхээ дагуу явах байх гэж найдаж байна. Тийм санал хэлэх гэсэн юм. Баярлалаа.

П.Бадамрагчаа: Сайн байцгаана уу? Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Намайг П.Бадамрагчаа гэдэг. Нээлттэй нийгэм форумын эрх зүйн хөтөлбөрийн менежер. Өнөөдрийн энэ арга хэмжээнд бас Иргэний нийгмийн төлөөлөл болоод оролцож байгаа учраас тэр өнцгөөсөө ганц хоёр санал, асуудал дэвшүүлье гэж бодсон юм. Энэ процесст явж байгаа хэлэлцүүлэг маань цаашид үргэлжлээд өрнөөд явна гэсэн утгаараа ажлын хэсэг болон бусад хүрээнд хэлэлцэх хүмүүст бодолцоосой гэж үзэж байгаа хэдэн асуудал байгаа юм. Өнөөдрийн мэдээллүүдийг сонсож байхад Үндсэн хуулийн эрх зүйгээр мэргэшээгүй, эрх зүйч хүний хувьд харахаар, дээрээс нь Иргэний нийгмийн хувьд нөлөөллийн чиглэлээр ажилладаг хүний хувьд харахад Үндсэн хуулийн цэц гэдэг институт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянаж үзэх ёстой эсэх асуудал дээр бас нэлээн 2 талд явж байх шиг байна. Үндсэндээ бол УИХ-ын шийдвэр учраас бол болно гэсэн байдлаар явж байна. Гэхдээ ялангуяа 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үеэр Иргэний нийгмийн байгууллагууд нэлээн идэвхтэй оролцоод явж

байсны хувьд нэмэлт, өөрчлөлтийг бусад хуультай адилтгаж хүлээж авах нь өрөөсгөл санагдаж байгаа. Яагаад гэхлээр энэ чинь өөрөө Үндсэн хуультай адилхан байдаг байсан бол тусдаа журам гараад дор хаяж 57 хүний ирцтэйгээр хэлэлцэх суурь асуудал болж явах байсан уу. Энэ хүрээнд 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хувьд нэлээн өргөн хүрээнд нийгмийн зөвшилцөл явсан гэж харж байгаа. Энэ хүрээнд яригдсан асуудал 9 хүний бүрэлдэхүүн бүхий институт дээр очоод Үндсэн хуулийн үнэт зүйлтэй нийцэхгүй гэдэг энэ үндэслэлийг гаргаж тавих нь жинлээд үзэх юм бол процесс талаасаа ч тэр төлөөлөл талаасаа ч тэр хэр шударга юм бэ? гэдэг асуулт гарч ирж байгаа юм. Процесс гэж бараг байхгүй учраас процессын туршлагагүй хүмүүс ордог байж магадгүй.

Нэг талдаа дүгнэлттэй сонсоход бол хоёрдох асуудал, шүүх гээд үзчих юм бол үүнийгээ дагаад процессын асуудлууд ороод ирчих байх. Хувийн туршлагаас бас харахад сая энэ оны эхээр 3 сард анх удаагаа нэлээд хугацааны дараа Цэцийн хуралдаанд орох гээд очиж байхад яг энэ Иргэний нийгмийн төлөөллийн хувьд бол яг илт нээлттэй байдлын асуудлыг цохож харахгүй бол ерөөсөө боломжгүй юм байна лээ. Маргаж байгаа 2 тал нь хоёулаа нээлттэй явуулъя гээд байхад ямар үндэслэлээр гэдэг нь ойлгомжгүй байдлаар хурлаа хаалттай явуулчихдаг. Тэр өөрөө энэ институцийн хувьд итгэл хүлээх асуудал нь хурцаар тавигдсан байгаа өнөөгийн үед бол яг энэ нээлттэй, ил тод процессын талаасаа хаана хаанаа ямар байх юм бэ гэдгийг тодорхой, ядаж шүүхийн түвшинд ил тод, нээлттэй байдлаа хангахгүй бол болохгүй байгаа. Тэгэхээр би ялангуяа Цэцийн өөрийнх нь тавьсан мэдээлэл дунд зөвлөмж санал дотроо өөрсдөө энэ нээлттэй ил тод байдлаа хэрхэн хангах боломжтой юм бэ? тэр талын статистик, мэдээллүүдийг мөн гаргаж ирвэл илүү үр өгөөжтэй юм шиг санагдлаа.

Дараагийнх нь асуудал бол Үндсэн хуулийн цэц гэдэг чинь өөрөө Үндсэн хууль тогтоогч мөн юм уу биш юм уу гэдэг асуулт толгой дотор эргэлзээд байлаа л даа. Яагаад гэвэл энэ агуулгын хяналтыг хийж байх явцад Үндсэн хуулийн өнцгөөс харна гээд харахаар тодорхой хэмжээнд нэлээд дэвшилттэйгээр олон жилийн туршид нөлөөллийн хүрээнд оруулж ирж байгаа асуудлуудыг ямар нэгэн улс төрийн юм уу бусад учир шалтгааны улмаас буцаах оролдлогууд аягүй их яваад байгаа. Тэрний нэг жишээ нь энэ 7 хоногт хэлэлцэх гэж байна л даа. Би бол 2008 оноос эхлээд шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх ажлаар ажиллаад сүүлд 2019 оны нэмэлт өөрчлөлт болон Шүүхийн тухай хуулиар дамжуулаад Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо гэх байгууллагуудын шүүгч бус гишүүдийг нээлттэй сонсголын журмаар томилогддог болгоод түүнийг УИХ-ын хяналтын тухай хуульд тусгаад ороод ирэнгүүт тэрийг

хүчингүй болгоно, Үндсэн хуульдаа нийцээгүй байна гэсэн мэдээлэл гарчихсан. Тэр нь одоо энэ 5 дахь өдөр хуралдах гээд байж байх жишээтэй. Яг энэ тохиолдолд бид нарын зүгээс энэ асуудлыг дэмжээд явж байгаа Иргэний нийгмийн зүгээс ямар асуудал байна уу? гэхээр тухайн мэдээлэл гаргаж байгаа, өргөдөл гаргаж байгаа этгээд нь ямар үндэслэлээр гэдэг нь, хурал болно гэдэг зар байгаа болохоос ямар ч мэдээлэл байхгүй. Ийм нэг мэдээлэл гаргасан гэдэг сураг сонсоод, зарыг нь хараад л хардаг. Үүнд бид нар үнэт зүйлийн хүрээнд асуудлыг ярих гэж байгаа бол хангалттай мэдээлэл өгөх, нийгэмд discourse нь ярилцлага, хэлэлцүүлэг нь явж байдаг. Үүнийг мөн харгалзаж үзэж шийдвэрээ гаргадаг байхгүй бол яг 9 хүн хаалттай өрөөнд суугаад шийдвэр гаргаад явах юм бол энэ нь өөрөө аягүй учир дутагдалтай, нийгмийн суурь асуудлыг бид нарын зөвшилцлөөр бий болгосон асуудлуудыг авч үзэх гэж байгаа учраас. Тэгэхээр эдгээр асуудал процесс талаасаа ч тэр агуулгын болон хэлбэрийн хяналтууд тавих гэдэг дээрээ ер нь бодолцож үзэх, цаашдаа анхаарч үзэх асуудал учраас энэ чиглэлээр ярилцах цаашаа авч явах ажлын хэсгийн хүмүүст нь дуулгачихъя гэж бодсон юм. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ одоо болтол 20 жил бид нар үндсэн эрхийн асуудлыг яриад шийдэж чадахгүй яваад байгаа. Цэцээ бэхжүүлчхээд үүнийг хийх гэхээр Цэц нь бэхжиж өгдөггүй, шүүх болж төлөвшдөггүй гээд хүлээлгээд байдаг л даа. Үүнийг хийхгүй болбол шүүхийнхээ үүргийг биелүүлж чаддаггүй, илүү улам л улс төрийн байгууллагын шинж аяс нь нэмэгдээд байдаг тийм ээ, нэг ийм зовлон байгаа. Нөгөө талаас яаруу түргэн хийчих юм бол одоо нэг тогтож ядаж байгаа ажиллаж байгаа шүүхээ ч самраад хаячихдаг, шүүх ч үгүй болчихдог, Цэц ч үгүй болчихдог 2 талтай, бөөн эцэс төгсгөлгүй маргаанууд яваад байдаг. Тэгэхээр бид нар ойлгохдоо яах гэж шүүх байдаг юм, маргааныг эцэслэх гэж л байгаа шүү дээ. Хаана нэгэн газар эцэс тавих гэж шүүх гэж байдаг. Гэтэл үүний үүд хаалгыг нээчих юм биш биздээ, тэгээд эргэлзээтэй асуудлууд их байгаа юм л даа. Явсаар байгаад хууль тогтоогчийн хувьд бидний хийх ёстой хамгийн том ажил бол энэ олон юмыг л дэнслэх асуудал л даа. Зарчим, хүсэл зориг нөгөө талаас бодит чадавх байна уу? Хүний нөөц байна уу? Санхүүгийн нөөц байна уу? Эрх зүйн соёл байна уу? гээд энэ олон юмнуудыг бид нар нийлүүлж байж Монголынхоо нөхцөл байдалтай уялдуулж байж шийдэх ёстой байгаа юм. Цаг хугацаа авна л даа. Хамгийн гол нь хэлэлцүүлгээ хэдүүлээ хийгээд, жишээ нь стратегийн хувьд хууль тогтоогчийн хувьд шүүх болгож шахаж хязгаартай ч гэсэн, хязгаартай, нэлээн Германых шиг тийм гурван үндэслэлээр биш нэг үндэслэлээр ч юм уу үндсэн

эрхийн маргааны гомдлыг хэлэлцдэг тэр үүд хаалгыг нээж өгдөг хийсвэр хяналтыг багасгаж, бодит тухайн хүний өөрийнх нь субъектив эрх зөрчигдөж байгаа тохиолдолд үндсэн эрх нь зөрчигдөж байгаа тохиолдолд Цэц ямар нэгэн байдлаар зөрчигдсөн эрхийг хамгаалах тэр функцийг биелүүлж эхэлж, ингэж процессыг эхлүүлэх үү гэх мэтийн олон асуудлууд байгаа байхгүй юу. Яг л ийм байх ёстой эсвэл тийм байх ёсгүй гэдэг судлаачдад тийм байр суурь байж магадгүй. Хууль тогтоогч нарт тийм лухигу буюу давуу тал байхгүй тийм ээ, зовлонтой асуудлууд их байгаа юм аа. Түрүүн В.Удвал гуай илтгэлдээ чухал сэдвийг хөндөж байгаа юм л даа. Үндэслэлтэй байх ёстой гээд. Тэгэхээр үндэслэлтэй байна гэдгийн хамгийн нэг гол би УИХ дээр олон жил суучаад Цэцээс миний мэдэхийн хоёрхон удаа гаргаж байгаа шийдвэрийнхээ эрх зүйн үндэслэлийг тайлбарласан шийдвэр хоёрхон л удаа орж ирж байгаа байхгүй юу, ерөөсөө л хоёр. Бусад дээр нь яадаг вэ? гэхээр мэдээлэл гаргагч ингэж хэллээ, хариуцагч ингэж хэллээ, дунд суудал дээр ийм шийдвэр гарлаа, тогтоох нь гээл ерөөсөө ингээд үндэслэлээ зааж өгдөггүй. Үндэслэлээ заахгүй болохоор бид нар аргаа бараад та нар яагаад ингээд байгаа юм бэ гээд ингээд маргаан, хэрүүл хийгддэг. Тэрийг нь манай Цэцийн хараат бус байдалд халдаа гээд Цэцийн дүгнэлтээс УИХ дээр асуух асуулт байхгүй болгочхож байгаа юм. Асуулт асууж болохгүй. Үндэслэлгүй байхад үндэслэлтэй ч байна уу, үндэслэлгүй байна уу, үндэслэлийнхэн талаар асуулт асууж болохгүй болохоор жишээ нь хууль тогтоогч дараа дараагийн удаа хууль тогтоомжоо батлахад тэр нөгөө Цэцийн тайлбар, үндэслэл байхгүй болохоор хууль тогтоох ажил доголчихож байгаа байхгүй юу, тийм ээ. Мэдээж хувь хүний харилцаа, бие биеийгээ янз бүрээр хэлэх, нөгөө уурлах уцаарлах юмнууд байгаа юм л даа. Гэхдээ ядаж үндэслэлээ тайлбарладаг болох хэрэгтэй байгаа юм. Үндэслэлээ тайлбарла гээд хууль дээр зөндөө биччихсэн байгаа юм л даа. Үндэслэлтэй байна, ингэнэ, тэгнэ гээд. Энэ байхгүй Цэц өөрөө шийдвэрүүдээ гаргачхаад байдаг. Тэр байтугай Үндсэн хуулийн цэцийн гишүүд Дээд шүүхийн шүүгч тусгай санал гаргаад тэрийгээ заавал хэвлэ гэж шахаад байна гээд дүгнэлт гаргаад байдаг, ямар ч тийм шахсан шаардлага тавиагүй байхад л тусгай саналыг хүртэл хэвлүүлэхгүй гээд шийдвэр гаргачхаад байгаа юм л даа. Энэ олон юуны нэг талаас бодит амьдрал, улс төрийн шахалт, дарамт, бидний хүч чадал, чадавх, хүний нөөц эрх зүйн боловсрол, соёл, улс төрийн соёл гээд энэ бүх юмны дундуур зөв балансыг олж, ёстой нөгөө нэг эмч нарын нэг гол зарчим байгаа шүү дээ тэ, эмчилж чадахгүй бол ядаж битгий дордуулчих гээд тэр зарчмыг л баримталж явмаар юм билээ, миний хувийн бодол шүү.

Б.Гүнбилэг: Тэрэнд юу хэлэх гээд байна вэ гэхээр Венийн конвенцын *pacta sunt servanda* гээд зарчим. Засгийн газрыг тогтоолоор соёрхон батлуулъя гээд шийдвэрлэж байх шиг байгаа юм. Тэгэнгүүтээ цаашаа УИХ-аар орчхож байгаа юм. Энэ завсарт нь би нэг удаа Цэцэд хандаж үзсэн юм. Эдийн засгийн ил тод гэрээ чинь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд халдаж байна аа. Ийм юм баталж болохгүй гээд. Тэгээд Цэцэд өгөөд Цэц юу гэж хариулж байна уу гэхээр хуулийн эцсийн хүчин төгөлдөр болоогүй байна, соёрхон батлаагүй байна. Тэгэнгүүт тэрийгээ баталчихсан л даа. Баахан барьж барьж байгаад Цагаан сарын өмнө ч билүү, хүний анхаарал татахгүй үеэр баталдаг шүү дээ УИХ чинь, тэгээд соёрхон баталчихсан. Тэгэхээр энд процесс дунд энэ олон улсын гэрээ гэдэг чинь өөрөө хяналт байгаа учраас тэрийг нэг анхаараад ажлын хэсгийнхэн судалгаа хийгээч ээ. Нэгэнт бид баталчихвал *pacta sunt servanda*-аараа тэрийг Үндсэн хуулиараа тайлбарлаж, хүчингүй болгож болохгүй гэсэн олон улсын гэрээний зарчмаа бид нар өөрсдөө хүлээчихсэн улс. Тэгэхээр энд нэг жижигхэн процессын хуулиар шийдэл гаргачих боломж байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

(Хурлын бичлэг №4-ийн 1:05:50-цагаас): Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаасаа өмнө процессын хуулиар Цэцээс, Ерөнхийлөгчөөс санал авъя гэтэл практик дээр харахаар санал ирсэн гээд доторх агуулга нь ямар байна авч хэлэлцэхгүй явуулчихдаг. Гэтэл яг энэ үед бол Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалыг хамгаалах том эрх, чиг үүрэг нь байгаад байх шиг харагдаад байдаг юм. Тухайлбал, энэ 1992 оны Үндсэн хуулийг баталж байгаа хууль тогтоогчдын үзэл баримтлалаа эхлээд батлаад дараа нь Үндсэн хуулиа баталсан байгаа шүү дээ. Тэрний дагуу одоо протоколууд нь бүх бичиг баримтууд нь байна. Үүний дагуу суурь бүтэц, үзэл баримтлал дээр нийцэж байна уу? үгүй юу? нэмэлт, өөрчлөлт. Нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнээсээ давсан уу, үгүй юу. Сүүлд 2010 оныхоор хүчингүй болсон тоон үзүүлэлтээс илүү гарсан уу, үгүй юу гэдэг ч юм уу энэ бүх юм нь дээр нь дүгнэлтээ хийгээд Цэц өгөхөд тэрийг нь УИХ авч үзээд энэ бол нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнээс хальчихсан байна. Тийм учраас энэ УИХ-ын эрх мэдлээс хэтэрсэн байна. Тэгэхээр бид нар нэмэлт, өөрчлөлтийнхөө хэм хэмжээн дотор Цэцийн өгч байгаа хэмжээн дотор оруулах нэмэлт, өөрчлөлт хэрэгтэй юм байна гэдэг. Ингэмээр байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг анзаарах ёстой юм юу вэ гэхээр практик дээр харахаар УИХ Цэцэд энэ дээр ажиллах боломж олгохгүй, цаг хугацааны хувьд шахдаг, өргөн барьсныхаа дараа Үндсэн хуулийн цэц Ерөнхийлөгч рүү өгөөд нэгэнт хэлэлцээд эхэлчихсэн үед бол Цэц

симболныцны гэмээр юм уу санал өгчихдөг. Тэр саналыг нь доторх агуулгыг нь анхаарахгүй санал өгсөн гэдгээр нь цаашаа хэлэлцээд явчихдаг. Тэгэхээр би энэ дээр одоо байгаа Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулахгүйгээр Ц.Мөнх-Оргил гишүүний ахалж байгаа хууль дээр илүү тодорхой оруулчихвал Үндсэн хуулийн цэцийн өгч байгаа санал, Ерөнхийлөгчийн өгч байгаа саналуудын агуулгыг нь харгалзан үзэх, УИХ хэлэлцэхдээ, ийм юмыг. Сая Б.Гүнбилиг доктор хэлж байна шүү дээ. Олон улсын гэрээ, конвенцыг нэгдэн орохоос өмнөх асуудлыг соёрхон батлаагүй байна гээд орхичихдог. Нэгэнт баталсны дараа заавал тэр нь дээр өөрчлөлт хийх боломжгүй. Яг энэ Үндсэн хууль чинь өөрөө мөн агуулга нэг байгаа байхгүй юу. Өмнө нь ингээд боломжтой, нэмэлт, өөрчлөлтөөс хэтэрчихсэн байна гэж хэлэх боломж байтал цаг, хугацааны хувиар шахдаг, дээрээс нь болбол Үндсэн хуулийн цэц өөрөө их “басейба”. Энэ дээр үнэхээр өмнөөс нь анхаараад, ард түмний дунд хийж байгаа хэлэлцүүлгийн үед өөрсдөө бэлдчихье гэсэн бол болох байхгүй юу. Гэтэл тэр нь дээр санаачилгатай ажиллаагүй байж дараа нь нэг иргэдийн мэдээллээр энэ асуудлыг аваад эцэслэдэг. Тэгэхээр одоо жишээ нь сонгуультай давхар Засгийн газрын гишүүн, УИХ-ын гишүүний асуудлаар үүнийг хэлэлцчихээд одоо дахиад дараа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн өөр нэг заалтыг барьж аваад мэдээлэл өгөх юм бол хэлэлцээд явах юм уу гэдэг ийм байдал гаргаж байгаа байхгүй юу. Үүнийг болбол журмын тухай хуулиараа, бусад хуулиараа цэгцлэх боломж байгаа юм аа. Хоёрт нь нэг асуудал болбол хийсвэр дүгнэлтийн талаар. Үндсэн эрхийн асуудлыг илүү эрх хэмжээг нь өгье гэж байна. Би бас Д.Мөнхтуяа шүүгчийн саналыг нэлээн дэмжиж байна. Нөгөө талд нь ачаалал их болох юм чинь хийсвэр дүгнэлт өгдөг асуудлыг больё, нэлээн популист чиглэлийн байна гэсэн хийсвэр дүгнэлт дээр энэ эрхийг хаачих юм бол их харамсалтай болох гээд байна. Жишээ нь, УИХ-ын шийдвэр нэлээн хийдэлтэй гарч байна. Одоо ялангуяа бид нар мэдэж байна шүү дээ. 1999 оны нэмэлт өөрчлөлт, 2000 онд олонх, цөөнх 2 нийлж байгаад л хавсайдаж байгаад л цаг хугацаагаа шахаж байгаад л дуурийн маягтай ийм нэмэлт, өөрчлөлт хийчихсэн шүү дээ. Гэтэл тэрийг иргэн хүн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргахгүй ээ. УИХ-ын цөөнхийн гишүүн ч юм уу, тодорхой тооны гишүүд л гомдол гаргах эрхтэй гээд өөрчилчихдөг. Гэтэл тэд нар нийлээд хуулиар хийчихсэн өөрчлөлтүүдийг яах юм. Цөөнх нь байсан ч өргөдөл гаргахгүй шүү дээ, мэдээлэл, хүсэлт гаргахгүй шүү дээ. Тэгэхээр энэ маш их чухал одоогийн байгаа иргэний мэдээлэл гаргах энэ эрхийг хаагаад зөвхөн үндсэн эрхтэй нь холбоод өгчих юм болбол энэ их гажуудалтай болно оо. Бусад Герман зэргийн улсуудад бол нэлээн цэгцэрчихсэн байгаад

байх шиг байна. Манайх шиг хууль тогтоох үйл явц нь өөрөө бүрэн төлөвшиж амжаагүй байгаа, энэ дээр мөн цоорхой гарч байгаа. Зөвхөн цөөнхөд найдуулаад ч юм уу, тодорхой УИХ-ын хэдэн гишүүд нь өөрсдөө гомдол гаргах үед авч хэлэлцдэг гээд ингээд явцууруулах юм бол осолтой байх байх шүү гэж саналаа хэлж байна. Баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Б.Нармандах: Нармандах гэж хүн байна. Энэ дээр процессын харилцааг боловсронгуй болгохтой холбоотой Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөөг дээшлүүлэх гээд анхаарвал зохих тодорхойгүй асуудлууд байдаг. Тэгэхээр тухайлах юм бол түрүүн Д.Мөнхтуяа шүүгчийн өгүүлбэрт гарсан. Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргаад УИХ-д өргүүлээд орхичихоор тодорхойгүй хугацаагаар хариу ирүүлдэггүй асуудал. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны процессын ажиллагаанууд тодорхойгүй байдлаар хугацаа алддаг эсхүл Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн гээд асуудлыг шийдвэрлээд ирэхээр тухайн хууль, эрх зүйн актаар хүчингүй болгонгуутаа өөр нэрээр баталдаг ч гэдэг юм уу, ийм практикууд байгаад байгаа асуудал нь Цэцийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөөтэй байх явдлыг сулруулаад байна. Тэгэхээр энэ бүхнийг хязгаарлахад чиглэгдсэн зохицуулалтыг Үндсэн хуулийн процессын хууль дээр оруулж өгөхдөө анхаарах нь зүйтэй юм болов уу гэж бодож байна.

Өөр нэг асуудал, урьд болсон хурал дээр Ц.Сарантуяа докторын илтгэл дээр маш тодорхой санал гарч байсан. Хүсэлт гаргах эрх бүхий субъектүүд бол хүсэлтээсээ татгалзах замаар процессын үйл ажиллагааг тодорхой бус байдалд оруулдаг. Улс төрийн шинжтэй тийм акцуудыг дэвэргэдэг ийм асуудлууд байна. Тийм учраас хүсэлт гаргаж байгаа субъектүүд хүсэлтээсээ татгалздаг асуудлыг бас процессын хуулиар хязгаарлаж өгвөл яасан юм бэ гэсэн ийм саналыг давхар гаргаж байна. Үдээс өмнөх хуралдаан дээр үг хэлэх боломж олдоогүй учраас үдээс өмнөх хуралдаантай холбоотой нэгэн санал хэлье. Үндсэн хуулийн цэц өөрөө Үндсэн хуулийн шүүхийн, Үндсэн хуулийн манаач юм бол тэр Үндсэн хууль гэдэг объектоо өөрийг нь өөрчлөх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах процессын ажиллагаанд зайлшгүй оролцмоор байна. Тэр санал авна гэдэг байдлаар орчихсон боловч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой үйл ажиллагаанд Цэцийн оролцоо, нөлөө огт байхгүй гэж хэлж болохоор явж ирсэн. Тэгсэн хэр нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийг хянан хэлэлцэхгүй байхаар Үндсэн хуульд нэмэлт, оруулж байгаа энэ нь үндсэндээ манаачаас далдуур Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь бүтцийг

хөндөх боломжийг бий болгоод байна гэж харж байна. Тэгэхээр энэ талаар нь анхаарч өгөөч ээ гэж хэлэх байна. Баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

1:13:35-аас: Санал хэлэх гэсэн юм. Сая нэг иргэний нийгмийн төлөөлөл гээд нэг эмэгтэй ярьж байна л даа. Цэц гэдэг шүүх мөн гээд. Англи хэлний нэр томъёонд байгаа. Constitution court гээд шүүх гэж явдаг байгаа. Ардын Их хурлын хэлэлцүүлгийн протоколд Цэц гээд үндэсний онцлогтой нэр өгсөн гэдгийг хэлмээр байна. Гишүүдийг анх томилохдоо харгалзан хууль тогтоогчид буюу УИХ томилохдоо анхаарах хэрэгтэй байна. Анхнаас нь яг ямар хүмүүсийг томилох юм, насыг их бас анхаармаар байна. Мөн Цэцийн гишүүний нас дээд хязгаар 65 гэдэг нь бусад улсад яг тийм байна уу, үгүй байна уу насаар нь томилдог ч жишээ байна. Ихэнх нь 70 хүртэл байдаг юм байна лээ эх газрын эрх зүйн системтэй улс оронд.

Сонсгол хийе гэдгийг нь би хувьдаа дэмждэг. Жишээ нь, АНУ ч юм уу бусад хөгжилтэй улсуудад бол бараг хөршийг нь авчирч байгаад томилдог, асуулт, хэлэлцүүлэг явдаг байгаа. Нэр томъёоны хувьд ч гэсэн манайд гишүүн, зарим Турк улсад member гэж явдаг. Бусад улс, оронд ихэвчлэн justice гэж явж байгаа. Justice гэдэг нь өөрөө үлгэр жишээч баймааж л хуульчийн этик, морал, үнэт зүйл, нийт ард түмний эрх ашгийн төлөө Үндсэн хуулийн төлөө байгаа зүйлийг хамгаалдаг хүний хувьд тэрийг justice гэж нэрлээд байгаа юм. Зүгээр judge гэж биш байгаа. Нэр томъёоны хувьд ч гэсэн ингээд үзэж байгаа. Сая мөн Иргэний нийгмийн эмэгтэй хэлж байна л даа, 9-хөн хүн шилжчихдэг гээд. АНУ-ын 335 сая гаруй хүмүүст мөн 9-хөн шүүгч байдаг шүү, Federal supreme court-д. Тэгэхээр анх тэр хүмүүсийг томилохдоо л анхаарах хэрэгтэй. Зургаан жилээр томилчхоод байх чинь бас нэг насыг нь бодолцож хууль тогтоогч буюу УИХ-аас томилж байх нь зөв юм болов уу. Гурван эрх бүхий байгууллагуудаас томилж байгаа гишүүдийг нийт ард түмний төлөөлөл, элч буюу УИХ-аас тэднийг томилж байна. Тэд нар хараат бус байхаараа дундаасаа даргаа томилж байна. Манайд нэг буруу ойлголт байдаг. Энэ гурван гишүүдийг тэр байгууллагын төлөөлөл юм шиг, дундаасаа ардчилсан маягаар нууцаар санал хураагаад даргаа томилж байхад, УИХ-аас томилогддог даргатай, удирдлагатай ийм байгууллага гэдэг асуудлууд хууль тогтоогчдын зүгээс явдаг байгаа.

Цэцийн шийдвэрүүдийн үндэслэлийг шүүмжилж байна. Мөн УИХ-д Монгол Улсын хувьд дүгнэлтийг ингээд өгдөг. УИХ хуулиа засаач ээ гэдэг боломжийг өгдөг цөөхөн бараг ганцхан улсын нэг нь байх. УИХ яагаад зөвшөөрөөгүй вэ гэдгийг бас өөрсдөө Хууль зүйн байнгын хороо нь ч юм уу, хууль эрх зүйн орчноосоо үндэслэлээ яагаад зөвшөөрөөгүй

вэ гэдэг практик манайд байдаггүй гэдэг 2 талдаа аль аль талдаа бодолцох хэрэгтэй юм шиг байгаа юм. Ханс Кельзен Үндсэн хуулийн эрх зүйн онолыг анх үндэслэгч байна. Мөн Австрийн Үндсэн хуулийн шүүхийн дарга Кристоп Гуардунпартер гээд хүн байна. Эдгээр хүмүүс Үндсэн хуулийн шүүхийг negative slaughter гээд хэлчихсэн байгаа. Яагаад negative slaughter вэ гэдгийг эрхэм багш нар, докторууд бүгд мэдэж байгаа байх аа. Ийм санал хэлэх гэсэн юм. Анх томилохдоо анхаараач ээ гэж. Баярлалаа.

1:16:48-аас: Давхардуулахгүйгээр 2 санал хэлье. Үдээс өмнөх хуралдаан дээр санал хэлэх боломж олдсонгүй. Нийлүүлээд хэлчихье гэж бодож байна. Ц.Сарантуяа багшийн илтгэлд дотор ер нь бол тоочих зарчмаар биш ерөнхийлөн тоймлох зарчмаар Үндсэн хуулийн маргааны асуудлыг Үндсэн хуулийн Цэц хэлэлцэх маргааны асуудлыг хянуулах нь зүйтэй гэсэн агуулга хөндөгдөж байсан. Энэ дээр бол санал нийлж байгаа. Яагаад гэвэл Үндсэн хуулийн 68.2 дахь заалтыг бид хэд нэлээн тойрч ярилаа. Хууль, зарлиг Ерөнхийлөгч, УИХ-ын бусад шийдвэр гэдэг дотор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг агуулга бол хөндөгдөж орж байгаа гэж судлаачийн хувьд харж байгаа. Тийм учраас заавал тоочиж нэр зааж эрэмбэлэхээсээ илүү Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх тэр агуулга нь өөрөө тодорхой ерөнхийлсөн байдлаар заачих юм бол одоо энэ үндсэн эрхийн маргааны асуудал ч гэсэн дагаад ороод ирэх боломжтой юм уу гэж харж байна, нарийвчлан тоочихгүйгээр.

Хоёрдох асуудал бол мөн энэ Х.Сэлэнгэ багшийн илтгэлд дурдагдаж байсан объектыг өргөтгөх асуудал дээр бол үндсэн эрхийн маргааныг авч хэлэлцэх нь зүйтэй гээд үзэхэд сая Д.Мөнхтуяа шүүгчийн санал дотор орж байсан. Захиргааны хэргийн шүүхтэй давхардсан хяналтын механизмыг нэг тийш нь болгож өгөхгүй бол тухайлбал, цаашдаа үдээс өмнөх нээлт дээр хэлж байсан, аймаг, нийслэлийн иргэдийн хурлын шийдвэрийг Цэц хянадаг болбол яасан юм бэ гэсэг поинт орж ирж байсан л даа, санаа. Ийм байдлаар Цэцийн маргаан шийдвэрлэх харьяалан шийдвэрлэх маргаануудыг өргөтгөөд явах юм бол Цэц өнөөдөр хийж байгаа ажлынхаа хувьд бол их ажил хийж байгаа. Гэхдээ цаашлуулаад нарийвчлаад тоочоод заагаад өгөх нь процессынхоо хувьд ямар нөхцөл байдал үүсэх вэ? гэдгийг том зургаар нь харах нь зүйтэй байх гэж харж байна.

О.Мөнхсайхан докторын болон Ц.Сарантуяа докторын тэр асуултад хариулж байсан, илтгэл дунд яригдаж байсан зүйл бол Цэцийн бүрэлдэхүүнийхээ шаардлагыг эргээд нэг гаргах хэрэгтэй. Мэдээж Цэцийн тухай хууль шинэчилсэн найруулга явж байгаа, процессын

хуулийн шинэчилсэн найруулга явагдаж байгаа үед бол хуульчид бид бүхэн бол Цэцийн гишүүнд тавигдаж байгаа энэ шаардлагыг бол хос шаардлага гэж харж байгаа. Хууль зүйн болон улс төрийн гэдгийг хос шаардлага гэж хардаг. Улс төрийнхний нүдээр бол харж байгаа өнцөг нь болохоор тус тусдаа аль нэг нь байх юм аа гэж хараад байдаг. Энэ зарчмаар өдийг хүртэл явчихсан. Тэгэхээр энэ зарчмыг нэг тийш болгож өгөх нь зүйтэй. Яагаад гэвэл хууль зүйн өндөр мэргэжилтэй гэдэг нь 15-аас дээш жил процессын ажиллагаа явуулсан, эрдэм шинжилгээний ажил хийсэн, хууль зүйн салбартаа ажилласан. Улс төрийн мэргэжил гэдгийг бол улс төрийн салбарт аль нэгэн албан тушаал эсвэл сонгуульд ажил эрхэлж байсан юм бол тэр эрхэлж байсан хугацаанаасаа хойш 10 жилийн дараа та Цэцийн гишүүнээр ажиллах боломжтой юм гэдэг, арай нэг улс төрийн гэдэг хязгаарлал тогтоож өгсөн нь Үндсэн хуулийн цэцийг дагасан, тойрсон ийм талцсан маргаанууд нэг тийш болж өгөх болов уу гэж судлаачийн хувьд харж байгаа.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Баясгалан, Тамгын газрын хууль зүйн дарга Н.Болортунгалаг нарын илтгэлдээ дурдагдсан процесстой холбоотой зүйл дээр 1 гишүүн маргаан үүсгэх асуудлаар маргаанаа шийдвэрлүүлж байгаа нь өөрөө дахиад маргаан үүсгэж байгаа. Тэгэхээр шууд 3 гишүүн түрүүн илтгэлд дурдагдаж байсан санааг дэмжиж байгаа үүднээс хэлж байгаа юм шүү, Цэцийн 3 гишүүн бүрэлдэхүүнээрээ шийдвэрлээд энэ асуудлыг бол маргаан мөн, цаашид үргэлжлүүлэх үү, үгүй юу гэдгээ шууд шийдээд явчихсан дээр. Дахин дахин процесс хийж байгаа нь өөрөө цаг хугацааны хувьд ч гэсэн асуудалтай. Н.Болортунгалаг судлаачийн илтгэл дээр дурдагдсан дунд суудал, их суудал хоёрын хуралдааны маргааныг тус тусад нь зохицуулж өгөх шаардлага байна гээд, энэ бол процесс дээр яг тулгамдаж байгаа асуудал. Яагаад гэвэл, дунд суудлын бүрэлдэхүүнээсээ авхуулаад шийдэх асуудал байна гэж харж байна. Энэ асуудлуудыг өргөн зургаар нь харахад бол Цэцийн хууль, процессын хууль дээр хэлэлцэгдэж байгаа энэ цаг үед бас дахиад улс төрийн намуудын төлөөлөл оролцсон Үндсэн хуулийн шинэчлэн найруулгын төсөл бас зэрэгцээ явж байгаа юм байна лээ, та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Энэ дунд бас нэг ухралт хийсэн агуулгууд орж ирж байгаа. Энэ бас манай хэлэлцүүлгийг үнэгүйдүүлэх гэдэг ч юм уу ийм зүйл байх магадлалтай байна. Яагаад гэвэл Улсын Дээд шүүхэд Цэцийн хяналтыг шилжүүлэх гэсэн яриа үүсгээд явж байгаа тохиолдлуудыг та бүхэн анхааралдаа авах нь зүйтэй байх гэж бодож байна. Бид нар урагшаагаа явж байгаа болохоос биш хойшоо ухарч байгаа бол биш шүү дээ гэсэн санал хэлье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа.

Б.Сайнсанаа: Үндсэн хуулийн тухай буюу хуулийн биелэлтэд хяналт тавих тухай ярьж байна. Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалаа судлаагүйгээр зарим нэг юмыг ойлгохгүй. Өөрөөр хэлэх юм бол, Үндсэн хуулийн үг бүрийн ард баримт дүүрэн ном бий гэдэг үг байдаг. Суурь үзэл баримтлалаа ойлгоогүйгээс ингээд Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавина гэдэг үгийг түрүүний В.Удвал докторын илтгэлд гарлаа. 255 УИХ-ын хуулийг хууль зөрчсөн гэж гарсан гэж. Бид нар хууль зөрчсөн хууль гаргасныхаа дараа Үндсэн хуулийн цэцийн ачаалал ихэснэ гэж ярих юм уу, эсхүл наана нь Үндсэн хуулийн хяналтаа хаана нь тавих юм бэ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийг маань зөрчсөн хуулиуд, органик хуулиуд гараад байх юм уу. Үндсэн хууль хэзээ амилдаг вэ? гэхээр Үндсэн хуульчилсан буюу органик хууль, бусад хууль Үндсэн хуульдаа нийцэж байж тэр хууль маань өөрөө амилна. Үндсэн хуулийг сурталчлахгүйгээр, таниулахгүйгээр хүмүүс ойлгохгүй. Бүх юмыг Үндсэн хууль руу чихдэг. УИХ-ын өөрийнх нь функц нь хяналт тавих үүрэг нь байж байдаг. Үндсэн хуулийг өөрчлөх шалтгаан нь хяналт тавьж чадахгүй байна гэдэг юм яригддаг. Тэгэхээр энэ дээр бид нар Д.Мөнхтуяа шүүгчийн түрүүний хэлсэн бүх сууриараа, процесс тэр чигээрээ өөрчлөгдөнө. Харьялал гээд аваад үзэх юм болбол амьд явах эрхтэй, эрүүл аюулгүй орчинд байх ёстой гэдэг энэ хуулийг ямар хуулиар амилуулж байж ямар объектуудаар Үндсэн хуулийн цэц рүү очих вэ? гэдэг онолын судалгаануудыг нэлээн үндэслэж ярих шаардлагатай байгаа. Түрүүн шүүх эрх мэдэл гээд Д.Мөнхгэрэл гишүүн өөрөө хэллээ. Шүүх эрх мэдэлд оруулах ёстой гээд.

Үндсэн хуулийн анхны хэлэлцүүлгийг та нар уншсан болов уу, сая 13 боть гарсан. Хэлэлцүүлгийн явцад, Ард нийтийн хурлаар хэлэлцүүлж байх явцад Үндсэн хуулийн цэц нь шүүх байгууллага юм гэдэг үндсэн бүтцэд орж явж байгаад сүүлд нь Үндсэн хуулийн цэц гээд тусгай бүлэг рүү ороод Үндсэн хуулийн цэц хэрвээ шийдвэр өөрөө гаргах юм болбол Үндсэн хуулийн шүүхийн дарга нь өөрөө хүчингүй болгоно гэдэг эрх. Дээрээс нь Үндсэн хуулийг Үндсэн хуулийн цэц тайлбарлана гэдэг бүх юмыг Ардын их хурлын хэлэлцүүлгийн явцад аваад хаячихсан учраас бид нар Үндсэн хуулийнхаа суурь үзэл баримтлалыг ахиж сайн ул суурьтай шийдмээр байна. Энэ дотор яригдаж байгаа Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох гэдэг асуудал яригдаж байх явцад Үндсэн хуулийг өөрчлөх гэдэг асуудлууд бас дунд нь тавигдаж байна л даа. Тухайн тэр тавигдаж байгааг харахад Үндсэн хуулиа бүрэн судлаагүй тэр дотор нь байгаа агуулгыг ийш нь оруулж ирээд энэ болоогүй байна гэсэн юмнууд тавигдаж байна. Тэгэхээр бид нар Үндсэн хуулиа таниулах, сурталчлах, мэдүүлэх ажлуудыг нэлээн хийхгүй

болбол Үндсэн хуулийн өөрийнх нь хүчин чадал болбол шавхагдаагүй. Үндсэн хуулийн эхийг баригчийн хүүхэд ярьж байгаа, энийг хамгаалж байна аа гэдэг утгаараа биш, Үндсэн хууль судлаачийн хувьд энэ нь өөрөө хоорондоо бүх хуулиуд амсалдаж бие биеийгээ нэг мөр ойлгосны дараа л хуулиуд чинь бүгдээрээ хэрэгжинэ. 2016 онд УИХ-ын гишүүн хэлж байсан, Үндсэн хуулийн өөрчлөлтийн хэлэлцүүлэг дээр. Хууль гараад 10 жил хэн ч мэддэггүй тийм хууль байна гэж. Тэгэхээр УИХ өөрөө Үндсэн хуульд нийцэж байгаа хууль гаргачхаад тэрнийхээ хяналтыг хэрэгжиж байгааг, хэрэглэж байгаа энэ субъектүүдийн хувьд нь эргэх холбоотой ажиллах тийм юм байж байж Үндсэн хуулийн цэцийн одоо нэмэгдэх гээд байгаа, өөрөөр хэлбэл 1992 оноос хойших тоон баримтууд яригдлаа, өсөж байна, нэмэгдэж байна энэ 9 гишүүн барагдахгүй нь ээ гэдэг юмыгаа, объектоо яаж авах уу гэхээр органик хуулиудаа сайн хийж өгч байж л тэрийг Үндсэн хуулийнхаа манаачийг УИХ хийж чадах байх. Үндсэн хуулийн цэц. УИХ нь Үндсэн хуульдаа нийцсэн хууль Үндсэн хууль зөрчсөн хууль гаргахгүйгээр бусад хууль тогтоомж болон шийдвэрүүд Үндсэн хууль зөрчихгүй гэдгийг хэлэх хэрэгтэй байна. Түрүүн олон улсын гэрээ Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд эргээд хүчингүй болгох гээд. Бид нар соёрхон батлахдаа эхлээд Үндсэн хуульд нийцэж байна уу? үгүй юу гэдэгт түрүүн Б.Гүнбилэг докторын хэлсэнтэй санал нэг байна. Ингэж хийхгүйгээр хойноос нь яриад байх шиг байна л даа бид нар. Үндсэн хуулийнхаа уг суурь үзэл баримтлалыг аягүй сайн таниулах ажиллагаа дутагдалтай байна гэж үзэж байна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Бид нар одоо тоочих зарчмаа аажмаар болиод ерөнхийлөн заах зарчим руу шилжье гэдэг бол бид нар эрх зүйн хөгжлийн шинэ шатанд гарч байгаагийн л илрэл л дээ, тийм ээ. Энэ чинь өөрөө манай Цэцийнхнээс ерөнхийлөн заасан ойлгож тэрийг тайлбарлаж хэрэгжүүлэхийг шаардаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл, асар өндөр түвшний ур чадвар, эрх зүйн мэдлэг, практик шаардлагатай, тийм ээ. Тэр нь дээр бид бэлэн байвал зүгээр тооччихоод байхад л асуудал гараад байна шүү дээ. Тэгэхээр анх хууль тогтоогч бол зүгээр санамсаргүй тооччихоогүй л байгаа шүү дээ. Бусад зөндөө улс орнуудын хуулийг хараад ингээд тоочдоггүй юм байна, заавал нэг ерөнхий завсрын хэлж байж тэрийг нь хэрэгжүүлээд явдаг юм байна гэдгийг хэдийгээр мэдэж байсан ч гэсэн улаан шугам татаад тоочиж. Яагаад уу, яагаад уу гэвэл эрх зүйн хөгжил, эрх зүйн соёл, бидний хүний нөөцийн бололцоо, чадавхыг л бас л нэг л харгалзсан нэг хэрэг л дээ. Тэгэхээр тэр шатандаа бид нар хөгжөөгүй байна гэдэг чинь өөрөө миний хувьд бас л эргэлзээтэй том асуудал, тийм ээ, зовлонтой

асуудал. Тооччихсон байхад бол сайн байна. Гэхдээ мэдээж сул талууд байна, проблемууд байна гэдгийг харах л ёстой юм байна. Хууль, улс төрийн өндөр мэргэжилтэй гэдгийг бол хосолж хэрэглэнэ гэвэл тийм хүн олдохгүй шүү дээ. 10 хэдэн жил шүүгч хийчихсэн, тэгээд хууль тогтоочихсон юм уу, улс төрийн туршлагатай гэсэн тийм хүнийг олж Цэцэд оруулна гэвэл манж, тэрэнд орохгүй, Цэцэд ажиллаж байгаа багш нар ч орж чадахгүй. Тэр бол хэтэрхий өндөр шаардлага болно. Үндсэн хуульд бид нар нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр энэ Цэцийн хууль тайлбарлах замаар л гарц хайх хэрэгтэй. Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулчихаад тэрийгээ хийнэ гэвэл бүтэхгүй л дээ. Хэзээ ч Үндсэн хуульд нэмэлт оруулах юм. Одоо ярьж байгаа юм нь бүтэх ч юм уу? Цэцтэй холбоотой 4, 5 заалтаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг тэр бол хэцүү, бүтэхгүй. Тэгэхээр хэдүүлээ яг энэ Үндсэн хуульд бичигдсэн заалтаа яаж тайлбарлах уу, яаж дэлгэрүүлэх үү, гэхдээ зөв хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд яаж авч явах уу гэдэг л зарчмыг баримтлах байх гэж бодож байна.

Тэгээд одоо хэдүүлээ ингэе тэх үү? Дараа, дараагийнхаа ажлын процессыг товчхон ярилцаадахъя. Би бол ингэж ойлголоо шүү, өнөөдөр энд сууж байгаа судлаачид ер нь нэг тийм том албан бус ажлын хэсэг байгуулагдлаа шүү. Та нар чөлөөтэй санал бодлоо хэлж байх хэрэгтэй байна. Болдог бол бүр ингэмээр байх юм М.Үнэнбатаа, өнөөдөр оролцсон хүмүүс дотор *vibe* групп бий болгоод, санал бодлоо чөлөөтэй хэлээд, энэ ажлыг зангидаж байгаа хүн бол манай М.Үнэнбат байгаа, Цэцээс Г.Баясгалан дарга байгаа. УИХ-аас би байгаа. Хэдүүлээ санал бодлоо нэмж хэлэлцүүлье. Ойрын үед хуулийн төсөл өргөн баригдахгүй. Хэрвээ баригдахдаа тулбал эхлээд үзэл баримтлалаа хэлэлцэнэ, үзэл баримтлалаа тал талаасаа ярьж заавал тохирох албагүй, ерөнхий нэг баримжаатай болсны дараа хуулийн төсөл дээр ажиллаж эхэлнэ. Хуулийн төсөл дээр ажиллаад эхлэхээр би бодож байна, энд сууж байгаа олон судлаачдыг татаж оролцуулах байх аа. Хоёрт, зохион байгуулалтын хувьд ийм юм хиймээр байгаа юм. Эд нар бол манай ТББ-ынхан Н.Бадамрагчаа байна уу? гараад явчихсан уу? Энэ Венийн конвенцын *Constitutional justice*-н зөвлөмжүүдийг *conflation* хийгээд нийлүүлчихсэн байгаа. Сая би Баясаа даргаас авлаа л даа. Жишээ нь энэ дээр бүтэц, бүрэлдэхүүн, процесс, хяналтын объект, хэлбэр гээд бүх юм нь дээр зөвлөмжүүд байгаа. Тэгэхээр энэ бол бүгдийг нь бид нар заавал хэрэгжүүлэх албагүй л дээ, бололцоогүй. Гэхдээ ерөнхийдөө олон улсын *best practice* буюу хамгийн сайн туршлага ямар байна, бидний олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн хэрэгжилт дээр тусгаж хийсэн ийм *conflation* байгаа. Үүнийг нэгдүгээрт энд сууж байгаа

хүмүүстээ viber группээр тараачихмаар байна. Бүгдээрээ нэг ойлголтод хүрмээр байна шүү дээ, тийм ээ. Яг ийм мэдээлэлтэй юм байна аа гээд. Хоёрт, болдог бол аятайхан Монгол руу оруулчихмаар байна О.Мөнхсайхан, энэ ажлыг зохион байгуулаадхаач.

О.Мөнхсайхан: Үндсэн эрхийн маргаан, үндсэн эрхийн гомдлыг шийдвэрлэх сайн туршлагын Венецийн комиссын 70 хуудас тайлбарыг манай Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн орчуулчихсан юм. Одоо хэвлэгдэж байгаа.

Ц.Мөнх-Оргил: “On Individual access to constitutional justice” гээд үү?

О.Мөнхсайхан: 2020 оныхыг. Энийг мөн орчуулна. Эхний байдлаар Нээлттэй нийгэм форумтай ярьж байгаад тэгээд ажлын хэсгийн ахлагчаар дамжуулаад яаралтай шийдье дээ.

Ц.Мөнх-Оргил: Үүнийг хэдүүлээ ямар ч байсан англи хэл дээр нь тараачхаад Монгол хэл рүү нь орчуулаад бага багаар нь гэсэн, нэг нэгээр нь ч гэсэн тийм ээ, орчуулаад тавиад баймаар байна. Гуравт би Баясаа даргаа өнөөдөр хэлэлцүүлгээс надад ийм л санаа төрлөө. Хэдүүлээ хэлэлцүүлгээ цааш нь үргэлжлүүлээд гол гол асуудлуудаа яриад явж байя. Гэхдээ өнөөдрийн байдал, процессын хууль дээрээ саяын үндсэн эрхийн асуудал зэргийг хөндөхгүйгээр яг одоогийнхоо практик дээр сууриалаад процессын хуулиа жоохон дэлгэрүүлэх ажлыг хийгээд явж байвал яасан юм бэ, саяын манай Н.Болортунгалаг зэрэг маш олон асуудлуудыг ярилаа шүү дээ, тийм ээ. Ер нь ингээд харахаар хэдийгээр жишээ нь одоо юу гэдэг юм УИХ Цэцэд хандаж асуудал тавьж байгаагүй ч гэсэн тавивал яаж ёстой юм бэ? Ямар дэс дарааллаар явах юм бэ? гэдэг нь бүр нарийвчлаад гаргаад явж байя. Ерөнхийлөгч тавивал яах юм. Дээд шүүх тавивал яах юм. Бүгдийг нь задлаад үүгээр явж байвал яадаг юм бэ? Тэгэх үү? Тэгээд хэдүүлээ ярьж байгаад тодорхой хязгаар хүрээтэйгээр үндсэн эрхийн буюу constitutional complaint-ыг Цэц хүлээж авдаг боллоо гэж бодоход тэрийгээ засаад залруулаад явах суур нь тавигдчихаар. Энэ бүгдийн хэлэлцүүлгийн дунд миний жишээ нь надад ямар үүрэг ноогдож байна уу гэхээр би бол УИХ дахь 2 улс төрийн намын бүлэгт энэ том том суурь зарчмын асуудлуудаа танилцуулах хэрэгтэй болж байгаа юм. Бид нар ийм юм ярьж байна шүү, ийм үр дагавартай шүү, та нар мэдээллээ аваарай, юмаа бэлдэж байгаарай гэж нөгөөдүүлийгээ мэдээлүүлэх асуудал чухал болчихоод байгаа юм, тийм ээ. Бид нар мэдээлчихээс гадна цаана нь шийдвэр гаргагч нараараа мэдээлүүлэх асуудал чухал болчихоод байгаа юм. Ингээд өнөөдрийнхөө хэлэлцүүлгийг өндөрлөө. Би бол зориудаар ямар нэгэн дүгнэлт хийхгүйгээр зөвлөмж гаргахгүйгээр эрдэм шинжилгээний бага хурал юм чинь гэхдээ ерөнхий хандлага бол гарч байна гэж ойлгож

байгаа. Хүн хүн янз янз ойлгох байх. Гэхдээ ерөнхий хандлага бол тогтож байна. Энэ хэлэлцүүлгийг зохион байгуулах, энэ эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн Хууль, зүй дотоод хэргийн яам, Төрийн нарийн бичгийн газрын дарга П.Сайнзориг, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх М.Үнэнбат, Цэц, Цэцийн гишүүн Г.Баясгалан, Н.Болортунгалаг, Хүрээлэнгийнхэн, О.Мөнхсайхан багш, энд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Дахиад хэд хэдэн удаа уулзаж энд асуудлаараа дэлгэрэнгүй ярилцана аа. Баярлалаа.

